УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
СУРГАЛТЫН
ХҮРЭЭЛЭН

# ПАРЛАМЕНТ



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

БОТЬ
43

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

# “ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)

**БОТЬ**
**43**

- Нийгмийн судалгааны хэсэг

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛААНБААТАР ХОТ, 2023

“Парламент” судалгааны эмхэтгэл (43 дугаар боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа,
сургалтын хүрээлэнгээс эрхлэн гаргав.

Хянасан: Ц.Цогзолмаа
Ц.Норовдондог (Ph.D)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл
Р.Оргилмаа

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Төгсзаяа

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УИХ-ын Тамгын газар ©
“ПАРЛАМЕНТ” СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ - БОТЬ 43

# ГАРЧИГ

## I БҮЛЭГ. НИЙГЭМ


**1.1** Оршуулгын зан үйлийн Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал болон гадаадын зарим орны хууль эрх зүйн зохицуулалт (СТ-22/219)......................... 6

*Ц.Норовдондог (Ph.D), Б.Батцэцэг, С.Золжаргал, Б.Мөнгөнсувд*

**1.2** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах байгууллагын талаарх бусад орнуудын туршлага (СТ-22/221)............................................................ 39

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Оргилмаа, Д.Жигваагүнсэл,*
*Д.Амаржаргал (Ph.D), О.Билгүүтэй*

**1.3** Номын баярын талаарх мэдээлэл, лавлагаа (СТ-22/408) ............................. 66

*Д.Аюуш, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл,*
*Р.Оргилмаа, С.Золжаргал, Б.Мөнгөнсувд*

**1.4** Цагийн ажлын эрх зүйн зохицуулалт, төрөөс үзүүлж буй дэмжлэг: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага (СТ-22/222)................................. 82

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Жигваагүнсэл, О.Нарантуяа,*
*Р.Оргилмаа, Э.Дашзэгвэ*

**1.5** Эмийн хяналтын лаборатори ба эмийн чанар, стандартын шинжилгээний үнэ тариф: зарим орны туршлага (СТ-22/223).................................................. 122

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш, О.Нарантуяа,*
*Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Э.Дашзэгвэ*

**1.6** Эмийн хөнгөлөлтийн тогтолцоо, эрх зүйн орчны талаарх бусад орнуудын туршлага ба Монгол Улс дахь хөнгөлөлттэй эмийн худалдааны статистик мэдээлэл(СТ-22/227)........................................................................................ 181

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш, Б.Батцэцэг,*
*С.Золжаргал, Б.Баянмөнх*


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# БҮЛЭГ I

## НИЙГЭМ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛИЙН МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), О.Нарантуяа,*
*Б.Батцэцэг, С.Золжаргал, Б.Мөнгөнсувд*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

I.МОНГОЛ УЛСЫН ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

II.ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛИЙН ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1.Оршуулгын үйл ажиллагааны олон улсын чиг хандлага, туршлага

2.2.Гадаадын зарим орны туршлага

-Америкийн Нэгдсэн Улс

-Бүгд Найрамдах Солонгос Улс

-Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

-Япон Улс

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгын дагуу “Оршуулгын зан үйлийн Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, гадаадын зарим орны хууль эрх зүйн зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

***Судалгааны зорилго***

Оршуулгын зан үйлтэй холбоотой харилцааны эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд гадаадын зарим орны оршуулгын зан үйлийг журамласан байдал, уг харилцаанд гарч буй зөрчил шийдвэрлэлтийн талаарх туршлага болон Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдлыг харьцуулан судлах.

***Судалгааны хамрах хүрээ***

Судалгааны зорилгын хүрээнд мэдээллийн хайлт, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, бусад орнуудын туршлагыг судлахдаа АНУ, Герман, БНСУ, Япон, Казакстан зэрэг орнуудыг сонгон авч оршуулгын зан үйлийн эрх зүйн орчин, уг харилцаанд гарч буй зөрчил шийдвэрлэлтийн хүрээнд мэдээллийг нарийвчлан судлав.

Түүнчлэн оршуулгын зан үйлийн талаарх Монгол Улсын эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдлын мэдээлэл болон холбогдох бусад судалгааны мэдээлэлд тулгуурлан бэлтгэлээ.

***Судалгааны тайлангийн бүтэц***

Судалгааны тайлан нь хоёр бүлэгтэй.

*Нэгдүгээр бүлэг.* Монгол Улсын оршуулгын зан үйлийн эрх зүйн орчин, өнөөгийн нөхцөл байдал

*Хоёрдугаар бүлэг.* Гадаадын зарим орны оршуулгын зан үйлийн талаарх эрх зүйн зохицуулалт

***Судалгааны арга зүй***

Холбогдох мэдээлэл, эрх зүйн зохицуулалтын актуудыг гадаад хэлнээс хөрвүүлэх, судалгааны захиалга болон удирдамжид заасан чиглэлийн дагуу мэдээлэл боловсруулах, мэдээллийг харьцуулах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглав.

***Түлхүүр үг:*** *оршуулга, чандарлах, далд оршуулах, булш, авс, талийгаач, оршуулгын тэтгэмж, оршуулах зан үйл, нас барсны гэрчилгээ*

***Keywords:*** *funeral, cremation, burial, grave, coffin, deceased, funeral allowance, burial rites, certificate of death*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Монголчуудын оршуулгын зан үйл нь нүүдэлчдийн түүх соёлын онцлогийг илэрхийлэх өвөрмөц нэг хэлбэр бөгөөд эрт дээр үеэс үе улиран уламжилж ирсэн шороонд оршоох, усанд урсгах, галд өргөх, салхинд хатаах, төмөрт авслах зэргээр таван махбодын ялгалаар оршуулах зан үйлийг үйлддэг байжээ. Эдгээрээс булшлах, ил оршуулах хоёр нь нийтийн түгээмэл ёс байсан бөгөөд түүнээс ил гээгдүүлэн оршуулах зан үйлийг булшлан оршуулах ёсоор халж, тэрхүү булшлан оршуулах заншил нь орчин үеийн монгол нийтийн ёс болж байна. Нас барагсдыг оршуулах ёс нь газар авах, талийгаачийн шарилыг гэр орондоо байрлуулан уй хийх, талийгаачийг хөдөөлүүлэх, гашуу тайлах зэрэг үндсэн хэсгээс бүрддэг байна.

Нийгэм, шашин, зан заншил, ард түмний амьдралын хэв маяг, мэдлэг боловсрол, шинжлэх ухаан техникийн дэвшил зэргээс хамаарч оршуулгын зан үйл ч хувьсан өөрчлөгдөж байна. Мөн сүүлийн жилүүдэд нийслэлийн байгаль экологи, агаар, хөрсний бохирдол, хүн амын

эрүүл аж төрөх орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө олон улсын чиг хандлага, шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх зайлшгүй шаардлага үүсч байна. Манай улсад оршуулгын зан үйлийн талаар баримтлах нэгдсэн бодлого байхгүйн улмаас уламжлалт ёс заншил, түүх соёлд үл нийцэх сөрөг дагаврууд гарч, оршуулгын зан үйлийн харилцаанд тулгамдсан асуудлууд үүсч, төрөөс зохицуулалт хийх шаардлага үүссэнийг судалгаанаас харж болохоор байна.

Манай улс оршуулгын зан үйлтэй холбоотой харилцааг анх 1929 онд Улаанбаатар хотын захиргаанаас “*Аливаа наснаас нөгчсөнийг нутаглуулах тухай*” анхны дүрмийг боловсруулан гаргаж, нас барагсдыг зүүн, баруун Алтан-Өлгийд нутаглуулж байхаар шийдвэр гаргаснаар эрх зүйн зохицуулалт эхэлжээ. Үүнээс хойш төрийн холбогдох байгууллага болон нийслэл Улаанбаатар хотын захиргаанаас талийгаачийн оршуулгын үйл ажиллагааг эмх журамтай болгох чиглэлээр олон дүрэм журам, тогтоол шийдвэрийг гаргажээ.

Одоогийн байдлаар Монгол Улсад Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6841:2020, Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS 5605:2006, Байгаль орчны хамгаалал. Чандарлах зуух (крематор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5606-1:2016 гэсэн 3 стандартыг голлон баримталж байгаа бөгөөд бусад хуульд заасан холбогдох зохицуулалтаар эрх зүйн орчин хязгаарлагдаж байна.

***Оршуулгын үйл ажиллагааны олон улсын чиг хандлага, туршлага***:

Даяаршлын энэ цаг үед улс орнууд харилцан туршлага солилцож, оршуулгын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлж байна. Үүний илрэл нь дэлхийн өнцөг булан бүрд оршуулгын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, хувь хүмүүс зорилго, чиглэлээ нэгтгэсэн анхны холбоо 1887 онд байгуулагдаж байсан бол одоогоор 7500 гишүүн байгууллагатай олон улсын оршуулгын холбоо (*International Cemetery, Cremation and Funeral Association)*, 1800 гишүүн байгууллагатай Ази-Австралийн оршуулгын холбоо *(Australian Cemeteries and Crematoria Association),* 19000 гишүүнтэй Үндэсний оршуулгын захирлуудын холбоо (*National Funeral Directors Association)* зэрэг болон өргөжиж байна. Олон улсын энэ холбоодын зорилго нь бурхан бологсдын дурсгалыг мөнхжүүлэхдээ байгаль, экологид ээлтэй, иргэдийн эрүүл мэнд, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахыг зорьж байна.

***Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг авч үзвэл*:** Судалгаанд авагдсан ХБНГУ, БНСУ, Япон улсад оршуулгын үйл ажиллагааг бие даасан хуулиар зохицуулж байна. Харин АНУ-д Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуульд “Оршуулгын үйл ажиллагаа” гэсэн бүлгээр, БНКазУ-ын хувьд Үндэсний эдийн засгийн сайдын тушаалаар “Булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах үлгэрчилсэн дүрэм”-ээр оршуулгын зан үйлийг зохицуулж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***АНУ-ын Калифорни мужийн хувьд*:** 1939 оны Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуульд “Оршуулгын үйл ажиллагаа” гэсэн бүлгээр оршуулгын зан үйлтэй холбоотой харилцааг зохицуулжээ. Талийгаачийг оршуулахдаа далд булшлан оршуулах, эсхүл чандарлах үйл ажиллагааг ар гэрийнхний нь хүсэлтийн дагуу шийдвэрлэдэг. Шарилыг чандарлахад талийгаачийн ар гэрээс зөвшөөрөл авах, амьд ахуйдаа гэрээслэсэн гэрээсийн дагуу чандарладаг байна. Мөн нас барснаас хойш хамгийн багадаа 24 цаг, эсхүл 48 цагийн дотор чандарладаг. АНУ-д чандарлах зан үйл нь 2021 оны байдлаар нийт оршуулгын 51 хувийг эзэлж байгаа бөгөөд 2025 онд 60 хувьд хүргэхийг зорьж байна. Америкчуудын чандарлах зан үйлийг сонгож байгаа нөхцөл шалтгаан нь оршуулгын

уламжлалт далд булшлан оршуулахтай харьцуулахад байгаль экологид ээлтэй, олон улсаас нэвтрүүлж байгаа “*ногоон оршуулга*”-д нийцсэн, мөн үнэ хөлсний хувьд хямд гэж үзэж байна. Оршуулгын зан үйлийн харилцаанд зөрчил үүссэн тохиолдолд Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн 8113.6 дугаар зүйлд заасны дагуу “Оршуулгын газар нь энэ бүлгийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд хуулийн бусад зүйл, заалтаас үл хамааран сахилгын шийтгэл онооно” гэж заажээ.

***БНСУ-ын хувьд*:** Оршуулах зан үйлийн уламжлалыг нарийн баримталдаг бөгөөд талийгаачийн шашин шүтлэг, ар гэрийнхний хүсэлтээс хамаарч өөр өөр байдаг боловч ихэвчлэн Күнзийн уламжлалт зан үйлийн дагуу явагддаг. Тус улсад оршуулах зан үйлтэй холбоотой харилцааг Оршуулгын тухай хууль, Гэр бүлийн эрүүл зан үйлийн журам, Оршуулгын тухай хуулийн хэрэгжилтийн тухай заавар болон холбогдох бусад хуулиар зохицуулдаг байна. 2015 онд шинэчлэн найруулсан Оршуулгын тухай хуулиар оршуулах арга, оршуулгын байгууламжийг суурилуулах, байгуулах, зохион байгуулах, төрийн байгууллага болон оршуулгын үйл ажиллагаа эрхлэгчтэй холбогдох харилцаа, оршуулгын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт, хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулсан. Нийтийн болон хувийн оршуулгын газарт булш суурилуулах хугацааг 30 жил болгож, зөвхөн нэг удаа 5-30 жил хүртэл хугацаагаар сунгаж болохоор өөрчилсөн нь байгальд ээлтэй оршуулгыг нэвтрүүлэхэд чиглэж байна. Мөн дурсгалын модны цэцэрлэгт хүрээлэнд чандарласан булшийг 15 жилийн хугацаатай ашиглалтын төлбөр төлж байршуулах зэрэг нэмэлт, өөрчлөлтийг оруулж өгчээ. Байгалийн аргаар оршуулж байгаа тохиолдолд чандарласан үнсийг хийж байгаа сав нь байгальд шингэх боломжтой байхыг шаарддаг байна.

БНСУ-д оршуулгын газар нь нийтийн болон хувийн оршуулгын газраас бүрдэх бөгөөд хотын дарга, эсвэл захирагч, Си/Гүн/Гү хотын дарга нь нийтийн оршуулга, олон нийтийн чандарлах байгууламж, нийтийн бунхны газар, нийтийн оршуулгын газрын өргөтгөлийн байгууламжийг барих, байгуулах, удирдан зохион байгуулах ажлыг хариуцан ажилладаг. Улсын бүртгэлийн байгууллага нь нас барсан тухай мэдүүлгийг нас барснаас хойш нэг сарын дотор эмнэлгийн магадлагаа болон задлан шинжилгээний баримт, нас барсан газар, оршуулсан газар эсвэл чандарласан газрын талаарх мэдээлэлд үндэслэн бүртгэдэг. Оршуулгын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хотын дарга, эсвэл захирагч, Си/Гүн/Гү хотын дарга хяналт тавих бөгөөд Оршуулгын тухай хуульд заасан хариуцлагын арга хэмжээг ногдуулах эрхтэй.

***БНКазУ-ын хувьд*:** Тус улсад манай улстай адил тусгайлсан оршуулгын тухай хууль байхгүй бөгөөд БНКазУ-ын Үндэсний эдийн засгийн сайдын 2019 оны 48 дугаар тушаалаар Булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах үлгэрчилсэн дүрмийг баталсан байна. Орон нутгийн засаг захиргаа нь уг үлгэрчилсэн дүрмийн дагуу орон нутгийн булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах дүрмийг боловсруулна. Уг дүрмийг боловсруулахдаа суурин газрын нутаг дэвсгэрийн онцлог, хөгжил, түүх соёлын өвийн хадгалалт, шашны зан үйл, байгалийн тогтоц зэргийг харгалзан үздэг байна. Тус дүрмийн хэрэгжилтэд хот, нийслэлийн засаг захиргаа нь дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллах, оршуулгын газрын нөөц болох ашиглагдсан талбай болон ашиглагдаагүй талбайн талаарх мэдээллийг олон нийтэд цахимаар ил тод байршуулах ажлыг зохион байгуулна.

***ХБНГУ-ын хувьд*:** Оршуулгын зан үйлийг муж улс бүр өөрсдийн тогтоосон хууль журмаар зохицуулдаг хэдий ч муж улсуудын эрх зүйн зохицуулалтын зарим утга агуулга нь нийтлэг төстэй байна. Үүнээс Бавари мужийн 1970 онд баталсан Оршуулгын тухай хуулийг авч үзвэл, нас барагсдыг оршуулах, оршуулгын үйл ажиллагааг хариуцах газар, зохион байгуулах хүнийг тусгайлан зааж өгсөн. Мөн оршуулгын зардалтай холбоотой харилцааг

иргэний болон холбогдох хуулиар зохицуулж байна. Оршуулгын тухай хуулиар нас барагсдыг далд булшлан оршуулах, чандарлах, чандарласан үнсийг усанд уусах зориулалтын савтай далайд тавихыг зөвшөөрсөн байдаг. Мужийн засаг захиргаа тус хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, Хотын захиргаа оршуулгын газар, чандарлах газар, шарил хадгалах газар болон түүнтэй адилтгах байгууламжид олон нийтийн аюулгүй байдал, хэв журмыг сахиулах, ялангуяа хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дэг журам, нэр төрд халдах зэрэг үйлдлийг хориглох шаардлагатай захирамж гаргаж болно.

***Япон Улсын хувьд*:** Оршуулгын ёслолын 90 орчим хувь нь буддын шашны зан заншлаар явагддаг. Буддын шашны урсгал тус бүр өөр өөрийн онцлог шинж чанартай бөгөөд оршуулгын нарийн дэг жаяг, аргатай боловч "сэрэх - оршуулах ёслол - чандарлах" гэсэн цуврал нэрээр нэрийдсэн ёслолыг түгээмэл хэрэглэдэг байна. Японд нас барагсдын 99.9 хувийг чандарладаг. Оршуулга нь нас барагсдын гэр бүл, төрөл төрөгсөд, эргэн тойрных нь хүмүүсийн хувьд чухал хүндэтгэлтэй үйл ажиллагаа учраас талийгаачийн араас үйлдэх зан үйл болгон өөрийн утга учиртай байдаг.

Япон Улс нь оршуулгын зан үйлтэй холбоотой харилцааг 1948 онд батлагдсан Оршуулгын газар, оршуулгын тухай хууль болон Үндсэн хууль, Байгаль орчны тухай хууль, Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль зэрэг холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулж иржээ. Тус улс газар нутгийн хэмжээ багатай учир орон нутгийн засаг захиргаа нь нас барагсдыг чандарласны дараа чандарыг хөрсөнд булах газрыг тухайн хот тосгон, муж тойргийн газар зүйн байршил, хүн амын нягтаршлаас хамаарч 2-4 метр квадрат талбай олгодог байна.

Оршуулгын үйл ажиллагаа явуулдаг бүх байгууллагыг нэгтгэсэн *“Японы оршуулгын холбоо”* нь оршуулгын зан үйл, оршуулгын газрын менежментийг боловсронгуй болгон хөгжүүлэх, улмаар иргэдийн эрүүл мэнд, нийгмийн сайн сайхан байдлыг хангах зорилгоор оршуулгын газруудыг судалгаа, мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Мөн сүүлийн үеийн оршуулгын зан үйлийн төрөл, оршуулгын байгууламжийн нөөц бололцоо, олон улсын оршуулгын зан үйлийн чиг хандлагыг олон нийтэд таниулах зорилготойгоор 2005 онд *“Оршуулгын сурталчилгааны сан”*-г байгуулсан бөгөөд нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, оршуулгын зан үйлийн талаарх судлаачид хамтран ажилладаг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын харьцуулалт*

| Улсын нэр | Эрх зүйн зохицуулалт | Оршуулгын зан үйлийн хэлбэр | Чандарлах оршуулгын хувь хэмжээ (нийт оршуулга) | Булш байршуулах талбайн хэмжээ | Төрийн байгууллагын оролцоо | Хариуцлага | Онцлог зүйлс |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Монгол** | - Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6841:2020<br>- Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS 5605:2006<br>- Байгаль орчны хамгаалал. Чандарлах зуух (крематор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5606-1:2016 болон холбогдох хуулийн зүйл заалтаар зохицуулж байна. | - газарт булшлан оршуулах<br>- чандарлах<br>- ил оршуулах | 29.3% | 12м2 | - Нийслэлийн засаг захиргаа<br>- Орон нутгийн засаг захиргаа<br>- Оршуулгын үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд | Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулга түүнтэй холбогдох үйл ажиллагаа зохион байгуулах журамд хариуцлагын асуудлыг журамласан боловч хэрэгжиж эхлээгүй байна. | Буддын шашны зан үйлээр талийгаачийн амьсгал хураасан өдөр, цаг, минутыг нарийвчлан тогтоож шинжээ хийх буюу “алтан сав”-тай холбоотойгоор оршуулах зан үйлийг тодорхойлж хэрэгжүүлж байна. |
| **АНУ** | - Эрүүл мэндийн аюулгүй байдлын хуульд “Оршуулгын үйл ажиллагаа” гэсэн тусдаа бүлэг байна. | - газарт булшлан оршуулах<br>- чандарлах | 51% | 2.4м2 | - Муж орон нутгийн засаг захиргаа | Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуульд заасанаар хариуцлага ногдуулна. | Нас барагчийг чандарлах тохиолдолд ар гэрийнхнээс нь зөвшөөрөл /гарын үсэг/ авахыг хуульчилсан байна. |
| **БНСУ** | - Оршуулгын тухай хууль,<br>- Гэр бүлийн эрүүл зан үйлийн журам,<br>- Оршуулгын тухай хуулийн хэрэгжилтийн тухай заавар<br>- Бусад холбогдох хууль, дүрэм журам | - газарт булшлан оршуулах<br>- чандарлах<br>- байгалийн жамаар оршуулах | 80% | 2 м.кв-аас ихгүй | - Хотын дарга эсвэл захирагч, Си/Гүн/Гү хотын дарга<br>- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам | Оршуулгын тухай хуульд заасан хариуцлагыг ногдуулна. | Дурсгалын мод буюу төрийн өмчийн модны цэцэрлэгт хүрээлэн байгуулсан. Оршуулгын газарт булш суурилуулах хугацаа 30 жил болгож багасгасан |
| **БНКазУ** | БНКазУ-ын Үндэсний эдийн засгийн сайдын 2019 оны 48 дугаар тушаалаар Булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах үлгэрчилсэн дүрмийг баталсан байна. Орон нутгийн засаг захиргаа нь уг | - газарт булшлан оршуулах | чандарладаггүй | 6м2 | - Хот нийслэлийн засаг захиргаа<br>- Орон нутгийн засаг захиргаа | | Оршуулгын зан үйл нь уламжлалт буюу газарт оршуулах хэлбэрээр гүйцэтгэдэг бөгөөд хуулиар чандарлах үйл ажиллагааг |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үлгэрчилсэн дүрмийн дагуу орон нутгийн дүрмийг боловсруулна. | | | | | | хориглоогүй ч Шариатын үзлээс шалтгаалан шарил чандарлах үйл ажиллагаа явуулдаггүй байна. |
| **ХБНГУ** | - Оршуулгын тухай хууль | - газарт булшлан оршуулах<br>- чандарлах | | - чандарыг оршуулгын газарт оршуулахдаа 80 см<br>- шарилыг булшлан оршуулахдаа 1.8- 2 м2 | Хот, дүүргийн засаг захиргаа | Оршуулгын тухай хуульд заасан хариуцлагыг ногдуулна. | |
| **Япон** | Оршуулгын газар, оршуулгын тухай хууль, Үндсэн хууль, Байгаль орчны тухай хууль, Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль, Иргэний хууль зэрэг холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулж ирсэн байна. | - чандарлах | 99.9% | 2-4м2 | - Хотын захирагч<br>- Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам | Оршуулгын газар, оршуулгын тухай хууль болон Эрүүгийн хуулийн “Булшны газар, бунхантай холбоотой гэмт хэрэг” зүйл заалт | Бүх оршуулгын үйл ажиллагаа явуулдаг газрыг нэгтгэсэн Оршуулгын холбоотой мөн оршуулгын сурталчилгааны сантай байна. |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

## I.МОНГОЛ УЛСЫН ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын хувьд оршуулах зан үйлтэй холбоотой харилцааг анх 1929 онд Улаанбаатар хотын захиргаанаас “*Аливаа наснаас нөгчсөнийг нутаглуулах тухай*” анхны дүрмийг боловсруулан гаргаж, нас барагсдыг зүүн, баруун Алтан-Өлгийд нутаглуулж байхаар шийдвэр гаргаснаар эрх зүйн зохицуулалт бий болжээ. Үүнээс хойш төрийн холбогдох байгууллага болон нийслэл Улаанбаатар хотын захиргаанаас талийгаачийн оршуулгыг эмх журамтай болгох чиглэлээр олон дүрэм журам, тогтоол шийдвэрийг гаргажээ.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөл, МАХН-ын төв хорооны Тэргүүлэгчдийн 1955 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн “*Нас барагчдын хүүрийг журамтай болгох тухай*” хамтарсан тогтоолоор Улаанбаатар хотод “*Хүүр оршуулах товчоо*” байгуулах тухай асуудлыг тусгасан нь оршуулгын асуудлыг эрхлэн хариуцах тусгай байгууллагыг байгуулах эрх зүйн үндэс бий болжээ. 1956 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “*Нас барагчдын хүүрийг оршуулах тухай*” тогтоолд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 1956 оны 03 дугаар сарын 01-нээс эхлэн “*Хүүр оршуулах товчоо*”-г байгуулан ажиллуулсугай гэж заасан байдаг. Улаанбаатар хотын захиргааны 1956 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн шийдвэрээр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын Хот тохижуулах хэлтсийн дэргэд орон тооны ажилчид, тээвэр, үйлдвэрийн газартай “*Хүүр оршуулах товчоог*” байгуулж байжээ. Энэ нь хүн ам төвлөрсөн суурин газар дахь оршуулгын асуудлыг хариуцсан төрийн захиргааны харьяа анхны байгууллага юм.[1]

Манай улсын хувьд 2022 оны байдлаар оршуулгын зан үйлтэй холбоотой харилцааг дараах дүрэм, журмаар зохицуулж байна.

**1.Монгол Улсын стандартууд:**

***Оршуулгад хамаарах үйлчилгээ. Ерөнхий шаардлага (MNS 6841:2020)*** Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн С/21 тушаалаар батлагдсан тус стандарт Монгол Улсын нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагаанд хамаарах үйлчилгээ эрхлэн явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж болон хувь хүн, гадаад улсын иргэн, харьяалалгүй этгээд, хэн бүхэнд хамаарна. Түүх, археологийн малтлага, палентлоги, түүхэн дурсгалт газрын судалгаа нь энэхүү стандартад хамаарахгүй.

***Шарил чандарлах үйлчилгээний байгууллагад тавих ерөнхий шаардлага (MNS 5605:2006)*** Стандартчилал, хэмжилзүйн үндэсний Зөвлөлийн 2006 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан тус стандартад шарил чандарлах, оршуулах үйлчилгээг төрийн ёслол, шашны зан үйлийн хүрээнд эрхлэх, уг үйлчилгээтэй холбогдуулан агаар, ус, хөрсийг цэвэр ариун байлгах, үйлчлүүлэгчийн хүсэл шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд тавих шаардлагыг тодорхойлсон.

***Байгаль орчны хамгаалал. Чандарлах зуух (круматор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS5606-1:2016)***

Бүх төрлийн чандарлах зуух (круматор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох, тэдгээрийн ялгаралд хяналт тавих, үнэлэхэд оршино.

[1] Монголчуудын хойлгын зан үйл III боть

**2.Хууль тогтоомж**

***Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн*** 20 дугаар зүйлд:

- Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ 36 сараас доошгүй хугацаагаар төлсөн даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас нас барвал түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно;
- Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан бол оршуулгын тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацааг харгалзахгүйгээр олгоно;
- Нийгмийн даатгалын тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авч байсан иргэн нас барвал түүний оршуулгад зориулан оршуулгын тэтгэмж олгоно.

21 дүгээр зүйлд: Оршуулгын тэтгэмжийн хэмжээг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

***Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн*** 22.1-т Мөрдөгч…хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах, оршуулсан цогцсыг гарган шинжлэх, мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах, хяналттай хүргэлт, хяналтын худалдан авалт, мөрдөн шалгах нууц туршилт, нууц ажиглалт, таньж олуулах ажиллагааг нууцаар хийхийг прокурорын зөвшөөрлөөр явуулна.

23.4.5. “Мөрдөгч цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжилгээ хийх тохиолдолд прокурорын зөвшөөрөл авах ба уг ажиллагааг гүйцэтгэхэд шүүх эмнэлгийн шинжээчийг байлцуулна” гэж заасны дагуу хуулийн байгууллага цогцсыг гаргах, шинжилгээ хийх, газарт далд булшлан оршуулах бүх үйл ажиллагаа болон зардлыг хариуцах бөгөөд цогцост шинжилгээ хийхээс өмнө ар гэрийнхэнд нь мэдэгдэх боловч ар гэрийнхний зөвшөөрөлгүй гагцхүү прокурорын зөвшөөрлөөр уг ажлыг гүйцэтгэнэ.

23.4.5. Мөрдөгч цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжилгээ хийх тохиолдолд прокурорын зөвшөөрөл авах ба уг ажиллагааг гүйцэтгэхэд шүүх эмнэлгийн шинжээчийг байлцуулна.

23.4.8. Цогцсыг оршуулсан газраас нь гаргаж шинжлэх бол энэ зүйлд заасан үзлэгийг урьдчилан хийж, энэ тухай тэмдэглэлд тусгана.

***Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн*** 10.3 дахь хэсэгт Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хөрөнгийг Эрүүгийн хуулийн зүйл ангиудад үндэслэн 10.3.2-т заасны дагуу оршуулгын зардал олгоно.

***Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн*** 20.1 дэх хэсэгт Цэргийн алба хаагч, түүнчлэн дайчилгаатай сургууль цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн нас барахад түүний оршуулгад зориулан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж олгоно.

***Иргэний хуулийн*** 508.1 дэх хэсэгт Хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зайлшгүй зардал болон гэм хор учруулсны төлбөрийг түүний өв залгамжлагч шаардах эрхтэй.

530.1.Эд хөрөнгө хүлээн авсан өвлөгч тухайн эд хөрөнгөөс 530.2.1-т заасан өвлүүлэгчийг өвчтэй байхад асрах болон түүнийг оршуулахад гарсан зардлыг гаргах эрхтэй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Нийгмийн халамжийн тухай хуулийн*** 4 дүгээр бүлэг. Нас барсан иргэнийг оршуулах зардлын нормативыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

***Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн*** 23.1.7. Хорих ял эдэлж байхдаа нас барсан хоригдлын тухай гэр бүлд нь мэдэгдсэнээс хойш 7 хоногийн дотор хариу ирээгүй бол хорих анги өөрийн зардлаар оршуулах бөгөөд нас барсан шалтгаан, нөхцөлийн талаарх материалыг хувийн хэрэгт хавсаргана.

***Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан болон өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн (I) конвенцын*** 17 дугаар зүйл. Нас барагсдыг ёс төртэй, боломжтой бол шашны нь зан үйлийн дагуу оршуулах, булшийг хүндэтгэх, боломжтой бол нас барагсдын үндэс угсааг харгалзан бүлэглэн байрлуулах, зохих ёсоор хадгалах болон тэднийг хэзээд олж болохуйцаар тэмдэглэх явдлыг цаашид хангана.

***МУ-ын дээд шүүхийн тогтоол.*** Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай 96.1.4. Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол түүнийг оршуулахтай холбогдсон зардал болон гэм хор учруулсны төлбөрийн хэмжээг Иргэний хуулийн 508 дугаар зүйлийн 508.3-т зааснаар тогтооно.

***Засгийн газрын тогтоол.*** Зарим цогцос оршуулах тухай.

Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцост (цаашид “зарим цогцос” гэх) шүүх эмнэлгийн магадлан шинжилгээ хийх, түүнийг хадгалах, оршуулахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

***Коронавируст халдвар (COVID19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад баримтлах түр заавар*** 8.2. Цогцсыг зориулалтын газарт чандарлах болон булшлах аргаар оршуулах бөгөөд ил тавихыг хориглоно.

***Төрийн албаны тухай хуулийн*** 60.2. Албан үүргээ гүйцэтгэх явцад төрийн албан хаагчийн амь нас хохирсон тохиолдолд 60 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламжийг түүний ар гэрт нь олгоно.

***Газрын тухай хуулийн*** 12.2. Нийтийн эдэлбэрийн газарт хот, тосгон, бусад суурины гудамж, талбай, зам, нийтийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, оршуулгын газар, хог хаягдлын цэг, цэвэршүүлэх талбай зэрэг газар хамаарна.

***Иргэний бүртгэлийн тухай хуулийн*** 13 дугаар зүйлд заасны дагуу бүртгэлийн үйл ажиллагаа хариуцсан байгууллага бүртгэж, нас барсан гэрчилгээг олгоно.

***Шарил нүүлгэн шилжүүлэхэд баримтлах түр журам***- **Монгол Улсын Их Хурлын 2013 оны “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” 23 дугаар тогтоол.** Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн (цаашид “НИТХ” гэх) 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн “Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн байгуулах тухай” 109 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/733 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, Самбалхүндэвийн оршуулгын газрын 10 га талбайд бурхан болоочдыг дурсан хүндэтгэх иж бүрэн тохижилт, барилга байгууламж бүхий “Дурсгалын цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төслийг хэрэгжүүлэхээр заасан.

***Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулга түүнтэй холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах журмын талаар:*** НИТХ-ын тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 09-ний

өдрийн 86 дугаар тогтоолоор “Нийслэлийн нутаг дэвсгэрт оршуулгын үйл ажиллагааг зохион байгуулах журам”-ыг баталсан боловч энэхүү журам нь эрх зүйн чадамжгүй гэж үзэн одоогоор хэрэгжиж эхлээгүй байна.

Энэхүү журмаар оршуулгын газрыг байгуулах, хамгаалах, тохижуулах, хаах болон шарилыг оршуулах, чандарлах, нүүлгэн шилжүүлэх ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна. Энэхүү журам нь хэн болох нь тогтоогдоогүй, гэмт хэргийн холбогдолтой шарилыг оршуулах үйл ажиллагаанд хамаарахгүй.

*Хариуцлага:* Журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мөнгөн торгууль ногдуулж хариуцлага хүлээлгэнэ.

- *Иргэнд* хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ногдуулж, зөрчлийг арилгахад гарсан зардлыг нөхөн төлүүлнэ;
- *Зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллага* болон шарилын хайрцаг, чулуу хийдэг байгууллагад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10-30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ногдуулахаас гадна үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авна;
- *Албан тушаалтныг* хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ногдуулах болон тухайн албан тушаалаас чөлөөлөх арга хэмжээ авна;
- *Лам хувраг, бөө удган, зурхайч*, бусад шашны номлогч нарт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн торгууль ногдуулна.

**Монгол Улсын оршуулгын зан үйлтэй холбоотой зарим статистик мэдээллээс үзэхэд,** нийслэлийн нутаг дэвсгэрт нийт 758.5 га талбайд оршуулгын газар эзэлж байгаагаас 524.5 га талбай нь зөвшөөрөгдсөн, 176.5 га талбай нь албан ёсоор хаагдсан, 57.5 га талбайд зөвшөөрөлгүй оршуулга хийгдэж байна. Үүнээс гадна Төв аймгийн нутаг дэвсгэрт хотын баруун, зүүн талын 2 байршилд нийт 140 га талбайд оршуулгын газар ажиллаж байна.[2]

Улаанбаатар хотод буяны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй 40 орчим аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 20 орчим байгууллага байна.

Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 17000 орчим хүн нас барж байгаагаас 8000 орчим нас баралт нийслэлд бүртгэгдэж түүнээс 7.6%-ийг чандарлаж, нийслэл хотод оршуулгын газрын хамрах талбай жилд 10 га талбайгаар нэмэгдэж байна гэсэн тоо мэдээ байна. Далд оршуулгыг 15-20 м.кв газарт булах, чандарлаж байгаа тохиолдолд талбайн хэмжээ нь 1 м.кв гэж заасан байдаг.

*Хүснэгт 2. Нас баралтын тоо*

| Он | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|---|---|---|---|---|---|---|
| **МУ-ын хэмжээнд нас баралтын тоо** | | | | | | |
| Нийт нас баралт | 17763 | 17357 | 17864 | 18403 | 15924 | 19929 |
| Чандарласан тоо | 1554 | 1414 | 1317 | 1450 | 1208 | |
| **Улаанбаатар хотын хэмжээнд нас баралтын тоо** | | | | | | |
| Нийт нас баралт | 7275 | 7605 | 7561 | 7801 | 7795 | 10333 |
| Чандарласан тоо | 1554 | 1414 | 1317 | 1450 | 1208 | 3032 |

*Эх сурвалж: Буяны зан үйлийн холбоо http://mfa.mn/*

[2] Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны мэдээлэл 2022 он (Монголчуудын оршуулгын зан үйл:уламжлал, орчин үе, чиг хандлага ЭШХ III)

*Хүснэгт 3.Оршуулга эзлэх газрын тооцоолол*

| Он | Нийт нас баралтын тоо | Чандарласан тоо | Далд булшлан оршуулсан тоо | 1 шарилд оногдох газрын хэмжээ м2 | Тухайн жилд оршуулганд зориулах газрын нийт хэмжээ м2 | Га-д шилжүүлбэл |
|---|---|---|---|---|---|---|
| **2016** | 17763 | 1554 | 16209 | 12 | 194,508 | 19.5 |
| **2017** | 17357 | 1414 | 15943 | 12 | 191,316 | 19.1 |
| **2018** | 17864 | 1317 | 16547 | 12 | 198,564 | 19.9 |
| **2019** | 18403 | 1450 | 16953 | 12 | 203,436 | 20.3 |
| **2020** | 15924 | 1208 | 14716 | 12 | 176,592 | 17.7 |
| | | | | | 5жилд | 96.4 |

*Жич: Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээ 4700000м2/10000=470 га газар*

## II.ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ОРШУУЛГЫН ЗАН ҮЙЛИЙН ТАЛААРХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

### 2.1. ОРШУУЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА, ТУРШЛАГА

Даяаршлын энэ цаг үед улс орнууд харилцан туршлага солилцож оршуулгын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлж байна. Үүний илрэл нь дэлхийн өнцөг булан бүрд оршуулгын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, хувь хүмүүс зорилго, чиглэлээ нэгтгэсэн анхны холбоо 1887 онд байгуулагдаж байсан бол 7500 гишүүн байгууллагатай олон улсын оршуулгын холбоо (International Cemetery, Cremation and Funeral Association)[3], 1800 гишүүн байгууллагатай Австралийн оршуулгын холбоо (Australian Cemeteries and Crematoria Association)[4], 19000 гишүүнтэй Үндэсний оршуулгын захирлуудын холбоо (National Funeral Directors Association)[5] зэргээр олон улсын хамтын ажиллагаа улам бүр өргөжиж байна. Олон улсын эдгээр холбоодын зорилго нь бурхан бологсдын дурсгалыг мөнхжүүлэхдээ байгаль, экологид ээлтэй, иргэдийн эрүүл мэнд, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахыг зорьж байна.

Дэлхий нийтийн даяарчлал, нийгэм, эдийн засгийн хөгжил, амьдралын хэв маягтай холбоотойгоор оршуулах зан үйл, ёслолд ч өөрчлөлт шинэчлэлтүүд гарч байна. Энэ нь хүн төрөлхтний хувьсан өөрчлөгдөж буй сэтгэлгээний өөрчлөлт, зан заншил, цаашлаад техник технологийн дэвшлээс харвал ирээдүйд оршуулах ёслол бидний зуршил болсон зан үйлийн хэлбэрүүдээс нэлээд өөрчлөгдөх төлөвтэй байна. Сүүлийн үед дэлхийн олон оронд уран сэтгэлгээний олон санаачлага, өөрчлөлтүүд нэвтэрч эхэлжээ. Мөн дэлхий нийтээр оршуулгын урьдчилсан үйлчилгээ ихээхэн эрэлт хэрэгцээтэй байна. Энэхүү үйлчилгээ нь хүмүүст маргаашийн үйлчилгээнд өнөөдрийн үнээр тооцоог хийх боломж санал болгож ихээхэн хэмжээний зардал хэмнэх боломжийг олгодог байна. Үүнд дараах төрлийн үйлчилгээнүүдийг санал болгож байна.

- **Технологид суурилсан оршуулгын хэлбэрүүд**
  Талийгаачийн гурван хэмжээст голограмм, жишээлбэл, талийгаачийн дуртай, сонирхолтой зүйлсийг баримтжуулах, аялал, мөрөөдлийн талаар, мөн гэрээслэлийн урьдчилж бэлтгэсэн бичлэгүүдийг ёслолын ажиллагаанд ашиглах. Талийгаачийн эдгээр мэдээ, мэдээллийг булшны чулуунд шинэ технологиор суурилуулах болсноор шарилыг эргэх зочдод ухаалаг гар утсаа ашиглан нэвтрэн орж, талийгаачийн дамжуулан авах боломжтой.

[3] International Cemetery, Cremation and Funeral Association https://iccfa.com/
[4] Australian Cemeteries and Crematoria Association https://accaweb.com.au/
[5] National Funeral Directors Association https://nfda.org/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- **Удирдлагатай хөргүүр хайрцаганд оршуулах**
  Мумбайд төвтэй Lunatic Koncepts агентлагийн зохион бүтээсэн Aeternal бол жолоочгүй технологид тулгуурладаг орчин үеийн хайрцаг. Aeternal хайрцаг нь орчин үеийн оршуулгын сонголтуудын талаарх цөөхөн ойлголтуудын нэг бөгөөд орчин үеийн технологи дээр суурилсан, оршуулах үйл ажиллагаа болон чандарлах үйл ажиллагаанд хүн оролцохгүйгээр бүхий л үйл ажиллагаа нь автоматаар хийгдэж, оролцогчид цахимаар оролцох юм.
- **Байгальд ээлтэй оршуулга**
  Хүн төрөлхтөн ирээдүйдээ нүүрстөрөгчийн ул мөр бага үлдээхийг хичээж, энэ чиглэлээрээ ч эхлүүлсэн ажлын нэг нь оршуулгын үйлчилгээнд чандарлах үйл явц илүү даяарчлагдаж, байгаль орчинд ээлтэй орчин үеийн хувилбарууд болох
  - Био шатаах (оршуулсны дараа мод тарих)
  - Мөнхийн хад (талийгаачийн үнсийг тогтоц сайтай цемент орлуулагчтай хольж, хиймэл шүрэн хөшөө бий болгох арга)
  - Дахин хуваарилах (энерги зарцуулалт, эсхүл чандарлах бохирдлын тодорхой хэсгийг л нунтаг болгон хувиргах шүлтлэг гидролиз ашиглах)
- **Олон улсад нээлттэй оршуулгын ажиллагаа**
  Дэлхийн өнцөг булан бүрд найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ цахим орчноор видео үйлчилгээг ашиглан оршуулгын шууд дамжуулалт хийх боломж нь бурхан болоочийн салах ёслолын арга хэмжээнд оролцох боломжтой гэсэн үг юм. Хэрэв оролцогчид өөр улс оронд амьдардаг бол эдгээр хэлбэрээр оршуулгын үйл явцыг бүрэн дамжуулан оролцоог хангах боломжтой.
- **Чандраас эрдэнийн чулуу бүтээх үйл ажиллагаа**
  Нарийн мэргэжилтэн бутархай үнсийг цэвэрлэн өвөрмөц технологиор чандрыг 800*С хайлуулан үнэт чулуу болгодог. 2012 онд Дэлхийн Эрүүл Мэнд, Байгаль Орчны нийгэмлэгээс чандрын үнэт чулуун бүтээлийг сайшаан “Байгаль дэлхийд ээлтэй ногоон оршуулга” хэмээн зарласан.
- **Чандраар бороо оруулах үйлчилгээ**
  Талийгаачийн ар гэр болон талийгаачийн гэрээслэсний дагуу чандрыг тусгай зориулалтын өндөр хүчин чадалтай даралтат шүршүүрээр хүссэн газарт нь бороо хэлбэрээр цацах үйлчилгээ.

Олон улсад оршуулгын зан үйлийн чандарлах болон далд оршуулга гэсэн 2 төрөл давамгайлж байна.

*Хүснэгт 3. Оршуулгын зан үйлийн статистик үзүүлэлт*

| Улсын нэр | Чандарлах | Далд оршуулга |
|---|---|---|
| **Монгол** | 7.6% | 78% |
| **Франц** | 45% | 55% |
| **Хятад** | 46.6% | 51.4% |
| **АНУ** | 47% | 53% |
| **Унгар** | 60% | 40% |
| **Канад** | 65% | 35% |
| **Өмнөд Солонгос** | 81.6% | 18.4% |
| **Тайвань** | 92.47% | 7.53% |
| **Япон** | 99.97% | 0.03% |

*Эх сурвалж: АНУ-д төвтэй Олон улсын оршуулгын холбооноос гаргасан статистик*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 2.2. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

### АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС (АНУ)

АНУ-ын насанд хүрсэн иргэдийн 42 хувь нь протестант, 21 хувь нь католик, 5 хувь нь шашингүй үзэлтэн бол үлдсэн хувь нь бусад шашинтай. Тус улсад 2020 оны статистик мэдээллээр 2,960 хүн нас барсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад нас баралтын хувь 1.79 хувиар өссөн бол 2010 оноос хойш нас баралтын тоо нийт 18.84 хувиар өссөн байна.[6] Нас барагчийн шарилыг чандарлахад талийгаачийн ойрын хамаатан садны зөвшөөрлийг авсан байх шаардлагатай байдаг бол зарим муж улсуудад чандарлах зөвшөөрлийг агент (authorizing agent)-д шилжүүлдэг. Энэ нь шарилыг чандарлахаас өмнө тухайн талийгаачийн гэр бүлийхэн “чандарлахыг зөвшөөрсөн бичиг”-т гарын үсэг зурсан байх ёстой.

**Хууль, эрх зүйн орчин**

АНУ-ын муж улс бүр өөрийн гэсэн хууль дүрэмтэй байдаг бөгөөд судалгаанд Калифорни мужийн оршуулгын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг сонгон авсан болно.

***Оршуулгын тухай хуулиар*** шарилыг чандарлахад зөвшөөрөл авах, шарил чандарлах газарт зөвшөөрөл олгох, шарил чандарлах хугацаа зэрэг харилцааг зохицуулсан байна.

Мөн “Ойрын төрөл, хамаатан садан гэдэгт эцэг эх, насанд хүрсэн хүүхдүүд, эхнэр нөхөр, насанд хүрсэн ач, зээ нар, эхийн талын эцэг эх, эцгийн талын эцэг эх, насанд хүрсэн авга ах, нагац эгч, эсхүл цусан төрлийн насанд хүрсэн хүнийг хэлнэ” гэж тодорхойлсон. Хэрвээ эцэг, эх нь нас барсан тохиолдолд бүх хүүхдүүд чандарлахыг зөвшөөрөн гарын үсэг зурсан байх, мөн 2,4 м2-ын хэмжээтэй газарт шарилыг оршуулах ерөнхий хэмжээг хуульчилсан байна.

АНУ-ын муж улс, орон нутгийн чандарлах хууль өөр хоорондоо ялгаатай байдгаас шалтгаалан АНУ-ын зарим мужид нас барснаас хойш хамгийн багадаа 24 цагийн дотор чандарладаг бол зарим муж улсад 48 цагийн дотор шарил чандарлахыг хуульчилсан байдаг байна. Хэрэв талийгаач эрүүл мэндийн ноцтой асуудалтай бол эрүүл мэндийн байгууллага болон шүүх эмнэлгийн зөвшөөрөлтэйгээр цогцсыг шууд буюу яаралтай журмаар чандарлана. Талийгаачийг газарт оршоох, эсхүл чандарлах нь өөрсдийн сонголтын асуудал байдаг. Сүүлийн жилүүдэд ихэнх хүмүүс байгаль орчинд ээлтэй байх үүднээс газарт оршоохоос илүүтэй чандарлахыг сонгодог болсон байна.

***Чандарлах ёс*** нь олон зуун жилийн түүхтэй ба зарим шашинд дараа төрлөө олох хамгийн зөв зам гэж үздэг байхад зарим шашинд итгэгчид ДНХ-ээ үлдээхгүй байхад нөлөөлдөг гэдэгт итгэдэг байна. Америкчуудын чандарлах зан үйлийг сонгож байгаа гол шалтгаан нь санхүүгийн хувьд оршуулгын уламжлалт зан үйлээс илүү хямд байдагтай холбоотой гэжээ. Тус улсад чандарлах зан үйл нь одоогийн байдлаар 51%-тай байгаа бол 2025 онд 60%-д хүрэх магадлалтай байна.

***Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хууль*** (California Health and Safety Code)[7]- нь 1939 онд хүчин төгөлдөр болсон бөгөөд 50 бүлэгтэй. Тус хуульд оршуулгатай холбоотой дараах зохицуулалтыг тусгасан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[6] United States of America - Number of deaths https://knoema.com/atlas/United-States-of-America/topics/Demographics/Mortality/Number-of-deaths

[7] Health and Safety Code https://leginfo.legislature.ca.gov/faces/codesTOCSelected.xhtml?tocCode=HSC&tocTitle=+Health+and+Safety+Code+-+HS

*Нас барсны гэрчилгээ авах* (Duty of Registering Death)[8]- Нас барсан цаг, нас барахаас өмнөх буюу хамгийн сүүлд эрүүл мэндийн нөхцөл ямар байсныг эмч, мэс заслын эмч тэмдэглэнэ. Нас барсны гэрчилгээг эрх бүхий эмч, мэс заслын эмч бөглөж, баталгаажуулах бөгөөд 72 цагийн дотор холбогдох газарт хүлээлгэн өгнө. Эрх бүхий эмч, эмнэлгийн ажилтан нь нас барсан цагийг баталгаажуулсан тохиолдолд хамгийн сүүлд үзлэг хийсэн эмч, мэс засалчийн нэрийг бичиж нас барсан гэрчилгээний хуулбарыг өгөх ёстой. Эмч, мөрдөн байцаагч тухайн хүнийг нас барснаас хойш 15 цагийн дотор нас барсны гэрчилгээг бүрэн бөглөх, эсхүл мөрдөн байцаагч цогцост шалгалт хийснээс 3 хоногийн дараа нас барсны гэрчилгээг бөглөж, бүрдүүлнэ. Тухайн хүн нас барснаас 15 цагийн дотор нас барсны гэрчилгээг оршуулгын газарт хүргүүлнэ.

*Оршуулгын газрын зохицуулалт (Local Regulation of Cemeteries)*[9]- Тухайн муж улсын удирдах байгууллага нь оршуулга, бунхан, оршуулгын газар, түүний бүтэц, оршуулгын газрын чанараас шалтгаалан үүсэх хор уршигаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор эрх зүйн зохицуулалтыг хийнэ.

*Оршуулгын зан үйл үйлдэхэд тавигдах шаардлага (Requirements for Burials*)- Энэ зүйлээр оршуулгын газрын үйл ажиллагаа явуулдаг бүх байгууллага, шашны байгууллага, нийгэмлэг, нийгэмлэгийн дэргэдэх оршуулгын газрын асуудлыг зохицуулна. Энэ бүлгийн 8113.4 дүгээр зүйлд “Оршуулгын газар нь шарилыг зүй бусаар оршуулах, шарилыг заасан хэмжээнээс бага шороогоор хучих, зүлэгжүүлсэн бол тухайн шарилыг дахин оршуулах зардлыг хариуцна” гэж заасан. Мөн уг бүлгийн 8113.5 дугаар зүйлд “шарилд хяналт тавих эрх бүхий хүний зөвшөөрөлгүй, эсхүл хоёр талын зөвшөөрөлгүйгээр шарилыг давхарлаж оршуулсан мөн нэг хайрцагт оршуулахыг хориглоно.”

*Үүрэг хариуцлага:* Дор дурдсан хуулийн заалтыг зөрчсөн тохиолдолд гэмт хэргийн хариуцлага хүлээлгэнэ:

- Гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг жилийн дотор дахин ижил төрлийн гэмт хэрэг үйлдвэл мужийн хорих ангид нэг жил хорих ял;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг жилийн дотор дахин гэмт хэрэг үйлдвэл Эрүүгийн хуулийн 1170 дугаар зүйлд заасны дагуу мужийн хорих ангид нэг жилийн хорих ял;
- Гэмт хэрэгтэн удаа дараалан ижил төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн 1170 дугаар зүйлд заасны дагуу хорих ял тус тус ногдуулна.

Зөрчил үүссэн тохиолдолд Эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулийн 8113.6 дугаар зүйлд заасны дагуу буюу “Оршуулгын газар нь энэ бүлгийн шаардлагыг зөрчсөн тохиолдолд хуулийн бусад зүйл заалтаас үл хамааран сахилгын шийтгэл ногдуулна.” гэж заасан байдаг. Мөн уг бүлгийн 8113.7 дугаар зүйлд зааснаар буюу “хуулийн бусад заалтаас үл хамааран 8113.5 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа зөрчлийг илрүүлснээс эхлэн тооцно” гэх мэт зохицуулалтыг хуульчилсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (БНСУ)

Улс орон бүрд оршуулах зан үйлийн ойлголт, агуулга нь бага зэрэг өөр өөр байдаг ч үхэл нь хүний биологийн үйл ажиллагаа зогсох төдий бус, хүний сүнс энэ ертөнцөөс нөгөө ертөнц рүү шилждэг гэж үздэг.

БНСУ-д оршуулгын зан үйлд бөөгийн зан үйл, буддын шашны зан үйл, Күнзийн зан үйл, Христийн шашны зан үйлийг эрт дээр үеэс хэрэгжүүлж ирсэн бөгөөд орчин үед оршуулгын

[8] Duty of Registering Death
https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?lawCode=HSC&sectionNum=102795.
[9] Local Regulation of Cemeteries
https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?sectionNum=8115.&lawCode=HSC

зан үйл талийгаачийн шүтдэг шашин, ар гэрийхнээс хамаарч өөр өөр байдаг боловч ихэвчлэн Күнзийн уламжлалт зан үйлийн дагуу явагддаг байна. Оршуулах зан үйлд нэлээд өөрчлөлт гарч байгаа бөгөөд уламжлалт оршуулгын соёл тодорхой хэмжээнд хэвээр байгаа хэдий ч жижиг газар нутаг, амьдралын хэв маягтай холбоотойгоор чандарлах хувь хэмжээ өсөн нэмэгдэж байна. Тухайлбал, чандарлах ажиллагаа нийт оршуулгын 80%-аас давсан бөгөөд улсын хэмжээнд Пусан хот 91.6%-аар тэргүүлдэг байна. Түүнчлэн хүмүүсийн сэтгэлгээ, амьдралын хэв маягтай холбоотойгоор оршуулгын зан үйлд өөрчлөлт орж байгааг 2016 онд Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгааны тайлангаас харж болохоор байна. Судалгаанаас үзэхэд, шарил чандарласны дараа байгалийн цэцэрлэгжүүлэлт түүний дотор модны цэцэрлэгт хүрээлэнд оршуулах хэлбэр хамгийн тохиромжтой гэж судалгаанд оролцогчдын 45.5% нь үзсэн байна. Харин 39.8% нь чандарласны дараа бунханд байрлуулах, 12.6% нь оршуулах гэж үзсэн байна. Насны байдлаар авч үзвэл, 20-60 насныхан модны цэцэрлэгт хүрээлэнг дэмжсэн бол, 70-аас дээш насныхан оршуулгын газарт байрлуулахыг илүүд үзжээ.[10]

**Хууль эрх зүйн орчин:**

БНСУ-ын хувьд оршуулах зан үйлтэй холбоотой харилцааг Оршуулгын тухай хууль (장사 등에 관한 법률)[11], Гэр бүлийн эрүүл зан үйлийн журам (건전가정의례준칙)[12], Оршуулгын тухай хуулийн хэрэгжилтийн тухай заавар (시행령)[13] болон холбогдох бусад хуулиар зохицуулдаг.

***Оршуулгын тухай хууль*** нь 7 бүлэг, 43 зүйлтэй. Энэхүү хуулиар оршуулах арга, оршуулгын байгууламжийг суурилуулах, байгуулах, зохион байгуулах, төрийн байгууллага болон оршуулгын үйл ажиллагаа эрхлэгчтэй холбогдох харилцаа, оршуулгын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан зохицуулсан.

Эрүүл гэр бүлийн зан үйлийг бий болгох, дэмжих тухай хуульд заасны дагуу ***Гэр бүлийн эрүүл зан үйлийн журмыг***[14] Ерөнхийлөгчийн зарлигаар баталсан бөгөөд 6 бүлэг, 25 зүйлтэй. Энэхүү журмаар оршуулгын зан үйлтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан.

***Гэр бүлийн харилцааны бүртгэлийн тухай хуулиар*** нас барсан тухай мэдүүлэг гаргаж бүртгүүлэх бөгөөд бүртгүүлэхдээ эмнэлгийн магадлагаа, задлан шинжилгээний баримт болон нас барсан газар, оршуулсан газар, эсвэл чандарласан газрын талаарх мэдээллийг бүртгүүлэхээр зохицуулжээ.

***Оршуулгын зан үйл**:* Шарилыг оршуулах арга хэлбэрүүдэд газарт оршуулах, чандарлах, байгалийн жамаар оршуулах зэрэг орно. Оршуулгын тухай хуульд зааснаар оршуулах гэдэг нь шарил болон үнсийг газарт булж булшлахыг хэлнэ. Харин чандарлах гэж цогцсыг шатаах замаар оршуулахыг хэлнэ. Байгалийн оршуулга гэж чандарласан шарилын үнсийг мод, цэцэг, өвсний доор эсвэл эргэн тойронд нь булахыг хэлнэ гэж тодорхойлжээ. Оршуулга

UILMN СУДАЛГААНЫ САН

[10] БНСУ-ын Үндэсний статистикийн хорооны судалгааны тайлан мэдээ https://blog.daum.net/schwein-s/800
[11] https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EC%9E%A5%EC%82%AC%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0
[12] https://www.law.go.kr/LSW/LsiJoLinkP.do?lsNm=%EA%B1%B4%EC%A0%84%EA%B0%80%EC%A0%95%EC%9D%98%EB%A1%80%EC%A4%80%EC%B9%99&paras=1&docType=JO&languageType=KO&joNo=001700000#
[13] https://www.law.go.kr/LSW/lumLsLinkPop.do?lspttninfSeq=118494&chrClsCd=010202
[14] 건전가정의례준칙https://www.law.go.kr/LSW/LsiJoLinkP.do?lsNm=%EA%B1%B4%EC%A0%84%EA%B0%80%EC%A0%95%EC%9D%98%EB%A1%80%EC%A4%80%EC%B9%99&paras=1&docType=JO&languageType=KO&joNo=001700000#

болон чандарлах үйл ажиллагааг зөвхөн зөвшөөрөгдсөн, зориулалтын газар хийнэ. Тухайлбал, Оршуулгын тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд зааснаар нийтийн болон хувийн оршуулгын газарт оршуулна. Байгалийн жамаар оршуулж байгаа тохиолдолд чандарласан шарилыг оршуулах бөгөөд үнсийг саванд хийж булах тохиолдолд сав нь биологийн хувьд задралд ордог давирхайн бүтээгдэхүүн, эсхүл биохимийн аргаар задрах цардуул зэрэг байгалийн гаралтай материал байх ёстой.

Оршуулгын газар дахь нэг булшны талбай, булшны чулууны хэмжээ нь 10 м.кв-аас хэтрэхгүй байх ёстой бөгөөд хувийн оршуулгын газар нь 30 м.кв, бунхануудын дунд өвөг дээдсийн булшны өндөр 70 см-ээс өндөргүй, булш бүрд ногдох талбай 2 м.кв-аас ихгүй байна. Савнаас бусад чандарласан шарил, шороо, дурсгалын нунтаг ясыг хамтад нь булахыг хориглоно. Нас барсан, амьгүй төрсөн цагаас хойш 24 цаг өнгөрөөгүй бол оршуулах, чандарлахыг хориглох бөгөөд хууль тогтоомжид тусгайлсан зохицуулалт байгаа бол тэрхүү тусгай зохицуулалтыг дагаж мөрддөг. Тухайлбал, жирэмсний долоо дахь сараас өмнө эндсэн ураг, халдварт өвчнөөр нас барсан, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуульд заасны дагуу эрхтнийг нь авсан зэрэг болно. Зайлшгүй нөхцөл байдлаас бусад тохиолдолд оршуулах өдөр нь нас барсан өдрөөс хойш 3 дахь өдөр болох бөгөөд шашны зан үйлийн онцлогоос хамаарч 3-5 хоног үргэлжилдэг.

2015 онд оршуулгын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нийтийн болон хувийн оршуулгын газарт булш суурилуулах хугацаа 30 жил болгож өөрчилсөн. Булш суурилуулах хугацаа дууссан тохиолдолд Си/Гүн/Гү хотын даргад хугацаа сунгах хүсэлт гаргаж болох бөгөөд булш суурилуулах хугацааг зөвхөн нэг удаа 5-30 жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Булш суурилуулах хугацаа дууссан тохиолдолд хүсэлт гаргасан этгээд хугацаа дууссан өдрөөс хойш 1 жилийн дотор булшинд суурилуулсан байгууламжийг буулгаж, булсан чандарыг хаах үүрэгтэй. Хэрэв холбогдох этгээд байхгүй, байгууламжийг буулгаагүй тохиолдолд тухайн булшинд суурилуулсан байгууламжийг нурааж, булсан чандрыг оршуулгын бунханд байрлуулах боломжтой.

***Гэр бүлийн эрүүл зан үйлийн дүрэмд*** зааснаар нас барсны дараа оршуулах, эсвэл чандарласны дараа хийх зан үйл нь оршуулах ёслол болон дурсгалын ёслолын зан үйлээс бүрдэнэ. Ноже, Банвужэ, Самвужэ зэрэг зарим ёслолуудыг хийхгүй байж болох бөгөөд оршуулах ёслолын танхимд лааны суурь, хүж, утлагын дэнлүү, үүнээс гадна ижил төстэй байдлаар бэлтгэсэн эд зүйлийг заавал байршуулсан байна. Дурсгалын ёслолыг хийхдээ бунхныг байрлуулсны дараа талийгаачийн хөрөг, хүж, өргөл өргөх, залбирал унших болон мөргөн ёслох дарааллаар хийдэг. Чандарлах тохиолдолд чандарлах ажиллагаа дууссаны дараа дээрх дурсгалын ёслолыг гүйцэтгэдэг. Гашуудлын хувцас нь ханбугийн хувьд цагаан, костюмны хувьд хар өнгөтэй байдаг. Сонин хэвлэлд эмгэнэл нийтлэхдээ захиргааны байгууллага, төрийн байгууллагын нэрийг ашиглахыг хориглоно.

Гэр бүлийн харилцааны бүртгэлийн тухай хуульд[15] заасны дагуу нас барсан тухай мэдүүлгийг гэр бүлийн гишүүн, эсхүл хамт амьдардаг хамаатан садан нь нас барсныг нь мэдсэн өдрөөс хойш нэг сарын дотор эмнэлгийн магадлагаа болон задлан шинжилгээний баримтын хамт мэдээлнэ. Нас барсан газрын мэдээлэл нь нас барсан газар, оршуулсан газар, эсвэл чандарласан газрын талаар мэдээлнэ. Хэрэв нас барсан газар нь тодорхойгүй бол цогцос анх олдсон газар, галт тэрэг болон тээврийн хэрэгсэлд хүн нас барсан тохиолдолд тээврийн хэрэгслээс цогцсыг буулгасан газрыг мэдээлж болно. Хууль тогтоомжид заасан шаардлага хангасан хүмүүс оршуулгын зардал болон эмгэнэлийн мөнгийг авна гэж зохицуулсан.

[15] 가족관계의 등록 등에 관한 법률

UIH.MN СУДАЛГААНЫ САН

***Төрийн байгууллагын үүрэг, оролцоо***: БНСУ-д оршуулгын газар нь нийтийн болон хувийн оршуулгын газраас бүрдэх бөгөөд хотын дарга, эсвэл захирагч, Си/Гүн/Гү хотын дарга нь нийтийн оршуулга, олон нийтийн чандарлах байгууламж, нийтийн бунхны газар, нийтийн оршуулгын газрын өргөтгөлийн байгууламжийг барих, байгуулах, удирдан зохион байгуулах ажлыг хариуцна. Харин Солонгосын ойн албаны дарга, эсвэл бусад захиргааны төв байгууллагын дарга нь үндэсний ой зэрэг улсын газар нутагт мод үржүүлгийн газар, байгалийн бусад оршуулгын газрыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосны[16] дагуу байгуулж, удирдаж болно.

Хотын дарга нь цогцос, оршуулгын үйлчилгээний чиглэлээр мэргэшсэн мэдлэг, ур чадвар эзэмшсэн хүнд оршуулгын газрын даргын үнэмлэх олгох бөгөөд оршуулгын газрын дарга энэхүү үнэмлэхийг авсан байна. Солонгосын оршуулгын холбооноос хууль тогтоомжид заасны дагуу оршуулгын газрын дарга бэлтгэх сургалтыг зохион байгуулдаг.

Хотын дарга нар төрөл төрөгсөдгүй, нэр хаяг тодорхойгүй шарилыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тодорхой хугацаанд харьяаллын дагуу чандарлаж оршуулах бөгөөд оршуулгын ёслолд зарцуулсан зардлыг төр, орон нутгийн засаг захиргаанаас татаасаар олгодог.

Хувийн оршуулгын газрыг байгуулах гэж буй этгээд нь тус оршуулгын газрыг харьялах хотын захирагчаас зөвшөөрөл авна. Хувийн оршуулгын газар байгуулсан этгээд оршуулгын газар байгуулснаас хойш 30 хоногийн дотор харьялах хотын дарга болон бусад газарт мэдэгдэх бөгөөд хувийн оршуулгын газар байгуулах стандартыг хангасан байна. Хувийн чандарлах байгууламжийг хотын дарга эсвэл захирагч, Си/Гүн/Гү хотын даргаас бусад этгээд байгуулах бөгөөд чандарлах байгууламж байгуулах, байгууламжийн талбай, байгуулах байршил, чандарлах төхөөрөмж суурилуулах стандартыг хангасан байна. Төрөөс бусад этгээд болон хотын дарга Си/Гүн/Гү-ийн дарга нар байгалийн ойн сан бүхий газар буюу мод үржүүлгийн газар болон байгалийн бусад оршуулгын газар байгуулж болно. Хувийн эзэмшлийн байгалийн дурсгалт газар байгуулсан этгээд Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас баталсан журмын дагуу тус газрыг байгуулж дууссанаас хойш 30 хоногийн дотор эрх бүхий хотын даргад мэдээлэх бөгөөд тус газарт оруулсан бүхий л өөрчлөлтийг мөн адил мэдээлэх үүрэгтэй. Хотын дарга нь ирүүлсэн хүсэлт, тайланг хүлээн авч хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянан үзэж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ. Байгалийн оршуулгын газарт шарил, нас барсан хүний овог нэр бүхий тэмдэг, тав тухтай тохижилт хийхээс бусад байгууламж, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно.

***Оршуулгын тухай хуулийн*** 17 дугаар зүйлд зааснаар дараах газруудад оршуулгын газар, чандарлах байгууламж, байгалийн оршуулгын газар байгуулахыг хориглоно.

- Үндэсний газар төлөвлөлт, ашиглалтын тухай хуульд заасан ногоон байгууламжийн дунд;
- Усны байгууламжийн тухай хуульд заасан усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс;
- Соёлын өвийг хамгаалах тухай хуульд заасан тусгай хамгаалалттай газар нутаг.

Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад газар гэдэгт дараах бүс, нутаг дэвсгэр хамаарна. Үүнд:[17]

- Орон сууц, худалдаа үйлдвэрлэлийн бүс;
- Нийтийн зориулалттай орон сууцны хороолол;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[16]건전가정의례준칙https://www.law.go.kr/LSW/LsiJoLinkP.do?lsNm=%EA%B1%B4%EC%A0%84%EA%B0%80%EC%A0%95%EC%9D%98%EB%A1%80%EC%A4%80%EC%B9%99&paras=1&docType=JO&languageType=KO&joNo=001700000#

[17] 장사 등에 관한 법률 시행령https://www.law.go.kr/LSW/lumLsLinkPop.do?lspttninfSeq=118494&chrClsCd=010202

- Далайн эрэг орчмын бүс;
- Автозамын тухай хуулийн дагуу тогтоосон нэвтрэх талбай;
- Голын тухай хуулийн дагуу тогтоосон голын бүс;
- Хөдөө аж ахуйн газрын тухай хуульд заасны дагуу газар тариалангийн бүс;
- Ой хамгаалах тухай хуульд заасан ойн хамгаалалтын бүс;
- Ойн нөөц бүрдүүлэх, удирдах тухай хуульд заасан суулгац, туршилтын ой, ойн тусгай хамгаалалтын бүс;
- Үндэсний ойн менежментийн тухай хуульд заасан үндэсний ойн хамгаалалтын бүс;
- Тусгай хамгаалалттай газар нутаг;
- Цэргийн бааз, цэргийн байгууламжийн хамгаалалтын бүс;
- Нуралт, үерийн улмаас эрүүл мэнд, эрүүл ахуйн аюулд өртөх магадлалтай орон нутгийн засаг захиргааны байгууллагаас тогтоосон газар.

***Оршуулгын газрын үйл ажиллагаа эрхлэгч*** нь оршуулгын газрын түрээсийн төлбөр, оршуулгын хураамж, оршуулгын хэрэгслийн үнэ тус бүрийг харуулсан үнийн жагсаалтыг хэрэглэгчдийн үзэх боломжтой газар байрлуулж, оршуулгын мэдээллийн системд бүртгүүлэх бөгөөд оршуулгын байрны түрээсийн төлбөр, хураамжаас бусад мөнгө, үнэт зүйлийг хүлээн авах, оршуулгын хэрэгсэл худалдаж авах, ашиглахыг албадахыг хориглоно.

Оршуулгын газрын үйл ажиллагаа эрхлэгч нь оршуулгын газрын түрээсийн хураамж, оршуулгатай холбоотой хураамж, оршуулгын хэрэгслийн төлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хэрэглэгчдэд олгох үүрэгтэй бөгөөд оршуулгын газрыг ашиглах гэрээ байгуулахаас өмнө хэрэглэгчдэд дараах зүйлсийг нарийвчлан тайлбарлаж өгөх ёстой. Үүнд:

- Оршуулгын үйл ажиллагаа эрхлэгчийн нэр;
- Оршуулах ёслолын дэлгэрэнгүй мэдээлэл;
- Оршуулгын газрын ашиглалтын хугацаа, байгууламж;
- Хураамж, төлбөрийн арга, хугацаа;
- Оршуулах ёслол үйлдэх газрын ашиглалтын нөхцөл;
- Хэрэглэгчид болон оршуулгын газрын үйл ажиллагаа эрхлэгчдийн хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхтэй холбоотой бусад асуудал.

***Дурсгалын мод:*** Оршуулгын тухай хуульд заасны дагуу ойн асуудал эрхэлсэн сайдын байгуулсан төрийн өмчийн модны цэцэрлэгт хүрээлэнд нас барагсдын дурсгалыг хүндэтгэж дурсгалын мод тарьж болно. Энэхүү харилцааг Төрийн өмчийн модны цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалт, менежментийн журмаар[18] зохицуулдаг.

Дурсгалын мод гэж мод тарих талбай дахь модны дунд чандарласан шарилын үнсийг булж, мод тарих зориулалтаар урьдчилан тэмдэглэсэн модыг хэлэх бөгөөд дараах төрөлтэй байна. Үүнд:

- Ургийн мод-гэр бүлийн харилцаатай өөрийгөө, эхнэр/нөхөр, удам угсаа, ах/эгч, ах/эгчийн эхнэр, нөхрийн шарил хамаарна.
- Нийтлэг мод-ургийн модноос бусад бүх дурсгалын модыг хэлнэ.

Дурсгалын модыг зөвхөн чандарласны дараа ашиглах боломжтой бөгөөд дурсгалын модыг ашиглах хугацаа 15 жил байна. Түүнчлэн 15 жилээр 3 удаа сунгаж болох бөгөөд ашиглалтын хугацаа 60 жил хүртэл байж болно. Ашиглалтын хугацааг сунгахдаа дурсгалын модны ургалтын байдлыг харгалзан үзэж ашиглалтын хугацаа дуусахаас 3 сарын өмнө ашиглалтын хугацааг сунгах эсэхийг ар гэрийхэнд нь мэдэгдэнэ. Дурсгалын мод

[18] 국유 수목장림의 운영·관리에 관한 규정

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ашиглалтын төлбөр нь гэр бүлийн модны хувьд 1 жилийн 147,000-155,000, бусад дурсгалын модны хувьд 47,400-49,000 вон байдаг. Ашиглалтын төлбөр гэж мод үржүүлгийн дэд бүтцийн засвар үйлчилгээ, менежмент, дурсгалын модыг хамгаалах, удирдах, модлог цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтад шаардагдах зардлыг хэлнэ. Дурсгалын мод ашиглалтын төлбөрийг урьдчилан төлөх ёстой бөгөөд ашиглалтын төлбөрийг хоёр сарын дотор төлөөгүй тохиолдолд нэг сар хүлээн, энэ хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд дурсгалын мод ашиглах гэрээг цуцална. Дурсгалын 1 мод тутамд тавих ясны нунтаг буюу чандарласан үнсний тоо 10-аас бага байх ёстой бөгөөд ясны нунтагийг саванд хийхгүйгээр булах бол 30 см-ээс багагүй гүнд булна. Чандрын нунтагийг саванд хийх бол 30 см ба түүнээс бага хэмжээтэй саванд хийж газрын хөрснөөс 30 см ба түүнээс илүү гүнд булна. Дурсгалын модыг урьдчилан захиалах, худалдахыг хориглох бөгөөд дараах тохиолдолд ашиглалтын төлбөрийн 2 хувийг төлөөд захиалах боломжтой. Тухайлбал, 70-аас дээш насны ахмад настан, эрхтэн шилжүүлэн суулгах тухай хуулийн дагуу тархи нь үхсэн донор, эмчийн магадлагаагаар өвчний улмаас 6 сарын дотор нас барах төлөвтэй байгаа хүн. Дурсгалын модыг ямар ч тохиолдолд худалдах, шилжүүлэх болон хувь хүмүүсийн хооронд шилжүүлэхийг хориглоно.

***Хяналт, шалгалт:*** Хотын дарга нь оршуулах байгууламжийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэврийн байгууламжийн ашиглалтын байдалтай танилцах, Оршуулгын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг шалгах шаардлагатай гэж үзвэл холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд мэдэгдэнэ. Бүх хэлбэрийн оршуулгын байгууламж, чандарлах байгууламж, бичиг баримт болон бусад байгууламжийг шалгах, эсхүл оршуулгын үйл ажиллагаа эрхлэгчээс шаардлагатай тайлан гаргаж өгөхийг шаардах эрхтэй. Оршуулгын үйл ажиллагаа эрхлэгч нь газарт оршуулах, чандарлах, булшлах, байгалийн оршуулга, оршуулгын газрын менежмент, ашиглалтад хяналт тавьж Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны журмын дагуу эрх бүхий хотын даргад мэдээлнэ. Оршуулах болон чандарлах байгууламж зэрэгт нэвтрэх төрийн албан хаагч ажлын үнэмлэхээ шалгуулж нэвтрэх ёстой.

***Хариуцлага:*** Оршуулгын тухай хуульд дараах хариуцлагын арга хэмжээнүүдийг ногдуулахаар зохицуулсан байна.

Дараах зөрчил гаргасан этгээдийг хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих, 20 сая воноос хэтрэхгүй торгох ял шийтгэнэ.

- Зөвшөөрөл авалгүй гэр бүлийн оршуулгын газар байгуулсан, зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн этгээд;
- Хориотой газарт оршуулгын газар, чандарлах байгууламж, бунхны газар, байгалийн оршуулгын газар суурилуулсан, байгуулсан этгээд;
- Оршуулгын байгууламжийг засварлах, тохижуулах зэрэг шийдвэр, ашиглалтыг хязгаарлах тушаал биелүүлээгүй этгээд

Дараах зөрчил гаргасан этгээдийг нэг жилээс илүүгүй хугацаагаар хорих, 10 сая воноос хэтрэхгүй торгох ял шийтгэнэ.

- Нас барсан, амьгүй төрснөөс хойш 24 цагийн дотор оршуулсан, чандарласан;
- Оршуулгын газраас өөр газарт оршуулсан, чандарлах газраас өөр байгууламж, газарт чандарласан;
- Оршуулах, чандарлах, өргөтгөх, өөрчлөх арга, стандартыг зөрчсөн;
- Зөвшөөрөл авалгүйгээр оршуулах байгууламжийн өргөтгөл, өөрчлөлт хийсэн;
- Оршуулгын газарт байрлуулах булшны талбай буюу суурилуулах стандартыг зөрчсөн;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Булш суурилуулах хугацаа дууссан ч оршуулгыг буулгаагүй эсвэл чандарлаж, оршуулаагүй;
- Хууль зөрчиж оршуулгын газрыг худалдах, бусдад шилжүүлэх, түрээслэх, ашиглах гэрээ байгуулсан;
- Оршуулгын газрыг татан буулгаж байгаагаа харьялах хотын даргад мэдэгдэлгүйгээр татан буулгасан;
- Бусдын газар зөвшөөрөлгүйгээр байрлуулсан булшийг зөвшөөрөлгүйгээр нээсэн;
- Оршуулгын газрын үйл ажиллагааг хаах шийдвэрийг биелүүлээгүй этгээд.

Дараах тохиолдолд 3 сая воноос хэтрэхгүй хэмжээний торгуулийг хотын дарга, Си/Гүн/Гү-ийн дарга ногдуулж, хурааж авна.

- Оршуулах, чандарлах, дахин нээх тухай тайлан өгөөгүй;
- Хувийн оршуулгын газар байгуулсан тухай мэдээлээгүй, тайлангаа өөрчилсөн;
- Оршуулгын газрын үйл ажиллагаа эрхлэгч нь булш, булшны байдлын талаарх бүртгэл хөтлөөгүй;
- Чандарлах байгууламж суурилуулсан тухай мэдээлээгүй болон өөрчилсөн талаарх тайлан ирүүлээгүй;
- Хувийн эзэмшлийн байгалийн дурсгалт газар байгуулсан талаар мэдээлээгүй;
- Оршуулгын зардлаас гадна мөнгө, үнэт зүйл хүлээн авсан;
- Оршуулах байгууламж, хэрэгсэл худалдаж авах, ашиглахыг албадсан;
- Оршуулгын байгууламжийг татан буулгахтай холбоотой арга хэмжээг аваагүй;
- Оршуулгын газрын үйл ажиллагааны өөрчлөлтийг мэдүүлээгүй, эрүүл ахуйн зохицуулалт зөрчсөн;
- Оршуулгын газрын үйл ажиллагаа эрхлэгч нь оршуулах үйл ажиллагаатай холбоотой төлбөр, хураамжийн талаар мэдээлээгүй, хуурамч мэдээлэл өгсөн, бүртгүүлээгүй болон түрээс, төлбөр хураамжийг тооцоогүй;
- Оршуулгын газрын үйл ажиллагааг хаасан талаар мэдээлээгүй;
- Оршуулгын газрыг ашиглах гэрээний талаар мэдээлэл өгөөгүй;
- Оршуулгын үйл ажиллагаатай холбоотой гарсан зардлын дэлгэрэнгүй мэдээллийг гаргаагүй;
- Төрийн албан хаагчийн хяналт, шалгалтаас татгалзсан, хөндлөнгөөс оролцсон, заналхийлсэн этгээд, эсхүл шаардлагатай дүгнэлт бус, худал дүгнэлт гаргасан.

### БҮГД НАЙРАМДАХ КАЗАКСТАН УЛС (БНКазУ)

БНКазУ-ын хүн амын 70 орчим хувь нь исламын шашинтай учир оршуулгын уламжлал нь ислам, христийн ёс заншлын гэсэн холимог байдаг. Оршуулгын зан үйл нь уламжлалт буюу газарт оршуулах хэлбэрээр гүйцэтгэдэг бөгөөд хуулиар чандарлах үйл ажиллагааг хориглоогүй ч шариатын үзлээс шалтгаалан шарил чандарлах үйл ажиллагаа явуулдаггүй байна. БНКазУ-д нас барсан гадаадын иргэд болон зайлшгүй чандарлах шаардлагатай шарилыг ОХУ-ын нутаг дэвсгэрийн чандарлах байгууллага руу шилжүүлдэг. Тус улсад оршуулгын зан үйлийг тусгайлан зохицуулсан хууль байхгүй бөгөөд Үндэсний эдийн засгийн сайдын тушаалаар баталсан “*Булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах үлгэрчилсэн дүрэм*”-ийн дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллагууд өөрсдийн дүрэм, журмыг баталдаг байна. Тус улсын иргэнд 6 м.кв-аас хэтрэхгүй хэмжээний булшны газрыг үнэ төлбөргүй олгодог байна.

#### Хууль эрх зүйн орчин

БНКазУ-ын Үндэсний эдийн засгийн сайдын 2019 оны 48 дугаар тушаалаар Булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах үлгэрчилсэн дүрэм (Типовые правила погребения и

UIH.MN СУДАЛГААНЫ САН

организации дела по уходу за могилами)[19]-ийг баталсан. Булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах үлгэрчилсэн дүрмийг Орон нутгийн засаг захиргаа ба өөрөө удирдах ёсны тухай хууль (О местном государственном управлении и самоуправлении в Республике Казахстан)[20]-д заасны дагуу баталсан.

***Булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах үлгэрчилсэн дүрмийг*** Эрүүл мэндийн сайдын тушаалаар ариун цэврийн болон эпидемиологийн шаардлагыг хангасан стандартаар оршуулгын газрыг ажиллуулах, арчлан сэргээх, нас барагсдыг оршуулах, дахин оршуулах ажлыг зохион байгуулна. Орон нутгийн засаг захиргаа нь уг үлгэрчилсэн дүрмийн дагуу орон нутгийн булш оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах дүрмийг боловсруулна. Уг дүрмийг боловсруулахдаа суурин газрын нутаг дэвсгэрийн онцлог, хөгжил, түүх соёлын өвийн хадгалалт, шашны зан үйл, байгалийн тогтоц зэргийг харгалзан үзнэ.

***Орон нутгийн оршуулах, арчлах ажлыг зохион байгуулах дүрэмд:***

- Оршуулах газар олгох журам;
- Нас барагсдын шарилыг булшлан оршуулах журам;
- Булшны зураг төсөл боловсруулах, зохион байгуулах журам;
- Оршуулгын газрыг тохижуулах, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах журам;
- Булш оршуулах газрыг тогтоох, бүртгэх үйл ажиллагааны журам;
- Оршуулгын газрын засвар үйлчилгээ, үйлчилгээ хийх байгууллагын гэрээ, дагаж мөрдөхөд хяналт тавих журам;
- Оршуулгын хэрэгцээний газраас тухайн орон нутагт оршин суугаа оршин суугч болон түр оршин сууж байгаа иргэн нас барахад тухайн газраас 6 м.кв-аас доошгүй газрыг үнэ төлбөргүй олгох;
- Оршуулгын газрын захиргааны үйл ажиллагааны журам зэргийг уг дүрэмд тусгасан байна.

Тус дүрмийн хэрэгжилтэд хот, нийслэлийн засаг захиргаа хяналт тавин ажиллах, цахим орчинд оршуулгын газрын нөөц болох ашиглагдсан талбай болон ашиглагдаагүй талбайн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод байршуулах ажлыг зохион байгуулна.

*Орон нутгийн гүйцэтгэх байгууллагын чиг үүрэг:*

- Орон гэргүй хүмүүсийн оршуулгыг төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх;
- Олдсон, живсэн, гэнэт нас барсан цогцсыг шүүх эмнэлгийн дүгнэлт хийлгэн ар гэрийг тодруулах, эрэн хайх үйл ажиллагаа зохион байгуулах;
- Танигдаагүй цогцсыг оршуулах үйл ажиллагааг зохион байгуулах.

*Оршуулгын захиргааны газрын чиг үүрэг:*

- Оршуулгын газрын байгууламжийн талаарх мэдээллийг ил тод байршуулах;
- Булш байршуулах газрыг дүрэм журмын дагуу цаг тухайд нь бэлтгэх;
- Оршуулах газрыг хуваарилах, булш бэлтгэх тогтсон стандартыг мөрдөх;
- Оршуулгын газрын барилга байгууламж, инженерийн тоног төхөөрөмж, хашаа гэрэлтүүлгийн стандартыг баримтлах;
- Оршуулгын газрын арчилгаа, цэвэрлэгээний ажлыг тогтмол зохион байгуулах;
- Ногоон байгууламжийг цаг тухайд нь арчлах, нөхөн сэргээх;

[19] Типовые правила погребения и организации дела по уходу за могилами https://tengrinews.kz/zakon/pravitelstvo-respubliki-kazahstan-premer-ministr-rk/konstitutsionnyiy-stroy-i-osnovyi-gosudarstvennogo-upravleniya/id-V1900018771/
[20] О местном государственном управлении и самоуправлении в Республике Казахстан https://kodeksy-kz.com/ka/o_mestnom_upravlenii_i_samoupravlenii.htm

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Зам засварыг тогтмол хийх;
- Ойр дотны хүмүүс нь талийгаачийн булшийг эргэх, сэргээхэд түрээсийн тоног төхөөрөмжөөр хангах;
- Талийгаачийг оршуулах үйл ажиллагааны зан үйлд тэгш хүртээмжтэй хандах.

**ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (ХБНГУ)**

ХБНГУ-ын нийт хүн амын 23.76 сая католик, 22.27 сая протестант, 4.4 сая исламын шашин, 100.000 еврей, 100.000 буддын шашинд итгэгчид байдаг. ХБНГУ-ын оршуулгын зан үйлд шарилыг чандарлах, чандрыг далайд цацах, далайд хөвүүлэх, шарилыг газарт оршоох, чандрыг байгальд оршоох гэсэн төрлүүд байдаг. Тодруулбал, чандрыг далайд цацах гэдэг нь чандарыг далайд хөвүүлэх, эсхүл далайд цацах юм. Чандрыг далайд хөвүүлэхдээ зориулалтын буюу байгаль орчинд ээлтэй, усанд уусдаг бумбанд хийж, задгай далайд тавьдаг. Чандрыг газарт оршоох зан үйл нь оршуулгын хамгийн эртний төрлүүдийн нэг юм. Өнгөрсөн зууны 70-аад оны эхэн үед нас барагсдыг газарт оршуулахыг хуулиар журамлаж эхэлсэн бөгөөд энэ үеэс чандарлах төрөл илүү дэлгэрчээ. Шарилыг оршуулгын газарт оршоох гэж гэр бүлийн гишүүдийн сонгосон хайрцагт, сонгосон газарт, эсхүл тухайн оршуулгын газраас зааж өгсөн газарт оршоохыг[21] хэлдэг бол байгальд оршоох гэдэг нь модны доор нутаглуулах, эсхүл тэнгис далайд оршоох нь байгаль дэлхийд хайраа шингээн уусаж байгаа гэсэн утга агуулгатай байдаг байна.

2021 оны статистик мэдээллээр 1.023.723 хүн нас барсан бөгөөд өмнөх онтой харьцуулвал нас баралтын тоо 3.9 хувиар нэмэгдсэн байна.[22] 2020 оны нийт нас баралтын 76 хувийг чандарлах аргаар оршуулсан байна. Үүнээс үзэхэд шарилыг газарт булшлан оршуулах нь жил ирэх тусам буурч байгаа бөгөөд шашны зан үйлийг дагаж оршуулгын зан үйл үйлдэх нь цөөрсөөр байгаа гэсэн судалгааны дүн гарсан байна.[23]

**Хууль, эрх зүйн орчин**

ХБНГУ нь холбооны бүтэцтэй ба 16 муж улстай бөгөөд нийтээр дагаж мөрдөх оршуулгын тухай хууль, журам байдаггүй боловч муж улс бүр өөрийн гэсэн оршуулгын тухай хуультай байдаг. Тус улсад оршуулах зан үйлийг дүрэм, журмаар зохицуулах нь эрт үеэс эхлэлтэй бөгөөд христийн шашны шарилыг газарт булшлан оршоох уламжлалт заншлаас эхлэлтэй. 20 дугаар зууны эхэн үеэс Германы муж улсууд оршуулгын зан үйлийг тусгайлсан хуулиар зохицуулж эхэлсэн. Тус хуулиар нас барагчийг оршуулах үйл ажиллагаа, оршуулгын ажлыг хариуцах хүн, оршуулгын газар, шарилд задлан шинжилгээ хийх, дутуу төрөлт (500 граммаас доош жинтэй), амьгүй төрөлтийн тодорхойлолт, түүнийг хэрхэн оршуулах, шарил хадгалах газарт шарил хадгалах хугацаа, шарил тээвэрлэх хугацаа, шарилыг оршуулах хугацаа (*Жишээлбэл шарилыг 36 цаг шарил хадгалах газарт хадгалах, шарилыг хамгийн багадаа 48 цагийн дотор, хамгийн ихдээ 8 хоногийн дотор*) оршуулах зэргийг хуульчилсан байна.

Оршуулгын зардлыг хариуцах үүрэг дан ганц муж улсуудын оршуулгын тухай хуулиар зохицуулагдахгүй харин иргэний болон бусад холбогдох хуулиар зохицуулна. Оршуулгын зардлыг ар гэрийнхэн төлөх ёстой гэж оршуулгын тухай хуульд заасан байдаг боловч зарим тохиолдолд ар гэрийнхэн оршуулгын зардлыг төлөх үүргээс чөлөөлөгддөг. Жишээлбэл, талийгаачийн ар гэр оршуулгын зардлыг төлөх санхүүгийн чадамжгүй бол оршуулгын зардлыг тухайн орон нутгийн нийгмийн халамжийн газар хариуцдаг. Энэ тохиолдолд талийгаачийн ар гэр санхүүгийн чадамжгүй гэдгээ батлах шаардлагатай. Оршуулгын

[21] Feuerstattung https://sozialbestattung.de/feuerbestattung/
[22]Sterbefälle in Deutschland https://de.statista.com/statistik/daten/studie/156902/umfrage/sterbefaelle-in-deutschland/#professional
[23] https://de.statista.com/themen/9131/tod-beerdigung-und-sterbehilfe/#dossierKeyfigures

UIH.MN СУДАЛГААНЫ САН

зардлыг нийгмийн халамжийн газар хариуцсан тохиолдолд оршуулах ёслолын төрлүүдээс чөлөөтэй сонгох эрхтэй ч чандарлах арга нь хамгийн тохиромжтой байдаг.[24] ХБНГУ-ын Бавари мужийн оршуулгын тухай хуулийг жишээ болгон сонгон авч судлав.

***Бавари мужийн оршуулгын тухай хууль*** *(Bayerische Bestattungsgesetz)* [25] нь 1970 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд 2016 оны 08 дугаар сарын 02-ны өдөр тус хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулсан байдаг.

Тус хууль нь нийт 4 бүлэг, 21 зүйлтэй.

*Оршуулга*-Талийгаачийг газарт нутаглуулах, далайд цацах, чандарлахыг хуулиар зөвшөөрсөн. Шарилыг оршуулахдаа талийгаач нас барахаасаа өмнө чандарлах хүсэлтээ байгаа эсэхээ тодорхойлох, эсхүл талийгаачийн ар гэрийнхний санал, хүсэлтийг хүндэтгэн үзнэ.

*Цогцост эмчийн үзлэг хийх*- Талийгаачийг оршуулахаас өмнө заавал эмчийн үзлэг хийж нас баралтын нөхцөл байдлыг (жам ёсны, эсхүл гадны нөлөөтэйгээр нас барсан эсэх) тодорхойлох бөгөөд үхлийн шалтгааныг эмч шалгаж, дүгнэлт гаргана.

*Цогцос таних, таниулах*- Талийгаачийн нас барахаас өмнөх эрүүл мэндийн байдлыг асран хамгаалагч, эмчилгээ хийж байсан эмч, нас барсан мэдээллийг задлан шинжилгээ хийх эмчид заавал өгөх ёстой. Хэрвээ мэдээлэл өгөх хүн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 383 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасны дагуу өөрөө, эсхүл бусад ар гэрийнхэн нь хариуцлага хүлээх эрсдэлтэй бол баримт бүрдүүлэх, мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй.

*Нас барсны гэрчилгээ авах*- Нас барсны гэрчилгээг олгохдоо нас барсны дараах шинжилгээний хариуг нууц болон нууц бус хэсгээс бүрдсэн бичиг баримтын хамтаар хүлээлгэн өгнө. Хэрэв талийгаач харьяаллын бус газарт нас барсан тохиолдолд талийгаачийн харьяа газар нутгийн эрүүл мэндийн байгууллага болон холбогдох бусад байгууллагад нас барсны гэрчилгээг хүлээлгэн өгнө. Нас барсны гэрчилгээний нууцын хэсэгт байгаа талийгаачийн хувийн мэдээлэлтэй талийгаач нас барахаас өмнө зөвшөөрөл олгосон тохиолдолд, эсхүл шүүх, прокурор, цагдаагийн байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэн, шалгах зөвшөөрөл өгсөн тохиолдолд танилцах боломжтой.

*Оршуулгын зардал*- Нас барсны дараах шинжилгээний зардлыг хуульд өөрөөр заагаагүй бол оршуулгын зардал зохицуулах хуулийг дагаж мөрдөнө.

*Нийтлэг шаардлага*- Олон нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын тулд шарил болон чандрыг зохих газарт нь байрлуулна. Энэ нь оршуулга, нас барсны дараах шинжилгээ авах, шарилыг асран хамгаалах зэрэгт хамаарна.

*Амьгүй, эсхүл дутуу төрөлт, бие, эсхүл цогцсын хэсэг*- Амьгүй төрөлт, төрөхийн эндэгдэл эсхүл 500 граммаас доошгүй жинтэй ургийг оршуулахдаа чандарлаж болно. Хэрэв ургийг судалгаа, шинжилгээ хийх зорилгоор ашиглах хүсэлтэй байгаа тохиолдолд эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг зайлшгүй авсан байна.

*Оршуулгын үйлчилгээ үзүүлэх*- Хотын захиргаа олон нийтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн оршуулгын газар, шарил хадгалах газрыг байгуулж, ялангуяа дутуу, амьгүй төрсөн ургийг оршуулахад тохиромжтой оршуулгын газар байгуулж, засвар, үйлчилгээ хийх үүрэгтэй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[24] Seebestattung https://sozialbestattung.de/seebestattung/
[25] Bayerische Bestattungsgesetz https://www.gesetze-bayern.de/Content/Document/BayBestG

*Оршуулгын газар-* Оршуулгын газар нь талийгаачийн дурсгалыг хүндэтгэх, хүндэтгэл үзүүлэх газар юм. Оршуулгын газрыг хуулийн этгээд хариуцах бөгөөд тухайн хариуцагч оршуулгын газрын үйл ажиллагааг бүрэн хариуцаж ажиллана. Муж, эсхүл дүүргийн оршуулгын газарт тухайн дүүргийн иргэдийг оршуулна. Сүм, шашны нийгэмлэгийн оршуулгын газарт тэдгээрийн шашны зан үйлийг хүндэтгэн үзэж өөр шашинд итгэгч, тухайн шашны зан үйлээрээ оршуулагдах боломжгүй шарилыг оршуулахыг зөвшөөрнө.

*Оршуулгын газарт тавигдах шаардлага-*Оршуулгын газар нь усны менежмент, олон нийтийн аюулгүй байдал, ялангуяа эрүүл мэндийн шаардлагад нийцсэн байх ёстой. Оршуулгын газрууд нь хотын өнгө төрхтэй нийцсэн байх ёстой; хот байгуулалтын шаардлага, орон зайн төлөвлөлтийн зорилгыг дагаж мөрдөх, орон зайн төлөвлөлтийн зарчим болон бусад шаардлагыг харгалзан үзнэ. Зөвхөн эрх бүхий байгууллага оршуулгын газар байгуулах, оршуулгын газрыг өөрчлөх зөвшөөрөл олгоно. Муж, хотын хөгжлийн төлөвлөгөөнд оршуулгын газар барих, байгуулах, өөрчлөх тухай ажил багтсан тохиолдолд зөвшөөрөл авахгүй.

*Оршуулгын чулуу олборлоход хүүхэд ажиллуулахыг хориглох-* Олон улсын хөдөлмөрийн тухай 182 дугаар конвенцын 3 дугаар зүйлд заасны дагуу байгалийн чулуугаар хийсэн булшны чулууг үйлдвэрлэхдээ хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг ашиглаагүйг нотлох бичигтэй байна. Булшны чулууг олборлохоос эхлээд үйлдвэрлэлийн эцсийн шат хүртэл бүх шатанд хүүхэд хөдөлмөр эрхлээгүй байхыг хэлнэ.

*Булш хаах-* Оршуулгын газрын удирдлага, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн газар шарил, чандарын задрах хугацааг тогтоосны дараа, тухайн шарилыг хэдэн жил хадгалахыг тодорхойлж булш хаах ажлыг эхлүүлнэ.

*Оршуулгын газрын үйл ажиллагааг зогсоох болон шинэ оршуулгын газар байгуулах-* Оршуулгын газрыг хааж, тодорхой хугацаанд байсан шарил, чандарыг зохих ёсны дагуу шилжүүлснээр тухайн газарт дахин оршуулгын газар байгуулж болно. Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд халдаж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн оршуулгын газрын удирдлагын саналыг сонссоны дараа булш хаах хугацааг үл харгалзан оршуулгын газрын үйл ажиллагааг зогсоож болно. Оршуулгын газрыг хууль тогтоомжид заасны дагуу нийтийн хэрэгцээнд ашиглаж байгаа тохиолдолд булш хаах хугацаа нь болоогүй байгаа шарил, чандарыг дахин оршуулах ёстой.

*Оршуулгын газраас өөр газарт шарилыг оршуулах-* Шарилыг оршуулгын газраас өөр газарт оршуулах зайлшгүй шаардлага үүссэн тохиолдолд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авна. Талийгаачийн итгэл үнэмшил, хүсэл зориг, шашны зан үйл, зайлшгүй нөхцөл байдал үүсэн тохиолдолд шарилыг оршуулгын газраас өөр газарт оршуулах эрхийг өгнө. Шарилыг өөр газарт оршуулахдаа шарил оршуулсан ойр орчмын газартаа, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхгүй байх, булш хаах хугацааны дагуу заасан хугацаанд нь шарилыг чандарлах, чандарыг цацах, бунханд хадгалах гэх мэт арга хэмжээг авна.

*Чандарлах газар-* Чандарлах газар нь уг хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу оршуулгын газарт тавигдах шаардлагыг хангахуйц байх ёстой. Чандарлах газрыг эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр ажиллуулах, эсхүл өөрчлөх боломжтой. Хэрвээ оршуулгын газрыг барих, ажиллуулах, эсхүл өөрчлөх шаардлагатай тохиолдолд Баварын Барилгын тухай хуулийн дагуу зөвшөөрөл авах ёстой. Чандарлах газар олон нийтийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд чандарлах газрын үйл ажиллагааг хориглож болно.

УИХ.MN СУДАЛГААНЫ САН

*Нөхөн олговор олгох*-Баварын өмчлөх эрхийн тухай хуулийн 2141-1-I хэсэгт заасны дагуу тухайн оршуулгын газрыг өөрчлөх, оршуулгын газар байгуулах зорилгоор хураан авч, нөхөн олговор олгоно.

***Хяналт тавих***- Хот, дүүргийн засаг захиргаа нь төрийн захиргааны байгууллагын хувьд энэ хуулийн заалт, түүний үндсэн дээр гаргасан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ёстой. Дээр дурсдсан эрх бүхий байгууллагын гаргасан журам, шийдвэр нь эрх зүйн чадамжгүй, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн тохиолдолд оршуулгатай холбоотой бүх асуудлыг цагдаагийн байгууллага хариуцан ажиллах бөгөөд энэ хугацаанд гаргасан зардлыг нөхөн төлүүлэх боломжтой.

***Хууль зөрчсөн үйлдэл***- Улсын прокурорын газар, дүүргийн шүүгч зөвшөөрөхөөс өмнө эсхүл нас барсныг бичгээр батлаагүй байхад хэн болох нь тодорхойгүй цогцосыг эсхүл гадны нөлөөтэй нас барсан байх магадлалтай цогцосд задлан шинжилгээ хийх, эмнэлгийн болон шинжлэх ухааны зорилгоор ашигласан тохиолдолд мөнгөн торгууль олгоно.

*Бусад зүйл заалт*- Засгийн газар хоорондын хэлэлцээр, тухайлбал, цогцос тээвэрлэх тухай, цагдаагийн хуулийн заалт, хотын хуулийн 24 дүгээр зүйл, дүүргийн хуулийн 18 дугаар зүйл, дүүргийн хуулийн 18 дугаар зүйл, түүнд үндэслэсэн дүрмүүд нь хамаарах хэмжээгээрээ өөрчлөгдөөгүй хэвээр байна. энэ хууль болон 16 дугаар зүйлийн заалт нь одоо мөрдөж буй хууль тогтоомжид харшлахгүй. Оршуулгын газар нь Хотын захиргааны хуулийн 24-р зүйлийн 3-т заасан байгууллагууд юм.

***Хүлээлгэх үүрэг хариуцлага***- Эрүүл мэнд, халамжийн газар нь шарилд үзлэг хийх, булш хаах, оршуулгын ажил зохион байгуулах, шаардлагатай арга хэмжээ авах, тухайн хариуцсан болон төлөвлөсөн ажлыг хэдий хугацаанд хэн, хэрхэн зохион байгуулахыг тодорхойлно.

Орон нутгийн дүрэм, журам- Нийтийн эрүүл мэндийг хамгаалах болон оршуулгын газрын үйл ажиллагааг зохицуулах өөр хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй тул хотын захиргаа оршуулгын ажлыг зохион байгуулах, шарил хамгаалах үйлчилгээ, шарил хадгалах авс, шарилыг оршуулахад өмсгөх хувцас зэргийг тодорхой зааж өгсөн байна. Хотын захиргаа оршуулгын газар, чандарлах газар, шарил хадгалах газар болон түүнтэй адилтгах байгууламжид олон нийтийн аюулгүй байдал, хэв журмыг сахиулах, ялангуяа хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дэг журам, нэр төрийг зөрчсөн үйлдлийг хориглох шаардлагатай захирамж гаргаж болно. Хотын захиргааны гаргасан захирамжийг дагаж мөрдөнө.

## ЯПОН УЛС

Япон Улсын оршуулгын ёслолын 99.9 хувь нь буддын шашны зан үйлээр чандарлагддаг байна. Буддын шашин нь олон урсгалтай, урсгал тус бүр өөр өөрийн онцлог шинж чанартай бөгөөд оршуулгын нарийн арга барилтай "сэрэх - оршуулах ёслол - чандарлах" гэсэн дарааллаар ёслол үйлдэх нь түгээмэл байдаг. Оршуулгын ёслол нь нас барагсдын гэр бүл, төрөл төрөгсөд болон эргэн тойрных нь хүмүүст чухал үйл ажиллагаа юм. Тиймээс талийгаачийн араас үйлдэх гашуу тайлах үйл болгон өөрийн утга учир зан үйл, дэг жаягтай байна.

### 1. Эрх зүйн зохицуулалт

Оршуулгын ёслол нь оршуулгын дэг жаяг, уламжлалаас хамаарч олон төрлийн хуулиар зохицуулагдах шаардлагатай болдог. Тухайлбал, Байгаль орчны тухай хуулийн дагуу оршуулах газрыг, Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулиар нас барсны бүртгэл, Иргэний хуулийн өв залгамжлал, гэрээслэлтэй холбоотой заалт болон булш, буддын тахилын ширээ

зэрэг өвөг дээдсийнхээ зан үйлийг удирдах ёстой хүнийг залгамжлах тухай тусгаж өгсөн байдаг. Мөн Япон Улсад Оршуулгын газар, оршуулга гэсэн тусдаа бие даасан хууль байдаг.

***Оршуулгын газар, оршуулгын тухай хууль***[26] нь 1948 онд батлагдсан. 4 бүлэг 22 зүйлтэй.

Хуульд оршуулгын газар, шарил, чандарлах газрын менежмент, оршуулах аргачлал, чандарлах, дахин оршуулах, хиргисүүр, булш, оршуулгын газар, ясны оршуулгын газар, чандарлах гэсэн ойлголтын тодорхойлолт болон аргыг тусгасан.

*Оршуулах, чандарлах, дахин оршуулах талаар:*

- Оршуулгын газар, сүм хийд, чандарлах газар байгуулахын тулд мужийн захирагчаас зөвшөөрөл авах;
- Оршуулгын газрын гадна оршуулах, чандарлах газраас гадуур чандарлахыг хориглох;
- Чандарлах, оршуулах үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүс Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны захирамжийн дагуу тосгон, тойргийн захирагчаас зөвшөөрөл авах;
- Оршуулах, чандарлах үйл ажиллагааг нас барснаас хойш болон амьгүй төрснөөс хойш 24 цагийн дотор хийж болохгүй. Гэхдээ энэ нь жирэмсний долоон сараас бага хугацаанд амьгүй хүүхэд төрүүлсэн тохиолдолд хамаарахгүй;
- Шатаасан ясыг оршуулах, булшлахыг оршуулгын газраас бусад газарт хийж болохгүй бөгөөд чандарлах газраас бусад байгууламжид чандарлахыг хориглоно;
- Оршуулах, чандарлах, дахин оршуулахад Эрүүл мэндийн яамны сайдын тушаалын заалтын дагуу хотын захирагчаас зөвшөөрөл авах ёстой;
- Хотын захирагч оршуулах, дахин оршуулах, чандарлах зөвшөөрөл олгохдоо оршуулах зөвшөөрөл, дахин оршуулах, чандарлах зөвшөөрөл гэсэн тус тусад нь зөвшөөрөл олгоно;
- Цогцсыг оршуулах, чандарлах хүн байхгүй, эсхүл хэн болох нь тогтоогдоогүй шарилыг оршуулах үйл ажиллагааг хотын захирагчийн албанаас гүйцэтгэнэ.

*Оршуулах болон чандарлах газар:*

- Оршуулгын газар, ясны оршуулгын газар, чандарлах газар ажиллуулахад мужийн захирагчаас зөвшөөрөл авна;
- Оршуулах зөвшөөрөл, дахин оршуулах, чандарлах зөвшөөрөл аваагүй тохиолдолд оршуулгын газрын дарга чандарласан ясыг булшлах, оршуулахыг зөвшөөрөхгүй;
- Чандарлах газрын дарга оршуулах зөвшөөрөл, чандарлах, дахин оршуулах зөвшөөрлийг хүлээн авсан өдрөөс хойш таван жилийн хугацаанд хадгална.

Хуулийн дагуу эрх зүйн бусад актуудаар оршуулгын зан заншлын хэм хэмжээ мөн зохицуулагддаг.

***Оршуулах, чандарлах талаарх хотын захирагчийн журмын ерөнхий үйл ажиллагааны чиглэл нь:***

- Оршуулах, чандарлах, дахин оршуулах хүсэлтэй хүмүүс хотын захирагчаас зөвшөөрөл авах;
- Зөвшөөрөлгүйгээр оршуулах, чандарлах зэргийг хориглох;

Оршуулгын газрын удирдлагуудын үүрэг хариуцлага:

[26] Оршуулгын газар, оршуулгын тухай хууль https://elaws.gov.go.jp/document?lawid



UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Оршуулгын газар, чандарлах газрын дарга нь өмнөх сарын оршуулгын болон чандарласан байдлын талаарх мэдээллийг тухайн орон нутгийн засаг захиргааны даргад сар бүрийн 05-ны өдрийн дотор мэдээлэх;

Хотын дарга нарын үүрэг:
- Мужийн захирагчид (хотын дарга, эсвэл тойргийн дарга нар) оршуулгын газрын удирдлагуудаас тайлан цуглуулах;
- Нийгмийн эрүүл мэнд, нийгмийн сайн сайхны үүднээс оршуулгын газрыг тохижуулах, ашиглах талаар бүхэлд нь буюу хэсэгчлэн хязгаарлах, хориглох тушаал гаргах;
- Хүн амын эрүүл мэнд, нийгмийн халамжийн үүднээс шаардлагатай гэж үзвэл мужийн захирагч (хотын болон тусгай тойргийн хувьд хотын дарга, дүүргийн захирагч) оршуулгын газар, сүм хийд, чандарлах газрын зөвшөөрлийг цуцлах.

***Оршуулгын газар, оршуулга гэх мэт хууль сахиулах байгууллагын захирамж***[27] нь 2003 оны 03 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан. Үүнд:
- Оршуулгын газар, усан сан, чандарлах газрыг удирдах удирдлагын шалгуур нь хотын иргэдийн шашин шүтлэгтэй нийцэж байгаа эсэхэд анхаарч, нийгмийн эрүүл мэнд болон бусад нийгмийн сайн сайхан байдалд сөрөг нөлөөгүй байх ёстой.
- Оршуулгын газрын байршил нь дараах стандартад нийцсэн байх:
    - Оршуулгын газар ажиллуулах газар нь өмчлөх эрхтэй байх;
    - Гол мөрөн, нуураас 20 метр ба түүнээс хол зайд байх;
    - Цэцэрлэгт хүрээлэн, сургууль, цэцэрлэг, эмнэлэг болон бусад нийтийн байгууламж, оршин суух газраас 100 метрээс хол зайд байх;
    - Ундны усыг бохирдуулах эрсдэлгүй газар байх;
    - Оршуулгын газрын талбайн ногоон байгууламжид нөлөөлөх талбайн харьцаа 20%-аас илүүгүй байх;
    - Хиргисүүрийн 5 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний автомашины зогсоолтой байх;
    - Булш тус бүртэй холбосон бетон, чулуу зэрэг хучилттай үндсэн булшны өргөн нь 1.5 метр ба түүнээс дээш, бусад булш нь 1.2 метр ба түүнээс дээш өргөнтэй гарцтай байх;
    - Борооны ус зэрэг ус зайлуулах байгууламжийг суурилуулах;
    - Удирдлагын байр, бие засах газар, ус хангамжийн тоног төхөөрөмж, хог хаягдлыг зайлуулах байгууламжтай байх;
    - Чандарлах зуух нь тоос нэвтэрдэггүй, үнэр дарагч гэх мэт төхөөрөмжөөр тоноглогдсон байх;
    - Үнсний агуулахтай байх;
    - Машины зогсоол, бие засах газар, хүлээлгийн өрөө, захиргааны байраар хангасан байна гэж журамласан байна.

***Үндсэн хуулийн***[28] 25 дугаар зүйлд заасан “Хүн амьд явах эрх”-д үндэслэн ***Төрийн тусламжийн тухай хууль***[29]-ийн зорилтын дагуу оршуулгын ажлыг саадгүй хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж өгсөн. Талийгаачийн цогцсыг задлан шинжилгээ хийх, тээвэрлэх, чандарлах, оршуулах зэрэг оршуулгын үйлчилгээнд хамрагдах зардалгүй тохиолдолд тодорхой тусламж олгохоор тухайн хуульд заасан.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[27] Оршуулгын газар, оршуулга гэх мэт хууль сахиулах байгууллагын захирамж https://www1.g-reiki.net/matsubushi/reiki_honbun/e392RG00000560.html
[28] Үндсэн Хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=321CONSTITUTION
[29] Төрийн тусламжийн тухай хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=325AC0000000144

***Эрүүгийн хуулийн***[30] 24 дүгээр бүлэгт "Булшны газар, бунхантай холбоотой гэмт хэрэг" гэсэн тусгай бүлэгт үүрэг хариуцлагыг заасан байдаг. Мөргөл болон мөргөлийн газрыг үл хүндэтгэх, номлолд саад учруулах зүйл анги нь оршуулгын газар болон бусад мөргөлийн газрыг олны өмнө үл хүндэтгэсэн этгээдийг зургаан сараас илүүгүй хугацаагаар баривчлах, эсхүл 100,000-аас илүүгүй иенээр торгох шийтгэл ногдуулна. Номлол, мөргөл, оршуулгын ажилд хөндлөнгөөс саад хийсэн хүнийг нэг жилээс илүүгүй хугацаагаар хорих, эсхүл 100,000 иенээс илүүгүй торгууль ногдуулна  (оршуулгын малталт). Булш ухсан хүнийг хоёр жилээс илүүгүй хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. Авсанд хийсэн цогцос, үлдэгдэл, үс, эд зүйлийг устгасан, хаясан, олж авсан хүнийг гурваас дээш жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ (нас барсан хүмүүсийг нууцаар оршуулах). Задлан шинжилгээ хийлгэхгүйгээр, мөн зүй бусаар талийгаачийг оршуулсан хүнийг 100,000-аас илүүгүй иенээр торгох заалтууд байна. Үхлийн шалтгааныг тогтоохтой холбогдуулан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд булш ухах, цогцос задлахыг зөвшөөрдөг. Задлан хийсний дараа эвэрлэг бүрхэвч болон зарим эрхтнүүдийг шилжүүлэн суулгахыг зөвшөөрөх тухай заасан байна.

***Зөрчлийн тухай хуулийн*** дагуу мөргөл үйлдэх газар, бунхантай холбоотой гэмт хэрэг, аж ахуйн үйл ажиллагаанд саад учруулсан гэмт хэрэг, залилан мэхлэх замаар бизнест саад учруулах гэмт хэрэгт  эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдол байдаг.

***Тэнгисийн цэргийн тухай хуулийн*** 15 дугаар зүйлд тодорхой нөхцөлд далайд талийгаачийн үнсийг  оршуулахыг мөн зөвшөөрдөг байна. Энэ нь онцгой тохиолдол боловч захиргааны хуулийн ангилалд багтдаг. Чандарласан үнс  цацах явдал сүүлийн үед олны анхаарлыг татаж байгаа ч өнгөрсөн хугацаанд Эрүүгийн хуулийн 4 дүгээр зүйл, 190 дүгээр зүйлд тус тус зааснаар үнс нурам хаях зэргийг хориглож байсан юм.

***Иргэний хууль***[31]-ийн 309 дүгээр зүйл нь оршуулгын зардлыг зээлэх эрхийн тухай зохицуулсан бөгөөд оршуулгын зээлдүүлэгчид бусад зээлдүүлэгчдээс төлбөр авах боломжийг олгодог тусгай заалт юм. Өөрөөр хэлбэл, сүм, дуган, оршуулгын газрууд оршуулгын зардлыг цуглуулах, санхүүгийн эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх зорилготой юм. Мөн Иргэний хуулийн 896, 897 дугаар зүйлд “Өвөг дээдсийн зан үйлийг удирдах ёстой хүнийг залгамжлах” тухай заасан. Ёслолын залгамжлагч заавал өв залгамжлагч байх албагүй. Ёслолын өмч нь өв залгамжлах өмч биш тул өв залгамжлах эрхгүй  эхнэр, нөхөр ч зан үйлийн өв залгамжлагч болж чадна. Мөн уг зан үйлийн залгамжлагчийг нас барсан хүний аман гэрээслэлээр тодорхойлж болно.

***Гэр бүлийн бүртгэлийн тухай хууль***[32]-ийн 86,87 дугаар зүйлд нас барсан бүртгэлийн тухай нарийвчлан тусгасан байдаг. Гэр бүлийн гишүүд, хамаатан садан, хамтран амьдрагч, түрээслэгч, түрээслүүлэгч (байшингийн) менежер, газрын менежер, асран хамгаалагч, туслах, сайн дурын асран хамгаалагч нар нас барсан өдрөөс хойш 7 хоногийн дотор (гадаадад нас барсан тохиолдолд 3 сарын дотор) нас барсныг мэдэгдэх, бүртгэл хийлгэх маягтыг бүрдүүлж, нас барсны гэрчилгээтэй хамт нас барсан  газар, оршин суугаа хаяг, эсхүл мэдэгдэл гаргаж буй хүний байршлын дагуу, хотын алба, тойргийн алба, хот, тосгоны албанд илгээнэ.

***Нас барсны гэрчилгээ*** гэдэг нь хүн нас барахад гэр бүлийн гишүүд болон бусад хүмүүс нас барсан тухай төрийн байгууллагад мэдэгддэг баримт бичиг юм. Энэхүү мэдэгдлээр нас барсныг овгийн бүртгэл, оршин суугчийн бүртгэлд тусгана. Уг мэдэгдлийг өгөх үед цогцсыг чандарлах зөвшөөрөл авах шаардлагатай тул оршуулгын компаниар дамжуулан мэдэгдэж

[30] Эрүүгийн хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=140AC0000000045
[31] Иргэний хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=129AC0000000089
[32] Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн заалт https://www.moj.go.jp/ONLINE/FAMILYREGISTER/5-4.html

UIH.MN СУДАЛГААНЫ САН

болдог байна. Тэтгэврийн насны хүн нас барсан тухай мэдэгдлийг тусад нь тэтгэврийн байгууллагад мэдэгдэх шаардлагатай.

***Оршуулгын ёслолын төрлүүд***

Оршуулгын газрын төрлөөс хамаарч оршуулах ёслолын газар, хэмжээ болон дэг жаяг нь хэд хэдэн төрөл байна.[33]

*Байгалийн оршуулга:* Тусгай оршуулгын газарт оршуулахгүй, байгаль эхдээ буцах гэсэн утгаар шарилыг үнс нурам болгон байгальд цацах.

*Модны оршуулга:* Энэ оршуулга нь үнсийг модны ёроолд булах, эсхүл бэлгэдлийн мод тарьж үнсийг нь модны сууринд цацдаг.

*Далайн оршуулга:* Үнс нурмыг тусгай завиар тээвэрлэн далайд цацдаг.

*Агаарт оршуулах:* Агаарт оршуулахдаа үнсийг бөмбөлөгт хийж, газраас 30 орчим км-ийн өндөрт хөөргөж, агаар мандалд хүрэхэд бөмбөлөг хагарч үнс нь агаарт цацагддаг.

***2. Бүх Японы оршуулгын газрын холбоо[34] (All Japan Cemetery Association)***

Японы оршуулгын газрын нийгэмлэг нь оршуулгын газрын талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, оршуулгын газрын менежментийг зөв боловсронгуй хөгжүүлэх, улмаар иргэдийн эрүүл мэнд, нийгмийн сайн сайхныг хангах зорилгоор оршуулгын газруудыг судалгаа, мэдээллээр хангах зэрэг үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2010 оны 10 дугаар сараас олон нийтийн ашиг сонирхлын корпорацын шинэ тогтолцоог хэрэгжүүлснээр *"Бүх Японы оршуулгын газрын холбоо*" болсон. Тус холбоо нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна. Үүнд:

- Оршуулгын газрын төлөвлөлт, менежментийн судалгаа;
- Оршуулгын газрын төлөвлөлт, менежмент, ашиглалтын талаар зөвлөгөө, заавар;
- Оршуулгын газрын менежерийн мэргэшлийг баталгаажуулах семинар, харилцааны сургалт;
- Судалгаа, судалгааны тайлан, сэтгүүл болон бусад хэвлэмэл материалыг хэвлэн нийтэлж түгээх;
- Гадаадын оршуулгын газартай холбоотой байгууллагуудтай санал солилцох;
- Энэ корпорацын үйл ажиллагааны хүрээнд шаардлагатай бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй.

***3. Оршуулгын зан үйлийн сурталчилгааны сан[35] (SOUMU General Incorporation Foundation)***

Япон Улсад нийгэм өөрчлөгдөхийн хэрээр 1948 онд батлагдсан Оршуулгын газар, оршуулгын тухай хуулиар шийдвэрлэх боломжгүй асуудлууд гарч ирсэн. Оршуулгын зан заншилд нийгмийн эрүүл мэндийг чухалчлан үздэг байсан бол чандарлах явдал ихэссэнтэй холбоотойгоор оршуулгын газрын менежментийн байнгын ажиллагаа, хүрээлэн буй орчинтойгоо зохицохыг чухалчилж, оршуулгын газрын ирээдүйн бодлогод оршуулгын байгууламжийн хангамж, менежментийн арга зүй гэх мэт үүргийг зохих ёсоор хуваарилах шаардлагатай болсон. Оршуулгын байгууламжууд нь төрөл бүрийн хэрэгцээг хангах шаардлагатай байдаг ч ариун дагшин газар байснаа цэцэрлэгт хүрээлэн болон хувирч, нийтийн эзэмшлийн талбай болгон орон нутагтай зэрэгцэн орших санаачилгууд гарч байна. Нийгэмд үүсч буй эдгээр асуудлуудыг таниулах үүднээс Сурталчилгааны

[33] Оршуулах ёслолын төрлүүд https://www.yoriso.com/sogi/article/sogi-shurui/
[34] Бүх Японы оршуулгын газрын холбоо http://www.zenbokyo.or.jp/indexpdf.html
[35] Оршуулгын сурталчилгааны нийгэмлэг https://www.somu.or.jp/about.html

судлаачид үүсгэн байгуулж, 2013 оны 04-р сараас эхлэн нэгдсэн сан болон ажиллаж байна.

Сурталчилгааны сан нь судалгааны ажлаар зогсохгүй орон нутаг, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд оршуулгын газрын бизнесийн зөв менежментийн талаарх мэдлэгийг нь дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилладаг байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


МОНГОЛ УЛС

- Монголчуудын хойлгын зан үйл III боть
- Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын албаны мэдээлэл 2022 он (Монголчуудын оршуулгын зан үйл: уламжлал, орчин үе, чиг хандлага ЭШХ III)
- International Cemetry, Cremation and Funeral Association https://iccfa.com/
- Australian Cemeteries and Crematoria Association https://accaweb.com.au/
- National Funeral Directors Association https://nfda.org/
- United States of America - Number of deaths https://knoema.com/atlas/United-States-of-America/topics/Demographics/Mortality/Number-of-deaths
- Health and Safety Code https://leginfo.legislature.ca.gov/faces/codesTOCSelected.xhtml?tocCode=HSC&tocTitle=+Health+and+Safety+Code+-+HS
- Duty of Registering Death https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?lawCode=HSC&sectionNum=102795.

СОЛОНГОС УЛС

- Embalming and Transportation https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displayText.xhtml?lawCode=HSC&division=7.&title=&part=1.&chapter=5.&article=2.
- Local Regulation of Cemeteries https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?sectionNum=8115.&lawCode=HSC
- БНСУ-ын Үндэсний статистикийн хорооны судалгааны тайлан мэдээ https://blog.daum.net/schwein-s/800
- 장사 등에 관한 법률-Оршуулгын тухай хууль https://www.law.go.kr/%EB%B2%95%EB%A0%B9/%EC%9E%A5%EC%82%AC%EB%93%B1%EC%97%90%EA%B4%80%ED%95%9C%EB%B2%95%EB%A5%A0
- 장사 등에 관한 법률시행령-Оршуулгын тухай хуулийн хэрэгжилтийн тухай заавар https://www.law.go.kr/LSW/lumLsLinkPop.do?lspttninfSeq=118494&chrClsCd=010202
- 건전가정의례준칙-Гэр бүлийн эрүүл зан үйлийн журам https://www.law.go.kr/LSW/LsiJoLinkP.do?lsNm=%EA%B1%B4%EC%A0%84%EA%B0%80%EC%A0%95%EC%9D%98%EB%A1%80%EC%A4%80%EC%B9%99&paras=1&docType=JO&languageType=KO&joNo=001700000#
- 가족관계의 등록 등에 관한 법률 Гэр бүлийн харилцааны бүртгэлийн тухай хууль
- https://www.law.go.kr/LSW/LsiJoLinkP.do?lsNm=%EA%B1%B4%EC%A0%84%EA%B0%80%EC%A0%95%EC%9D%98%EB%A1%80%EC%A4%80%EC%B9%99&paras=1&docType=JO&languageType=KO&joNo=001700000#

КАЗАКСТАН УЛС

- Типовые правила погребения и организации дела по уходу за могилами https://tengrinews.kz/zakon/pravitelstvo-respubliki-kazahstan-premer-ministr-rk/konstitutsionnyiy-stroy-i-osnovyi-gosudarstvennogo-upravleniya/id-V1900018771/
- О местном государственном управлении и самоуправлении в Республике Казахстан https://kodeksy-kz.com/ka/o_mestnom_upravlenii_i_samoupravlenii.htm


UIH.MN СУДАЛГААНЫ САН

ГЕРМАН УЛС

- Feuerstattung https://sozialbestattung.de/feuerbestattung/
- Sterbefälle in Deutschland https://de.statista.com/statistik/daten/studie/156902/umfrage/sterbefaelle-in-deutschland/#professional
- Bayerische Bestattungsgesetz https://www.gesetze-bayern.de/Content/Document/BayBestG
- Seebestattung https://sozialbestattung.de/seebestattung/

ЯПОН УЛС

- Оршуулах ёслолын төрлүүд https://www.yoriso.com/sogi/article/sogi-shurui/
- Үндсэн Хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=321CONSTITUTION
- Төрийн тусламжийн тухай хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=325AC0000000144
- Иргэний хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=129AC0000000089
- Иргэний хууль https://elaws.e-gov.go.jp/document?lawid=129AC0000000089
- Гэр бүлийн бүртгэлийн тухай хуулийн заалт https://www.moj.go.jp/ONLINE/FAMILYREGISTER/5-4.html
- Оршуулгын газар, оршуулгын тухай хууль https://elaws.gov.go.jp/document?lawid=323AC0000000048_20150801_000000000000000
- Оршуулгын газар, оршуулга гэх мэт хууль сахиулах байгууллагын захирамж https://www1.g-reiki.net/matsubushi/reiki_honbun/e392RG00000560.html
- Бүх Японы оршуулгын газрын холбоо http://www.zenbokyo.or.jp/indexpdf.html
- Оршуулгын сурталчилгааны нийгэмлэг https://www.somu.or.jp/about.html

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГСДИЙГ ЦАГААТГАХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Р.Оргилмаа,*
*Д.Амаржаргал (Ph.D), О.Билгүүтэй, Д.Жигваагүнсэл*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ЧИГ ХАНДЛАГА

1.1. Хэлмэгдүүлэлт, улс төрийн хэлмэгдүүлэлт

1.2. Хүний эрхийн олон улсын байгууллагууд

1.3. Хэлмэгдүүлэлтийн талаарх орчин үеийн чиг хандлага

ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ЦАГААТГАХ БАЙГУУЛЛАГА

2.1. Оросын Холбооны Улс

2.2. Казахстан Улс

2.3. Болгар Улс

2.4. Гүрж Улс

2.5 Өмнөд Солонгос Улс

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах байгууллагын талаарх бусад орнуудын туршлага" сэдэвт харьцуулсан судалгааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгаанд хэлмэгдүүлэлт, түүнээс сэргийлэх, хэлмэгдүүлэлтийн өнөөгийн чиг хандлага, хүний эрхийн олон улсын байгууллагууд болон гадаадын зарим улс орнуудын манай улстай ижил төстэй цагаатгалын байгууллага, тэдгээрийн статус, бүтэц, чиг үүргийг холбогдох хууль, эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судалсан болно.

**Судалгааны бүтэц:** Судалгаа нь дараах хоёр хэсгээс бүрдэнэ. Нэгт, төрийн эрх баригчдын зүгээс эрх мэдлээ хамгаалах, улс орныхоо дотоод дахь эсэргүүцлийг дарахын тулд хийж буй хууль бус үйлдэл-хэлмэгдүүлэлтийн талаар болон олон улсын хүний эрхийг хамгаалах байгууллагуудын тайланд дурдагдсан дэлхий дахинд гарч буй хүний эрхийн зөрчил, хэлмэгдүүлэлтийн өнөөгийн байдлын талаарх ерөнхий мэдээлэл, Хоёрт, Оросын Холбооны Улс (ОХУ), Казахстан, Болгар болон Гүрж Улсуудын улс төрийн хэрэгт хилсээр шийтгүүлсэн хэлмэгдэгсдийг цагаатгах байгууллагын талаар хийгээд дайны үед хэлмэгдүүлэлтэд өртсөн Өмнөд Солонгос Улсын хэлмэгдэгсдийг цагаатгах байгууллагын талаарх мэдээлэл зэрэг болно.

***Түлхүүр үг:*** *хэлмэгдүүлэлт, улс төрийн хэлмэгдүүлэлт, цагаатгал, цагаатгалын байгууллага*

***Keywords:*** *repression, political repression, vindication/rehabilitation of political repression, commission on political vindication*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Судалгаанаас үзэхэд дэлхийн түүхэнд төрийн эрх мэдэлтнүүд яс үндэс, угсаа гарал, улс төр, үзэл бодол зэрэг олон учир шалтгаанаар ард иргэдээ хэлмэгдүүлэн хохироож байсан үзэгдэл олноор гарч байсан бөгөөд 21-р зуунд ч бид энэ асуудлыг ярьсаар байна. Улс төрийн зөрчилдөөн нь хэлмэгдүүлэлтийн үндсэн шалтгаан бөгөөд төрөөс зохион байгуулалттайгаар хийгддэг улс төрийн цэвэрлэгээ нь зөвхөн үзэл бодлын зөрүүгээр хүнийг хэлмэгдүүлэх бус үндэс угсаагаар нь хүйс тэмтрэх геноцид хэлбэрээр ч үйлдэгдэж байв.

Хэлмэгдүүлэлт нь хүний эрхийн зөрчил юм. Тиймээс өнөө үед төрийн болон төрийн бус хүний эрхийн байгууллагууд, түүн дотроо хүний эрхийг хамгаалах олон улсын, сайн дурын байгууллагууд хүнийг улс төрийн аливаа хэлмэгдүүлэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлж, хүний эрхийн тэмцлийг тууштай дэмжиж байгаа хэдий ч дэлхий даяар хүний эрх зөрчигдсөөр байна. Хүний эрхийг хамгаалсан олон улсын хөтөлбөр болон үндэсний хууль тогтоомж, баримт бичгүүд ихэнх улс орнуудад батлагдсан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Олон улсын хүний эрхийг хамгаалах байгууллагуудын тайлангаас үзэхэд дэлхийн өнцөг булан бүрд (ардчилал хөгжсөн орнуудад ч мөн ялгаагүй) хүмүүс "улс төрийн эрх"-ээ эдлэн, эвлэлдэн нэгдэж, тэмцэл, хөдөлгөөн өрнүүлж, засгийн газар, эрх баригчдын эсрэг шүүмжлэлт дуу хоолойгоо илэрхийлснийхээ төлөө үндэслэлгүйгээр баривчлах, шударга бусаар яллах, айлган сүрдүүлэх, хилс хэрэг тулгах, захиргааны хязгаарлалт тогтоох, заналхийлэл, хүчирхийлэл, тэр дундаа хүчээр алга болгох, эрүүдэн шүүх зэрэг эрх баригчдаас явуулж буй хууль бус үйл ажиллагааны золиос болж бие махбод, сэтгэл санааны болон бусад олон төрлийн хохирол амсан, хэлмэгдсээр байгаа тухай дурдсан байна.

Дэлхийн улс орнуудад ардчилал, хүний эрхийн асуудал чухлаар тавигдах болсон цаг үе буюу өөрөөр хэлбэл, 1990-ээд оноос улс төрийн хилс хэргийн золиос болсон хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох талаар авч үзэж, ЗХУ-ын харьяанд байсан улс орнууд болон хэлмэгдүүлэлт хүчтэй явагдсан улс орнуудад энэ асуудлыг шийдвэрлэх ажлыг эрчимтэй явуулж эхэлсэн. Үүний нэг гол үйл ажиллагаа нь тухайн асуудлыг хариуцан явуулах байгууллагыг байгуулан ажиллах явдал байв.

Судалгаанд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг хариуцан ажилладаг манай улстай ижил төстэй цагаатгалын байгууллага бүхий ОХУ, Казахстан, Болгар, Гүрж улсууд болон дайны үеийн хэлмэгдүүлэлтэд өртсөн Өмнөд Солонгос Улсын цагаатгах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хууль эрх зүйн орчны талаар авч үзлээ.

*Цагаатгалын байгууллагын үйл ажиллагааны хамрах хүрээг үзвэл,* судалгаанд авагдсан орнуудаас ОХУ, хуучнаар ЗХУ-ын харьяанд байсан Казахстан, Гүрж түүнчлэн ЗХУ-ын нөлөөнд байсан Болгар болон Монгол Улсад цагаатгалын байгууллагыг коммунист дэглэмийн **тодорхой хугацааны хооронд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн** иргэдийг цагаатгах зорилготой байгуулсан байна. Тухайлбал, 1990 онд Монгол Улсад Ардчилсан хувьсгал ялж, Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссыг 30, 40, 50-аад онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах зорилгоор анх байгуулан, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль”-ийн 5 дугаар зүйлд мөн тодорхой хугацаанд улс төрийн гэмт хэргийн золиос болсон хэлмэгдэгсдийг цагаатгахаар заасан бол, ОХУ-ын “Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай” хуулиар 1917 оны 10 дугаар сарын 25-ны (11 дүгээр сарын 07) өдрөөс эхлэн ОХУ-ын нутаг дэвсгэр дээр улс төрийн хэрэгт хэлмэгдсэн хохирогчдыг цагаатгах, Болгар Улсын “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах тухай” хуульд 1944 оны 09 дүгээр сарын 12-ноос 1989 оны 11 дүгээр сарын 10-ныг хүртэлх хугацаанд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгана гэж тус тус заасан байна. Харин “Гүрж улсын иргэнийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогч гэж хүлээн зөвшөөрөх тухай, хэлмэгдэгсдийн нийгмийн хамгааллын тухай” хуулийн[36] 1-р бүлгийн 1.2-т “Энэхүү хууль нь 1921 оны 02-р сараас 1990 оны 10-р сарын 28 хүртэл хуучин ЗХУ-ын нутаг дэвсгэрт, дараа нь тусгаар тогтносон Гүрж улсын нутаг дэвсгэрт улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж байсан Гүржийн иргэдэд хамаарна” гэж заасан байна. Энэ нь коммунист дэглэмийн үед төдийгүй түүнээс хойш хэлмэгдсэн иргэдийн асуудлыг зохицуулахаар заасан байна.

Судалгаанд авагдсан орнуудад улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах асуудлыг бие даасан хуулиудаар зохицуулж байна.

*Цагаатгалын байгууллагын статусын хувьд*, ОХУ, Казахстан, Болгар улсуудад “**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах байгууллага” нь төрийн байгууллага** байх бөгөөд Казахстан болон ОХУ-д Ерөнхийлөгчийн дэргэдэх зөвлөх статустай байгууллага байна. Харин Гүрж болон Өмнөд Солонгост хэлмэгдсэн иргэдийг шүүх болон захиргааны байгууллагаар дамжуулан цагаатгаж, тэдэнд нөхөн олговор олгох, дурсгалыг мөнхжүүлэх зэрэг бусад үйл ажиллагааг төрийн бус байгууллагууд хариуцан явуулдаг байна.

**ОХУ-ын** Ерөнхийлөгчийн дэргэдэх Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс (одоогоор 15 гишүүнтэй байна)[37] бүрдэнэ. Комиссын

[36] https://matsne.gov.ge/en/document/view/31408?publication=11
[37] http://kremlin.ru/structure/commissions#institution-25

UIH.MN СУДАЛГААНЫ САН

даргыг ОХУ-ын Ерөнхийлөгч томилно. Комиссын бүрэлдэхүүнийг комиссын даргын санал болгосноор ОХУ-ын Ерөнхийлөгчийн захиргааны дарга (тамгын газрын дарга) батална. Гишүүдэд төр захиргааны болон олон нийтийн байгууллагын удирдлага, архив, судалгаа шинжилгээний байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, хэлмэгдэгсдийн төлөөлөл ордог байна. ОХУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын иргэд, байгууллагын өргөдөл, хүсэлтийг хүлээн авах алба нь Комиссын үйл ажиллагааны техник зохион байгуулалтыг ханган ажилладаг байна.

**Казахстан Улсын** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг бүрэн цагаатгах улсын комисс нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Улсын комиссын дарга нь БНКазУ-ын Төрийн нарийн бичгийн дарга байна. Улсын комисс нь төрийн байгууллагын дарга, олон нийтийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаач бүхий 44 гишүүдээс бүрдэнэ. Улсын комиссын ажлын алба нь БНКазУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яам байна.

**Болгар Улсад** "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах тухай" хуульд заасны дагуу Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах улсын төв комисс, орон нутаг дахь салбар комиссуудаараа дамжуулан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна. Улсын Төв комисс нь Ерөнхий сайдын томилсон 9 гишүүнээс, харин орон нутаг дахь салбар комиссууд нь Төв комиссоос томилсон тус бүр 5 гишүүдээс бүрддэг байна.

**Гүрж Улсын хувьд** цөөн тооны төрийн бус байгууллагууд Зөвлөлтийн хэлмэгдүүлэлт ба түүнтэй холбоотой цагаатгалын асуудлыг авч үздэг бөгөөд Мэдээллийн эрх чөлөөний хөгжлийн хүрээлэн (Institute for Development of Freedom of Information-IDFI), Гүржийн "Мемориал" нийгэмлэг, ЗХУ-ын өнгөрсөн үеийг судлах лаборатори (SovLab), Гүржийн залуу хуульчдын холбоо (GYLA-Georgian Young Lawyers' Association) зэрэг байгууллагууд хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагааг эрхэлдэг байна. Эдгээрээс Гүржийн төрийн бус байгууллага "Мемориал" нийгэмлэг нь 1992 онд байгуулагдан улс төрийн хэлмэгдэгсдийг дэмжиж туслах, тэдэнд нөхөн олговор олгох хуулиудыг батлуулж, хэрэгжүүлэх тал дээр ажиллаж иржээ. Мөн уг байгууллага нь хэлмэгдүүлэлттэй холбоотой Европын хүний эрхийн шүүхээс гаргасан нөхөн олговрыг барагдуулах, хэлмэгдсэн хүмүүст олгох тэтгэмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

**Өмнөд Солонгос Улсын** хувьд дайны үед хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нөхөн олговор олгох зорилготой байгуулагдсан Албадан хөдөлмөр эрхэлж байсан хэлмэгдэгсдэд нөхөн олговор олгох тухай зөвлөлдөх комисс энэ үйл ажиллагааг хариуцдаг. Комиссыг Үндэсний Батлан хамгаалахын сайдын дэргэд байгуулах тухай хуульд заасан байна. Зөвлөл нь комиссын даргыг оролцуулаад 9 гишүүнээс бүрдэнэ. Комиссын гишүүдийг холбогдох салбарын өргөн мэдлэг, туршлагатай хүмүүсээс сонгон, Ерөнхийлөгчийн зарлигт заасны дагуу Үндэсний Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилдог байна.

Үндэсний Батлан хамгаалах яамнаас цэргийн алба хаагчид болон тэдний ар гэрийнхэнд нөхөн олговор олгохтой холбогдсон асуудлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Хэлмэгдэгсдийн нөхөн төлбөрийн асуудлыг хэлэлцэх хороог байгуулсан. Хороо нь шүүх, өмгөөлөл, судалгаа, шинжилгээний ажлын туршлага бүхий 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

Дайны үеэр хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг судалгаанд орсон бусад улсуудын адил "Солонгосын дайны өмнө болон дайны үед хүнд хөдөлмөр эрхлэгсдийн нөхөн төлбөрийн тухай" бие даасан хуулиар зохицуулж байна. Тус хуульд Өмнөд Солонгосын дайны өмнө болон дайны үеэр дайсны нутаг дэвсгэрт цэргийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

алба хааж, онцгой үүрэг гүйцэтгэсэн, улс орны төлөө онцгой золиос гаргасан цэргийн алба хаагчид болон тэдний ар гэрийнхэнд нөхөн олговор олгох асуудлыг зохицуулах тухай заажээ.

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

## НЭГ. ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ЧИГ ХАНДЛАГА

### *1.1 Улс төрийн хэлмэгдүүлэлтийн талаарх ойлголт, тодорхойлолт*

**Хэлмэгдүүлэлт, улс төрийн хэлмэгдүүлэлт** гэдэг нь иргэдийг улс төрийн шалтгаанаар хүчээр хянах, хавчих, нийгэм, улс төрийн амьдралд оролцох боломжийг нь хязгаарлах зорилгоор олон нийтийн дунд нэр төрийг нь гутаах зэрэг төрийн эрх баригчдаас явуулж буй бусармаг үйлдлийг хэлдэг байна.[38]

1991 онд Монгол Улсын “Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс”-оос “улс төрийн хэлмэгдэгч” гэдэг ойлголтыг тодорхойлон тогтоох үүргийг харьяа “Улс төрийн хэлмэгдэгсдийн судалгааны төв”-д даатгаснаар тус төвийн судлаач эрдэмтэд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хууль батлагдах хүртэл **“улс төрийн хэлмэгдэгч”** хэмээх ойлголтыг дараах байдлаар тайлбарлажээ. “Өөрийн амьдарч ахуй тухайн цаг үедээ оршин тогтнож буй засаг төрийн байгууллын эсрэг хууль бус аргаар тэмцэх үйлдэл хийгээгүй, харин засаг төрийн удирдагчдын үйл ажиллагааны алдаа дутагдал болон улс төрийн бодлогын агуулга, шинж чанар, үр дагаврын талаар гарч буй болон цаашид гарч болзошгүй алдаа, доголдлыг засч арилгах зорилгоор санал бодлоо илэрхийлж, шүүмжлэл, санал гаргасныхаа улмаас эсвэл өөрийн шашин шүтлэг, сүсэг бишрэлийн улмаас шүүхээр болон шүүхээс гадуур гэсгээн цээрлүүлэгдэгчдийг улс төрийн талаар хэлмэгдэгч хэмээнэ” гэж анх тодорхойлжээ.[39]

Улмаар 1998 онд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” Монгол Улсын хууль батлагдаж тус хуулийн 3 дугаар зүйлд “улс төрийн хилс хэрэг” болон “улс төрийн хэлмэгдүүлэлт” гэдгийг дараах байдлаар томьёолсон байна.[40] Тухайлбал:

3.1.1.**"улс төрийн хилс хэрэг"** гэж тухайн үеийн эрүүгийн хууль тогтоомжид заасан улс төрийн буюу төрийн эсрэг гэмт хэрэг, эрүүгийн хуульд шууд заагаагүй боловч намын эсрэг гэх хэргийг гүтгэлэг, бие махбодийн болон сэтгэл зүйн хүчирхийлэл, албадлага зэрэг хууль бус аргаар зохиомлоор бүрдүүлсэн хэргийг;

3.1.2.**"улс төрийн хэлмэгдүүлэлт"** гэж хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан бөгөөд зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн албадлагын арга хэмжээг хэлнэ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[38] https://www.psqonline.org/article.cfm?IDArticle=18366#
[39] “Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал” М.Ринчин УБ 2000, 156, 157-р тал.
[40] https://legalinfo.mn/mn/detail/510

Харин Монголын эрх зүйн эх толь бичигт **“хэлмэгдүүлэлт”** гэдэг нь төрийн байгууллагаас хэрэглэж буй залхаан цээрлүүлэлт гэж тайлбарласан байна.[41]

Улс төрийн хэлмэгдүүлэлт нь тодорхой улс төр-эдийн засгийн тогтолцоотой (тухайлбал, эдийн засгийн буурай хөгжил, авторитар дэглэм, хүн ам олонтой болон гадаад улс орнуудтай зөрчил бүхий) улс орнуудад гол төлөв үүсдэг гэж судлаачид үзсэн байна. Харин хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орсон, соёрхон баталсан улс орнууд хүний эрхийг дээдэлж, хүний эрхийн зөрчил гаргах нь бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага байдаг нь судалгаагаар нотлогдсон байна.[42]

### *1.2. Хүний эрхийг хамгаалах олон улсын байгууллагууд*

Олон улсад хүний эрхийн байгууллага байгуулах, хүний эрхийг хамгаалах, энэ талаар хамтран ажиллах, дэмжих явдал улам бүр өсөн нэмэгдэж байна. Хүний эрхийн олон улсын байгууллагууд улс орнууд дахь өөрийн салбар байгууллагууд болон үндэсний хүний эрхийн төрийн болон төрийн бус, түүнчлэн бусад олон улсын, сайн дурын байгууллагуудтай үйл ажиллагаагаа нэгтгэн, хүний эрхийг хамгаалах ажилд хамтран ажиллаж байна. Эдгээр байгууллага нь НҮБ-аас батлан гаргасан Хүний эрхийн суурь баримт бичгүүд болон өөрийн байгууллагын дүрэм, чиг үүрэг, улс орнуудын хууль тогтоомжид заасан хүний эрхийн зохицуулалт зэргийн уялдаа холбоо, хэрэгжилтэнд анхаарч ажилладаг байна. Хүний эрхийн олон улсын болон тив, бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудаас түүвэрлэн дараах байгууллагуудын үйл ажиллагааны талаар товч авч үзлээ.

**НҮБ (United Nations)**

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ) нь олон улсын хэмжээнд хүний эрхийг хамгаалах байгууллага юм. НҮБ нь өөрийн 5 гол байгууллагаараа дамжуулан дэлхий дахинд хүний эрхийг хамгаалж байна. НҮБ-ын дүрэмд Хүний эрхийн зөвлөл (UN Human rights council)-ийн гишүүн орнууд нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжих талаарх хамтын ажиллагааг хөгжүүлнэ гэж заажээ. Түүнчлэн тус дүрэмд НҮБ-ын Аюулгүйн зөвлөл (UN Security Council)[43] нь олон улсад энх тайван, аюулгүй байдлыг бий болгох, түүнийг сахин хамгаалахтай холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй гэж заасан байна.

НҮБ-аас баталсан хүний эрхийн олон улсын суурь гэрээ:[44]

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
- Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу Хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц
- НҮБ-ын Дүрвэгсдийн тухай конвенц

НҮБ нь өөрийн гишүүн дэлхийн 193 орныг хамарсан Хүний эрхийн төлөв байдлын дүгнэлт хэлэлцүүлэг (UPR - Universal Periodic Review)-ийг 4 жил тутам зохион байгуулдаг бөгөөд ингэхдээ гэрээгээр хязгаарлахгүй аливаа улсын хүний эрхийн бүхий л асуудлыг авч хэлэлцдэг байна. UPR нь дэлхийн бүх хүний тусын тулд улс орнуудын хүний эрхийн нөхцөл

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[41] “Монголын эрх зүйн эх толь бичиг” УБ, 2015. С.Нарангэрэл
[42] https://web.archive.org/web/20070614024800/http://www.bsos.umd.edu/gvpt/davenport/STATER~2.PDF
[43] https://www.un.org/securitycouncil/
[44] http://www.mn-nhrc.org/372-rtr-rr-rtrrr-rrrrrr-rrrr-rrrrr-rrrrr.html

байдлыг газар дээр нь сайжруулах зорилготой байна. Энэ зорилгодоо хүрэхийн тулд улс орнууд дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, хүний эрх зөрчигдөх тохиолдол бүрд анхаарлаа хандуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн салбар дахь шилдэг туршлагуудаас хуваалцах, бие биенээсээ суралцах боломжийг олгох, хүний эрхийн асуудлыг сайнаар шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх зорилготой ажээ. UPR нь бүх улс оронд ялгаваргүй, тэгш хандах, хэлэлцүүлэгт орж байгаа улстай хамтран ажиллах зарчимд үндэслэдэг ба улс орнууд дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад төр засагт туслах зорилготой.[45] UPR-ийн хэлэлцүүлэгт тухайн орны Засгийн газрын үндэсний илтгэл, Хүний эрхийн үндэсний комиссын илтгэл, тухайн улс дахь НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон төрийн бус байгууллагууд тус тусын мэдээлэл, дүгнэлтээ илгээн хэлэлцүүлдэг байна. Дүгнэлт хэлэлцүүлгийг үндэслэн Хүний эрхийн зөвлөлөөс тухайн улсад хүний эрхийн нөхцөл байдлаа сайжруулах талаар дүгнэлт, зөвлөмж хүргүүлдэг байна. Зөвлөмж хүлээн авсан Засгийн газар нь хүний эрхийн аливаа зөрчлөө арилган, хүний эрхийг дээдлэн сахих үүрэгтэй.

**Эмнести Интернэшнл (Amnesty International)**

Дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн болох Эмнести Интернэшнл (Amnesty International) нь ихэвчлэн хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, шударгаар шүүлгэх эрх, харгислалд өртөхгүй байх эрх, цаазаар авах ялыг хориглох зэрэг эрхүүдийн хэрэгжилтийг олон улсын хэмжээнд хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. 1961 онд Их Британийн өмгөөлөгч Петер Бененсоны үндэслэн байгуулсан уг байгууллага нь өнөөдөр дэлхийн 150 гаруй оронд салбартай, 10 сая гаруй гишүүд дэмжигчтэй, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоохын төлөө дэлхий даяар компанит ажил өрнүүлдэг олон улсын хүний эрхийн томоохон байгууллага болон өргөжөөд байна.

**Хүний Эрхийн Ажиглагч (Human Rights Watch)[46]**

Human Rights Watch олон улсын байгууллага нь дэлхийн өнцөг булан бүрд гарч байгаа хүчирхийллийн талаар судалж, мэдээлдэг байна. Тус байгууллага нь 70 гаруй үндэстний 450 орчим хүний эрхийн мэргэжилтнүүд, хуульч, сэтгүүлчид зэрэг ажилтнуудаас бүрдэх бөгөөд үндэсний цөөнх, энгийн иргэд, дүрвэгсэд, тусламж шаардлагатай хүүхдүүд зэрэг дэлхийн өнцөг булан бүрд эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа хүмүүсийг хамгаалахын төлөө ажилладаг. Тус байгууллага нь улс орны засгийн газрууд, зэвсэгт бүлэглэлүүд болон томоохон бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа чиглүүлж, тэднийг хууль тогтоомж, бодлого, үйлдлээ өөрчлөх, хэрэгжүүлэхэд нөлөө үзүүлдэг байна. Human Rights Watch нь бие даасан байдлаа баталгаажуулахын тулд аливаа улсын засгийн газрын санхүүжилтээс татгалзаж, хүлээн авч байгаа бусад хандив, тусламжийг өөрийн байгууллагын бодлого, эрхэм зорилго, үнэт зүйлстэй нийцэж байгаа эсэхийг сайтар нягталдаг байна. Улс орнуудын тэмцэгч, идэвхтнүүдийг хамгаалах, хүчирхийлэгчдэд хариуцлага хүлээлгэх, хохирогчдыг хамгаалах, шударга ёсыг тогтооход туслах зорилгоор дэлхийн өнцөг булан бүр дэх хүний эрхийн болон бусад байгууллагуудтай хамтран ажилладаг байна.

**Олон улсын Улаан Загалмай хороо (International Committee of the Red Cross)**

Тус хороо нь дэлхийн 100 гаруй орны 20.000 гаруй ажилтнуудаас бүрдсэн дэлхийн томоохон хүмүүнлэгийн байгууллага бөгөөд зэвсэгт мөргөлдөөн болон бусад хүчирхийлэлд өртөгсдийг

[45] https://www.upr-mongolia.mn/index.php?cmd=Content&menuid=6&/UPR-%D0%B3%D1%8D%D0%B6-%D1%8E%D1%83-%D0%B2%D1%8D

[46] https://www.hrw.org/about/about-us

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хамгаалж, тэдэнд тусалдаг, улс төрийн хэргээр шоронд хоригдогсдын эрхийн асуудалд анхаардаг бие даасан, төвийг сахисан байгууллага юм.

### *1.3.Хэлмэгдүүлэлтийн талаарх орчин үеийн чиг хандлага*

Хэлмэгдүүлэлт нь хүний үндсэн, салшгүй эрхэд халдаж буй хэрэг бөгөөд өнөө үед дэлхийн улс орнуудад олон сая хүн өдөр бүр энэ эрхийнхээ төлөө тэмцэлд нэгдсэнээр амь нас, сэтгэл санаа, бие махбод, эд хөрөнгийн хохирлыг амссаар байна. Түүнчлэн олон сая хүн эх орноо орхин, амь насаараа дэнчин тавьж, дүрвэн цагаачлах замыг сонгож байна.

Олон улсын хүний эрхийн дээрх байгууллагууд нь аливаа улсын засгийн эрх баригчдаас хараат бусаар, тэдний нөлөөнд автахгүйгээр, дэлхийн улс орнууд дахь өөрийн салбар байгууллагуудаар дамжуулан үнэн бодит мэдээ, мэдээлэлд тулгуурлан ажилладаг тул НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын жилийн ажлын тайлан[47], НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн 50-р хуралдааны тайлан[48] болон Дэлхий даяарх хүний эрх хамгаалагчдын хөдөлгөөн болох Эмнести Интернэшнл (Amnesty International)[49], Human Rights Watch[50], Freedom House[51] зэрэг байгууллагуудын өмнөх оны тайланд үндэслэн дэлхий дахины хүний эрхийн төлөв байдал, улс орнууд дахь хүний эрхийн зөрчил, улс төрийн хэлмэгдүүлэлтийн өнөөгийн нөхцөл байдлын талаар авч үзлээ.

Улс орнуудын засгийн газрууд иргэнийхээ эрхэнд хэрхэн халдаж буй хууль бус үйл ажиллагааг тоймловол, улс төрийн эрхээ эдлэн эрх баригчдыг шүүмжилсэн, жагсаал цуглаан зохион байгуулсан болон оролцсон энгийн иргэд, сэтгүүлч, шүүмжлэгч, хүний эрх хамгаалагчдыг хууль бусаар саатуулах, барьж хорих, залхаан цээрлүүлэх, эрүүдэн шүүх, хилс хэрэгт гүтгэн ял оноох, бүр цаашлаад ор сураггүй алга болгох, цаазлах зэрэг хууль бус үйлдлүүд эрх баригчдын зүгээс үйлдэгдсээр байна. Түүнчлэн хүний эрхийн төлөө тэмцэгч төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, интернэт, нийгмийн сүлжээг хаах зэрэг иргэний орон зайд хууль бусаар халдсан үйлдлүүд дэлхийн олон оронд гарчээ.

Эмнести Интернэшнлийн “2021/22 оны Дэлхий дахины хүний эрхийн төлөв байдлын тайлан” [52]-д дэлхийн 154 улсыг хамруулан тэдгээр улсад хүний эрх хэрхэн зөрчигдөж байгаа талаар баримттай дурдсан байна.

Тухайлбал, 2021 онд засгийн газрууд аюулгүй байдлыг хангах нэрээр иргэний орон зайг хумих, тайван жагсаал цуглааныг гэмт хэрэгт тооцох, цагдаагийн байгууллагыг цэрэгжүүлэх, эсэргүүцлийн хөдөлгөөний эсрэг үндэсний аюулгүй байдлын эрх мэдлийг ашиглах зэргээр жагсаал цуглааныг нухчин дарах хандлага нэмэгдсэн байна.

Жагсаал цуглааны эсрэг аюулгүй байдлын хүчнийхний авч буй хариу арга хэмжээ харгис хатуу, жагсагчдын эсрэг шаардлагагүй, хэт их хүч хэрэглэсэн тохиолдлыг мониторинг хийхэд 154 орны 85-д[53] Аюулгүй байдлын хүчнийхэн галт зэвсэг болон нулимс асгаруулагч хий, резинэн сум зэрэг хөнөөл багатай бусад зэвсгийг байнга зүй бусаар ашиглаж, олон зуун хүнийг хууль бусаар хөнөөж, түүнээс ч олон хүнийг шархдуулсан байна. Зарим оронд

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[47] https://www.universal-rights.org/blog/report-on-the-50th-session-of-the-human-rights-council/
[48] https://www.universal-rights.org/blog/report-on-the-50th-session-of-the-human-rights-council/
[49] https://www.amnesty.mn/media/attachments/2022/04/08/20220406_delhiin-tailan-2022-for-web-2.pdf
[50] https://www.hrw.org/world-report/2022
[51] https://freedomhouse.org/sites/default/files/2021-02/FIW2021_World_02252021_FINAL-web-upload.pdf
[52] https://www.amnesty.mn/media/attachments/2022/04/08/20220406_delhiin-tailan-2022-for-web-2.pdf
[53]https://www.amnesty.org/en/documents/pol10/4870/2022/en/#:~:text=The%20Amnesty%20International%20Report%202021,in%20the%20corridors%20of%20power.

жагсаал цуглааны эсрэг төрийн хариу арга хэмжээг зэвсэгт хүчин, цэргийн техник хэрэгслийг ашиглах зэргээр цэрэгжүүлэх хандлага нэлээд газар авчээ.

Зарим улс орнууд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарласан шинэ хуулийн төслийг боловсруулж, өргөн барьсан байна. Тодруулбал, 67 улсад тийм хууль тогтоомжийг парламентаар баталсан байна.

Засгийн газрууд баривчлах, шүүн таслах ажиллагаагаа үргэлжлүүлсээр байсан бөгөөд жагсаал цуглааныг удирдагчид, оролцогчдыг тодорхойлохын тулд царай таних болон мөшгин хянах бусад хэлбэрийг агуулсан технологийн арга хэрэгслийг түлхүү ашиглах болсон байна.

Мөн шүүмжлэлт дуу хоолойг нухчин дарах хандлагаа хадгалсаар байсан бөгөөд олон улс орны засгийн газар өөрсдийг нь шүүмжлэгчдийг залхаан цээрлүүлэх арга хэмжээг хоёр дахин нэмэгдүүлжээ. Эдгээр арга хэмжээний ихэнх нь “Ковид-19 цар тахлын талаар нийгэмд ташаа мэдээлэл тараахыг зогсоох” нэрийдлээр хийгдсэн байна. Дэлхийн зарим улс орон иргэдийнхээ тайван жагсаал цуглааныг үндэслэлгүйгээр хориглон тарааж байсан ба ингэхдээ Ковид-19-ийн тархалтаас урьдчилан сэргийлэх дүрэм журмыг шалтаг болгож байжээ. Үүний зэрэгцээ, Ковид-19-тэй тэмцэх зорилготойгоор 2020 онд авч хэрэгжүүлсэн хязгаарлалтын арга хэмжээнүүдээ нийгмийн эрүүл мэндийн нөхцөл байдал сайжирсан ч хэвээр хадгалж үлджээ.

Зарим улс орнууд хүний эрхийн төрийн бус байгууллагууд болон хүний эрхийг хамгаалсан хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаах зэрэг алхмуудыг хийсэн байна, тухайлбал, Афганистанд талибанчууд засгийн эрхийг авсны дараа улс даяар 200 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгслийг хаажээ. Мөн засгийн газрууд сэтгүүлч, хүний эрх хамгаалагч, улс төрийн өрсөлдөгчид болон бусад шүүмжлэлт дуу хоолойг барихын тулд тагнах программ, технологийн хэрэгслийг улам ихээр ашиглах болжээ. Цөөнхийн бүлгүүд болон өөрөөр сэтгэгчид рүү төрийн бус тоглогчид халдан, заримдаа зэвсэгт халдлага хийх, зарим үед улс орнуудын эрх баригчидтай хамтран халдлага үйлдэж байсан байна.

Дэлхий даяар олон сая хүн мөргөлдөөн, хүчирхийлэл, тэгш бус байдал зэргээс үүдэлтэй хүний эрхийн зөрчлийн улмаас эх орноосоо дүрвэсээр байгаа бөгөөд үндэстний цөөнхүүд үүнд хамгийн ихээр өртжээ. 2021 оны дунд гэхэд дэлхий даяар 26.6 сая дүрвэгч, 4.4 сая orогнол хүсэгч байсан байна.

Энэ мэтчилэн хүний улс төрийн эрхийн зөрчил гарч, улс төрийн хэлмэгдүүлэлт үйлдэгдсээр байгаа өнөөгийн нөхцөлд дээрх хүний эрхийн байгууллагаас улс орнуудын засгийн газарт хандан дараах зөвлөмжийг гаргасан байна. Үүнд:

- Засгийн газрууд хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг гутаан доромжилж, гэмт хэрэгт тооцохын оронд тэдний гүйцэтгэдэг нэн чухал үүргийг хүлээн зөвшөөрөх;
- Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хэрэгжүүлэх орон зайг янз бүрийн шалтагт үндэслэсэн, төрийн халдлагаас хамгаалах;
- Улс орнууд мөшгин хяналтын нийгэм рүү халтирч буйг зогсоож, хууль дээдлэх ёсыг хүндэтгэж, шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах явдлыг таслан зогсоох.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## <u>ХОЁР. ГАДААДЫН ЗАРИМ УЛС ОРНУУДЫН ЦАГААТГАЛЫН БАЙГУУЛЛАГА</u>

Судалгааны захиалгын дагуу манай улстай ижил төстэй цагаатгалын байгууллага бүхий улс орнууд болох ОХУ, Болгар, Гүрж, Казахстан улсууд болон дайны үеийн хэлмэгдүүлэлтэд

өртсөн Өмнөд Солонгос Улсын цагаатгах байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хууль эрх зүйн орчны талаар авч үзлээ.

Судалгаанд авагдсан улс орнуудад тухайлбал, Орос, Казахстан, Болгар болон Гүрж улсын цагаатгалын байгууллагын анх байгуулагдсан зорилго нь Монгол Улстай ижил буюу тухайн коммунист дэглэмийн үед улс төрийн хилс хэрэгт гүтгэгдэн шийтгэгдэж, хэлмэгдсэн иргэд эрх бүхий байгууллагаар гэм буруугүй нь тогтоогдсон тохиолдолд тэдгээр иргэдийг цагаатгах, нэр төрийг нь сэргээх, тэдгээрийн болон тэдний өв залгамжлагчдын хохирлыг барагдуулах, нөхөн олговор олгох асуудлыг шийдвэрлэх зэрэг үндсэн зорилготой байгуулагдсанаараа нийтлэг байна. Мөн цагаатгалын байгууллагын бүтэц, үйл ажиллагааны хувьд ЗХУ-ын харьяанд болон нөлөөнд байсан улс орнуудад (ОХУ, Казахстан, Болгар) төрийн статустай байгаа бөгөөд төв комисс болон салбар комиссуудаараа дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

***Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс анх байгуулагдсан талаар***

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн холбогдолтой асуудлыг төрийн нэрийн өмнөөс эргэн харж, нягтлан судлах, тэднийг цагаатгах ажил 1939 он, 1957-1962 он, 1988 онд тэр үеийн улс орныг (төрийг) удирдаж байсан МАХН-ын Төв хорооны шийдвэрээр хэсэгчилсэн байдлаар хийгдэж байсан бол 1990 оноос хойш Монгол Улсын төрийн хууль, шийдвэрийн дагуу уг ажил зохицуулагддаг болсон байна. 1990-12-25-ны өдөр БНМАУ-ын Ерөнхийлөгч П.Очирбат “Комисс байгуулах тухай” 56 дугаар зарлиг гаргаж 30, 40, 50-аад оны эхэн үед улс төрийн хилс хэрэгт татагдаж, хэлмэгдсэн хүмүүсийн асуудлыг үргэлжлүүлэн судалж, цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссыг байгуулсан байна.[54] 1998-01-02-ны өдөр Монгол Улсын Их Хурал “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хууль”-ийг баталжээ. Тус хуулийн 5 дугаар зүйлд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг тодорхойлсон байна.

5.1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд дор дурдсан хүмүүс хамаарна:

5.1.1.шүүх, шүүхийг орлон ажилласан тусгай комисс, онцгой бүрэн эрхт комиссын шийдвэрээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн дор дурдсан зүйл ангид заасан гэмт хэрэгт хилсээр ял шийтгүүлсэн нь шүүхийн журмаар тогтоогдсон;

а/1922-1926 он /"Шүүх цаазны бичиг" гарах хүртэл хугацаа/-д эрүүгийн ял шийтгэлийг шинэчлэн тогтоосон болон хэрэглэсэн Ардын Засгийн газрын тогтоолууд;

б/1926 оны "Шүүх цаазны бичиг" /1929 онд нэмэн найруулсан/-ийн 7 дугаар бүлгийн 42-49 дүгээр зүйл; 8 дугаар бүлгийн 50-52 дугаар зүйл;

в/1934 оны "Шүүх цаазны бичиг"-ийн тусгай ангийн 1 дүгээр бүлгийн 42-50 дугаар зүйл; БНМАУ-ын Ардын СнЗ-ийн 1938 онд 1 дүгээр бүлэгт оруулсан нэмэлт, өөрчлөлт;

г/1942 оны "Эрүүгийн хууль"-ийн 55-69, 137 дугаар зүйл;

д/1961 оны "Эрүүгийн хууль"-ийн тусгай ангийн нэгдүгээр бүлгийн 45-52, 53-55, 57 дугаар зүйл.

5.1.2.ял шийтгүүлээгүй боловч энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан хэрэгт хилсээр холбогдон баривчлагдаж мөрдөгдсөн нь прокурорын тогтоолоор нотлогдсон;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[54] Монгол Улсын цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс Түүхэн товчоон УБ, 2015 он.

5.1.3.шүүх, тусгай болон онцгой бүрэн эрхт комиссоор хэлэлцэн шийдвэрлээгүй боловч улс төр, үзэл суртлын шалтгаанаар тухайн үеийн нам, төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр ажил, албан тушаалаасаа хууль бусаар халагдсан нь шүүхийн журмаар тогтоогдсон.” гэжээ.

Мөн хуулийн 24.2-т “Улсын комисс нь улс төрийн хэлмэгдэгчдийг цагаатгах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг нь хангуулах чиг үүрэг бүхий төрийн орон тооны бус байгууллага мөн” гэж заажээ.[55]

## 2.1.ОХУ

Оросын Холбооны Улс (ОХУ)-д улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг 1991 онд батлагдсан “Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай” хууль[56], ОХУ-ын Засгийн газрын “Улс төрийн хэлмэгдүүлэлтийн явцад иргэдээс хууль бусаар хураасан болон өөр замаар тэдний өмчлөлөөс гаргасан хөрөнгийг буцаан олгох, үнийг нөхөн төлөх, мөнгөн төлбөр төлөх журам”[57] болон бусад хууль, эрх зүйн актаар[58] зохицуулдаг.

“Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай” хуулиар 1917 оны 10 дугаар сарын 25-ны (11 дүгээр сарын 7) өдрөөс эхлэн ОХУ-ын нутаг дэвсгэр дээр улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах, тэдний иргэний эрхийг сэргээх, бусад сөрөг үр дагаврыг арилгах, эд материалын хохирлыг тухайн үеийн боломжийн хэрээр нөхөн төлөх зорилтыг тодорхойлсон.

Тус хуулийн дагуу улс төрийн хэлмэгдүүлэлтэд шууд өртсөн хохирогчдоос гадна тэдэнтэй хамт шорон, цөллөгт байсан тэдний хүүхдүүд, хэлмэгдүүлэлтийн улмаас бага насандаа эцэг, эхгүй өссөн хүүхдүүд, улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирсон ОХУ-ын иргэдээс гадна хуучин ЗХУ-ын Бүгд Найрамдах Улсуудын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй иргэдийг хэлмэгдүүлэлтэд өртсөнд тооцож, цагаатгахаар заасан.

Мөн буудуулсан, шоронд нас барсан, нөхөн цагаатгагдсан иргэдийн эхнэр (нөхөр), хүүхдүүд, эцэг, эх нь улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирсонд тооцогдоно.

**Цагаатгал:** “Улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирогчдыг цагаатгах тухай” хуульд улс төрийн хэлмэгдүүлэлтэд хохирсон иргэдийг цагаатгах журмыг хуульчилсан. Цагаатгуулах тухай өргөдлийг хэлмэгдэгсэд өөрсдөө болон тэдний өмнөөс хэн ч, тухайлбал, олон нийтийн байгууллага гаргаж болох ба хэргийн хамаарлаас шалтгаалан[59] Дотоод хэргийн Яамны болон прокурорын байгууллагад гаргана. Цагаатгуулах тухай өргөдлийг 3 сарын дотор хянан үзэж хариу өгөх ёстой.

Иргэд, байгууллагын өргөдлийн дагуу хэргийг хянан үзэж тухайн иргэнийг цөлсөн, албадан нүүлгэсэн, тусгай лагерьт явуулсан, эрх чөлөөг нь хязгаарлан албадан хөдөлмөрлүүлсэн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[55] https://legalinfo.mn/mn/detail/510
[56] ФЗ ”О реабилитации жертв политических репрессий”. http://base.garant.ru
[57] “Положение о порядке возврата гражданам незаконно конфискованного, изьятого или вышедшего иным путем из владения в связи с политическими репрессиями имущества, возмещения его стоимости или выплаты денежной компенсации.” http://www.zakonprost.ru
[58] Указ Президента РФ от 8 июня 1996 г. N 858 "О дополнительных мерах по реабилитации лиц, репрессированных в связи с участием в событиях в г. Новочеркасске в июне 1962 г.", Об организации деятельности органов прокуратуры по исполнению и надзору за исполнением настоящего Закона см. приказ Генеральной прокуратуры РФ от 5 февраля 2008 г. N 21. http://base.garant.ru
[59] Хэлмэгдүүлэлт шүүхийн ба шүүхийн бус байгууллагын шийдвэрийн дагуу явагдсан бол прокурорын байгууллагад, харин захиргааны байгууллагын шийдвэрийн дагуу явагдсан бол Дотоод хэргийн яамны байгууллагад өргөдлийг гаргана.

захиргааны хэргийг Дотоод хэргийн Яам, эрүүгийн хэрэг үүсгэн ялласан хэргийг хянан үзэж прокурорын байгууллага цагаатгасан тухай тодорхойлолт, эсхүл ийм тодорхойлолт олгохыг татгалзсан хариу өгнө.

Улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртөж цагаатгагдсан тухай, эсхүл улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогч болсон тухай тодорхойлолт олгохыг татгалзсан зохих байгууллагын шийдвэрийг эсэргүүцэн хуулийн дагуу[60] шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Тус хуулийн дагуу цагаатгагдсан иргэдийн нийгэм-улс төр, иргэний эрх, цэргийн, тусгай цолыг сэргээж, төр, засгийн шагналуудыг нь буцаан олгож, нийгмийн тусламж, дэмжлэг үзүүлж, нөхөн олговор олгоно.

Энэ тухай шийдвэрийг ОХУ-ын субъектүүдийн гүйцэтгэх засаглалын байгууллага, нутгийн удирдлагын байгууллага нь *Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэн цагаатгагдсан иргэдийн эрхийг сэргээх комисс*[61]-ын дүгнэлтийг үндэслэн гаргана.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах комисс**

Тус комиссыг "Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах тухай" хуультай холбогдох хүний болон иргэний эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулах Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Ерөнхийлөгчид туслах зорилгоор ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1992 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 1509 дүгээр зарлигаар анх байгуулжээ.[62]

Улмаар 1995 онд үйл ажиллагааг нь өргөтгөж, 1997 онд бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулсан зарлигууд гаргаж байсан бол 2004 оны 08-р сарын 25-ны өдрийн ОХУ-ын Ерөнхийлөгчийн 1113 дугаар зарлигаар "Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах комиссын тухай"[63] журмыг баталжээ.

Журамд зааснаар ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах комисс (цаашид "Комисс" гэх) нь 1991 оны 10 дугаар сарын 18-наас эхлэн хэрэгжсэн "Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах тухай" ОХУ-ын 1761-1 дүгээр хуультай холбогдох хүний болон иргэний эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулах Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Ерөнхийлөгчид зөвлөх байгууллага юм. Комисс нь өөрийн үйл ажиллагаандаа ОХУ-ын Үндсэн хууль, холбооны хууль тогтоомжууд, ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг, тушаал, мөн энэхүү журмыг баримтална.

*<u>Комиссын эрх, үүрэг</u>*

Комисс нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

a) "Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах тухай" ОХУ-ын хуультай холбогдох хүний болон иргэний эрх, эрх чөлөөг ханган баталгаажуулахад ОХУ-ын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ бодитой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэлдүүлэх;

b) Улс төрийн хэлмэгдүүлэлтийг судлах, шинжлэн дүгнэж үнэлэх;

c) Холбооны байгууллагуудад улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах ажилтай холбоотойгоор гүйцэтгэх эрх мэдлээ хэрэгжүүлэхэд нь үйл ажиллагааг уялдуулан

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[60] ФЗ "Об обжаловании в суд действий и решений, нарушающих права и свободы граждан". http://base.garant.ru
[61] Тус Комисс нь ОХУ-ын Ерөнхийлөгчийн Зарлигаар ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэд 2004 онд байгуулагдсан. 2010 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс ОХУ-ын Ерөнхийлөгчийн иргэд, байгууллагын өргөдөл, хүсэлтийг хүлээн авах Алба болсон. http://state.kremlin.ru/commission/25/statute
[62] http://kremlin.ru/structure/commissions
[63] https://www.prlib.ru/en/node/354156

зохицуулах;

d) ОХУ-ын улс төрийн талаар хэлмэгдсэн иргэдэд эрхээ сэргээхэд нь арга зүйн тусламж үзүүлэх;

e) Улс төрийн хэлмэгдүүлэлтийн төлөв байдал, тархалтын талаар тогтоосон журмын дагуу олон нийтэд мэдээлэл хийх;

f) Комиссын асуудал, үйл ажиллагааны талаар ОХУ-ын Ерөнхийлөгчид илтгэл тайлан бэлтгэх.

Комисс нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд дараах эрхийг эдэлнэ:

a) Төрийн байгууллагуудаас улс төрийн талаар хэлмэгдэгчийг цагаатгахтай холбоотой албан ёсны бичиг баримтыг шаардан авах;

b) Тусгай ажлыг гүйцэтгэхэд шинжээч, тусгай мэргэжилтнүүдийг гэрээгээр татан оролцуулах.

*Комиссын бүтэц, бүрэлдэхүүн*

Комисс нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Комиссын даргыг ОХУ-ын Ерөнхийлөгч томилно. Комиссын бүрэлдэхүүнийг комиссын даргын санал болгосноор ОХУ-ын Ерөнхийлөгчийн захиргааны дарга (тамгын газрын дарга) батална. Одоогийн байдлаар дарга, нарийн бичгийн дарга, 15 гишүүдээс бүрдэж байна.[64] Гишүүдэд төр захиргааны болон олон нийтийн байгууллагын удирдлага, архив, судалгаа шинжилгээний байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, хэлмэгдэгчдийн төлөөлөл зэрэг ордог байна.

Комиссын дарга нь:

- Комиссын ажлыг удирдана. Комиссын ажлын үр дүнгийн талаар ОХУ-ын Ерөнхийлөгчид шууд илтгэн танилцуулах эрхтэй.
- ОХУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын нэрийн өмнөөс шинжлэх ухааны байгууллага, мэргэжилтнүүдтэй Комиссын харьяалах асуудлаар ажил гүйцэтгэх гэрээ байгуулах тухай санал тавих.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын иргэд, байгууллагын өргөдөл, хүсэлтийг хүлээн авах алба нь Комиссын үйл ажиллагааны техник зохион байгуулалтыг ханган ажилладаг.

## 2.2.КАЗАХСТАН УЛС

Казахстан Улс нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох асуудлыг зохицуулах хүрээнд 1993 онд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах тухай хууль”[65], 2003 онд “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдэд мөнгөн төлбөр олгох тухай журам”[66] тус тус гаргасан байна.

Эдгээр хууль эрх зүйн зохицуулалтаар улс төрийн хэлмэгдэгч гэдэг нь төрийн байгууллага, тэднийг төлөөлж буй албан тушаалтнаас улс төрийн шалтгаанаар иргэний амь насыг нь хохироох, эрх чөлөөг нь хасах, тэр дундаа цагдан хорих, сэтгэцийн эмнэлэгт албадан эмчлэх,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[64] http://kremlin.ru/structure/commissions#institution-25
[65] О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года) http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200.
[66] Об утверждении Правил выплаты денежных компенсаций жертвам массовых политических репрессий (Постановление Правительства Республики Казахстан от 23 января 2003 года N 82)- http://adilet.zan.kz/rus/docs/P030000082.

эх орноосоо хөөх, албадан нүүлгэн шилжүүлэх, цөлөх, албадан хөдөлмөр эрхлүүлэх, улс төрийн итгэл үнэмшил, анги, нийгэм, үндэсний, шашин шүтлэг болон бусад харьяаллаар шүүх, шүүхээс гадуур гүтгэгдэн шийтгэгдсэн хүмүүсийг хэлнэ.

Энэ хууль нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан аль ч улс оронд хилс хэргээр ял шийтгэл хүлээсэн бөгөөд одоо Казахстан улсын иргэний харьяалалд байгаа иргэдийн хувьд мөн адил үйлчилнэ.

Хуульд зааснаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, хэлмэгдсэн иргэд, тэдний гэр бүлд учруулсан сэтгэл зүйн болон материаллаг хохирлыг нөхөн төлөх арга хэмжээ авч, тэдний хязгаарлагдсан эрхийг буцаан сэргээсэн байна. Энэ хүрээнд хуульд дараах зохицуулалтуудыг оруулжээ.

**Хэлмэгдсэн иргэний хязгаарлагдсан эрхийг сэргээх. Үүнд:**

- Иргэнийг зохих журмын дагуу цагаатгасны дараа түүний хязгаарлагдсан эрх, гавьяа шагнал, цэргийн болон бусад цол хэргэмийг сэргээх. Хэрэв иргэний хэрэг бүхэлдээ биш, зөвхөн нэг хэсэг нь цагаатгагдсан бол түүнтэй холбоо бүхий хязгаарлагдсан эрхүүдийг сэргээнэ;[67]
- Иргэнийг амьдарч байсан газраас өөр газар нутагт албадан шилжүүлсэн, цөллөгт явуулсан бөгөөд үүнд тухайн үед түүнтэй хамт амьдарч байсан гэр бүлийн гишүүд, хамаатан садан мөн адил өртсөн бол хэлмэгдсэн иргэн болон түүнтэй хамаарал бүхий эдгээр хүмүүсийн өмнө амьдарч байсан газар нутаг руу буцах эрхийг сэргээх;[68]
- Иргэн байх эрх нь хасагдсан хүний харьяатын эрхийг сэргээх зэрэг орно.

Хуулийн 11-р бүлэгт зааснаар Цагаатгуулах тухай өргөдлийг хэлмэгдэгсэд өөрсдөө, түүнчлэн шүүхийн журмаар хэлмэгдүүлэлт хийх шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны оршин суугаа газар дахь аливаа этгээд, сонирхогч олон нийтийн холбооноос хэлмэгдүүлэлтийг шүүхийн журмаар шийдвэрлүүлэхээр прокурор, холбогдох захиргааны байгууллага - дотоод хэрэг эсвэл үндэсний аюулгүй байдлын байгууллагад зохих журмын дагуу гаргана. Цагаатгуулах тухай өргөдлийг 3 сарын дотор хянан үзэж хариу өгөх ёстой.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг бүрэн цагаатгах улсын комисс**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах асуудлыг цогцоор нь судалж, шийдвэрлэх зорилгоор Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКазУ)-ын Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 456 дугаар зарлигаар **"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг бүрэн цагаатгах улсын комисс"**-ын тухай журмыг[69] баталжээ.

Уг журамд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг бүрэн цагаатгах улсын комиссын бүрэлдэхүүн, статус, чиг үүрэг, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар зохицуулсан байна.

Журамд зааснаар Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг бүрэн цагаатгах улсын комисс (цаашид Улсын комисс гэх) нь Бүгд Найрамдах Казахстан Улс (БНКазУ)-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх зөвлөх байгууллага юм.

UIH MN
СУДАЛГААНЫ САН

[67] О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года). Статья 19-http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200

[68] О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993

[69] О Государственной комиссии по полной реабилитации жертв политических репрессий Указ Президента Республики Казахстан от 24 ноября 2020 года № 456. https://adilet.zan.kz/rus/docs/U2000000456#z12

Бүтэц, бүрэлдэхүүн: Улсын комисс нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Улсын комиссын дарга нь БНКазУ-ын Төрийн нарийн бичгийн дарга байна. Улсын комиссын бүрэлдэхүүнийг төрийн байгууллагын дарга, олон нийтийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачдаас бүрдүүлнэ. Тухайлбал, одоогийн Улсын комиссын бүрэлдэхүүн нь:

- БНКазУ-ын Төрийн нарийн бичгийн дарга, Улсын комиссын дарга
- БНКазУ-ын Шадар сайд, Улсын комиссын орлогч дарга
- Нур Отан намын Тэргүүн дэд дарга, Улсын комиссын дэд дарга (тохиролцсоноор)
- БНКазУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын нэгдүгээр орлогч дарга, Улсын комиссын орлогч дарга
- БНКазУ-ын Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд, Улсын комиссын нарийн бичгийн дарга

*Улсын комиссын гишүүдэд:*

- Ерөнхийлөгчийн Тамгын газрын орлогч дарга
- Парламентын Сенатын депутат
- Парламентын Мажилисын депутат
- Ерөнхийлөгчийн туслах - БНКазУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газрын Иргэдийн өргөдөл, хүсэлтийг хянан шийдвэрлэх хэлтсийн дарга
- Батлан хамгаалахын сайд
- Дотоод хэргийн сайд
- Мэдээлэл, нийгмийн хөгжлийн сайд
- Хууль зүйн сайд
- Боловсрол, шинжлэх ухааны сайд
- Соёл, спортын сайд
- Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн шүүх бүрэлдэхүүний дарга
- Ерөнхий прокурорын нэгдүгээр орлогч
- Үндэсний аюулгүй байдлын хорооны орлогч дарга
- Гадаад хэргийн дэд сайд
- Хөдөлмөр, хүн ам, нийгмийн хамгааллын дэд сайд
- Улс төрийн их хэлмэгдүүлэлтэнд хэлмэгдэгсдийн нийгэмлэгийн ерөнхийлөгч
- Төрийн түүхийн хүрээлэнгийн дэд захирал болон их дээд сургууль, музей, хүрээлэнгийн захирал, эрдэмтэн, академич зэрэг **44 гишүүнээс** бүрдэж байна.[70]

Улсын комиссын үйл ажиллагаанд комиссын даргын шийдвэрээр холбогдох салбарын мэргэжилтэн, бусад этгээдийг оролцуулж болно.

**Улсын комиссын ажлын алба** нь БНКазУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яам байна.

**Төрийн болон орон нутгийн гүйцэтгэх төв байгууллага** нь Улсын комиссын үйл ажиллагаанд өөрийн эрх хэмжээний хүрээнд туслалцаа үзүүлнэ.

Чиг үүрэг, бүрэн эрх: Улсын комиссын үндсэн чиг үүрэг нь улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг хууль эрх зүйн үүднээс цагаатгах, нэр төрийг нь сэргээх явдал юм. Улсын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

[70] https://adilet.zan.kz/rus/docs/U2000000456#z12

UIH.MN СУДАЛГААНЫ САН

1) улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүсийн нэр хүнд, үйл хэргийг сэргээх, бүх төрлийн хэлмэгдэгсдийг цагаатгах ажлыг дуусгах санал боловсруулах;
2) улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг бүрэн цагаатгах хууль эрх зүйн актыг боловсруулах талаар санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;
3) Казахстанд улс төрийн хэлмэгдүүлэлтийн бодитоор цагаатгагдаагүй хохирогчдын ангиллын жагсаалтыг бүрдүүлэх; (үүнд: одоогийн хууль тогтоомжид хамрагдаагүй хохирогчдын ангилал; хууль тогтоомжид заасан боловч бодитоор цагаатгагдаагүй хохирогчдын ангилал)
4) зөвхөн хууль эрх зүйн төдийгүй улс төрийн нөхөн сэргээлтэд хамрагдах хэлмэгдүүлэлтийн хохирогчдын ангиллын жагсаалтыг бүрдүүлэх;
5) хэлмэгдэгсдийг цагаатгах төрийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, цагаатгаагүй хүмүүсийн эрхийг сэргээх тухай өргөдөл, гомдлыг хэлэлцэх;
6) Казахстаны эрх чөлөө, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө тэмцэлд баатарлаг гавьяа байгуулсан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх Төрийн хөтөлбөрийг боловсруулж, батлуулах талаар санал боловсруулж, өргөн мэдүүлэх.

*Улсын комисс өөрийн чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:*

1) Казахстаны эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэгчдийн эр зориг, баатарлаг үйлсийг алдаршуулах, улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгахтай холбоотой асуудлаар эрх зүйн акт боловсруулах санал, зөвлөмж гаргах;
2) төрөл бүрийн хэлбэрээр хэлмэгдэгсдийг цагаатгах аргачлал боловсруулах дэд хороо, тэдгээрийн үйл ажиллагааны талаар санал гаргах ажлын хэсэг байгуулах;
3) Улсын комиссын бүрэн эрхэд хамаарах асуудлаар төрийн байгууллага, олон нийтийн холбоо, бусад байгууллага, иргэдийн саналыг хэлэлцэх;
4) Улсын комиссын үйл ажиллагааны талаар төрийн байгууллагын дарга, бусад албан тушаалтныг сонсох;
5) Улсын комиссын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримт, материалыг төрийн байгууллага, бусад байгууллагаас шаардах, хүлээн авах;
6) Улсын комиссын чиг үүрэгтэй холбоотой бусад арга хэмжээг хэрэгжүүлэх.

Улсын комиссын үйл ажиллагаа нь түүний хуралдаан, дэд хороодын хуралдаан, ажлын хэсгийн хуралдаан болон бусад арга хэмжээг зохион байгуулах явдал юм. Улсын комиссын хуралдааныг зургаан сард нэгээс доошгүй удаа хийнэ. Улсын комиссын шийдвэрийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Улсын комиссын гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргалагчийн санал шийдвэрлэх үүрэгтэй. Хуралдаанаар Улсын комиссын чиг үүрэг, үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх ажлын хэсгүүдийн тайланг хэлэлцдэг. Мөн хуралдаанд Улсын комиссын гишүүн бус албан тушаалтан, түүнчлэн олон нийтийн байгууллага, хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийг урьж оролцуулж болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**2.3.БОЛГАР УЛС**

Бүгд Найрамдах Болгар Улс (Болгар Улс)-д улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах ажлыг Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах улсын төв комисс (Central

Commission on Political and Civil Vindication), орон нутаг дахь салбар комиссуудаараа дамжуулан хэрэгжүүлж байна. Комисс нь Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах тухай хууль (Political and Civil Vindication Act for Individuals who have undergone Repressive action)[71] болон Сайд нарын зөвлөлийн тогтоолоор баталсан тухайн хуулийг хэрэгжүүлэх журмын эрх, үүргийн хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг байна.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах тухай хууль**

Улс төрийн хэрэгт нийгмийн гарал, үндэс угсаа, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан 1944 оны 09 дүгээр сарын 12-ноос 1989 оны 11 дүгээр сарын 10-ныг хүртэлх хугацаанд улс төрийн хилс хэрэгт хууль бусаар холбогдуулж хэлмэгдүүлсэн иргэдийг цагаатгаж нэр төрийг нь сэргээх, нөхөн олговор олгох харилцааг зохицуулахад хуулийн зорилго оршино. Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Сайд нарын зөвлөлийн тогтоолоор журам батлагдсан байна.

Дараах хүмүүсийг хэлмэгдсэн гэж үзнэ:

1. 1944-1945 онд Ардын шүүхээс эрүүгийн гэмт хэрэгт хилсээр ял шийтгүүлсэн болон цаазлагдсан;
2. Дотоод явдлын яам, харьяа байгууллагуудад хилсээр баригдан, хоригдсон;
3. Ял шийтгүүлээгүй боловч хууль бусаар хилс хэрэгт холбогдон баривчлагдаж хөдөлмөрийн лагерь бусад газар хоригдсон;
4. Тухайн үеийн захиргааны шийдвэрээр нутаг заагдсан, эд хөрөнгөө хураалгасан;
5. Ажил албан тушаал, дунд сургууль болон их, дээд сургуулиас хөөгдсөн;
6. Хэлмэгдэгчтэй хамаарал бүхий этгээд гэж хүчээр тулгасан;
7. Баривчлагдан сураггүй алга болсон.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, нөхөн олговор олгох**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэж үзэж байгаа этгээд өөрөө буюу гэр бүлийн аль нэг гишүүн, хууль ёсны төлөөлөгч, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах улсын төв комисс, түүний орон нутгийн салбарт цагаатгуулах, нөхөн олговор авах хүсэлт гаргана.

Сайд нарын зөвлөлөөс гомдол, саналыг үндэслэн журмын дагуу холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах, эсхүл ял шийтгүүлсэн нь тогтоогдоогүй бол гомдлыг хэрэгсэхгүй болгох шийдвэрийг гаргана.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдэд олгох нөхөн олговрыг дор дурдсан этгээд нэхэмжлэх эрхтэй.**

Дараах хэлмэгдэгсэд, тэдгээрийн өв залгамжлагчид нэг удаагийн болон тодорхой хугацаанд сар бүр олгогдох хэлмэгдэгсдийн нөхөн олговор авах эрхтэй байна.

1951 оны 03 дугаар сарын 12-ныг хүртэл Ардын эрхийг хамгаалах тухай хуулийн I, II бүлгийн дагуу ял шийтгэгдсэн, 1968 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Эрүүгийн хуулийн Бүгд Найрамдах Улсын эсрэг үйлдсэн гэмт хэрэг-I бүлгийн дагуу ял шийтгэгдэн өршөөгдсөн, 1990 оны 06 дугаар сард хилс хэргээр шоронд ял эдлээд суллагдсан болон ял эдлэж байгаад Өршөөлийн хуулийн I хэсгийн дагуу өршөөгдсөн, хөдөлмөрийн лагерь болон ижил төстэй

[71] http://www.proyectos.cchs.csic.es/transitionaljustice/sites/default/files/maps/info/personal-rehabilitation/bulgaria_vindication_act_1991.pdf

UIH.MN СУДАЛГААНЫ САН

бусад газар хилсээр хоригдсон, нутаг заагдан цөлөгдсөн, ажил албан тушаалаасаа халагдсан, дунд болон их, дээд сургуулиасаа төгсөх боломжгүйгээр хөөгдсөн зэрэг болно.

Өөрийн амссан хохиролдоо нөхөн олговор авалгүй нас барсан тохиолдолд нөхөн олговрыг тэдгээрийн өв залгамжлагчид-үр хүүхэд, эхнэр нөхөр, эцэг эхэд нь олгоно. Мөн түүнчлэн 1944 оны 09 дүгээр сараас хойш баривчлагдан, сураггүй алга болсон, хилсээр шийтгэгдэн цаазлуулсан хүмүүсийн эдийн бус (non-property) хохиролд тэдгээрийн өв залгамжлагчдад нь нэг удаагийн нөхөн олговор олгоно.

Хилсээр ял шийтгүүлж цаазын ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгсдийн гэр бүлийн гишүүдэд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах тухай тогтоол гарган, 60 мянган левийн нэг удаагийн нөхөн олговор олгоно.

Ял шийтгүүлээгүй боловч хууль бусаар хилс хэргээр холбогдон баривчлагдаж хөдөлмөрийн лагерь бусад газар хоригдсон хэлмэгдэгсэд, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд сар бүр 1500 лев олгох бөгөөд нөхөн олговрын хэмжээ 50 мянган левээс хэтрэхгүй,

Тухайн үеийн захиргааны шийдвэрээр нутаг заагдсан, эд хөрөнгөө хураалгасан нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангасан хэлмэгдэгсдэд сар бүр 800 лев олгох бөгөөд нөхөн олговрын хэмжээ 20 мянган левээс хэтрэхгүй,

Ажил албан тушаал, сургууль болон их, дээд сургуулиас хөөгдсөн нэхэмжлэлийн бүрдүүлбэрээ хангасан хэлмэгдэгсдэд 10 мянган левийн нөхөн олговор нэг удаа олгоно.

Нэхэмжлэлийг бичгээр гаргах бөгөөд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгч мөн болох нь хууль ёсоор тогтоогдсон эрх бүхий байгууллагын шийдвэр, цагаатгагдсан үнэмлэх, нөхөн олговрыг авах эрхтэй бусад гэр бүлийн гишүүдийн бичиг баримт, нөхөн олговрыг ямар хэлбэрээр авах тухай харилцан тохиролцсоныг батлах баримтыг тус тус хавсаргана.

Нөхөн олговрыг олгох тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дотор бэлэн мөнгөөр болон төлбөрийн бусад хэлбэрээр олгох бөгөөд Сангийн яамны сайд тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд багтаан тухай бүр нөхөн олговор олгох хэмжээг тогтоон, харьяа байгууллагаараа дамжуулан олгоно.

**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах комисс**

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах тухай хуульд заасны дагуу Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах улсын төв комисс, орон нутаг дахь салбар комиссууд нь хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

**Төв комисс**

Төв комисс нь дараах 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Гишүүдийг Ерөнхий сайдын шийдвэр (order)-ээр томилж, чөлөөлнө:

1. Дарга – Сайд нарын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга;
2. Дотоод явдлын яамны Нарийн бичгийн дарга;
3. Сангийн дэд сайд;
4. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд;
5. Хэлмэгдэгсдийн нийгэмлэгийн таван төлөөлөгч (үүнд хэлмэгдсэн иргэдийн төлөөлөл байж болно). Эдгээрээс Комиссын нарийн бичгийн даргыг томилно.

Хүсэлт гаргагч нь орон нутгийн салбар комиссын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд төв комисс руу хүсэлтээ илгээж болно. Төв комисс нь нотлох баримтыг судлан,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

шаардлагатай томиолдолд нэмэлт бүрдүүлбэр хийсний үндсэн дээр орон нутгийн салбар комиссын шийдвэрийг хэвээр үлдээх болон хүчингүй болгох эрхтэй.

Төв комиссын шийдвэрийг комиссын нийт гишүүдийн олонхын саналаар батална. Шийдвэр нь үнэн зөв нотолгоонд суурилсан байна. Төв комиссын шийдвэр нь эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг хүчингүй болгох, давж заалдах боломжгүй.

**Орон нутаг дахь комисс**

Төв комиссын шийдвэрээр Орон нутаг дахь салбар комиссын гишүүдийг томилно. Орон нутаг дахь салбар комисс нь дараах 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна:

1. Дарга – Орон нутгийн захирагч;
2. Дотоод явдлын яамны тухайн орон нутаг дахь салбарын төлөөлөгч;
3. Хэлмэгдэгсдийн нийгэмлэгийн гурван төлөөлөгч буюу хэлмэгдсэн иргэдийн төлөөлөл. Эдгээрээс Орон нутаг дахь комиссын нарийн бичгийн даргыг томилно.

Орон нутаг дахь комисс нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ мэргэжилтэн, шинжээчидтэй хамтран ажиллаж болно. Доод тал нь 3 гишүүний ирцтэйгээр хуралдах бөгөөд комиссын бүх гишүүдийн олонхын саналаар шийдвэрийг гаргана. Комиссын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд хүсэлт гаргагч нь 2 сарын дотор багтаан Төв комисст хүсэлтээ тавина.

## <u>2.4.ГҮРЖ УЛС</u>

Тус улсад хэлмэгдүүлэлтийн хохирогчийг тодорхойлохдоо ЗХУ-ын нутаг дэвсгэрт 1921 оны хоёрдугаар сараас 1990 оны 10 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл Зөвлөлтийн Улаан армийн дайралтаас эхлээд анхны чөлөөт, олон намын сонгууль хүртэлх хугацаанд улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдийг гэж заасан байдаг ба үүнийг шүүхээр тогтоодог байна.[72] Хэлмэгдүүлэлтийн талаарх хууль эрх зүйн зохицуулалтын давуу тал  нь хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүс төдийгүй тэдний гэр бүл, ойр дотны хүмүүс, хорих, албадан гаргахад хамт байсан хүмүүсийг хэлмэгдүүлэлтийн золиос болсон гэж хүлээн зөвшөөрдөг ба тухайн хүн нас барсан бол хамгийн ойрын өв залгамжлагч нь нөхөн төлбөр нэхэмжилж болдог байна.

Эрх зүйн орчинд хэлмэгдүүлэлтийн асуудлыг “Гүрж улсын иргэнийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогч гэж хүлээн зөвшөөрөх тухай, хэлмэгдэгсдийн нийгмийн хамгааллын тухай” (Law on the Acknowledgment of Citizens of Georgia as Victims of Political Repression and Social Protection of Repressed Persons)  болон  "1940-өөд онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Гүрж Улсаас ЗХУ-д албадан нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийг эх оронд нь буцаах тухай" (Law on the Repatriation of Persons Involuntarily Displaced by the Former USSR from the Georgian SSR (The Soviet Socialist Republic of Georgia) in the 1940’s) хуулиар зохицуулдаг.

**Хэлмэгдүүлэлтийн талаарх ойлголт, чиг хандлага**

Тус улсын түүхэнд явагдсан хэлмэгдүүлэлтийн үйл ажиллагааг тусгасан баримт бичгүүд, Зөвлөлтийн эсрэг үйл ажиллагаа явуулсан улс төрийн байгууллагуудын үүрсэн хэргийн талаарх мэдээллүүд устгагдсан байх магадлалтай, мөн энэ талаар хийгдсэн судалгаа ч хомс байдаг. Гүрж улс 2003 оноос ОХУ-д хадгалагдаж буй холбогдох материалыг эх хувь эсвэл хуулбараар нь буцааж авах хэлэлцээр хийсэн боловч 2008 онд хоёр улс дипломат

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[72] Rehabilitation of victims of political repressions in Georgia, Institute for Development of Freedom of Information http://open-archives.org/en/newsblogs/interestingnews/29

харилцаагаа тасалснаар энэ оролдлого бүтэлгүйтсэн юм.

Гэсэн хэдий ч Гүржийн парламент 2014 оны 10-р сарын 31-нд улс төрийн хэлмэгдэгсдийг тодорхойлохдоо хуучнаар ЗХУ-ын нутаг дэвсгэрт 1921 оны 02-р сараас 1990 оны 10-р сарын 28-ны өдрийг хүртэл Зөвлөлтийн Улаан армийн дайралтаас эхлээд анхны чөлөөт, олон намын сонгууль хүртэлх хугацаанд улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн иргэдийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогчид гэсэн байна. Мөн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Гүрж улсад, дараа нь тусгаар тогтносон Гүрж улсын нутаг дэвсгэрт хэлмэгдүүлэлтэд өртсөн хүмүүстэй хамт байсан эхнэр, нөхөр, хүүхэд (үрчлэгдсэн хүүхэд), эцэг эх болон бусад төрөл төрөгсдийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогч гэж хүлээн зөвшөөрсөн байна.

Хуулийн дагуу улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн хүний иргэний болон бусад эрх, эрх чөлөөг нь сэргээж, цэргийн болон бусад цол хэргэмийг нь сэргээн, улс төрийн хэлмэгдүүлэлтийн улмаас хураагдсан төрийн шагналд дүйцүүлэн нөхөн олговор олгодог байна.

**Цагаатгалын асуудал эрхэлдэг байгууллагууд**

Гүржийн цөөн тооны төрийн бус байгууллагууд Зөвлөлтийн хэлмэгдүүлэлт ба түүнтэй холбоотой цагаатгалын асуудлыг авч үздэг ба Мэдээллийн эрх чөлөөний хөгжлийн хүрээлэн (Institute for Development of Freedom of Information-IDFI), Гүржийн "Мемориал" нийгэмлэг, ЗХУ-ын өнгөрсөн үеийг судлах лаборатори (SovLab), Гүржийн залуу хуульчдын холбоо (GYLA-Georgian Young Lawyers’ Association ) зэрэг байгууллагууд Гүржийн Дотоод хэргийн яам, Гүрж дэх Швейцарын ЭСЯ-ны туслалцаатайгаар "Гүржийн талаарх Сталины жагсаалт" төслийг хэрэгжүүлсэн байна. Энэ төслөөр 1937-1938 оны их хэлмэгдүүлэлтийн үеэр Сталины шийдвэрээр ял шийтгүүлсэн Улс төрийн товчооны 3600 гишүүдийн товч намтрыг судалж гаргасан байна.

Гүржийн “Мемориал” нийгэмлэг нь 1992 онд байгуулагдсан ба улс төрийн хэлмэгдэгсдэд нөхөн олговор олгох, тэднийг дэмжих хуулиудыг яаралтай батлуулж, хэрэгжүүлэх тал дээр ажиллаж ирсэн. Мөн уг байгууллага нь хэлмэгдүүлэлттэй холбоотой Европын хүний эрхийн шүүхээс гаргасан нөхөн олговрыг барагдуулах, хэлмэгдсэн хүмүүст олгох тэтгэмжийг нэмэгдүүлэх тал дээр ажиллаж байна. Гүржид 1996 оны 10-р сарын 16-нд №430 дугаараар батлагдсан "Цэргийн байгууллага, дотоод хэрэг, төрийн тусгай хамгаалалтын албаны ажилтан ба гэр бүлийн гишүүдийн нийгмийн хамгааллын тухай" хуулиар Гүржид байнгын оршин сууж буй болон Гүржийн иргэншил бүхий төрийн тусгай албаны ажилчдад нөхөн олговор олгохоор баталсан. Гэхдээ энэ нь зарим талаар хэлмэгдүүлэлтийн үед цаазаар авах үйл ажиллагаанд оролцсон дотоод хэргийн ажилтнууд хэлмэгдэгсдийн үр садаас илүү тэтгэмж олгох нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

**Хууль эрх зүйн зохицуулалт**

Хэлмэгдүүлэлтийн асуудалд холбогдох хуулийг Гүржид анх 1997 онд баталсан ба энэ нь "Гүржийн иргэнийг улс төрийн хэлмэгдүүлэлтийн хохирогч гэж хүлээн зөвшөөрөх тухай, хэлмэгдэгсдийн нийгмийн хамгааллын тухай" хууль юм.[73] Энэ хуулийн 2 дугаар зүйлд “Амь насыг нь хөнөөх, эрүүл мэндэд нь хохирол учруулах, хорих, цөлөх, албадан гаргах, сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагад албадан байрлуулах, эрх чөлөөг нь хасах зэрэг янз бүрийн хэлбэрийн албадлагын арга хэмжээг улс төрийн хэлмэгдүүлэлт гэж ойлгоно. Мөн иргэншлийг нь цуцлах, албадан хөдөлмөр эрхлүүлэх, эд хөрөнгийг нь хураах, устгах, албан тушаалаас

[73] Law on the Acknowledgment of Citizens of Georgia as Victims of Political Represion and Social Protection of Repressed Persons https://matsne.gov.ge/en/document/view/31408?publication=11

UIH.MN СУДАЛГААНЫ САН

болон ажлын байрнаас нь хууль бусаар чөлөөлөх, алслагдмал газарт хүчээр нүүлгэн шилжүүлэх, орон байрнаас нь гаргах болон Гүрж улсын бусад хууль тогтоомжоор баталгаажсан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах нь хэлмэгдүүлэлт юм. Шүүх болон төрийн бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр тухайн хүнийг улс төрийн үзэл бодлоо илэрхийлсний төлөө гэмт хэрэг үйлдсэн гэж хилс гүтгэх, шашны харьяалал, нийгмийн давхаргын байдалд суурилан аливаа албадлагын хэлбэрийг ашиглахыг хэлмэгдүүлэлтэд багтаасан байна.

Уг хууль хэдийгээр батлагдсан хэдий ч хэлмэгдүүлэлтэд өртөгсдөд нөхөн олговор олгох асуудал бэрхшээлтэй хэвээр байна. Тухайлбал, уг хуулийн 8 дугаар зүйлд цагаатгагдсан иргэний хураагдсан өмчийн эрхийг сэргээх журмын талаар заасан ч хэрэгжихгүй тохиолдол их байна.

2007 онд "1940-өөд онд Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Гүрж Улсаас ЗХУ-д албадан нүүлгэн шилжүүлсэн хүмүүсийг эх оронд нь буцаах тухай"[74] хуулийг баталсан ба буцах хүсэлтийг 2009 оны 07-р сарын 01-ний өдөр хүртэл авна гэжээ. Уг хууль хэрэгжсэний дараа нийт 5841 хүн Гүрж улсын иргэншлээ сэргээх хүсэлт гаргасан бөгөөд эдгээрээс 1998 хүнд энэ статусыг олгож, 494 хүнд "болзолт иргэншил" буюу өөр улсын иргэншлээс татгалзсан даруйд Гүржийн иргэншил олгох шийдвэр гаргажээ. Гэсэн ч иргэншлээ сэргээсэн хүн нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрт хамрагдах эрхгүй байх зэрэг олон дагалдах асуудал үүссэн байна.

## 2.5.ӨМНӨД СОЛОНГОС УЛС

Япон Улс нь Өмнөд Солонгос Улсыг Дэлхийн II дайны үед буюу 1910 оны 09-р сараас 1945 оны 08-р сар хүртэл 35 гаруй жил эрхшээлдээ байлгаж захирсан ба Япон Улс дэлхийн II дайнд ялагдаж, ноёрхол нь дуусгавар болсон. Үүнээс хойш 20 жилийн дараа буюу 1965 онд Япон, Өмнөд Солонгос хоёр улс хэд хэдэн гэрээ хэлэлцээр байгуулан дипломат харилцаагаа сэргээсэн байна. Хоёр орны үндсэн харилцааны тухай гэрээ, өмч, нэхэмжлэлийн асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай зэрэг хэлэлцээрүүдийг харилцан зөвшөөрч баталсан байна.

Өмч, нэхэмжлэлийн асуудлыг шийдвэрлэх, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн дагуу Япон Улс Өмнөд Солонгос Улсад 300 сая долларыг нөхөн олговор болгон төлсөн[75]. Энэхүү нөхөн олговрыг хийснээр хоёр улс дайны дараах бүх нэхэмжлэл, тэр дундаа дайны үеийн дайчилгаанд орж албан хүчээр хүнд хөдөлмөр эрхэлсэн Солонгосчуудын нэхэмжлэлийг шийдвэрлэсэн болохыг баталжээ. Гэвч зарим судлаачид тухайн үеийн хууль тогтоомжийн дагуу хүмүүсийг дайчлах, дайны үед “боолын хөдөлмөр” эрхлүүлдэг байсан нь хүнлэг бус, хүний эрхийг ноцтой зөрчсөн хэлбэр гэж үздэг байна. Дайны үеийн хүнд хөдөлмөр эрхлэгсдийн ар гэрт нөхөн олговор олгох ажил одоог хүртэл бүрэн дуусаагүй ба маргаантай хэвээр байсаар байна.

2018 оны 10-р сард Өмнөд Солонгос Улсын Дээд шүүх шийдвэр гаргаж, колоничлолын үед Японы пүүсүүдэд дайчлагдан ажиллаж байсан “хуучнаар цэргийн алба хааж байсан ажилчид”-д мөнгөн хохирлыг барагдуулах шийдвэрийг гаргасан. Янз бүрийн түвшний шүүхийн оролцоотойгоор Японы корпорацууд санхүүгийн нөхөн олговор олгох, дурсгалын

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[74] Law on the Repatriation of Persons Involuntarily Displaced by the Former USSR from the Georgian SSR https://matsne.gov.ge/en/document/view/22558?publication=6
[75] https://japan-forward.com/the-reality-of-the-mobilization-of-koreans-during-world-war-ii-an-analysis-based-on-statistics-and-written-records/

ёслол үйлдэх, дурсгалын хөшөө босгох зэргээр маргааныг шийдвэрлэж, нөхөн олговрын репертуар байгуулжээ[76].

Солонгосын дайны үеийн ажилчдын нэхэмжлэлийн асуудлыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэх "Өмнөд Солонгосын төр, хувийн хэвшлийн тусгай зөвлөл" байгуулагджээ.

Мөн Өмнөд Солонгосын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлснээр, дайны үеийн хэлмэгдэгсдийн төлөө Япон, Өмнөд Солонгосын компани, хувь хүмүүсээс бүрдсэн сайн дурын сан байгуулах санал гаргасан байдаг. Хэлэлцэж буй төлөвлөлтийн дагуу уг санг Өмнөд Солонгос Улсын шүүхэд гаргасан нэхэмжлэгч нарт нөхөн олговор олгоход зарцуулна гэж мэдээлж байна.

Түүнчлэн Өмнөд Солонгос Улсын засгийн газар Дайны үеийн нөхөн олговрын төлбөрийг хариуцаж дээд шүүхэд гомдол гаргасан хэлмэгдэгсдийн ар гэрт нөхөн олговор олгож дараа нь Японы талаас ирээдүйн төлбөрийг шаардах суброгацийн схем юм.[77]

### Солонгосын дайны өмнө болон дайны үед хүнд хөдөлмөр эрхлэгсдийн нөхөн төлбөрийн тухай хууль

(Act On Compensation To Persons Of Distinguished Service Who Conducted Operations As Irregular Forces In Enemy Territories Before And During The Korean War)

Энэхүү хуулийн зорилго нь Солонгосын дайны өмнө болон дайны үеэр дайсны нутаг дэвсгэрт цэргийн алба хааж, онцгой үүрэг гүйцэтгэсэн, улс орны төлөө онцгой золиос гаргасан цэргийн алба хаагчид болон тэдний ар гэрийнхэнд нөхөн олговор олгох асуудлыг зохицуулахад оршино. Уг хуульд 2021 оны 10-р сард хамгийн сүүлд нэмэлт өөрчлөлт орсон ба нийт 21 зүйлтэй байна.[78]

**1 дүгээр зүйлд**: Хуулийн зорилго;

**2 дугаар зүйлд**: Хэлмэгдэгсдийн тодорхойлолт, ар гэрийхний тодорхойлолтууд;

**3 дугаар зүйлд**: Уг хуульд заасан нөхөн олговор авах боломжгүй, ялыг хүчингүйд тооцсон этгээдийн тухай мэдээлэл;

**4 дүгээр зүйлд**: ***Албадан хөдөлмөр эрхэлж байсан хэлмэгдэгсдэд нөхөн олговор олгох тухай зөвлөлдөх комиссыг*** (Article 4 (Deliberation Commission on Compensation to Persons of Distinguished Service as Irregular Forces) Үндэсний Батлан хамгаалахын сайдын (Minister of National Defense) дэргэд байгуулах тухай тусгаж өгсөн байна. Уг комиссын чиг үүрэг

1. Тухайн хэлмэгдэгсэд нь нөхөн олговор авах шаардлагыг хангасан эсэх, түүний ар гэр түүнтэй хамааралтай эсэх;
2. Хуулийн 3 дугаар зүйлд заасан тодорхойлолтын дагуу хэлмэгдсэн эсэх
3. Хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу ар гэрийнхэнд нь нөхөн олговор олгох асуудлыг шийдэх
4. Хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу хэлмэгдэгсэд, тэдний ар гэрийнхэн болон гэр бүлийн гишүүдээс бүрдсэн байгууллагад олгох санхүүгийн дэмжлэг;
5. Нөхөн олговрын талаар Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад асуудал гэх мэт.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[76] https://www.usip.org/publications/2022/08/formula-resolve-south-korea-japan-wartime-forced-labor-issue
[77] https://japan-forward.com/editorial-south-korea-must-solve-its-wartime-labor-issue-domestically/
[78] https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=compensation&x=30&y=24#liBgcolor23

Уг зөвлөл нь комиссын даргыг оролцуулаад есөн гишүүнээс бүрдэнэ. Комиссын гишүүдийг холбогдох салбарын өргөн мэдлэг, туршлагатай хүмүүсээс сонгодог ба Ерөнхийлөгчийн зарлигаар Үндэсний Батлан хамгаалахын сайдын тушаалаар томилно. Мөн даргыг комиссын гишүүдээс Үндэсний батлан хамгаалахын сайд томилно.

**5-р зүйлд:** (Онцгой гавьяа шагнал)

Дайны үед онцгой гавьяа байгуулсан хүнд шагнал урамшуулал олгох;

Онцгой урамшуулал олгох шалгуур, төлөх хэмжээ, уг шагналыг олгох арга, шаардлагатай бусад асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно.

**6 дугаар зүйлд**: (Амь насаа алдсан гэр бүлийн гишүүдийн эрх)

Гэр бүлийн гишүүнд уг нөхөн олговрыг олгохоор шийдвэрлэсэн үед Иргэний хуульд заасан өв залгамжлалын дагуу энэхүү хуульд зааснаар нөхөн олговор авах эрхтэй.

**7 дугаар зүйлд**: (Нөхөн олговор авах тухай өргөдөл)

Хэлмэгдэгсэд, эсхүл түүний ар гэрийн гишүүн (цаашид "өргөдөл гаргагч" гэх) өргөдөл гаргах тухай.

**8 дугаар зүйлд**: (Нөхөн олговрыг тодорхойлох)

Хороонд нөхөн олговор олгох тухай өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн дотор нөхөн олговор олгох эсэх, түүний хэмжээг Хороо тогтооно. Баримт илрүүлэлт хоцрогдсон гэх мэт шалтгааны улмаас уг хугацаанд багтаан шийдвэр гаргах боломжгүй байх.

**9 дүгээр зүйлд:** (Бичгээр хариу өгөх) Хороонд хэлмэгдэгсдийн нөхөн олговор олгох тухай, эсхүл олгохгүй байх шийдвэрийн тухайн шийдвэр гарснаас хойш нэг сарын дотор бичгээр өргөдөл гаргагчид хариу өгнө.

**10 дугаар зүйлд:** (Дахин хэлэлцэх)

8 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос гаргасан шийдвэрийг эсэргүүцэж байгаа өргөдөл гаргагч нь дахин хэлэлцүүлэх үндэслэлийг нотлох баримтын хамт Комисст дахин хэлэлцүүлэх хүсэлт гаргаж болно.

**11 дүгээр зүйлд:** (Нөхөн олговор авах)

Өргөдөл гаргагч нь онцгой үүрэг гүйцэтгэснийх нь төлөө нөхөн олговор олгох тухай бичгээр шийдвэрийн жинхэнэ хуулбарыг хүлээн авч Комисст хандана.

**12 дугаар зүйлд:** (Нөхөн олговор авах эрхийг бусдад шилжүүлэх, баталгаа болгож өгөх, хавсаргах эрхгүй тухай)

**13 дугаар зүйлд:** (Шүүх маргаан гарахаас өмнө тогтоох зарчим)

Гагцхүү Хороо энэ тухай шийдвэр гаргасны дараа хүнд хөдөлмөр эрхэлж хэлмэгдсэний төлөө нөхөн олговор олгохыг шаардсан нэхэмжлэлийг гаргаж болно.

**14 дүгээр зүйлд:** (Нөхөн олговрын дүнг тогтооно)

Өргөдөл гаргагч нь энэхүү хуулийн дагуу нөхөн олговор олгох мөнгөний хэмжээг зөвшөөрсөн тохиолдолд түүнийг авах эрхийн талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шүүхийн тохиролцоонд хүрсэн гэж үзнэ.

**15 дугаар зүйлд:** (Нөхөн олговрыг хуурамчаар авсан тохиолдод буцаан төлүүлэх тухай)

**16 дугаар зүйлд:** (Баримт олдвор)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Хороо нөхөн олговор авах эсэхийг шалгахын тулд онцгой алба хашиж байсан хүн, гэрч, эсхүл лавлагаа авах хүний мэдүүлэг, мэдүүлгийг сонсох, эсхүл магадлах ажиллагаа явуулж болно. Шаардлагатай гэж үзвэл мөрдөн байцаалт явуулах; холбогдох байгууллагын дарга нарт хүсэлт гаргаж болно. Ийм тохиолдолд хүндэтгэх шалтгаан байхгүй бол холбогдох байгууллагын дарга нар уг хүсэлтийг биелүүлнэ.

**17 дугаар зүйлд:** (Устгах заалт)

Өргөдөл гаргагчид бичгээр гаргасан тогтоолын жинхэнэ хуулбарыг гардуулснаас хойш гурван жилийн дотор нөхөн олговор авах эрхээ эдлээгүй тохиолдолд уг эрх нь хөөн хэлэлцэх журмаар хүчингүй болно.

**18 дугаар зүйлд:** (Холбогдох байгууллагуудад үзүүлэх санхүүгийн дэмжлэг)

Хороогоор хэлэлцэн шийдвэрлэсний дараа төрөөс гавьяа зүтгэлтэн, тэдний ар гэрийнхэн болон бусад хүмүүсээс бүрдсэн байгууллагад бизнесийн шаардлагатай зардлыг нөхөхөд нь туслах зорилгоор төсвийн хүрээнд татаас олгож болно.

**19 дүгээр зүйлд:** (Давхар нөхөн олговор олгохыг хориглох)

(1) Энэ хуульд заасны дагуу хэлмэгдэгсэд давхар нөхөн олговор олгохгүй байх тохиолдлууд

**20 дүгээр зүйлд:** (Хорооны гишүүн төрийн албан хаагч байх тухай)

**21 дүгээр зүйлд:** (Торгуулийн заалт)

Залилан болон бусад зүй бус аргаар бусдын нөхөн олговрыг хүлээн авсан этгээдийг гурван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл гучин саяас дээшгүй воноор торгох ял оноонo.

**Хэлмэгдэгсдийн нөхөн төлбөрийн асуудлыг хэлэлцэх хороо**

(Irregular Military Contribution Compensation Deliberation Committee)

Хэлмэгдэгсдийн нөхөн төлбөрийн асуудлыг хэлэлцэх хороо нь 1948 оны 08-р сарын 15-наас 1953 оны 07-р сарын 27-ны хооронд цэргийн алба хашиж байсан болон Солонгосын дайны өмнө болон дараа дайсны бүс нутагт улс орныхоо төлөө чухал онцгой үүрэг гүйцэтгэх, онцгой золиос гаргаж эх орныхоо төлөө хэлмэгдсэн энгийн иргэд болон тэдний ар гэр, холбоо бүхий хүмүүст нөхөн олговор олгохоор байгуулагдсан байна. Тухайн үед эх оронч сэтгэл, улс орныхоо төлөөх өөрийн биеэ золиослон ирсэн гавьяаг зохих ёсоор өвлүүлэн үлдээж тус хорооны зүгээс шударгаар хэлэлцэж шийдвэрлэхийн төлөө хариуцлагатай ажилладаг байна.[79]

Цэргийн алба хаагчид болон тэдний ар гэрийнхэнд нөхөн олговор олгохтой холбогдсон асуудлыг хянан шийдвэрлэхийн тулд Үндэсний батлан хамгаалах яамнаас уг хороог байгуулсан байна.

**Хорооны чиг үүрэг:**

1. Нөхөн олговор авахаар өргөдөл гаргасан хүн хэлмэгдэгсэд болон түүний ар гэрийнхэнд харьяалагдах эсэх асуудал;
2. Хэлмэгдэгсэд болон түүний ар гэрийнхэнд нөхөн олговор (мөнгө) олгох тухай асуудал;
3. Хэлмэгдэгсэд болон тэдний ар гэрийнхэн нь нийлж байгуулсан байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэхтэй холбоотой асуудал;

[79] https://new.mnd.go.kr/user/indexMain.action?siteId=ncdc

UIH.MN СУДАЛГААНЫ САН

4. Нөхөн олговортой холбоотой Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад асуудал гэх мэт.

***Бүтэц, зохион байгуулалт***

Хэлмэгдэгсдийн нөхөн төлбөрийн асуудлыг хэлэлцэх хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Хорооны гишүүдийн тоо, даргалах хүнд тавигдах шаардлага нь хуульд (**Солонгосын дайны өмнө болон дайны үед хүнд хөдөлмөр эрхлэгсдийн нөхөн төлбөрийн тухай хууль**) тусгасан байдаг.




Хорооны гишүүдэд тавигдах шаардлага:

- Шүүгч, улсын яллагч, цэргийн шүүгч, өмгөөлөгчөөр 10-аас доошгүй жил ажилласан байх;
- Үндэсний батлан хамгаалах яам, Ахмад дайчдын яаманд харьяалагдах төрийн алба хаагчдаас агентлагийн даргын санал болгосон хүн байх;
- Цэргийн алба хааж байсан, судалгаа, ажлын туршлага зэрэг холбогдох чиглэлээр арвин мэдлэг, туршлагатай байх.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


- “Улс төрийн хэлмэгдүүлэлт ба цагаатгал” М.Ринчин УБ 2000
- “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” Монгол Улсын хууль https://legalinfo.mn/mn/detail/510
- “Монголын эрх зүйн эх толь бичиг” УБ, 2015. С.Нарангэрэл
- Human rights and political repression around the world https://revistaidees.cat/en/drets-humans-i-repressio-politica-al-mon/
- Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын шинэчлэн найруулсан дүрэм https://legalinfo.mn/mn/detail?lawId=200042&showType=1
- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох талаарх зарим орны эрх зүйн зохицуулалт СТ-15/207УИХ-ын Тамгын газрын ПССХ
- Freedom in the world 2021 https://freedomhouse.org/sites/default/files/2021-02/FIW2021_World_02252021_FINAL-web-upload.pdf
- UN Human Rights Council https://www.ohchr.org/en/hr-bodies/hrc/about-council
- UN Security Council https://www.un.org/securitycouncil/
- Report on the 50th session of the Human Rights Council https://www.universal-rights.org/blog/report-on-the-50th-session-of-the-human-rights-council/
- High Commissioner’s annual report https://www.universal-rights.org/blog/report-on-the-50th-session-of-the-human-rights-council/
- Монгол Улс ба НҮБ-ын хүний эрхийн зөвлөл file:///Users/munkhtungalag/Downloads/https___mfa.gov.mn_wp-content_uploads_2021_01_Mongolia_HRC.cleaned.pdf
- State repression and the Democratic peace https://www.psqonline.org/article.cfm?IDArticle=18366#
- State repression and Political order https://web.archive.org/web/20070614024800/http://www.bsos.umd.edu/gvpt/davenport/STATER~2.PDF
- Political repression https://academic.oup.com/book/7722/chapter-abstract/152856074?redirectedFrom=fulltext#no-access-message
- Эмнести Интернэшнл (Amnesty International) тайлан https://www.amnesty.mn/media/attachments/2022/04/08/20220406_delhiin-tailan-2022-for-web-2.pdf
- Human Rights Watch тайлан https://www.hrw.org/world-report/2022
- Freedom House тайлан https://freedomhouse.org/sites/default/files/2021-02/FIW2021_World_02252021_FINAL-web-upload.pdf
- UPR https://www.upr-mongolia.mn/index.php?cmd=Content&menuid=6&/UPR-%D0%B3%D1%8D%D0%B6-%D1%8E%D1%83-%D0%B2%D1%8D
- Rehabilitation of victims of political repressions in Georgia, Institute for Development of Freedom of Information http://open-archives.org/en/newsblogs/interestingnews/29
- Law on the Acknowledgement of Citizens of Georgia as Victims of Political Represion and Social Protection of Repressed Persons https://matsne.gov.ge/en/document/view/31408?publication=11
- Law on the Repatriation of Persons Involuntarily Displaced by the Former USSR from the Georgian SSR https://matsne.gov.ge/en/document/view/22558?publication=6


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=compensation &x=30&y=24#liBgcolor23
- https://www.ft.com/content/94171a69-569f-4dc6-a557-d716906c9c79
- https://www.usip.org/publications/2022/08/formula-resolve-south-korea-japan-wartime-forced-labor-issue
- https://japan-forward.com/editorial-south-korea-must-solve-its-wartime-labor-issue-domestically/
- https://new.mnd.go.kr/user/indexSub.action?codyMenuSeq=163867120&siteId=ncdc&menuUIType=sub
- https://japan-forward.com/the-reality-of-the-mobilization-of-koreans-during-world-war-ii-an-analysis-based-on-statistics-and-written-records/
- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн иргэдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох талаарх зарим орны эрх зүйн зохицуулалт (CT-15/207), УИХТГ-ын Судалгаа, шинжилгээний хэлтэс
- ФЗ ”О реабилитации жертв политических репрессий”. http://base.garant.ru
- “Положение о порядке возврата гражданам незаконно конфискованного, изьятого или вышедшего иным путем из владения в связи с политическими репрессиями имущества, возмещения его стоимости или выплаты денежной компенсации.” http://www.zakonprost.ru
- Указ Президента РФ от 8 июня 1996 г. N 858 "О дополнительных мерах по реабилитации лиц, репрессированных в связи с участием в событиях в г. Новочеркасске в июне 1962 г.", Об организации деятельности органов прокуратуры по исполнению и надзору за исполнением настоящего Закона см. приказ Генеральной прокуратуры РФ от 5 февраля 2008 г. N 21. http://base.garant.ru
- ФЗ "Об обжаловании в суд действий и решений, нарушающих права и свободы граждан". http://base.garant.ru
- http://kremlin.ru/structure/commissions
- https://www.prlib.ru/en/node/354156
- http://kremlin.ru/structure/commissions#institution-25
- О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года) http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200.
- Об утверждении Правил выплаты денежных компенсаций жертвам массовых политических репрессий (Постановление Правительства Республики Казахстан от 23 января 2003 года N 82)-http://adilet.zan.kz/rus/docs/P030000082.
- О реабилитации жертв массовых политических репрессий (Закон Республики Казахстан от 14 апреля 1993 года). Статья 19-http://adilet.zan.kz/rus/docs/Z930002200


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# НОМЫН БАЯРЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА

*Д.Аюуш, И.Жаргалзаяабямба, Д.Жигваагүнсэл,*
*Р.Оргилмаа, С.Золжаргал, Б.Мөнгөнсувд*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

НЭГ. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН НОМЫН БАЯР

ХОЁР. ОРЧИН ҮЕИЙН НОМ, ХЭВЛЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

ГУРАВ. ХҮҮХДИЙГ НОМОНД ДУРТАЙ БОЛГОХ, НОМ УНШУУЛАХ АРГА ЗҮЙ

ДӨРӨВ. НОМЫН ШАГНАЛ (AWARD)

ТАВ. МОНГОЛ УЛСЫН НОМЫН БАЯР

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын даргаас ирүүлсэн шуурхай захиалгын дагуу 1) Дэлхийн улс орнуудын номын баяр, 2) Орчин үеийн ном, хэвлэлийн чиг хандлага, 3)Хүүхдийг номонд дуртай болгох, ном уншуулах арга зүй гэсэн агуулгын хүрээнд мэдээлэл, лавлагааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

## НЭГ.ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН НОМЫН БАЯР

НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас 1995 онд анх 04 дүгээр сарын 23-ны өдрийг Дэлхийн номын болон зохиогчийн эрхийн өдөр болгон зарласан билээ. Энэ өдөр дэлхийн 100 гаруй оронд зохиолч, хэвлэн нийтлэгчдэд хүндэтгэл үзүүлэх, ном уншихын ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулах зэрэг өргөн хүрээний арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулдаг байна.

Номын баярыг тэмдэглэх анхны санааг 1922 онд Испанийн зохиолч Висенте Клавел Андрес, зохиолч Мигель де Сервантесийг хүндэтгэх зорилгоор гаргасан бөгөөд тус баярыг анх Испанид 1926 оны 10-р сарын 07-нд Сервантесийн мэндэлсэн өдөр тэмдэглэж эхэлсэн байна. Гэхдээ энэ өдрийг задгай агаарт алхаж, ном үзэхэд илүү таатай улиралд зохион байгуулах нь зүйтэй гэж үзээд 1930 онд XIII Альфонсо хаан “Номын баяр” тэмдэглэх өдрийг зохиолчийн таалал төгссөн өдөр буюу 04-р сарын 23-нд тэмдэглэхээр шийдвэрлэсэн.

Түүнээс хойш дэлхийн олон улс орнуудад номын баярыг энэ өдөр, эсвэл ойролцоо амралтын өдрүүдэд нь тэмдэглэж иржээ. Харин Ирланд, Их Британид улаан өндөгний баяртай нь давхацдаг тул 03-р сард номын баярыг сайн үйлсийн аян хэлбэрээр зохион байгуулдаг байна.

Ихэнх улс орнуудад “Дэлхийн номын өдөр” (Номын баяр)-өөр ном зохиогчдыг алдаршуулах, номын төрөлжсөн үзэсгэлэн гаргах, ном уншихын ач холбогдлыг сурталчлах, зохиогчид болон уншигчдын дунд хэлэлцүүлэг, яриа өрнүүлэх, клубын үйл ажиллагаа, урлагийн тоглолт, кино болон жүжгийн үзүүлбэр, сайн үйлсийн аян зэрэг олон арга хэмжээг нийтлэг зохион байгуулдаг болжээ.

Дэлхийн номын өдрийг дэмжих зорилгоор ЮНЕСКО-оос 2001 онд “Дэлхийн номын нийслэл” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ нь улс орнуудад жил бүр номын томоохон үзэсгэлэн, ном сурталчлах үйл ажиллагаа, ном бүтээгч, уншигчдыг холбох арга хэмжээг тогтмол зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлснээрээ чухал ач холбогдолтой.

Улс орнууд нь Дэлхийн номын өдрийг өргөн тэмдэглэхээс гадна Үндэсний номын баяр, Ном унших өдөр, Хүүхдийн номын баяр гэх мэт номын баяруудыг мөн зохион байгуулдаг. Тухайлбал, АНУ-д Конгрессын номын сангийн Үндэсний номын баярыг 22 дахь удаагаа зохион байгуулж байна. Энэ үеэр номын худалдаа, шинэ номын танилцуулга, хандивын үйл ажиллагаа, номын баатруудын багт наадам, гарын үсэг зурах ажиллагаа зэргийг зохион байгуулдаг. Мөн Хадсоны хүүхдийн номын наадмыг 2009 онд бичиг үсгийг сурталчлах зорилгоор байгуулжээ. Жил бүр Хадсон хотын олон нийт болон сургуулиудтай хамтран номын баярт гэр бүлээрээ оролцох, ном бүтээгчидтэй уулзах, хүүхдийг номонд дурлахыг уриалах зэрэг арга хэмжээ зохион байгуулдаг байна.

Мөн зарим номын баяруд тогтмол нэг газарт зохион байгуулагддаг бол зарим нь сэдэв, төрөл зүйлийн онцлогоос хамаарч өөр өөр газруудад зохион байгуулагдах нь бий. Сүүлийн жилүүдэд Ковид-19 цар тахлын улмаас номын баярыг онлайн хэлбэрээр зохион байгуулах туршлага ч бий болсон. Тухайлбал, виртуал хэлбэрээр номын үзэсгэлэн үзэх, онлайнаар

UIH.MN СУДАЛГААНЫ САН

худалдаа хийх, цахим уулзалт, номын танилцуулга, хэлэлцүүлэгт оролцох зэргээр оролцох боломжтой болжээ.

1. Энэтхэг Улсын Жайпур хотын утга зохиолын баяр[80]

Жил бүрийн 01 дүгээр сард утга зохиолын холбоод дэлхийд томд тооцогдох Жайпур хотын Утга зохиолын баярт цугларцгаадаг. Энэхүү баяраар Нобелийн шагналтнууд, “Man booker prize”[81]-ийн шагналтнуудаас авахуулаад шинээр төрж буй утга зохиолчид, уншигчид цугларч таван өдрийн турш Ражастани хотын Дигги ордонд уншлага, мэтгэлцээн, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг байна.

2. Колумби Улсын Картагена хотын номын баяр[82]

Энэхүү баяр нь Испани хэлтэй орнуудын хамгийн чухал утга зохиолын арга хэмжээнд тооцогддог байна. Жил бүр утга зохиол төдийгүй дүрслэх урлаг, кино урлаг, хөгжим, геополитик, сэтгүүл зүй, байгаль орчныг хамруулсан дөрвөн өдрийн турш үргэлжилдэг тус баярт иргэд маш идэвхтэй оролцдог байна.

3. Мьянмар Улсын Ирравади утга зохиолын баяр[83]

Бирм нь уран зохиолын баялаг түүхтэй улс юм. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд тус улсын хэвлэлийн салбар цэргийн дэглэмийн улмаас нэлээд боомилогдсон байна. Ирравадигийн утга зохиолын наадам бол урагшлах чухал алхам юм. Тус баяраар жил бүрийн 02 дугаар сард ЮНЕСКО-ийн дэлхийн өвд бүртгэгдсэн Мандалай хотын “Kuthodaw Pagoda” хэмээх үзэсгэлэнт газар ном сонирхогчдод зориулан дэлхийн хамгийн олон ном цуглардаг байна.

4. Хятад Улсын Шанхай хотын утга зохиолын баяр

Жил бүрийн Гуравдугаар сард дэлхийн өнцөг булан бүрээс зохиолчид Шанхай хотод цуглан 11 өдрийн турш энэхүү сонирхолтой арга хэмжээнд оролцдог байна. Тухайлбал, “Man booker prize” шагналтан Элеанор Каттон, бестселлэр зохиолч Эми Тан нар оролцож байжээ.

5. ИБУИНХУ-ын Камбриа хотын “Ways with words” номын баяр[84]

Жил бүрийн Гуравдугаар сард Камбриа хотод зохиолч, уншигчид цугларан арав хоногийн турш үзэл бодлоо хуваалцан, номын нээлт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээ зохион байгуулагддаг байна.

6. АНУ-ын “Өмнөдийнхний утга зохиолын баяр”

“Өмнөдийнхний утга зохиолын баяр” төрийн бус байгууллага нь 1937 онд анх өмнөд нутгийнхны утга зохиолыг дэмжих, хөгжүүлэх зорилготой АНУ-ын ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудыг хамруулан байгуулагдсан юм. Жил бүр сургуулиуд ээлжлэн тус баярыг хариуцан зохион байгуулдаг байна.

7. АНУ-ын Нью Йорк хотын PEN “Дэлхийн дуу хоолой” олон улсын утга зохиолын баяр

АНУ дахь PEN – Олон улсын утга зохиол, хүний эрхийн байгууллагаас “Дэлхийн дуу хоолой” олон улсын утга зохиолын баярыг жил бүр зохион байгуулдаг бөгөөд жил бүрийн Дөрөвдүгээр сард дэлхийн өнцөг булан бүрээс зохиолчид Нью Йорк хотод цугларан уран

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[80] https://jaipurliteraturefestival.org/
[81] https://www.britannica.com/art/Booker-Prize
[82] https://www.hayfestival.com/cartagena/home
[83] http://irrawaddylitfest.com/
[84] http://wayswithwords.co.uk/

зохиол төдийгүй улс төр, өөрийн хувийн амьдралын талаар мөн үзэл бодол, дуу хоолойгоо чөлөөтэй илэрхийлдэг байна.

8. Австрали Улсын Сидней хот дахь “Сидней зохиолчдын фестиваль”[85]

Жил бүрийн Тавдугаар сард нэг долоо хоногийн турш зохион байгуулагддаг “Сидней зохиолчдын фестиваль”-аар шилдэг зохиолчдыг уншигчидтай биечлэн уулзуулах зэрэг 300 гаруй сонирхолтой арга хэмжээг зохион байгуулж, уншигчид төдийгүй зохиолчдод олон боломжуудыг нээж өгдөг байна.

9. Итали Улсын Ром хотын эртний Форум дахь номын баяр[86]

Эртний түүхт Базилика Ди Массенциогийн түүхэн орчинд зохион байгуулагддаг энэхүү наадам нь харьцангуй цомхон гэж хэлж болох хэдий ч жил бүрийн Зургадугаар сард таван өдрийн турш зохиолчид, орон нутгийн хамтлаг, хөгжимчдийг уншигчидтай уулзуулсан сонирхолтой арга хэмжээнүүдээр дүүрэн байдаг байна.

10. Шотланд Улсын Эдинбург дахь номын баяр[87]

Эдинбургийн олон улсын номын баяр нь жил бүрийн Наймдугаар сард 14 хоногийн турш зохион байгуулагддаг бөгөөд дэлхийн өнцөг булан бүрээс шилдэг болон шинээр төрж буй зохиолч, сэтгэгчид ирж оролцдог байна. "Номын баяр"-ын үйл ажиллагааны гол цөм нь ардчиллын талаарх хэлэлцүүлэгт оролцох оролцоог өргөжүүлэх, ном унших дур сонирхол, бүтээлчээр суралцах сэдлийг хүн бүрд төрүүлэх, төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилготой үйл ажиллагаа юм.

11. АНУ-ын Конгрессын номын сангаас зохион байгуулдаг Үндэсний номын баяр

АНУ-ын Үндэсний номын баярыг Тэргүүн хатагтай асан Лаура Буш, Конгрессын номын санч Х.Биллингтон нар анх үүсгэсэн байна. 2001 онд анх эхэлснээс хойш жил бүр зохион байгуулагддаг утга зохиолын томоохон үйл ажиллагаанд тооцогддог байна. Ерөнхийлөгч асан Барак Обама, тэргүүн хатагтай асан Мишель Обама нар 2009 оноос өнөөг хүртэл энэхүү үйл ажиллагаанд оролцдог хүндтэй зочид юм. Номын баяр нь олон нийтэд нээлттэй бөгөөд үнэ төлбөргүй юм. Баярын үеэр уншигчид хайртай номын зохиолчидтойгоо уулзах, гарын үсгийг нь авах, зургаа авахуулах, номын баатруудтай зургаа авахуулах зэрэг төрөл бүрийн сонирхолтой, дурсгалтай арга хэмжээнд оролцдог байна. Түүнчлэн гайхамшигтай киноны зохиолчид, кино урлагийн зүтгэлтнүүдтэй уулзан, тухайн зохиолоос сэдэвлэсэн киног үзэх зэрэг сонирхолтой арга хэмжээг зохион байгуулдаг ажээ.

12. Бруклиний номын баяр[88]

Бруклиний номын баяр (The Brooklyn Book Festival) нь АНУ-ын хамгийн том номын баяруудын нэг юм. Энэ нь олон нийтэд үнэ төлбөргүй утга зохиолын арга хэмжээ зохион байгуулах хэрэгцээ шаардлагаас үүдэн 2006 онд анх зохион байгуулагдаж байжээ. Эдүгээ номын баярын арга хэмжээ нь 300 зохиолч, 250 бие даасан болон томоохон хэвлэн нийтлэгчид оролцсон 8 өдрийн номын нэгдсэн арга хэмжээ, хүүхдийн номын уншлагын өдөр, виртуал баярын өдөр зэрэг томоохон арга хэмжээнүүдээс бүрдэж байна. Номын баяр нь жил бүрийн 09.25-10.03-ны өдрүүдэд зохион байгуулагддаг. 2021 оны номын баяраар Алисон Бечдел,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[85] https://www.swf.org.au/
[86] https://culture.roma.it/
[87] https://www.edbookfest.co.uk/
[88] https://brooklynbookfestival.org/

Ханиф Абдурракиб, Сара Маклин зэрэг томоохон зохиолчидтой хийсэн арга хэмжээ, яриа хэлэлцээг зохион байгуулав.

13. Франкфуртын номын яармаг

Франкфуртын номын яармаг[89] нь олон улсын яармаг бөгөөд жил бүрийн 10 дугаар сард зохион байгуулагддаг. Тус яармагийг Германы Номын Худалдааны Биржийн Холбоо 1949 онд байгуулсан. Номын яармагийн үеэр Германы номын шагнал, Германы номын худалдааны Энхтайвны шагнал, Германы хүүхдийн утга зохиолын шагнал зэрэг салбарын олон шагналууд гардуулдаг байна.

## ХОЁР.ОРЧИН ҮЕИЙН НОМ, ХЭВЛЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн хувьсгалд тулгуурлан аж үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжих, даяаршиж буй нийгэмд шилжиж байна. Ирээдүйн технологийн чиг хандлага зөвхөн зарим технологийн дэвшлийг хурдасгах төдийгүй мэдээлэл био зэрэг технологийн хам нөлөөний үйлчлэлээр аж амьдралын бүхий л хүрээнд хувьсгал хийх юм. Энэ хувьсгал нь ном хэвлэлийн салбарыг мөн тойроогүй.

Сүүлийн жилүүдэд зурагт радио болон цахим хэлбэрээр мэдээ, мэдээлэл их авдаг болсноор хэвлэмэл сонин номын зах зээл дээрх эрэлт буурах хандлагатай болсон байна. Сонингоос авах мэдээллээ цахим ертөнцөөр авдаг болсон нь нэг талдаа үйлдвэрлэлд сөрөг нөлөөтэй ч, нөгөө талдаа өнгөт хэвлэмэл сэтгүүл номын эрэлт хэрэгцээ өсөж буй нь үйлдвэрлэлийн өсөлт, бүтээгдэхүүний чанар, өртөгт эерэг нөлөөтэй гэж үзэж болохоор байна. Мөн ном хэвлэл, сонинг судалгаа шинжилгээ хийх, номын өв санг хадгалах, түүх архивын зориулалтаар ашиглах эрэлт хэрэгцээ хэвийн түвшинд байна.

**Монгол Улсын хэвлэлийн үйлдвэрлэлийн нөхцөл байдал (2020 он)[90]**

***Үйлдвэрлэл, борлуулалт***

2020 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар хотод 250 гаруй, хөдөө орон нутагт 50 гаруй, нийт 300 гаруй хэвлэлийн үйлдвэр, цех үйл ажиллагаа явуулж, 4000 орчим хүнийг ажлын байраар хангаж байна. Нийт хэвлэх үйлдвэрүүдийн 203 буюу 70% нь эх бэлтгэх, цөөн тоогоор олшруулах, бэлэг дурсгалын зүйл хэвлэх жижиг үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр ажиллаж байна. Харин 24 % буюу 70 дунд үйлдвэр нь офсет, торгон хэвлэл болон бусад үлдсэн 6 % буюу 17 том үйлдвэр нь ихээр захиалга хүлээн авах боломжтой, өндөр технологитой, нэг буюу түүнээс дээш өнгө үйлдэл бүхий хэвлэх машинтай, олон үйлдэлтэй тоног төхөөрөмжит үйлдвэрүүд байна.

Сав баглаа боодлын бүтээгдэхүүн




Импортын бүтээгдэхүүн




UIH.MN СУДАЛГААНЫ САН

[89] Франкфуртын номын яармаг-Die Frankfurter Buchmesse https://de.wikipedia.org/wiki/Frankfurter_Buchmesse
[90] https://mofa.gov.mn/exp/blog/11/179 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, 2020 оны байдлаар

Бүтээгдэхүүний нэр төрлөөр




*Эх сурвалж: ХХААХҮЯ, салбарын мэргэжлийн холбоо, 2020 он*

Өнөөдрийн байдлаар сонингийн 70%-ийг үйлдвэрлэдэг Чөлөөт хэвлэлийн сан, Өдрийн сонин, Зууны мэдээ зэрэг 5 үйлдвэр байна. Мөн томоохон хэвлэлийн үйлдвэрүүдийн дэргэд Мөнхийн үсэг ХХК-ны Аз хур, Адмон ХХК-ны Монсудар, Сэлэнгэпресс ХХК-ны Номын хүрдэн зэрэг хэвлэлийн редакцууд ажиллах ба тэдгээр нь хэвлэл ном зохиолын зохиогчийн эрхтэй ажиллаж байна.

Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг авч үзвэл хэвлэх, дуу бичлэг хувилах, дахин үйлдвэрлэх үйлдвэрлэл 2019 оны мөн үетэй харьцуулахад 4.1 (3.0%) тэрбум төгрөгөөр буурч, цаас, цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 13.1 (22.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

*Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл, тэрбум.төг*




*Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрлэл, борлуулалт, тэрбум.төг*




*Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, Аж үйлдвэрийн салбар 2020 он*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл*

| Гол нэр төрлийн бүтээгдэхүүн | Хэмжих нэгж | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020* он |
|---|---|---|---|---|---|---|
| Ном | сая х.д.х | 53 | 38.9 | 106.5 | 168.3 | 139.9 |
| Сонин /7 хоногт 4-өөс дээш гардаг/ | сая х.д.х | 35.4 | 26.2 | 22.3 | 17.5 | 36.8 |
| Хүснэгт, маягт | сая х.д.х | 12 | 10.1 | 12.7 | 17.8 | 40 |

*Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо, Аж үйлдвэрийн салбар 2020 он*

Сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлтийг харахад уг салбар бусад хөнгөн үйлдвэрийн салбартай харьцуулахад, зээл тусламж, хөнгөлөлттэй нөхцөл шаардахгүй бие даан хөгжиж буй бөгөөд тодорхой түвшинд хүрч нэгэн жигд хэвийн өсөлттэй байгааг харуулж байна. Энэхүү өсөлт нь эдийн засгийн уналт савлагаанд эрсдэлд өртөхгүй дархлаа суусан гэж үзэж болохоор байна.

Сүүлийн жилүүдэд зурагт радио болон цахим хэлбэрээр мэдээ, мэдээлэл их авдаг болсноор сонин, номын зах зээл дээрх эрэлт буурах хандлагатай болсон байна. Сонингоос авах мэдээллээ цахим ертөнцөөр авдаг болсон нь нэг талдаа үйлдвэрлэлд сөрөг нөлөөтэй ч, нөгөө талдаа өнгөт хэвлэмэл сэтгүүл номын эрэлт хэрэгцээ өсөж буй нь үйлдвэрлэлийн өсөлт, бүтээгдэхүүний чанар, өртөгт эерэг нөлөөтэй гэж үзэж болохоор байна. Мөн ном хэвлэл, сонинг судалгаа шинжилгээ хийх, номын өв санг хадгалах, түүх архивын зориулалтаар ашиглах эрэлт хэрэгцээ хэвийн түвшинд байна.

***Ажиллах хүч***

Аж үйлдвэрийн салбарт 2020 оны байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 6355 буюу 78.4 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаа эрхэлж байна. 15 ба түүнээс дээш насны ажиллагсдын 163.9 мянга буюу 14.1 хувь нь аж үйлдвэрийн салбарт ажиллаж байгаагаас 89.7 мянга буюу 54.7 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ногдож байна. Хөнгөн үйлдвэрийн салбарт нийт 3000 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулж, 53000 гаруй хүнийг ажлын байраар хангаж байна. Үүнээс тухайн салбарт 4000 гаруй буюу 7.5 хувь нь ажиллаж байна.

Салбарын ажиллах хүчний байдал




*Эх сурвалж: ХХААХҮЯ, салбарын мэргэжлийн холбоо, 2020 он*

Тухайн салбарт ажиллагсдын хувьд эрүүл мэнд, ажлын байрны хортой нөхцөлд тооцогддог байсан ч, орчин үеийн техник технологийн дэвшлээр эдгээр эрсдэлээс бүрэн хамгаалагдсан гэж үзэж болно. Салбарт ажиллагсдын боловсон хүчин бэлтгэх, гадаад дотоодод сургах,

давтан сургах, мэргэжлийн инженер техникийн ажилтан бэлтгэх, сургах чиглэлээр их дээд сургууль болон мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран ажиллаж байгаа ч өөр олон төрлийн ажил арга хэмжээг зохион байгуулах шаардлага байсаар байна. Нөгөө талаас, орчин үеийн үйлдвэрлэлийн өндөр хурдтай тоног төхөөрөмжүүд нь хүний оролцоог багасгаж, өндөр мэдлэг ур чадвар шаардаж буй нь ажлн байрны хомстол, ажилгүйдлийг өсгөж байна.

**Тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам:**

Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт 2016 онд хийгдсэн нөхцөл байдлын судалгаагаар дотоод зах зээлийн 92%-ийг хангаж байна гэсэн тооцоо гарсан. Гадаад зах зээл дээр урд хөршөөс чанар муутай, хямд өртөг бүхий бүтээгдэхүүн нийлүүлдэг байсан ч эрхзүйн тодорхой зохицуулалт, бодлогын дэмжлэг эерэг нөлөө авчирсан байна.

Хэвлэлийн үйлдвэрлэлийн салбарт тулгамдаж буй асуудал нь бүх түүхий эд материалаа 100% импортоор авдаг бөгөөд үндэсний үйлдвэрлэлийг гааль, татварын бодлогоор дэмжих, түүхий эд материал, бүтээгдэхүүний чанар стандартыг шинэчлэх, шинээр батлуулах, орчуулан нутагшуулах асуудал тулгарч байна. Иймд дараах ажлуудыг цаашид хийж хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Түүхий эд материал, бүтээгдэхүүний чанар стандартыг боловсронгуй болгож шинэчлэх, шинээр батлуулах, нутагшуулах;
- Хэвлэлийн үйлдвэрлэл эрхлэгчдэд бодлогын дэмжлэг үзүүлэх, гааль, татварын бодлогоор дэмжих эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Дотоодын үйлдвэрүүдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, үзэсгэлэн худалдаанд хамруулах, дотоодын худалдан авалтаар дэмжих;
- Салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхыг нэмэгдүүлэх, сургах, мэргэшүүлэх, давтан сургах.

**2017 онд БСШУСЯ-аас зохион байгуулсан “Ном хэвлэл ба уншигчдын оюуны хэрэгцээ” салбар хуралдаанаас гаргасан зөвлөмж, санал**

Хуралдааны гол зорилго нь ном хэвлэлийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, уншигч хэрэглэгчдийг чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх гарц арга замыг хэлэлцэх, салбар хоорондын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн юм.

Энэ салбар хуралдааны онцлог нь анх удаа зохиолч, уран бүтээлчид, хэвлэлийн газар, хэвлэх үйлдвэр, номын худалдааны төлөөлөл, номын санчид хамтран нэгдэж ном хэвлэлийн салбарын цаашдын зорилго зорилт, хамтын ажиллагаагаа хэлэлцэж, санал бодлоо солилцсон.

**Хуралдааны зөвлөмж, санал:**

*Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд:*

- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг яаралтай хэлэлцэх;
- Ном хэвлэлийн салбарын үйл ажиллагааг зохицуулах стандарт, дүрэм, журмыг боловсруулах /цахим номын стандарт, ном хэвлэлийн хяналтын стандарт г.м/;
- Монгол Улсын ISBN-ий Үндэсний товчооны үйл ажиллагааг төр өөрийн мэдэлд авах /хураамжийг нь хувийн эзэмшилд нь үлдээх боломжтой./;
- Утга зохиолын төрөл зүйлүүдийг жигд хөгжүүлэхэд онцгой анхаарах, “Монголын утга зохиолын хөгжил” үндэсний хөтөлбөрийг дэмжих;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Номын худалдааны нэгдсэн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх;
- Ном хэвлэлийн салбарын нийгмийн хангамж, цалин урамшууллыг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой ажиллуулахад онцгой анхаарах;
- Ном хэвлэлийн салбарын боловсон хүчнийг /зохиолч, яруу найрагч, орчуулагч, шүүмжлэгч, номын санчид, номын худалдаа, худалдааны менежмент, хэвлэлийн ажилтан г.м/ гадаад, дотоодод бэлтгэх, чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах, солилцооны хөтөлбөрийг дэмжих;
- Монгол хэл, уран зохиолын сургалттай холбоотой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сурах бичгийн эх зохиохдоо МЗЭ-ийн Удирдах зөвлөл, Шүүмж судлалын үндэсний төвтэй хамтран ажиллах;
- Номын санчдын мэргэжлийн зэрэглэл тогтоох тогтолцоог бий болгох;
- Номын сангийн сан хөмрөгийн эрсдэлийн санг бий болгох /Тооллогоор дутагдсан ном хэвлэлийг номын санчид цалингаар төлдөг системд өөрчлөлт оруулах/;
- Яаманд утга зохиол хариуцсан мэргэжилтэн ажиллуулах;
- Номын санг зориулалтын барилга байгууламжтай болгох;
- Үндэсний ном хэвлэлийн болон уншигч, хэрэглэгчдийн цогц судалгааны үндсэн дээр ном хэвлэлийн салбарын үйл ажиллагааг боловсронгуй болгох.

*Орон нутгийн удирдлагуудад:*

- Орон нутгийн зохиолчид, салбар зөвлөл, хэвлэлийн байгууллагыг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх;
- Аймаг, нийслэл, орон нутгийн номын сангийн мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах, орон нутгийн болон ур чадварын нэмэгдлийг дүрэм журмын дагуу олгох;
- Номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, техник, тоног төхөөрөмж, програм хангамжаар хангах төсөв, хөрөнгийг нэмэгдүүлэх гэсэн санал, зөвлөмжийг гаргасан байна.

## Ном, хэвлэлийн орчин үеийн чиг хандлага

### Хэвлэл бол маркетинг

Сүүлийн үед зохиолчид бие даан номоо хэвлүүлэх нь ихэссэн. Үнээс үүдэлтэй чанартай, чанаргүй маш олон бүтээлүүд хэвлэгдэх болсон. Ихэнх зохиолчид нь хэвлэлийн салбарын стандарт, маркетингийн тал дээр мэдлэг дутмаг байдаг. Үр дүнд нь ихэнх бүтээлүүд нь хэний ч анхаарлыг татахгүй, онц биш, хэрэгцээгүй бүтээлүүд болж хувирдаг. Энэ дунд амжилт гаргаж байгаа цөөн хэдэн зохиолчид бий. Тэдний давуу тал нь ихэвчлэн дижитал маркетинг, график дизайны чиглэлээр өндөр мэдлэгтэй байдаг. Энэ мэдлэгийнхээ ачаар сэтгэл хөдөлгөм график дизайн, мөн сошиал медиагийн оролцоотойгоор маркетингийн сурталчилгааны ажлыг бий болгодог. Эдгээр чадвар нь дутмаг хүн сайн бүтээл бий болгохыг хүсвэл дижитал маркетингийн ажилтантай хамтран ажиллаж амжилтанд хүрэх боломжтой. Мөн зохиолчид бие даасан хэвлэн нийтлэгчидтэй хамтран ажиллах нь ихсэх болсон. Бие даасан хэвлэн нийтлэгчид нь хэвлэлийн компаниудаас ялгаатай нь урьдчилгаа төлбөр шаардахгүйгээр ном хэвлэж дараа нь зохиогчийн эрхийн төлбөрөөс хуваалцдаг. Бие даасан хэвлэн нийтлэгчид зохиогчидтой илүү их хамтын ажиллагааг бий болгож бүтээлээ амжилтанд хүргэхийн тулд хамтран маркетинг хэвлэлийн стратеги боловсруулдаг. Бие даасан хэвлэн

нийтлэгчид мөн санхүүгийн бүх эрсдлийг хариуцдаг. Маркетинг, түгээлт, ном үйлдвэрлэл гээд бүх үйл явцад нь оролцдог.[91]

Ном унших нь одоо ч гэсэн өмнөх шигээ чухал хэвээрээ байна. Ном уншигчдын тоо ч нэг үеэ бодвол өсөх хандлагатай байна. Мөн зохиолчид Амазоны платформ мөн түүнтэй төстэй өөр олон түгээлтийн компаниудыг ашиглах болсон нь уншигчдад илүү таатай нөхцөлийг бүрдүүлж өгч чадсан.

## ГУРАВ. ХҮҮХДИЙГ НОМОНД ДУРТАЙ БОЛГОХ, НОМ УНШУУЛАХ АРГА ЗҮЙ

Хүүхдэд төрсөн цагаас нь эхлээд л ном уншиж өгөх нь амьдралын сайн сайхан эхлэлийг тавихад тусалдаг. Бяцхан хүүхэддээ ном уншиж өгөхдөө номон дээрх дүрс, эд зүйлс, амьтдын гаргаж буй дуу чимээ, авианы талаар ярилцан унших хэрэгтэй. Хүүхдүүд уншиж сурахаасаа өмнө номонд дуртай болж сурдаг гэдгийг ойлгоорой.

Ном бол хүүхдийн төсөөлөн бодох болон хэлний чадварыг нэмэгдүүлдэг хамгийн чухал арга юм. АНУ-ын сэтгэл судлаач Мерян Волф (Maryanne Wolf) “Ном уншдаг тархи” хэмээх бүтээлдээ ном унших нь тархинд хамгийн сайн тэжээл болдог учир шалтгаан бол тархийг маш сайн цочроож өгдөг учраас тэр гэж онцлон хэлсэн байдаг. Бичиг үсгийг ойлгон, тэмдэглэгээг тайлбарладаг тархины хажуугийн хэсэг (Temporal Lobe- энэ хэсэг нь харах болон хэлний чадвар зэргийг хариуцдаг), нөхцөл байдлыг задлан шинжилж, ямар нэгэн зүйлийн хэлбэр дүрсийг харах мэдрэхүйгээр төсөөлдөг тархины урд хэсэг (Frontal Lobe- дүгнэх, үйл хөдлөл, заах чадварыг хариуцдаг), сэтгэл хөдлөлийг мэдэрдэг тархины төв хэсэг (Limbic System) гэх мэт ном уншсанаар цочрол авдаггүй тархины хэсэг гэж бараг үгүй ажээ.[92]

Хүүхэддээ хэрхэн үр дүнтэй ном уншиж өгөх, хүүхдээ хэрхэн номонд дурлуулах талаар мэргэжилтэн Мэм Фоксын бичсэн “Хүүхэдтэйгээ хамт чанга дуугаар ном унших 15 минутын гайхамшиг” номонд бичсэн арга барилд:

- Өдөр бүр хүүхэддээ 15 минут ном уншиж өгөх. Өдөр болгон тогтмол ном уншиж өгнө гэдэг бидний бодож байгаа шиг тийм ч амархан ажил биш. Тийм болохоор мартахгүйн тулд гэрийнхээ өнцөг булан бүрд ном байрлуулах хэрэгтэй.
- Хүүхэддээ өдөрт хамгийн багадаа 3 төрлийн ямар нэгэн сонирхолтой зүйл ярьж өгөх.
- Хүүхэддээ ном уншиж өгөхдөө эрч хүчтэй цоглог байх хэрэгтэй. Ингэснээр хүүхэд залхахгүй төвлөрөн, анхааралтай сонсож чаддаг.
- Номыг хөгжилтэйгөөр унших. Ингэснээр эцэг эх болон хүүхэд хоорондын харилцаа сайжран, улам дотно болдог.
- Хүүхдийн тань байнга сонсох дуртай түүх яриаг хэдэн ч удаа хамаагүй, давтан уншиж өгч байх нь хүүхэд ном унших улам сонирхолтой болдог.
- Дуу, хүүхдийн шүлэг гэх мэт төрөл бүрийн бүтээлийг ашиглах.
- Хүүхэддээ ном уншина гэдгийг хичээл биш, тоглоом наадам мэтээр ойлгуулах. (Хүүхдээ их мэдлэгтэй болгох нь чухал биш, ном уншихад сонирхолтой болгох нь хамгийн чухал юм. Эцэг эхчүүд өөрсдийн бодол санааг түрүүнд тавихаас болгоомжлох хэрэгтэй)
- Дургүй байхад нь хүүхэддээ хүчээр ном уншиж өгч болохгүй. Ингэснээр хүүхдийг номонд сонирхолгүй болгодог муу талтай.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[91] https://www.entrepreneur.com/growing-a-business/this-is-the-future-of-book-publishing/378653
[92] Еврей хүмүүсийн боловсрол болон амжилтын нууц., Ку Жэ Хаг., 19 дэх тал.,

Унтахаасаа өмнө хүүхэддээ ном уншиж өгөх хугацааны тухайд 15-30 минут орчим байх нь тохиромжтой. 30 минутаас дээш хугацаагаар болбол хүүхэд залхах хандлагатай болдог. Гэхдээ хүүхэддээ ном уншиж өгөх нь өдрийн аль ч цагт байж болно. Харин тогтсон газар, цагт тогтмол уншиж өгөх нь маш чухал юм.

БНСУ-ын KBS телевизийн “Уншлагын нээлт” хөтөлбөрийн найруулагч Хун Гён Сү “Эцэг эх өөрсдийн дуу хоолойгоор хүүхэддээ ном уншиж өгөх нь хайр халамжаа хүүхэддээ мэдрүүлж буй бас нэг чухал зүйл юм. Хүүхдэд ном тогтмол уншиж өгснөөр мэдрэмжийг нь цочроон, сэтгэл санааг тайвшруулан, төсөөлөн бодох болон бүтээлч чадвар, илэрхийлэх чадвар зэргийг нь гайхалтай сайжруулж өгдөг” гэж онцлон хэлсэн байдаг.

Хүүхдийн сонирхлоос шалтгаалаад эрэгтэй, эмэгтэй хүүхдийн номын сонголт өөр, өөр байдаг байна. Хөвгүүдийг охидтой харьцуулахад уншихдаа шалгуур өндөртэй сонголт хийдэг байна. Охид бол янз бүрийн сэдэв, төрөл жанрын номноос өргөн хүрээтэй уншдаг. Тиймээс хөвгүүдэд ном сонгохдоо юу анхаарах хэрэгтэй вэ?

Хөвгүүдэд ном сонгохдоо номыг өөрөөр нь сонгуулах, танин мэдэхүйн шинжлэх ухааны номуудыг санал болгох, хувийн сонирхолд нь тааруулах, ном нь кинотой бол сонирхол татах нэг үндэслэл болно. Хөвгүүдийн шинэ хандлага, сонирхлыг харгалзах, гоё зураг хавтастай байх хэрэгтэй.

Охид, хөвгүүд аль алинд нь хамааралтай чухал зүйл бол уншсанаа дүгнэх, хамтын зугаатай яриа өрнүүлэх юм. Энэ нь хэл ярианы чадвар, сэтгэлийн чадамжийг ч давхар хөгжүүлнэ.

Япон Улсын алдартай сургалтын төв болох Комацү[93] /Komatsu/ нь хүүхдүүдийн дунд судалгаа хийсэн үр дүнгээс  хүүхэд ном уншихгүй байх вий гэж санаа зовж байгаа эцэг эхчүүдэд зөвлөгөө гаргажээ.

Өнөөгийн хүүхдүүд янз бүрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өртөж, ном унших боломжоо алдаж байна. Уншсанаар өгүүлбэрийн унших хурд, өгүүлбэрийг ойлгох чадварыг хавсаргаж, уншиж ойлгох чадвар, төсөөллийг хавсаргана. Тиймээс хүүхдэд аль болох номтой болох арга замыг бий болгох хэрэгтэй.

Хүүхдүүд яагаад номыг эхний ээлжинд уншдаггүй вэ? Олон шалтгаан байгаа ч үндсэн гурван шалтгаан бий.

1. Унших сонирхолгүй, өөр зүйл сонирхдог.  Хичээл, гэрийн даалгавар, сургууль гээд зав гардаггүй;
2. Унших чадвар муу;
3. Хичээл, спортоор хичээллэх гэх мэт өөр сонирхолтой байх. Ийм учраас ном уншдаггүй, унших сонирхолгүй. Уншихаас зугтаж байдаг байна.

Үүнийг даван туулах 6 сэтгэлгээг дурдвал:

1. Хүүхдийн бодит нөхцөл байдлыг ойлгох;
2. Хүүхдийнхээ сонирхол, чадварт тохирсон зорилго тавих;
   Эхлээд суугаад ямар нэг юм унш, жишээ нь зурагт цуврал гэх мэт.

Найз нөхөд, гэр бүл нь ном унших сонирхолд том оролцоо болдог. Найзынхаа “Энэ сонирхолтой юм биш үү” гэж хэлсэн үг их нөлөө үзүүлдэг байна.

3. Номын сангаас уншихыг хүссэн номоо олох;

[93] Комацү сургалтын төв https://komatsu-ed.com/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Номын санд ном унших сайн талууд байдаг бөгөөд тэнд сууж уншиж сурвал хүүхдүүд сэтгэл амар ном унших боломжтой. Номын сангууд нь хүүхдүүдийг ном уншихыг дэмжихэд чухал үүрэгтэй байх ёстой. Бямба гараг бүрийн өглөө номын сан руу явах гэх мэт долоо хоногт нэг удаа номын сан руу явж хэвшүүлж сургаарай.

4. Ном унших цаг гаргах дүрэмтэй байх;

Ном уншихыг албадахын оронд уншихаас өөр аргагүй цагийг бий болгохыг хичээгээрэй. Тухайлбал:

- 20:00 цагаас хойш зурагт, тоглоом, ухаалаг утас ашиглахгүйгээр номоо унших;
- Амралтын өдрүүдэд өглөөний 7 цагт босож, 10 цаг хүртэл тоглоом тоглохгүй байх;
- Долоо хоногт нэг удаа номын сан явах цагийг тогтоох гэх мэт.

Уншсан номны нь талаар тэдэнтэй ярилцвал ном унших нь амьдралыг илүү тааламжтай болгодог гэдгийг ойлгох болно.

5. Насанд хүрсэн хүн ч ном уншдаг;

Насанд хүрэгчид ч бас ном уншиж буйгаа харуул. Тэгээд хүүхэд ч мөн адил том хүний дүрийг хараад “Ном унших сайхан биш гэж үү” гэж дүгнэнэ.

Хүүхдүүдийн хамгийн том өрсөлдөгч бол тэдний хамгийн дотны эцэг эх, багш нар юм. Том хүн "Би энэ долоо хоногт 2 ном уншлаа" гэхэд хүүхэд "Би 10 ном уншсан" гэж хариулдаг.

6. Унших дадлыг дэмжих;

Хүүхдээ унших, ярих, илүү их уншихад нь урамшуул.

## ДӨРӨВ. НОМЫН ШАГНАЛ (AWARD)

**Монгол Улс**

Монгол Улсад номын шагналыг улс, аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулж гардуулсаар иржээ. Улс болон нийслэлийн дараах шагналуудыг гардуулдаг байна. Үүнд:

**Улсын хэмжээнд**

- шилдэг уншигч (бага, дунд, ахлах анги);
- шилдэг уншигч анги хамт олон;
- шилдэг уншигч насанд хүрэгч;
- шилдэг ном;
- шилдэг номын сан;
- шилдэг хэвлэлийн газар.

**Нийслэлийн хэмжээнд**

- шилдэг уншигч (бага, дунд, ахлах анги);
- шилдэг уншигч анги хамт олон;
- шилдэг ном;
- шилдэг хэвлэлийн газар.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Дэлхий дахинд**

Зохиолч, зохиолчдод олгодог дэлхийн утга зохиолын нэр хүндтэй шагналыг[94] дурдвал:

[94] https://blueroseone.com/publish/prestigious-literary-awards/

1. Нобелийн утга зохиолын шагнал;
2. Үндэсний номын шагнал;
3. Букерын (Booker) шагнал;
4. Пулитцерийн (Pulitzer) шагнал;
5. Уран зохиолын эмэгтэйчүүдийн шагнал;
6. Америкийн утга зохиолын ПЕН (PEN) шагнал;
7. Нойштадтын (Neustadt) Олон улсын утга зохиолын шагнал;
8. Сахатиа (Sahitya) Академийн шагнал;
9. Америкийн шагнал;
10. Хинду (Hundu) утга зохиолын шагнал.

**Нобелийн шагнал**: Шведийн Академи утга зохиолын салбар, Нобелийн шагналд нэр дэвшүүлэх урилгыг жил бүрийн 10 дугаар сарын эхээр тогтоодог байна. Нобелийн утга зохиолын шагналыг 1901-2021 оны хооронд 118 хүн, үүнээс: 102 эрэгтэй, 16 эмэгтэй хүртжээ.

**Үндэсний номын шагнал:** Үндэсний номын шагналыг жил бүр хэвлэн нийтлэгчийг нэр дэвшүүлдэг байна. Баг бүр таван шүүгчтэй бөгөөд үүнд, зохиолч, номын санч, номын худалдаачид, утга зохиол судлаачид багтдаг.

**Букерын шагнал**: Энэ нь Их Британи болон Ирландад хэвлэгдсэн шилдэг романы зохиолчдод жил бүр олгодог шагнал юм. Зохиолч, номын санч, утга зохиолын төлөөлөгч, хэвлэн нийтлэгч, номын худалдаачдаас бүрдсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй багийг томилдог байна.

**Пулитцерийн шагнал**: Сонин, сэтгүүл, интернет сэтгүүл зүй, уран зохиол, хөгжмийн зохиолын салбарт гаргасан амжилтад АНУ-д олгодог шагнал юм. Шагналыг жил бүр хорин нэгэн төрлөөр олгодог. Хорин ангиллын ялагч бүр гэрчилгээ, 15.000 ам.долларын мөнгөн шагналтай. Төрийн албаны төрөлд түрүүлсэн хүнд алтан медаль олгодог байна.

**Уран зохиолын эмэгтэйчүүдийн шагнал:** Их Британи дахь хамгийн алдартай утга зохиолын шагнал юм. Жил бүр олгодог бөгөөд аль ч орны эмэгтэй зохиолч байж болно. Гол тавигдах шаардлага нь англи хэл дээр зохиолоо хэвлүүлсэн тохиолдолд энэ шагналд өрсөлдөх боломжтой болно. Өмнөх онд Их Британид хэвлэгдсэн хамгийн шилдэг бүрэн хэмжээний романд олгодог ажээ.

**Америкийн утга зохиолын ПЕН (PEN) шагнал:** уран зохиол, яруу найраг, театр, шинжлэх ухаан, спортын зохиол, эссэ, намтар, хүүхдийн уран зохиолын шилдэг зохиолчдыг шалгаруулдаг. Жил бүр зохиолч, орчуулагчдад нийт 350.000 ам.долларын 20 гаруй өргөмжлөл, тэтгэлэг, шагнал олгодог байна. Энэ шагнал нь 75.000 ам.долларын сантай бөгөөд АНУ-ын хамгийн дээд шагналуудын нэг юм.

**Нойштадтын олон улсын утга зохиолын шагнал:** дэлхийн хэмжээний утга зохиолын салбарын Нобелийн шагналтай харьцуулдаг хамгийн нэр хүндтэй утга зохиолын шагналуудын нэг гэж үздэг. Шагнал нь мөнгөн бүргэдийн өд, гэрчилгээ, 50.000 ам.доллар байдаг.

**Сахатиа академийн шагнал:** Энэтхэг Улсад хэвлэгдсэн уран зохиолын хамгийн шилдэг зохиолчдод олгодог шагнал юм. Энэхүү шагналыг 1954 онд бий болгосон бөгөөд 1.000.000 ам.долларын мөнгөн шагналтай. Шагналын зорилго нь шинэ чиг хандлагыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ Энэтхэгийн бичгийн шилдэг бүтээлийг таниулах, сурталчлах явдал юм. Жилийн сонгон шалгаруулалт нь арван хоёр сарын хугацаанд явагддаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Америкийн шагнал**: Энэхүү Америкийн шагнал нь гадаадын зохиолчдод олгодог уран зохиолын насан туршийн амжилтыг нь үнэлсэн, нэр хүндтэй шагнал юм.

**Хинду утга зохиолын шагнал:** Тус шагналыг 2010 онд "Хинду" өдөр тутмын "The Hindu Literary Review" сэтгүүл үүсгэн байгуулжээ. Жил бүрийн 05-06 дугаар сард хэвлэн нийтлэгчдээс зохиолчийн бүрэн хэмжээний роман, богино өгүүллэгийн түүврийг сонгон шалгаруулж, ялагчийг зохиолч, эрдэмтэн судлаач, шүүмжлэгчдээс бүрдсэн нэр хүндтэй шүүгчдийн баг шалгаруулдаг байна.

**ХБНГУ-ын номын шагналууд**

**Германы номын шагнал:** Герман хэлээр туурвисан тухайн жилийн хамгийн шилдэг романд олгодог. Тус шагналыг 2005 оноос хойш олгож эхэлсэн бөгөөд Үндэсний хэвлэлийн компаниуд, банкууд хамтран зохион байгуулж байв. Одоо Deutsche Welle (телевиз) болон Германы радио Биржийн холбоотой хамтран зохион байгуулдаг. Шалгарсан зохиолчийг 25000 еврогоор шагнадаг бол эцсийн шатанд шалгарсан 5 зохиолчид тус бүр 2500 евро олгодог байна.

**Германы номын худалдааны Энхтайвны шагнал:** Майн голын дэргэдэх Франкфурт хотын Паулын сүмээс утга зохиол, шинжлэх ухаан, соёлын салбарт энхтайвны үзэл санааг нэвтрүүлэхэд онцгой их хувь нэмэр оруулсан хувь хүнд олгодог. Тус шагналыг 25 мянган евро дагалдана. 1950 оноос эхэлж олгосон. Дэлхийн хамгийн том яармаг болох Франкфуртын яармаг дээр олгодог учраас тус шагнал нь олон улсад танигдсан, нэр хүндтэй шагнал юм. Сангийн зөвлөл шагналтныг шалгаруулдаг байна. Хэн ч нэрээ дэвшүүлж болно.

Германы хүүхдийн утга зохиолын шагнал - Утга зохиолын төрийн шагнал. 1956 онд тухайн үеийн Германы гэр бүлийн яамнаас эрхлэн анх олгож эхэлсэн. Хүүхэд залуусын утга зохиолын онцгой бүтээлд олгодог шагнал. Шагналын мөнгийг Холбооны Улсын Засгийн газрын Хүүхэд залуусын улс төр ба соёлын асуудлыг дэмжих сангаас гаргадаг байна.

## ТАВ. МОНГОЛ УЛСЫН НОМЫН БАЯР

Монгол туургатны мянганаар тоологдох өв их соёл, язгуур уламжлалын магнайд ном эрдмийг хүндэтгэн дээдэлж есөн эрдэнээр чимэглэн, шастир их цадиг, суу сэтгэлгээний охь болсон бүтээлүүдээ нандигнан хайрлаж, ном дор мөргөхийг сүслэн, эрхэмлэн уншдаг ариун ёс, уламжлал бий.

Манай улс Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны “Номын баярын өдөр тэмдэглэх тухай” 158 дугаар зарлигаар жил бүрийн 09 дүгээр сарын 3 дахь долоо хоногийн Бямба гарагт “Номын баярын өдөр” хэлбэрээр улс орон даяар тэмдэглэж ирсэн юм.

Мөн УИХ-ын чуулганы 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулж, хуулийн төсөлд Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлд “Үндэсний ном, бичиг соёлын өдрүүд”-ийг 05 болон 09 дүгээр сарын 3 дахь долоо хоногийн амралтын өдрүүд гэсэн 5.1.17 дахь заалтыг нэмсэн.

Үүнээс өмнө 1955 онд Ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэн хуучин номын худалдааг гаргах хэрэгцээ байгаа тухай “Монголын ард түмний соёл боловсрол өөдөлж мандахын хамтаар номын хэрэгцээ үлэмжхэн нэмэгдэж байна. Монголын сэхээтэн хүмүүс хувьдаа тус бүр жижиг номын сантай болж байгаа учраас номыг худалдаж авах хэрэгцээ нэмэгдэхийн хамтаар бас худалдах, солих хэрэгцээ ч нэмэгдэж байна” хэмээн тэмдэглэжээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

... Энэхүү хүсэлтээс гурван жилийн дараах нэгэн хэвлэлийн хуудсыг сөхөн үзвэл Улсын номын худалдааны газраас “1958-1959 оны хичээлийн жилийн нээлтийг тохиолдуулан хүүхдийн номын захыг нийслэлийн Сүхбаатарын талбайн баруун хойдтой” гаргажээ.

1950-аад оноос эхтэй номын худалдаа, үзэсгэлэнг 1990-ээд он хүртэл 40 орчим жил зохион байгуулсан Улсын номын худалдааны газар татан буугдаж, агуулахад нь байсан номууд цаасанд ачигдаж, .... 1990-2000 оны дунд үе хүртэл номын баяр, номын үзэсгэлэн худалдаа номын сангуудын нуруун дээр явж иржээ.

- “1999 онд жил бүрийн намар БСШУЯ, Монгол Улсын Үндэсний Номын Сантай хамтран “Номын яармаг” зохион байгуулж уламжлалт ажил болгон, жил бүрийн энэ арга хэмжээний үеэр ном хэвлэлийн салбарын үйл ажиллагааг сурталчилж, тэдний хамтын ажиллагааг өргөжүүлэх, ном хэвлэл тойрсон төрөл бүрийн уулзалт ярилцлага зэрэг олон арга хэмжээ зохион байгуулах болжээ.
- 2000 онд Бичиг соёлын хишиг өдөр Хаврын номын яармагийг зохион байгуулсан.
- 2001 оны 06 дугаар сарын 02-нд болсон “Монгол номын яармаг”[10]-ийг “Монгол Улсад номын зах, номын ордон байгуулах эхлэл энэ өдөр тавигдсан байна. “Номыг хүн бүхэнд хүртээцгээе” гэсэн үг нь яармагийг зохион байгуулж буй хүмүүсийн гол уриа юм” хэмээн Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт Л.Түдэв айлджээ. Уг номын баяр 5 өдөр болж өнгөрчээ.
- 2003 онд Хүүхдийн номын ордноос “Хүүхэд- Залуучуудын номын яармаг”-ийг “Шинэ үе шилдэг боловсрол” уриатай зохион байгуулжээ.
- 2004 оны 04-р сарын 02-нд Монгол Улсын төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн, хүүхдийн зохиолч Ж.Дашдондог “Дэлхийн хүүхдийн номын өдөр”-ийг Дэлхийн зөн Олон Улсын байгууллага, Хүүхдийн номын ордонтой хамтран зохион байгуулжээ.
- 2008 оны 04-р сард UBS телевизийн “Номын ертөнц” нэвтрүүлгийн нэг жилийн ойд зориулж “Номын гэрэлт ертөнц” ТББ-аас “Номын ертөнц-2008” номын үзэсгэлэн худалдааг Мэдээлэл технологийн үндэсний паркт гаргажээ.
- Тус оны 11-р сарын 20-23-ны хооронд Хүүхдийн номын ордонд “Номын яармаг-2008”-ийг зохион байгуулжээ.
- 2009 онд “Цахим номын яармаг-2009” үзэсгэлэн худалдааг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн хороо, Үндэсний номын сан, Хүүхдийн номын ордон хамтран 12 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд зохион байгуулжээ.

**“Үндэсний ном, бичиг соёлын өдрүүд”-тэмдэглэх хууль зүйн үндэслэл:**

**Нэг. Номын сангийн тухай хуулийн:**
9.3.3.нийгэмд номын сангийн гүйцэтгэх үүрэг, ном хэвлэлийн ач холбогдлыг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах;
24.2.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь уншлагыг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулах, уншлагыг дэмжих журам боловсруулан хэрэгжүүлэх, тэргүүний уншигч-иргэн, гэр бүл, байгууллагыг сурталчилна.

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2021 оны 07-р сарын 02 өдөр/
1 дүгээр зүйл. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 5.1.17 дахь заалт нэмсүгэй:
5.1.17.Үндэсний бичиг соёл, номын өдрүүд: 05 болон 09 дүгээр сарын гурав дахь долоо хоногийн Бямба, Ням гараг."

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хоёр. “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны “Нэг. Үндэсний нэгдмэл үнэт зүйл”-ийн** Зорилт 1.1.Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна. Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:
1.1.14.Дэлхийн болон Монгол сонгодог зохиолууд, үндэсний онцлогтой утга зохиолын бүтээлүүдээс бүрдсэн бичил номын сан, гэрийн номын сантай болгох аян өрнүүлж хүүхэд залууст заавал унших ном, сонсох подкаст, үзэх кино, цахим хуудас бий болгоно.
1.1.16.Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулах цуврал бүтээлч үйл ажиллагааг улсын болон хувийн номын сангуудад түшиглэн зохион байгуулна.
1.2.4.Хүүхэд, залуучуудын театр, Хүүхэлдэйн театр, номын сан, кино театр, дугуйлан, цэцэрлэгт хүрээлэн гэх мэт соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх хүүхдийн хөгжлийн төвүүдийг дэмжиж, шаардлагатай тоног төхөөрөмж, номын хөмрөг, хувцас хэрэглэлээр хангана. Номын сангийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

Зорилт 1.4.Үнэт зүйлийн судалгаа болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэл болсон нүүдлийн соёл иргэншил, Монголын түүх, хэл соёл, ёс заншил, шашин, гүн ухааны судалгаа хийж, нийтийн хүртээл болгон хэвшиж, нийгмийн соён гэгээрлийг өндөр түвшинд хүргэнэ.
1.4.3.Үндэсний утга зохиол, ном судар, баримтат өвүүдийг бүртгэн, цуглуулагчдыг алдаршуулж урамшуулна.

**Гурав. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт**

2.6.2.Соёл, урлагийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад чиглэсэн үндэсний зорилтот арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, харилцан уялдаатай, үр дүнтэй хэрэгжүүлнэ:
2.6.2.1.“Цахим соёл” арга хэмжээ;
2.6.2.2.“Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээ;
2.6.2.4.“Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II” арга хэмжээ;
2.6.3.Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ:
2.6.3.5.соёлын удирдлага, зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгож, санхүүжилтийн олон эх үүсвэртэй, хүртээмжтэй, үр ашигтай механизмыг бүрдүүлэн соёлын үйлчилгээг иргэдэд чанартай, шуурхай хүргэнэ.

**Дөрөв. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн** 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Номын сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн Дугаар А/683 тушаалаар "Уншлагыг дэмжих журам"-ыг баталсан.

2.1.Уншлагыг дэмжих ажиллагааг дараах хэлбэрээр зохион байгуулж болно.
2.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийн дагуу жил бүрийн 9 дүгээр сарын 3 дахь долоо хоногийн Бямба гаригт “Номын баярын өдөр” арга хэмжээ;

3.1.Аймаг, нийслэл, орон нутгийн Засаг дарга нь тухайн орон нутагт нийтийн уншлагыг хөгжүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулсан тэргүүний уншигч гэр бүл, байгууллага хамт олныг шалгаруулах болзлыг батлан, жил бүрийн “Номын баярын өдөр” шагнаж урамшуулах арга хэмжээг зохион байгуулна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# ЦАГИЙН АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ: МОНГОЛ УЛС БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Жигваагүнсэл,*
*О.Нарантуяа, Р.Оргилмаа, Э.Дашзэгвэ*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Ерөнхий мэдээлэл

Нэг. Монгол Улсын цагийн ажил эрхлэлтийн эрх зүйн зохицуулалт, төрөөс үзүүлж буй дэмжлэг

- Хууль эрх зүйн орчин
- Цагийн ажил эрхлэлт, ажил олгогчдын талаарх судалгаа
- Төрөөс цагийн ажил эрхлэлтийг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Хоёр. Гадаадын зарим орны цагийн ажил эрхлэлт, төрөөс үзүүлж буй дэмжлэг, эрх зүйн зохицуулалтын талаарх туршлага

- Америкийн Нэгдсэн Улс (АНУ)
- Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)
- Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)
- Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)
- Бүгд Найрамдах Финланд Улс (Финланд)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Цагийн ажлын эрх зүйн зохицуулалт, төрөөс үзүүлж буй дэмжлэг: Монгол Улс болон гадаадын зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

***Судалгааны зорилго:*** Цагийн ажил эрхлэлтийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход шаардлагатай хууль эрх зүйн зохицуулалт, төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаарх Монгол Улсын болон гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судлах.

***Судалгааны хамрах хүрээ:*** Энэхүү судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу Монгол Улс болон АНУ, БНСУ, БНХАУ, Финланд Улс, ХБНГУ зэрэг орнуудыг хамруулж, эдгээр орнуудын цагийн ажил эрхлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт болон төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаарх асуудлыг хууль эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судалсан болно. Судалгаанд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ-ILO) болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ-OECD)-аас гаргасан судалгаа, дүн шинжилгээний тайлан, холбогдох олон улсын гэрээ, конвенц, судалгаанд авагдсан орнуудын статистик мэдээлэл, хууль эрх зүйн баримт бичгүүд, бусад мэдээллийн эх сурвалжуудыг ашиглалаа.

***Судалгааны бүтэц:*** Судалгаа нь ерөнхий мэдээлэл болон үндсэн 2 хэсэгтэй. Ерөнхий мэдээллийн хэсэгт, цагийн ажлын тодорхойлолт, олон улсын чиг хандлагын талаар, Нэгдүгээр хэсэгт, Монгол Улс дахь цагийн ажил эрхлэлтийн өнөөгийн нөхцөл байдал болон хууль эрх зүйн орчин, төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаар, Хоёрдугаар хэсэгт, захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу судалгаанд авагдсан орнуудын цагийн ажил эрхлэлтийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, ажил олгогчдод төрөөс үзүүлж буй дэмжлэгийн талаарх мэдээллийг тус тус оруулсан болно.

***Түлхүүр үг:*** *Цагийн ажил, цагийн хөдөлмөр эрхлэлт, бүтэн бус цагийн ажил, хагас цагийн ажил, цагийн ажилтан, цагийн ажил олгогч, цагийн ажил олгогчид үзүүлэх дэмжлэг, цагийн ажилтныг хамгаалах, цагийн ажил эрхлэлтийн тухай хууль эрх зүй*

***Keywords:*** *Part-time work, part-time employment, part-time worker, part-time employer, part-time employee, support for part-time employers, protection of part-time workers, part-time employment legistation*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

“Цагийн ажил” гэдэг нь ажил олгогч байгууллага, иргэнд тодорхой ажил, үүргийг биечлэн гүйцэтгэж, ажлын гүйцэтгэл, ажилласан цагт тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгохыг хэлнэ.[95]

Олон улсад “part-time work” буюу цагийн ажил гэдэгт ерөнхийдөө улирлын чанартай болон богино хугацаанд гэрээгээр гүйцэтгэх ажил (regular part time work), цөөн цагаар түр хугацаанд гүйцэтгэх цагийн ажлууд (marginal part time work)[96]-ыг хамруулан ойлгож байна.

Цагийн ажил эрхлэлт нь ажилгүйдлийг бууруулах, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг уян хатан болгох, мөн хөдөлмөрийн зардлыг багасгах нэг чухал хүчин зүйл болдог байна. Ялангуяа ажил олгогчийн хувьд энэ нь зарим ажил үйлчилгээг бүтэн цагийн ажилтан ажиллуулахгүйгээр гүйцэтгүүлэх, тодорхой хэлбэл, зардлын хэмнэлттэйгээр ажлаа төлөвлөн зохион байгуулах боломжийг олгодог байна.

2015 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас гаргасан “Цагийн ажилтнууд (Part-time workers)” судалгааны тайланд[97] “цагаар ажиллахад уян хатан байдал нь давуу тал болдог хэдий ч бүтэн цагийн ажилтнуудтай харьцуулахад цагийн ажилтны ажлын хөлсний үнэлгээ бага байхаас гадна нийгмийн халамж зэрэг зарим тодорхой баталгаанд хамрагдах шаардлагыг хангадаггүй, ажил мэргэжлийн карьер хязгаарлагдмал, сургалтын хөтөлбөрт хамрагдах боломжгүй зэрэг олон сул талтай” байдгийг онцлон дурджээ.

Судалгаанаас үзэхэд, олон улсын хэмжээнд цагийн ажлыг тодорхойлсон нэгдсэн тодорхойлолт одоогоор байхгүй байна. Учир нь улс орнуудад цагийн ажлын ойлголт, тодорхойлолт, ажиллах цагийн хязгаар, ажиллах хүчинд тооцох насны хязгаар зэрэг нь харилцан адилгүй байдагтай холбоотой байна. Харин ОУХБ-аас 1994 онд баталсан “Цагийн ажлын тухай” 175 дугаар конвенцод “цагийн ажилтан” гэж долоо хоногт ажиллах цаг нь харьцуулж болох үндсэн ажилтны ажлын цагаас бага цагаар ажилладаг хүнийг хэлнэ гэж ерөнхийд нь тодорхойлсон байна.

Цагийн ажлын хязгаар нь орон бүрд харилцан адилгүй байх бөгөөд дунджаар 30-35 цагийн хооронд хэлбэлзэж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас цагийн ажилтны долоо хоногт ажиллах цагийг 30 цаг байх нь тохиромжтой гэж дүгнэжээ.[98]

Сүүлийн үед “цагийн ажил эрхлэлт” буюу хөдөлмөрийн энэ харилцаа шинэ чиг хандлага болтлоо хөгжиж байна. Үүний гол үндэс нь хүн ам хурдацтай өсөж, хотжилт улам бүр эрчимжин, түүнийг дагаж үйлчилгээний салбар ихээхэн хөгжиж байгаа явдал юм. Үүнийг дагаад олон төрлийн ажил, үйлчилгээг цагаар болон тодорхой хугацаанд гэрээгээр гүйцэтгэх, гүйцэтгүүлэх боломж, нөхцөл бүрэлдсэн байна. Нөгөө талд бодлого тодорхойлогчдын зүгээс шинээр ажлын байр бий болгох, ажлын байрыг нэмэгдүүлэхэд бүх талаар анхаарал хандуулж байгаа хэдий ч энэ бүх хүчин чармайлт нь асар хурдацтай өсөж буй хүн амын эрэлтийг бүрэн хангаж чадахгүй хэвээр байгаа ажээ.

Судалгаанд хамруулсан Монгол Улс болон АНУ, БНСУ, БНХАУ, ХБНГУ, Финланд зэрэг орнуудын туршлагаас үзэхэд, эдгээр улс орнуудад ажилгүйдлийн хэмжээг бууруулах, зохих

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[95] http://www.mnums.edu.mn/?page_id=7092
[96] Долоо хоногт дунджаар 15-аас бага цагаар ажиллахыг хэлнэ.
[97] Part-time workers https://www.ilo.org/global/statistics-and-databases/research-and-databases/kilm/WCMS_422424/lang--en/index.htm
[98] OECD: “The definition of part-time work for the purpose of international comparisons”, in Labour Market and Social Policy, Occasional Paper No. 22 (Paris, 1997) https://www.oecd-ilibrary.org/docserver/132721856632.pdf?expires=1667198219&id=id&accname=guest&checksum=A025900C74ABEFD539E9110BD83D0E35

түвшинд барих зэрэг хүн амын тодорхой хэсэг, ялангуяа бүтэн цагаар орон тооны ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй нөхцөлд байгаа эмэгтэйчүүд, залуучууд, зорилтот бүлгийн иргэдэд өөрсдийн боломжоороо ажил хөдөлмөр эрхлэх уян хатан зохицуулалт хийх, хөдөлмөрийн нөхцөлийг бий болгоход ихээхэн анхаарч, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэн ажиллаж байна. Түүнчлэн цагийн ажил эрхлэлтийг дэмжих хүрээнд ажил олгогчдод чиглэсэн дэмжлэгийг түлхүү үзүүлж байгаа нь судалгаанаас харагдаж байна. /Харьцуулсан мэдээллийг хүснэгт 1-ээс үзнэ үү/

***<u>Цагийн ажлын хууль эрх зүйн зохицуулалтын тухайд:</u>***

Судалгаанд авагдсан орнуудын цагийн ажил эрхлэлтийг зохицуулсан *хууль эрх зүйн орчны хүрээг авч үзвэл*, судалгаанд авагдсан нийт 6 улсаас ХБНГУ, БНСУ-д цагийн ажил эрхлэлтийг тусгайлан зохицуулсан **бие даасан хуультай** байх бөгөөд бусад 4 улсад (Монгол Улс, БНХАУ, АНУ, Финланд Улс) **хөдөлмөрийн харилцааны ерөнхий хуулиар** зохицуулсан байна.

*Цагийн ажлын долоо хоногт зөвшөөрөгдөх цагийн хязгаарыг авч үзвэл*, судалгаанд хамрагдсан орнуудад 20-35 цагийн хооронд байна. Тухайлбал, Монгол Улсад 32 цаг, БНСУ-д 35 цаг, АНУ, Финланд Улсад 30 цаг, БНХАУ-д 24 цаг, ХБНГУ-д 20 цаг тус тус байна. Энэ нь олон улсад нийтлэг зөвшөөрөгдөх цагийн ажлын дундаж (олон улсад 30-40 цаг)-тай харьцуулахад БНХАУ, ХБНГУ-д харьцангуй бага цаг ажиллахыг зөвшөөрч байгаа бол бусад 4 улсад (30-35 цаг) дундаж цагт тооцогдож байна.

Цагийн ажил эрхэлж буй хүмүүсийг насны байдлаар нь авч үзвэл, залуучууд, тэтгэврийн насныхан, харин хүйсээр нь авч үзвэл, эмэгтэйчүүд зонхилж байгаа нь нийтлэг байна.

*Цагийн ажилтны ажиллах нөхцөл, ажлын хөлс, ажилтны эрх, үүргийн зохицуулалтыг авч үзвэл*, БНХАУ-аас бусад орнуудад (АНУ, БНСУ, Монгол Улс, Финланд Улс, ХБНГУ-д) цагийн ажилтныг ялгаварлан гадуурхахаас сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал болон эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хангах зорилгоор цагийн ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээнд ажил гүйцэтгэх хугацаа, цалин хөлс, талуудын эрх үүрэг, ажил-амралтын цагийг тодорхой тусгахаас гадна ажилтны цалин хөлс, нийгмийн баталгаа, ажиллах нөхцөл нь харьцуулж болох үндсэн ажилтныхтай адил тэгш байхаар тус тус зохицуулжээ.

Судалгаанд хамрагдсан орнуудын *зарим онцлох зохицуулалтуудыг дурдвал:*

**БНХАУ-д** цагийн ажилтантай заавал бичгээр гэрээ байгуулах шаардлагагүй бөгөөд аль нэг талын санаачилгаар хэдийд ч гэрээг цуцалж болдог байна. Мөн ажлын цаг, илүү цаг, нөхөн олговор зэрэг хөдөлмөрийн нөхцөлийн талаар ямар нэгэн дүрэм журам, хориглолт, хязгаарлалт байдаггүй бөгөөд орон нутгийн шийдвэрээс шалтгаалан өөр өөр зохицуулалт байж болдог.

**БНСУ-д** цагийн ажилтныг ажилд авахад заавал хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд гэрээнд хуульд заасан шаардлага болон нөхцөлүүдийг тусгаагүй тохиолдолд 5 сая хүртэл воноор торгох шийтгэл ногдуулахаар заажээ. Мөн гэрээнд зааснаас илүү цагаар ажиллахыг хязгаарлах зохицуулалттай. Тухайлбал, цагийн ажилтны долоо хоногт ажиллах илүү цагийн хязгаар 12 цагаас хэтрэх ёсгүй. Ажилтан илүү цагаар ажиллахаас татгалзах эрхтэй. Мөн үндсэн орон тоон дээр бүтэн цагийн ажилтан авах тохиолдолд тухайн ажил үүргийг гүйцэтгэж буй цагийн ажилтанд уг ажилд ороход нь давуу эрх олгодог зохицуулалт байна.

**АНУ-д** цагийн ажилтны асуудлыг тусад нь авч үздэггүй бөгөөд хөдөлмөрийн харилцаанд оролцогч “ажилтан” гэх статусаар хуульд зохицуулсан байдаг. Харин Холбооны Засгийн газар, түүний харьяа агентлагуудын ажилтнуудын цагийн ажил эрхлэх харилцааг “Холбооны

UIH.MN СУДАЛГААНЫ САН

ажилтнуудын цагийн ажил эрхлэлтийн хууль”-аар тусгайлан зохицуулсан байдаг. Уг хуульд зааснаар хуулийн зохицуулалтад хамрагдаж байгаа төрийн зарим байгууллагын ажилтнуудад эрүүл мэнд болон ар гэрийн амьдралаа зохицуулах, мөн сурч боловсрох, сайн дурын ажилд оролцоход нь дэмжих зорилгоор хагас цагаар буюу долоо хоногт 16-32 цаг ажиллах боломж олгосон. Мөн үндсэн ажилтнуудаас гадна дээрх байгууллагуудад иргэд өөрсдийн хүсэлтээр тогтмол цагийн хөдөлмөр эрхлэх боломжтой байдаг байна.

**ХБНГУ-д** цагийн ажилтан өөрийн хүсэлтээр ажил олгогчтой харилцан тохиролцож, тодорхой хугацаагаар гэрээ байгуулсны үндсэн дээр ажлын цагаа багасгах боломжтой. Гэрээт хугацаа дуусгавар болсноор тухайн ажилтан эргэн бүтэн цагийн ажилтан болох эрх нь нээлттэй байдаг. Гэхдээ 46-200 ажилтантай аж ахуйн нэгжүүдийн хувьд 15 ажилтан тутмын нэг нь ийм хүсэлт гаргах эрхтэйгээр хязгаарлаж зохицуулсан байна. Үүнийг тодорхой хугацаанд бүтэн цагийн ажлаас бага цагаар ажиллах шаардлага үүссэн ажилтнуудын эрэлт хэрэгцээг ажлын байраа алдахгүйгээр, ажил олгогчийн үйл ажиллагааг доголдуулахгүйгээр зохицуулдаг байна.

**Финланд Улсад** цагийн ажилтантай заавал хөдөлмөрийн гэрээ байгуулах ба хөдөлмөрийн нөхцөлийг зөвхөн хөдөлмөрийн гэрээний хугацаа, ажлын цагийг тодорхой үндэслэл шалтгаангүйгээр харьцуулж болох үндсэн ажилтныхаас дордуулж болохгүй. Цагийн ажилтанд үндсэн ажилтнаар орох боломжийг хамгийн түрүүнд олгохоор зохицуулсан байна.

**Монгол Улсад** сүүлийн жилүүдэд цагийн ажлын эрэлт хэрэгцээ нэмэгдсэнээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, цагийн ажилтны баталгааг хангахад анхаарч 2021 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-д цагийн ажилтны эрх зүйн байдлын талаарх зохицуулалтыг оруулсан. Хуульд цагийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ заавал байгуулах ба хөдөлмөрийн гэрээнд цагийн ажилтны ажлын хугацаа, цалин хөлс, эрх үүрэг зэргийг тусгайлан тохирох, нийт ажилласан цагт нь тохирсон ээлжийн амралт, нэмэгдэл амралт олгох зэргээр тухайн ажлын байранд бүтэн цагаар ажиллах ажилтны нөхцөлтэй адил түвшинд авч үзэхээр тус тус зохицуулсан байна.

***<u>Төрөөс цагийн ажил олгогчдод үзүүлж буй дэмжлэгийн талаар</u>*:**

Судалгаанаас үзэхэд, улс орнуудад нийтлэг байдлаар зорилтот бүлгийн хүмүүс болон удаан хугацаанд ажилгүй байсан ажил хайгч, ядуу, орлого багатай болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, өвчтэй болон хүүхдээ асарч буй эмэгтэйчүүд, гэмт хэрэгт холбогдож ял эдэлсэн хүн зэрэг ажил олоход бэрхшээлтэй байгаа хүмүүсийг байнгын болон цагийн ажилд авсан, түүнчлэн ажлын байр шинээр бий болгосон ажил олгогчдод төрөөс тодорхой хэмжээнд дэмжлэг үзүүлдэг туршлага байна. Тухайлбал, эдгээр нөхцөлийг хангасан **ажил олгогчдод** санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажилтны тоогоор цалингийн тодорхой хувийг нөхөн олговор хэлбэрээр олгох, ажлын байранд дадлагажигч ажилтнуудад грант тэтгэмж олгох хөтөлбөр хэрэгжүүлэх, хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор санхүүгийн татаас олгох зэрэг дэмжлэгүүд үзүүлж байна.

Судалгаанд авагдсан орнуудын ажил олгогчдод үзүүлж буй дэмжлэгийн төрлүүдийг орнуудаар нь авч үзвэл:

- Цалингийн татаас олгох (АНУ, БНСУ, ХБНГУ, Финланд Улс)
- Санхүүгийн дэмжлэг үзүүлэх хэлбэр (Монгол Улс, БНХАУ, ХБНГУ)
- Татварын хөнгөлөлт үзүүлэх хэлбэр (АНУ, БНХАУ, Монгол Улс)
- Хөнгөлөлттэй зээл олгох (БНХАУ, Монгол Улс)-ыг тус тус нэрлэж болно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Судалгаанд хамруулсан улс орнуудад тухайлбал, Финланд Улсад удаан хугацаанд ажилгүй байсан ажил хайгч болон зорилтот бүлгийн иргэдийг ажилд авсан тохиолдолд цалингийн 30-50 хувийг цалингийн татаас хэлбэрээр олгодог бол АНУ-д дагалдан суралцуулах тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэн, ажлын байранд дадлагажигчийг цалинжуулан ажиллуулахад дадлагажигчийн тоогоор **цалингийн татаас** олгож байна. Мөн ХБНГУ-д ажил олгогчдод *ажил эрхлэлтийн тэтгэмжийг* олгож байна. Үүнийг ажлын туршлага мэдлэггүй иргэдийг сурган ажилд авсан болон өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авсан тохиолдолд ажилтны цалингийн 50 хүртэл хувиар тооцон 1 жилийн хугацаанд сар бүр олгодог байна. БНСУ-д “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд ажлын байр бий болгосон ажил олгогчид төсвөөс татаас олгож байна.

Харин **санхүүгийн дэмжлэг**ийг БНХАУ, Монгол Улс, ХБНГУ-д ажилгүй иргэдийг тэр дундаа зорилтот бүлгийн иргэдийг ажлын байраар хангах, цагийн болон үндсэн ажилтнаар ажилд авсан тохиолдолд ажлын байрыг нэмэгдүүлэх, хадгалахад нь зориулж санхүүгийн нэг удаагийн буцалтгүй тусламж, эргэлтийн хөрөнгийн дэмжлэг олгодог. Тухайлбал, Монгол Улсад “Ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд богино хугацааны **эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийг** 150 хүртэл мянган төгрөгөөс эхлэн 1 сар хүртэл хугацаатай олгох бөгөөд хугацаандаа зээлийг эргэн төлсөн тохиолдол бүрд **зээл авах боломжит хэмжээг нэмэгдүүлж 500 хүртэл мянган төгрөгийг хүүгүй, барьцаагүй, 100 хувийн эргэн төлөлттэйгөөр** олгодог.

**Татварын хөнгөлөлт**ийн хувьд АНУ-д тогтмол болон түр ажлын байранд зорилтот бүлгийн иргэдийг ажилд авсан тохиолдолд ажилтан тус бүрийн тоогоор 2400-9600 ам.долларын татварын хөнгөлөлтийг ХАОАТ-аас суутгуулах болон цалингийн татвараас хасуулан тооцуулдаг туршлага байна.

**Цагийн ажилтнуудад үзүүлж буй дэмжлэг**ийн тухайд, БНСУ-д амралтын болон илүү цагийн ажлын хөлс, нэмэгдэл цалин олгох, БНХАУ, ХБНГУ-д бага цалинтай ажилтнууд болон долоо хоногт цөөн цагаар ажилладаг эмзэг бүлгийнхэнд нэмэлт халамж, тэтгэмж олгох, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах зэргээр дэмжлэг үзүүлдэг байна. Харин Монгол Улсад цагийн ажилтанд олгох тусгайлсан дэмжлэг байхгүй байна.

*Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 1. Улс орнуудын цагийн ажлын хууль эрх зүйн зохицуулалт, төрөөс үзүүлэх дэмжлэгийн талаарх харьцуулалт*

| № | Улсын нэр | Гол зохицуулах хууль | 7 хоногт ажиллах цаг | Онцлог зохицуулалт | Төрөөс үзүүлэх дэмжлэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | Монгол Улс | - Хөдөлмөрийн тухай хууль<br>- Оюутны цагийн ажил эрхлэх журам | 32-оос илүүгүй | - Ажлын хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, эсхүл цагаар тооцож, хугацаанд нь олгоно.<br>- Ажлын цагт тохирсон ээлжийн болон нэмэгдэл амралт эдлэх эрхтэй.<br>- Хөдөлмөрийн хэм хэмжээ нь үндсэн ажилтныхтай адил тэгш байна. | - *Хөнгөлөлттэй зээл олгох;*<br>- *татварын хөнгөлөлт үзүүлэх;*<br>- *эргэн төлөх нөхцөлгүй болон нөхцөлтэйгээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх.*<br>(Хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, удаан хугацаанд ажил хайгч, оюутан залуучуудыг ажлын байраар хангасан ажил олгогчдод) |
| 2 | АНУ | - Шударга хөдөлмөрийн стандартын тухай хууль<br>- Холбооны ажилтнуудын цагийн ажил эрхлэлтийн тухай хууль | 30-аас доош, зарим тохиолдолд 34 хүртэл цагийг зөвшөөрдөг. | - Цагийн ажилтан гэсэн тусгай зохицуулалт байхгүй. Хөдөлмөрийн харилцаанд оролцогч ажилтан гэж үздэг.<br>- Холбооны Засгийн газрын хэмжээнд цагийн ажил эрхлэлтийг салбар болон ажилтны зэрэглэлээр хязгаарлаагүй. Ажилтны хүсэлтээр, ажлын шаардлагаар ямар ч ажлыг богино цагаар хийж болно.<br>- Мөн Холбооны Засгийн газрын яам, агентлагуудад иргэд цагийн эрхлэх боломжтой. | - *Татварын хөнгөлөлт (ХАОАТ-аас хүний тоогоор 3750-7500$)*<br>- *Цалингийн татаас (цалингийн 60%-тай тэнцэх)*<br>- *Ажилтны учруулсан хохирлын нөхөн төлбөр (5000-25000$)*<br>(Хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, өндөр настан, гэмт хэрэгт холбогдож ял эдэлсэн зэрэг ажил олоход бэрхшээлтэй иргэд, ажилгүй удаан хугацаанд байсан ажил хайгч, хүүхдээ асарч байгаа, өвчтөн асарч байгаа зайлшгүй цагийн ажил эрхлэх шаардлагатай иргэдийг ажилд авсан тохиолдолд) |
| 3 | БНСУ | - Хөдөлмөрийн жишиг тогтоох тухай хууль<br>- Тогтсон хугацаанд гэрээгээр ажиллагсад болон цагийн ажил эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль | 35-аас доош | - Цагийн болон тодорхой хугацаанд гэрээгээр ажиллагчтай заавал гэрээ байгуулах бөгөөд гэрээнд заавал тусгах нөхцөлүүдийг зөрчсөн ажил олгогчдод 5 сая хүртэл воны торгууль ногдуулна.<br>- Илүү цагаар ажиллуулахыг хориглоно.<br>- Цагийн ажилтан илүү цагаар ажиллахаас татгалзах эрхтэй. | - *Ажилтанд цалинтай амралт, гэрээнд зааснаас илүү цагаар ажиллахыг хязгаарлах, үндсэн ажилтан авахад цагийн ажилтанд давуу эрх олгох.*<br>- *Ажил олгогчдод цалингийн татаас олгодог. (160-720 сая)*<br>(Удаан хугацаанд ажилгүй байсан, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өрх толгойлсон эмэгтэй, арлын оршин суугчдыг ажилд авсан тохиолдолд) |
| 4 | БНХАУ | - Хөдөлмөрийн гэрээний тухай хууль | 24-өөс ихгүй | - Цагийн ажилтантай гэрээг заавал бичгээр байгуулах шаардлагагүй. Аль нэг талын санаачилгаар хэдийд ч цуцалж болно.<br>- Хөдөлмөрийн нөхцөлийн талаар тусгайлсан зохицуулалт байхгүй ч орон | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, хөтөлбөрүүд нь зорилтот бүлэгт чиглэсэн байдаг. Бодлого, хөтөлбөрүүдийн хүрээнд дараах дэмжлэгүүдийг олгодог:<br>- *Бичил зээл олгох;*<br>- *татварын хөнгөлөлт;* |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | нутгуудад журмаар зохицуулах тохиолдол бий.<br>- Тогтоосон цагаас илүү хугацаагаар ажиллавал түүнийг тухайн ажлын байртай холбоотой бүхий л хууль ёсны үүрэг, хариуцлагыг хүлээх үндсэн ажилтан гэж тооцдог байна. | - *нийгмийн халамжийн үйлчилгээ, цалингийн тэтгэмж;*<br>- *санхүүгийн дэмжлэг.* |
| 5 | ХБНГУ | - Цагийн ажил эрхлэлт болон тогтсон хугацаанд гэрээгээр хөдөлмөрлөх тухай хууль<br>- Цагийн ажил эрхлэлтийг цаашид хөгжүүлэх тухай хууль | 20 цаг | - Ажлын цагийн уян хатан зохицуулалттай. Ажилтан хүсвэл цагийн ажилд шилжиж болно. Гэрээнд заасан хугацаа дуусмагц үндсэн ажилд шилжих боломжтой. | - *Ажил олгогчид олгох ажил эрхлэлтийн тэтгэмж (цалингийн нөхөн төлбөр*-хөгжлийн бэрхшээлтэй, ажлын туршлагагүй, ахмад настныг сурган ажилд авсан тохиолдолд ажилтны тоогоор цалингийн 50 хувьтай тэнцэх)<br>- *Санхүүгийн татаас* (зорилтот бүлгийг ажлын байраар хангасан) |
| 6 | Финланд | - Хөдөлмөрийн гэрээний тухай хууль | 30 цаг | - Цагийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулна. Хөдөлмөрийн нөхцөлийг үндсэн ажилтныхаас дордуулж болохгүй. Үндсэн ажилтнаар орох боломжийг хамгийн түрүүнд олгоно. | - *Цалингийн нөхөн төлбөр* (удаан хугацаанд ажилгүй байсан ажил хайгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 25-аас доош насны ажил хайгч, өндөр настан зэрэг хүмүүсийг байнгын болон цагийн ажилд авсан ажил олгогчид 30-50 хувийн цалингийн нөхөн олговор олгодог) |

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

## ЦАГИЙН АЖЛЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ: МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Цагийн ажил (Part-time) буюу бүтэн бус цагийн ажил[99] гэдэг нь тодорхой ажлыг хийж гүйцэтгээд зарцуулсан цаг, хөдөлмөрийн бүтээмждээ тохирсон ажлын хөлсөө шууд авдаг ажил эрхлэлтийн нэг хэлбэр юм.

Сүүлийн үед хөгжингүй болон хөгжиж буй орнуудад цагийн ажилчдын тоо эрс нэмэгдэх хандлагатай байна. Энэ хандлага нь хүн амын өсөлтийн хурдац, эрчимтэй хотжилт, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт өссөн зэрэгтэй холбоотойгоос гадна аж үйлдвэр хоорондын шилжин ажиллах хөдөлгөөний зохицуулалт, үйлчилгээний салбарын өсөлт, хөгжилтэй холбоотой байна.

***Ерөнхий мэдээлэл:***

***Цагийн ажлын тухай олон улсын тодорхойлолт***

Дэлхий нийтээр “Part-time” буюу цагийн ажил гэдгийн нэгдсэн тодорхойлолтыг одоогоор гаргаагүй байна. Учир нь улс орон бүрд бүтэн цаг ба хагас цагийн ажил хоёрын хоорондын ялгааг тогтоох, эдгээр нэр томьёог ойлгох ойлголт зөрүүтэй байгаагаас шалтгаалан олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн хэмжүүрт хүрээгүй байна.[100]

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын 1994 оны Цагийн ажлын тухай (№ 175) конвенц (Part-Time Work Convention, 1994 (No. 175))-д “цагийн ажилтан” гэдгийг ажлын цаг нь харьцуулж болох үндсэн ажилтныхаас бага цагаар ажиллах ажилтныг хэлнэ гэж тодорхойлжээ.[101] Энэ нь цагийн ажлын тухай хууль эрх зүйн нийтлэг тодорхойлолт бөгөөд Европын холбооны цагийн ажлын удирдамжид тусгагдсан байдаг аж.

Харин Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ-OECD)-аас 1997 онд цагийн ажлын тодорхойлолтуудад дүн шинжилгээ хийж, 30 цагийн хязгаарыг үндэс болгон цагийн ажлыг тодорхойлох нь олон улсын харьцуулалтад илүү сайн тохирч байна гэсэн дүгнэлтийг гаргажээ.[102] Түүнээс хойш ЭЗХАХБ нь өөрийн гишүүн улс орнуудын мэдээллийг нэгтгэн гаргахдаа үндсэн ажлын 30 цагийн хязгаарыг үндэслэл болгодог болсон байна.

Цагийн ажлын талаарх мэдээлэл нь улс орон бүрд ялгаатай. Тухайлбал, улс орнуудын долоо хоногт ажиллах цагийн хязгаар үндсэндээ 30-40 цагийн хооронд байна. Долоо хоногт 35 болон түүнээс дээш цагаар ажиллагчдыг “бүтэн цагийн ажилтнууд”, харин 35-аас бага цагаар ажиллагчдыг “цагийн ажилтнууд буюу бүтэн бус цагийн ажилтнууд” гэж ангилах нь түгээмэл байна.

Энэ нь улс орнуудын бүтэн болон хагас цагийн ажлын тодорхойлолт, соёл, ажлын байрны хэм хэмжээ, ажиллах хүчинд тооцох насны дээд доод хязгаар зэрэг нь харилцан адилгүй

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[99] Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд “Цагийн ажил” гэсэн ойлголтыг “Бүтэн бус цагийн ажил” гэж томьёолсон байна.
[100] Part-time work https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---travail/documents/publication/wcms_170717.pdf
[101] the Part-Time Work Convention (No. 175) and Recommendation (No.182); https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:C175
[102] OECD: “The definition of part-time work for the purpose of international comparisons”, in Labour Market and Social Policy, Occasional Paper No. 22 (Paris, 1997) https://www.oecdilibrary.org/docserver/132721856632.pdf?expires=1667198219&id=id&accname=guest&checksum=A025900C74ABEFD539E9110BD83D0E35

ялгаатай байгаагаас шалтгаалж байна. Өөрөөр хэлбэл, зарим улсад хөдөлмөрийн насны доод хязгаар 10 байхад нөгөөд нь 16, тэтгэврийн насны хувьд зарим нь хязгаар тавиагүй байхад зарим улсад 65 нас гэх мэтчилэн тогтоосон байдаг. Тиймээс эдгээрийг зааглах хэмжүүрийг улс орнууд тус тусдаа тодорхойлж болохуйцаар нээлттэй орхисон байна.

*1994 оны “Цагийн ажлын тухай” 175 дугаар конвенцын* дагуу бүтэн бус цагаар ажиллаж байгаа хүмүүс бүтэн цагаар ажиллаж байгаа хүмүүсийн нэгэн адил зохион байгуулалтад хамрагдах, хамтын хэлэлцээ хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөр эрхлэлт, мэргэжилд ялгаварлан гадуурхагдахгүй байх эрхийг эдэлнэ. Түүнчлэн, эхчүүдийн эрх болон хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлт дуусгавар болохтой холбоотой бусад нөхцөлийг бүтэн цагийн ажилтнуудтай адил тэгш байхаар заасан. Мөн ажлын бүтэн өдрийн ажлаас цагийн ажилд шилжих, эсхүл цагийн ажлаас ажлын бүтэн өдөрт шилжих нь сайн дурын үндсэн дээр явагдах ёстой байдаг байна.

Үүнээс үзэхэд “цагийн ажил” гэдгийг олон улсад ажил хөдөлмөр эрхэлж байгаа цагийнх нь хувьд ялган нэрлэж байгаа бөгөөд бусад талаар аль болох ялгаварлан гадуурхахгүй, бүтэн цагийн ажилтнуудтай адил түвшинд нийгмийн баталгаагаар хангагдах ёстой гэсэн чиг хандлагыг баримталж байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хувьд Финланд Улсаас бусад нь дээрх конвенцод нэгдэн ороогүй байна.

2015 онд ОУХБ-аас гаргасан “Цагийн ажилтнууд (Part-time workers)” хэмээх судалгааны тайланд[103] цагаар ажиллахад уян хатан байдал нь давуу тал болдог ч бүтэн цагийн ажилтнуудтай харьцуулахад цагийн ажилтны ажлын хөлсний үнэлгээ илүү бага байхын зэрэгцээ зарим тодорхой нийгмийн халамж, баталгаанд хамрагдах шаардлагыг хангадаггүй, ажил мэргэжлийн карьер хязгаарлагдмал, сургалтын хөтөлбөрт хамрагдах боломжгүй байдаг зэрэг олон сул талтай хэмээн дурджээ.

Тиймээс 1990-ээд оны эхэн үеэс ЭЗХАХБ-ын ихэнх улс орнууд цагийн ажлын чанарыг сайжруулах арга хэмжээг авч эхэлсэн байна. Үүний үр дүнд цагийн ажилтнуудын нийгмийн халамжид хамрагдах байдал сайжирсан ч зарим улс орнуудын хувьд үндсэн ажилтан болон цагийн ажилтны хоорондох ажил мэргэжлийн ялгаатай байдал нь цагийн ажилтнуудын ажлын сонголтыг хязгаарладаг зэрэг асуудлуудыг дагуулсан хэвээр байна.

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр даяарчлагдаж, ажлын цагийн уян хатан байдал, цагийн ажил эрхлэх эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр цагаар ажиллах таатай нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ажил олгогчдыг дэмжих, ингэхдээ ялгаварлан гадуурхалтыг арилгах, цагийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалахад анхаарч ажиллахыг ОУХБ-аас дэлхийн улс орнуудад уриалж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр шинэчлэн баталсан Хөдөлмөрийн тухай хуульд хуучин “цагийн ажилтан” гэж байсныг “бүтэн бус цагийн ажилтан” гэж өөрчлөн томьёолж, зарим шинэ зохицуулалтуудыг хийсэн нь дээрх олон улсын чиг хандлагад нийцсэн чухал алхам болсон байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[103] Part-time workers https://www.ilo.org/global/statistics-and-databases/research-and-databases/kilm/WCMS_422424/lang--en/index.htm

## Нэг. МОНГОЛ УЛСЫН ЦАГИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ

***Хууль эрх зүйн орчин***

Манай улсад цагийн ажил эрхлэлттэй холбоотой харилцааг Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Монгол Улсад ажил олгогч цагийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах зохицуулалт байсан ч практикт хэрхэн хэрэглэх нь тодорхойгүй байсан. 2017 онд Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор цагийн ажилтны хөдөлмөрийн гэрээний эрх зүйн зохицуулалт бий болсон байдаг.

Улмаар 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас **Хөдөлмөрийн тухай хуулийн** шинэчилсэн найруулгыг хэлэлцэн баталсан. Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-аар зохицуулах харилцаа, хамрах хүрээг өргөтгөн, ажил олгогч болон ажилтны хуулиар хамгаалагдах эрх үүргийг тэнцвэржүүлэх, олон улсын хөдөлмөрийн суурь эрх болох эвлэлдэн нэгдэх, ялгаварлан гадуурхахгүй байх, үндсэн ажлын байранд хөдөлмөрийн гэрээг хугацаагүйгээр байгуулах, хөдөлмөр эрхлэлтийн гуравласан харилцаа, **бүтэн бус цагаар ажиллах**, зайнаас ажиллах зэрэг онцлог зохицуулалтуудыг тусгажээ.

Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 66.1-д ажлын **бүтэн бус цагийн ажилтан** (хуучин хуулиар цагийн ажилтан) гэж ажлын бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтнаас бага цагаар ажиллаж байгаа ажилтныг ойлгоно гэж заасан бөгөөд уг хөдөлмөрийн гэрээнд ажлын өдөр, ажил эхлэх, дуусах цаг, долоо хоногт ажиллах цагийг тусгайлан тохирохоор шинээр зохицуулжээ. Тухайлбал, тус хуулийн 86.1-д ажлын бүтэн бус цагаар ажиллах ажилтны 7 хоногт ажиллах цаг 32-оос илүүгүй байхаар, 111.1-д ажлын бүтэн бус цагийн ажилтны цагаар болон хийснээр тооцох цалингийн нэгжийн үнэлгээ нь ижил ажлын байранд бүтэн цагаар ажилладаг ажилтныхаас багагүй байхаар, 111.2-т ажлын бүтэн бус цагийн ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, эсхүл ажилласан цагаар нь тооцож ажилтантай тохиролцсон хугацаанд олгоно гэж заажээ. Мөн ажлын бүтэн бус цагийн ажилтан нь Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулгад)-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажлын бүтэн цагаар ажиллах ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нэгэн адил үйлчилнэ. Ажлын бүтэн бус цагийн ажилтанд тухайн жилд нийт ажилласан цагийг нь тооцож, ногдох ээлжийн үндсэн болон нэмэгдэл амралт олгохоор заасан тул ажлын бүтэн бус цагийн ажилтан мөн бүтэн цагийн ажилтны адилаар ээлжийн амралт эдлэх эрхтэй байна.[104] (Хүснэгт 2-оос дэлгэрэнгүй үзнэ үү)

Ажилгүйдлийг бууруулах, иргэдийн орлого, хөдөлмөрлөх идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас ажилгүй иргэдийг албан бус хөдөлмөрт хамруулах зохион байгуулалттай ажлууд хэрэгжүүлдэг. Үүний нэг жишээ нь, өнөөгийн хөдөлмөрийн зах зээл дээрх "Цагийн ажил" гэдэг ойлголтод хамрагдах "Нийтийг хамарсан ажил", "Оюутны цагийн хөдөлмөр эрхлэлт" зэрэг юм.

Монгол Улсын Их Хурлаас 2017 онд баталсан **Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн** 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалтад "хувийн хэвшлийн байгууллага (100 ба түүнээс дээш ажилтантай) нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц оюутны цагийн ажлын орон тоо гаргах", 11.3 дахь хэсэгт Засгийн газар холбогдох журмыг боловсруулахаар заасан. Дээрх хуулийн заалт, нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн "**Оюутны цагийн хөдөлмөр**

[104] Хөдөлмөрийн тухай хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751

**эрхлэх журам**”-ын төслийг боловсруулж Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталжээ.

Журамд оюутан цагийн хөдөлмөр эрхлэхэд баримтлах зарчим нь оюутны хүсэл, сонирхол, сонголт, хэрэгцээнд тулгуурласан байх, тухайн ажлын үнэлгээнд тохирсон цалин хөлстэй байх, оюутны эрүүл мэнд, аюулгүй байдал, бие хүний төлөвшил, хичээл сургалтад сөргөөр нөлөөлөхгүй байхаар тусгасан. Ингэхдээ оюутан хичээлийн бус үед тогтоосон цагийн хязгаар дотор ажил хийх, судалгаа шинжилгээний ажилд оролцох, бие даан бүтээл туурвих, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх замаар орлого олох боломжтой болсон.

*Хүснэгт 2. Монгол Улсын цагийн ажлын талаарх эрх зүйн зохицуулалт*

| | Баримт бичгийн нэр | Зохицуулалт |
|---|---|---|
| 1 | ***Хөдөлмөрийн тухай хууль***[105] | **66 дугаар зүйл.Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ**<br>66.1.Ажил олгогч ажилтантай тохиролцсоны дагуу ажлын бүтэн бус цагаар ажиллуулахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж болно. “**Ажлын бүтэн бус цагийн ажилтан**” гэж ажлын бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтнаас бага цагаар ажиллаж байгаа ажилтныг ойлгоно.<br>66.2.Ажлын бүтэн бус цагийн ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасан нөхцөлөөс гадна өдөрт, эсхүл долоо хоногт, эсхүл сард ажиллах нийт цаг, ажил эхлэх, дуусах цагийг тусгайлан тохирно.<br>66.3.Ажлын бүтэн цагийн ажилтны ажлын цагийг хууль тогтоомжид заасны дагуу богиносгосныг бүтэн бус цагаар ажилласанд тооцохгүй.<br>66.4.Ажлын бүтэн бус цагийн ажилтан энэ хуульд тусгайлан заасндаас бусад тохиолдолд ажлын бүтэн цагаар ажиллах ажилтны нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээх бөгөөд хөдөлмөрийн хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нэгэн адил үйлчилнэ.<br>66.5.Ажил олгогч түр ажил үүргийг гүйцэтгүүлэхээр ажилтныг цагаар ажиллуулж, гүйцэтгэсэн ажил, ажилласан цагт нь тохирсон цалин хөлсийг тухай бүр тооцож олгож болно.<br>82.4.Ажлын бүтэн бус цагийн ажилтны ажилласан цагийг бүтэн цагт шилжүүлэн тооцож, энэ хуулийн 82.1-д заасны дагуу тэтгэмж олгоно.<br>86.1.Ажлын бүтэн бус цагаар ажиллах ажилтны **долоо хоногт ажиллах цаг 32-оос илүүгүй** байна.<br>91.3.Ажлын бүтэн бус цагаар ажиллах хөдөлмөрийн гэрээнд заасан ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажилласанд тооцно.<br>99.7.Ажлын бүтэн бус цагийн ажилтанд тухайн ажлын жилд нийт ажилласан цагийг нь тооцож, ногдох ээлжийн үндсэн болон нэмэгдэл амралт олгоно.<br><br>**109 дүгээр зүйл.Нэмэгдэл хөлс**<br>109.1.Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.<br>109.2.Долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.<br>109.3.Шөнийн цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.<br>109.4.Нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.<br>109.5.Ажилтныг илүү цагаар, долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр шөнийн цагт ажиллуулсан бол энэ хуулийн 109.1, 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс дээр шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг нэмж олгоно. |

[105] Хөдөлмөрийн тухай хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751



UIH.MN ЧУУЛГАНЫ САН

| | | |
|---|---|---|
| | | 109.6.Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно.<br>109.7.Ажлын бүтэн бус цагийн ажилтанд энэ хуулийн 109.1, 109.2, 109.3, 109.4, 109.5, 109.6 дахь хэсэг нэгэн адил хамаарна.<br>**111 дүгээр зүйл.Ажлын бүтэн бус цагийн ажилтны цалин хөлс**<br>111.1.Ажлын бүтэн бус цагийн ажилтны цагаар болон хийснээр тооцох цалингийн нэгжийн үнэлгээ нь ижил ажлын байранд бүтэн цагаар ажилладаг ажилтныхаас багагүй байна.<br>111.2.Ажлын бүтэн бус цагийн ажилтны цалин хөлсийг гүйцэтгэсэн ажлын хэмжээ, эсхүл ажилласан цагаар нь тооцож ажилтантай тохиролцсон хугацаанд олгоно.<br>111.3.Нэг сараас дээш хугацаагаар ажиллах бүтэн бус цагийн ажилтны цалин хөлсийг энэ хуулийн 104.1-д заасны дагуу олгож болно.<br>144.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асардаг ажилтан хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч түүнд гэрээсээ, зайнаас, бүтэн бус цагаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжит арга хэмжээг авна.<br>145.3.Ажил олгогч ахмад настны хүсэлтээр ажлын цагийг богиносгож, бүтэн бус цагаар ажиллуулж, эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна. |
| 2 | ***Иргэний хууль***[106] | **359 дүгээр зүйл. Хөлсөөр ажиллах гэрээ**<br>359.1.Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.<br>359.2.Энэ гэрээний зүйл нь бүх төрлийн ажил, үйлчилгээ байж болно. |
| ***3*** | ***Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль***[107] | **14 дүгээр зүйл.Нийтийг хамарсан ажил зохион байгуулах**<br>14.1.Нийтийг хамарсан ажлыг ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон ажилгүй иргэнийг түр хугацаагаар ажиллуулах, орлого нэмэгдүүлэх төрөл бүрийн арга хэмжээний хэлбэрээр зохион байгуулна.<br>14.2.Нийтийг хамарсан ажлын хөтөлбөрийг аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллага орон нутгийн нөөц бололцоо, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн боловсруулж, нутгийн захиргааны байгууллага болон аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.<br>*/Энэ хэсэгт 2016 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*<br>14.3.Гамшгийн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх зорилгоор аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан байгууллагаас нийтийг хамарсан ажлын түр хөтөлбөр хэрэгжүүлж болно.<br>*/Энэ хэсэгт 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/*<br>14.4.Нийтийг хамарсан ажлын хөлс, тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас, бусад зардлыг орон нутгийн төсвөөс болон аж ахуйн нэгж, байгууллага гаргана.<br>14.5.Нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зардлын хэмжээг ажлын онцлогийг харгалзан хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.<br>14.6.Нийтийг хамарсан ажлын нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна. |
| ***4*** | ***Нийтийг хамарсан ажил зохион байгуулах журам***[108] | **Нэг. Нийтлэг үндэслэл**<br>1.2. Нийтийг хамарсан ажил нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэлбэр бөгөөд хөдөлмөр зарцуулалт ихтэй, мэргэжил шаардахгүй ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг зохион байгуулж оролцуулах замаар хэрэгжүүлнэ.<br>1.3. Нийтийг хамарсан ажил нь дараах зорилтыг хангахад чиглэнэ:<br>• Нийтийг хамарсан ажилд түр хугацааны болон улирлын чанартай ажил гүйцэтгүүлж улс, орон нутгийн болон тухайн байгууллагын хэрэгцээг хангах;<br>• Хөдөлмөрийн хөлс /орлого/-ний хэлбэрээр иргэдэд дэмжлэг үзүүлэх; |

UIH.MN ... САН

[106] https://legalinfo.mn/mn/detail/299
[107] https://legalinfo.mn/mn/detail?lawId=563
[108] https://legalinfo.mn/mn/detail?lawId=201051&showType=1

| | | |
|---|---|---|
| | ***/Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 31 дүгээр тогтоол/*** | • Удаан хугацаагаар ажилгүй байгаа болон мэргэжилгүй, эсхүл ажлын дадлага, туршлага багатай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний хөдөлмөрлөх идэвхийг өрнүүлэх.<br>**Гурав. Нийтийг хамарсан ажлын санхүүжилт зохион байгуулалт:**<br>13.Нийтийг хамарсан ажил зохион байгуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага уг ажилд оролцох иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулна.<br>**Дөрөв. Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдийн цалин хөлс, нийгмийн даатгал**<br>16.Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэнд ажлын гүйцэтгэлээр нь хөдөлмөрийн хөлс олгоно. Хөдөлмөрийн хөлс нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.<br>17.Нийтийг хамарсан ажилд оролцож байгаа иргэн болон зохион байгуулагч аж ахуйн нэгж, байгууллага Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлнө. |
| ***5*** | ***Оюутны цагийн хөдөлмөр эрхлэх журам***[109] | **Нэг. Нийтлэг үндэслэл**<br>1.1. Энэ журмын зорилго нь оюутан сайн дурын үндсэн дээр хичээлийн бус цагаар хөдөлмөр эрхлэн ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, дадлагажих, төгсөөд шууд ажлын байртай болох, орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.<br>1.2. Оюутныг хувийн хэвшлийн байгууллага (100 ба түүнээс дээш ажилтантай)-д цагаар хөдөлмөр эрхлүүлэх, түүнтэй холбоотой үүссэн харилцааг энэ журмаар зохицуулна.<br>1.3. “Оюутан” гэж их сургууль, дээд сургууль, коллежийн дипломын болон бакалаврын шатлалд суралцагчийг ойлгоно.<br>**Хоёр. Оюутан цагаар хөдөлмөр эрхлэх зохицуулалт**<br>2.1. Хувийн хэвшлийн байгууллага (100 ба түүнээс дээш ажилтантай) нийт ажилтнуудын 5 хувьтай тэнцэхүйц цагийн ажлын орон тоо гаргаж, оюутныг хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.<br>2.2. Оюутны цагийн ажлын үргэлжлэх хугацаа нь түүний сурч боловсрол нөхцөлийг хязгаарлахааргүй байна. Ажлын цагийн хязгаарлалт нь их, дээд сургууль, коллежийн оюутны улирлын амралтын хугацаанд хамаарахгүй.<br>2.3. Хувийн хэвшлийн байгууллага нь оюутантай цагийн хөдөлмөр эрхлэхтэй холбоотой хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд хөдөлмөрийн гэрээнд гүйцэтгэх ажил үүрэг, ажлын цаг, хөдөлмөрийн нөхцөл, цалин хөлсийг оюутны суралцах, ажиллах цагийн харьцаа, хийх ажлын чанар хэмжээг харгалзан талууд харилцан тохиролцож тусгана.<br>2.4. Мэргэжлийн чиг баримжаа, ажлын дадлага олгох зорилгоор 15 нас хүрсэн оюутантай эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулж, эрүүл мэнд, өсөлт хөгжилд нь сөрөг нөлөө үзүүлэхгүй, сурч боловсроход нь саад учруулахгүй нөхцөлд цагийн ажил эрхлүүлж болно.<br>2.5. Ажил олгогч нь хөдөлмөрийн гэрээнд тусгаагүй ажил үүрэг гүйцэтгэхийг оюутнаас шаардахыг хориглоно.<br>2.9. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв нь цагийн ажлын байрыг оюутнуудад нээлттэй танилцуулж, хөдөлмөр эрхлэх хүсэлтэй оюутнуудын бүртгэл хөтөлнө. |

***Цагийн ажил эрхлэлт, ажил олгогчдын талаарх судалгаа***

Монгол Улсад Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-ийн зорилтод тусгагдсан зохистой хөдөлмөр эрхлэлтийн зарим үзүүлэлтийг шинээр тооцдог болох хүрээнд 2019, 2020 онд цаг хугацаанаас хамаарсан бүтэн бус хөдөлмөр эрхлэгч, боломжит ажиллах хүч, цаг хугацаанаас хамаарсан **бүтэн бус хөдөлмөр эрхлэлт** болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин зэрэг үзүүлэлтийг тооцож эхэлсэн байна.

UIH MN СУДАЛГААНЫ САН

109 https://legalinfo.mn/mn/detail?lawId=211117&showType=1

*Бүтэн бус цагаар ажиллагчид*

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны “Цалин хөлсний бүтцийн судалгаа-2021” тайланд[110] дурдсанаар судалгаанд хамрагдсан Аж ахуйн нэгж, байгууллага (ААНБ)-ын ажиллагчдын 3.2 хувь нь бүрэн бус цагаар буюу 7 хоногт дунджаар 36.7 цаг хөдөлмөр эрхэлж байна. Тэдний 59.3 хувь нь эрэгтэй, 40.7 хувь нь эмэгтэй, дундаж нас 41.3 байгаа юм. Эмэгтэй ажиллагчдын 7 хоногийн ажлын дундаж цаг эрэгтэйчүүдээс 1.2 цагаар бага байна.

ААНБ-ын Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харвал тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбар (12.4 хувь), удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар (11.1 хувь), бөөний болон жижиглэн худалдааны салбарт (11.0 хувь) хамгийн олон бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчид байна.

Бүрэн бус цагаар ажиллагчид улсын нийт цалингийн дунджаас бага цалингаар хөдөлмөр эрхэлж байна. Нийт цалингийн дундаж 806.2 мянган төгрөг байгаагийн 90.9 хувь нь үндсэн цалин, мөн 4.3 хувь нь нэмэгдэл хөлс, 0.5 хувь нь шагнал урамшуулал байна.

Бүрэн бус цагаар ажиллагчдын үндсэн цалингийн дундаж 732.7 мянган төгрөг буюу улсын үндсэн цалингийн дунджаас 180.5 мянган төгрөгөөр бага байна. Хүйсийн харьцааны хувьд эрэгтэй бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэгчийн үндсэн цалингийн дундаж эмэгтэй ажиллагчдынхаас 34.0 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар доогуур байна.

Оюутан залуучуудыг бүтэн бус цагийн ажилд зуучлах арга хэмжээний хэрэгжилтийг зургаар харуулбал:




*Эх сурвалж: Нийслэлийн хөдөлмөр халамжийн газар*

Зуучилсан иргэдийг насны ангиллаар авч үзвэл: (*хувиар*)

| Ангилал | Насны ангилал | | | |
|---|---|---|---|---|
| Ажил хайгч иргэн | 25-35 нас | 36-45 нас | 46-55 нас | |
| | 47.7 | 43.1 | 9.3 | |
| Оюутан | 1-р курс | 2-р курс | 3-р курс | 4-р курс |
| | 39.8 | 28.6 | 16.2 | 15.4 |

*Эх сурвалж: Нийслэлийн хөдөлмөр халамжийн газар*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[110] https://www.slideshare.net/sbrnyak/2021-tsalin-hulsnii-butetsiin-sudalgaa-mnpdf

Ажилд зуучлагдсан хүмүүсээс ямар шалтгаанаар цагийн ажил эрхлэх болсныг тодруулахад:




*Эх сурвалж: Нийслэлийн хөдөлмөр халамжийн газар*

Дээрх үзүүлэлтээс харахад бүтэн бус цагийн ажилд зуучлуулагч иргэдийн дийлэнх нь 25-37 насны залуучууд тэр дундаа голчлон оюутнууд байна. Тэдгээрийн талаас илүү хувь нь өөрсдийн хэрэглээгээ хангах зорилгоор цагийн ажил эрхэлдэг ажээ.

***Төрөөс цагийн ажил эрхлэлтийг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ***

Монгол Улсад сүүлийн жилүүдэд бүтэн бус цагийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох, ажил олгогчдыг дэмжих зорилгоор холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгон, тэдгээрийн хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, түүнчлэн ажил олгогчдод түрээсийн хөнгөлөлт үзүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, бага хүүтэй зээл олгох, ажлын байр бий болгосны тоогоор санхүүгийн урамшуулал олгох зэргээр дэмжлэг үзүүлж иржээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хөтөлбөр, арга хэмжээ, үйлчилгээг ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, залуучууд, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх, ахмад настан, ажил олгогч зэрэг хөдөлмөрийн зах зээл дэх хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн хэрэгжүүлж байна. Үүнд:

1. *Ажлын байрыг дэмжих хөтөлбөр*
2. *Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр*
3. *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр*
4. *Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр*

Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдлыг 2016-2020 оны байдлаар авч үзвэл:

**“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр**”-ийн хүрээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийг санхүүгийн болон бусад дэмжлэг, арга хэмжээнд хамруулж, байнгын ажлын байр бий болгох, **ажил олгогчид урамшуулал олгох**, ажлын байрыг хадгалах, ажил хайгч, оюутан, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагчийг түр ажлын байраар хангаН ажиллажээ.

<u>Санхүүгийн дэмжлэг:</u> 2017-2018 онд 3 сая төгрөгийг 24 хүртэлх сарын хугацаатай, 2019-2020 онд 36 сарын хугацаатай 5 хүртэл сая төгрөг олгож байсан бол 2021-2022 онд богино хугацааны **эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийг** 150 хүртэл мянган төгрөгөөс эхлэн 1 сар хүртэл хугацаатай олгох бөгөөд хугацаандаа зээлийг эргэн төлсөн тохиолдол бүрд **зээл авах боломжит хэмжээг нэмэгдүүлж 500 хүртэл мянган төгрөгийг хүүгүй, барьцаагүй, 100 хувийн эргэн төлөлттэйгээр** олгохоор болсон байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Уг хөтөлбөрт 2016-2020 оны байдлаар нийт 149.915 иргэнийг хамруулж, 11.652 байнгын, 73.648 түр ажлын байр бий болгосон ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 51.4 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

**“Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”** нь:

1. Залуучуудад хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, Залуучуудад ажлын дадал, туршлага эзэмшүүлэх үйлчилгээ, Шилдэг “Старт-Ап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох, Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах үйл ажиллагаанд тус бүр 10-20 сая төгрөгийн **эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг** олгодог. Хөтөлбөрт 18-34 насны нийт 39.471 залуучуудыг хамруулж, 2800 байнгын, 11.270 түр ажлын байр бий болгосон. Дээрх арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 11.5 тэрбум төгрөг зарцуулжээ.
2. *Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд* 2014 онд ХААИС, МУИС, МУБИС, ХҮУИС зэрэг улсын их, дээд сургуулиуд, салбар сургуулиудын дэргэд оюутны цагийн ажлын байрыг дэмжих төвүүдийг байгуулсан. 2017 онд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэх газрын дэргэд “Цагийн ажлын бирж”-ийг байгуулж, их дээд сургууль, салбар сургуулиуд дахь дэмжих төвүүдийг нэгтгэж, сургууль тус бүрд 1 дэмжих төв байхаар тооцон нийт 25 их, дээд сургуулиудад салбар төвүүдийг тус тус байгуулсан.

**“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”** нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн (ХБИ)-ийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэднийг аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтад хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой.

Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ: 2019-2020 онуудад Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилго бүхий үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн бус төрийн бус байгууллагын **ажлын байр бий болгох төсөлд** 1 ажлын байранд 5 хүртэлх сая төгрөгөөр тооцон 30 хүртэл сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор байсан бол 2021-2022 онуудад ХБИ-д тусгайлсан ажлын байр бий болгосон ТББ-ийн төслийг шалгаруулж 1 ажлын байрыг 10 сая төгрөгөөр барьцаагүй, хүүгүй 20 хүртэл сая төгрөгийн **санхүүгийн дэмжлэгийг эргэн төлөх нөхцөлгүйгээр**, Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 144.2 дахь хэсэгт заасны дагуу ХБИ авч ажиллуулсан ажил олгогчид хуулиар тогтоосон хувиас давсан ХБИ-ний тоогоор урамшууллыг нэг удаа олгох заалтыг шинээр оруулсан байна.

Хөтөлбөрт нийт 24.521 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулж, 7.248 байнгын ажлын байр бий болсон ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 15.8 тэрбум төгрөг зарцуулсан.

**“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”** нь Ахмад мэргэжилтнүүдийн ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, тэдний мэдлэг, ажлын туршлагыг өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, өсвөр хойч, залуу үеийнхэнд хөдөлмөрийн дадал олгох чиглэлээр ажиллуулж, орлогын дэмжлэг үзүүлэх зорилготой хэрэгжсэн. 2016-2020 оны байдлаар 8585 ахмад настныг хамруулж, 1.526 байнгын, 7.082 түр ажлын байр бий болгосон ба Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 5.1 тэрбум төгрөг зарцуулсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 3. Ажил олгогчийг дэмжих арга хэмжээний мэдээлэл[111] (2016-2020)*

| No | | 1 | 2 | Нийт |
|---|---|---|---|---|
| **Хөтөлбөр** | | **ХБИХЭДХ*** | **АБДХ**** | |
| 2016 | Ажил олгогчийн тоо | 24 | 19 | 43 |
| | Ажлын байраар хангасан хүний тоо | 24 | 723 | 747 |
| | Зарцуулсан хөрөнгө (сая.төг) | 57,600.0 | 291,715.0 | 349,315.0 |
| 2017 | Ажил олгогчийн тоо | 98 | 143 | 241 |
| | Ажлын байраар хангасан хүний тоо | 213 | 207 | 420 |
| | Зарцуулсан хөрөнгө (сая.төг) | 721,126.0 | 531,647.0 | 1,252,773.0 |
| 2018 | Ажил олгогчийн тоо | 103 | 137 | 240 |
| | Ажлын байраар хангасан хүний тоо | 237 | 167 | 404 |
| | Зарцуулсан хөрөнгө (сая.төг) | 1,155,645.0 | 501,440.0 | 1,657,085.0 |
| 2019 | Ажил олгогчийн тоо | 110 | 140 | 250 |
| | Ажлын байраар хангасан хүний тоо | 226 | 202 | 428 |
| | Зарцуулсан хөрөнгө (сая.төг) | 1,047,307.0 | 669,881.9 | 1,717,188.9 |
| 2020 | Ажил олгогчийн тоо | 452 | 94 | 546 |
| | Ажлын байраар хангасан хүний тоо | 227 | 122 | 349 |
| | Зарцуулсан хөрөнгө (сая.төг) | 1,056,291.3 | 519,264.5 | 1,575,555.9 |

*Эх сурвалж: ХХҮЕГ*

** Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр*

*** Ажлын байрыг дэмжих хөтөлбөр*

## Хоёр. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ЦАГИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ТУРШЛАГА

### АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС (АНУ)

АНУ-ын хөдөлмөрийн зах зээл нь дэлхийд томд тооцогдох бөгөөд 154 сая гаруй ажиллах хүчнээс бүрддэг байна. 2008 онд дэлхий дахинд нүүрлэсэн эдийн засгийн хямралын үр дагавар бүрэн арилаагүй байхад дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөө мөн тус улсын хөдөлмөрийн зах зээлд нэлээдгүй хүндрэлийг учруулж, америкчуудын ажил эрхлэлт, цалин хөлс болон ажиллах нөхцөлд сөргөөр нөлөөлсөөр байна.

***Цагийн хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал***

АНУ-ын хөдөлмөрийн зах зээлд цагийн ажил эрхлэлт томоохон байр суурийг эзэлдэг. 2022 оны 08 дугаар сарын байдлаар АНУ-д 25.09 сая орчим буюу нийт хөдөлмөр эрхлэгчдийн 17 хувийг цагийн ажилтнууд эзэлж байна. 2022 оны статистикийн мэдээгээр 132.34 сая бүтэн цагаар ажиллагсад, 25.09 сая хагас цагаар ажиллагсад байна. Нийт ажилгүй иргэдийн 10.22 сая нь бүтэн цагийн ажил, 2.73 сая нь хагас цагийн ажил сонирхож байгаа гэж бүртгэгдсэн байна. 2022 оны эцэс гэхэд цагийн ажилтнууд 26.5 саяд хүрнэ гэсэн тооцоолол байна.[112] Нийт цагийн ажил эрхлэгчдийн дийлэнхийг худалдаа, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны салбаруудад ажиллаж буй эмэгтэйчүүд эзэлдэг ажээ. Мөн улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын үйл ажиллагаа цагийн ажилтнуудаас ихээхэн хамаардаг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[111] Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2016-2020 оны хэрэгжилтийн үнэлгээ судалгааны тайлан, 2021 он. https://projects.mlsp.gov.mn/api/uploads/public/20220413/a63dd58f-830c-4128-b08d- 440db05d2725.pdf

[112] https://www.zippia.com/advice/part-time-job-statistics/

Цагийн хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын болон сайн дурын бус (зайлшгүй нөхцөл байдлын улмаас цагийн хөдөлмөр эрхэлж буй) гэж ангилж байна. Сайн дурын бус цагийн ажилтнууд нь бүтэн цагаар буюу долоо хоногт доод тал нь 35 цаг ажиллах хүсэлтэй боловч бүтэн цагийн ажил олдохгүй, жилийн турш бүтэн цагаар ажиллах боломжгүй, улирлын чанартай ажил эрхэлдэг зэрэг янз бүрийн шалтгааны улмаас хагас цагийн ажил эрхэлдэг байна. Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний салбарын цагийн ажилтнуудын 1.26 сая нь сайн дурын бус цагийн ажилтнууд гэж судалгаанд хариулсан бол амралт, аялал жуулчлалын салбарын цагийн ажилтнуудын 1.22 сая, бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарын 1.08 сая цагийн ажилтнууд тус тус зайлшгүй нөхцөл байдлын улмаас хагас цагийн ажил эрхэлдэг гэсэн байна. Харин сайн дурын цагийн ажил эрхлэгчдийн хувьд сургуульд суралцах, хүүхэд болон гэр бүлийнхээ гишүүнийг асрах зэрэг амьдралын нөхцөл, шаардлагын улмаас хагас цагаар ажиллах сонирхолтой байдаг байна.

*АНУ дахь хөдөлмөр эрхлэгчид, үүнээс цагийн ажилтнуудын тоо (%-аар)*




*Бүтэн цагаар ажиллагсад (Full-Time) 63.1%*
*Хагас цагаар ажиллагсад (Part-time) 17%*
*Ажилгүй иргэд (Unemloyed) 14.7%*

*Цагийн ажилтнуудын тоо 2011-2021 он (саяар)*




<u>Салбарын хувьд,</u> боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээнд бусад салбаруудтай харьцуулахад хамгийн их буюу 8 сая гаруй цагийн ажилтнууд, бараа, бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарт 5 сая гаруй цагийн ажилтнууд, амралт, аялал жуулчлалын салбарын нийт ажиллагсдын 46 хувь буюу 4.8 сая гаруй, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 42 хувь буюу 3 сая гаруй, бусад мэргэжлийн болон бизнесийн үйлчилгээний салбаруудад 3 сая гаруй цагийн ажилтнууд тус тус ажиллаж байна.

<u>Цалин хөлс болон бусад нэмэгдлийн хувьд,</u> 2022 оны 09 дүгээр сарын байдлаар цагийн ажлын дундаж хөлс 27.77 ам.доллар байна.[113] Харин холбооны хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ цагт 7.25 ам.доллар байна.[114]

Аж ахуйн нэгжүүдийн ойролцоогоор 79 хувь нь цагийн ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд хамруулжээ. Цагийн ажилтнуудаа тогтвортой ажиллуулах үүднээс ажил олгогчид эрүүл мэндийн даатгал болон бусад нэмэгдлүүдэд хамруулах болсон байна. Үүнд, баярын өдрүүдээр амраах, өвчтэй өдрүүдэд цалин олгох, хүүхэд асрах чөлөө олгох, өндөр насны тэтгэвэр, сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон нөхөн төлбөрийн асуудлуудыг шийдвэрлэх болсон байна. Ажил олгогчид нь гэрээнд зааснаас илүү цагаар ажиллуулсан тохиолдолд

UIH.MN СУДАЛГААНЫ САН

113 https://tradingeconomics.com/united-states/wages
114 https://www.dol.gov/agencies/whd/minimum-wage

хуульд заасны дагуу ажилласан нэмэлт цаг тутамд илүү цагийн хөлс тооцон олгох үүрэгтэй байна.[115]

Хүн ам зүйн хувьд, цагийн ажилтнуудын 63 хувь, бүтэн цагийн хөдөлмөр эрхлэгчдийн 43.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь нэг талаар эрэгтэйчүүд бүтэн цагаар хөдөлмөрлөхийг илүүд үздэгтэй холбоотой ажээ. АНУ-ын зарим мужуудад өсвөр насны буюу 14-15 настай хүүхдүүдийг тодорхой цагаар, тодорхой төрлийн ажил хийх боломжийг нарийвчлан хуульчилсан байдаг байна. Цагийн ажилтнуудыг насаар ангилвал:

- 16-19 нас 15% хүртэл
- 20-24 нас 17%
- 25-55 нас 39%
- 55-64 нас 15% хүртэл
- 65-аас дээш нас 14% байна.

***Хууль эрх зүйн зохицуулалт***

АНУ-д хөдөлмөрийн зах зээл дэх харилцааг холбооны болон мужийн хууль, дүрэм журмуудаар зохицуулж байна. Холбооны Засгийн газраас АНУ даяар мөрдөгдөх ажлын байрны стандарт, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын цаг, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг хуульчлах бөгөөд Мужийн засгийн газрууд газар нутгийн онцлог болон бусад хүчин зүйлсээс хамааран, үндэсний хэмжээнд мөрдөгдөх суурь зарчмууд дээр үндэслэн, өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөх хууль, дүрэм журмуудыг баталсан байна. Холбооны хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийг Шударга хөдөлмөрийн стандартын тухай хууль (Fair Labor Standards Act)[116], Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (Occupational Safety and Health Act)[117], Гэр бүлийн гишүүн өвдсөн тохиолдолд эмнэлгийн чөлөө олгох тухай хууль (Family Medical Leave Act)[118] зэрэг суурь хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулдаг байна. Үндэсний хэмжээнд мөрдөх цагийн ажил эрхлэлтийг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй бөгөөд харин Холбооны ажилтнуудын[119] цагийн ажил эрхлэлтийн тухай хууль (Federal Employees Part-time Career Employment Act)[120]-ийг 1978 онд баталжээ.

**Шударга хөдөлмөрийн стандартын тухай хуульд** бүтэн цагийн хөдөлмөр эрхлэлт, хагас цагийн хөдөлмөр эрхлэлт гэсэн ялгаатай тодорхойлолт байхгүй бөгөөд “ажилтан” гэсэн статуст хамруулан авч үзэж байна.[121]

Харин **Боломжийн өртөг бүхий тусламж үйлчилгээний тухай хууль** (Affordable Care Act)-д долоо хоногт 30-аас доош цаг ажиллаж байгаа ажилтанг цагийн ажилтан гэж үзэхээр заажээ.[122] Хуульд цагийн ажилтны долоо хоногийн ажлын цагийн талаарх тодорхой зохицуулалт байхгүй ба тухайн ажил олгогчоос хамааран зарим тохиолдолд долоо хоногийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

115 https://www.dol.gov/general/topic/workhours/overtime
116 https://uscode.house.gov/view.xhtml?path=/prelim@title29/chapter8&edition=prelim
117 https://www.osha.gov/laws-regs/oshact/completeoshact
118 https://www.dol.gov/agencies/whd/fmla#:~:text=The%20FMLA%20entitles%20eligible%20employees,employee%20had%20not%20taken%20leave.
119 Холбооны Засгийн газар, түүний харьяа яам, агентлагуудад ажиллаж буй ажилтнуудыг хэлж байна.
120 https://www.congress.gov/bill/95thcongress/housebill/10126#:~:text=Passed%20Senate%20amended%20(08%2F25%2F1978)&text=Federal%20Employees%20Part%2DTime%20Career%20Employment%20Act%20%2D%20Requires%20the%20heads,to%2032%20hours%20a%20week.
121 https://webapps.dol.gov/elaws/faq/esa/flsa/014.htm?_ga=2.216254614.1249104559.1666143448113551718 8.1665115149
122 https://www.patriotsoftware.com/blog/payroll/part-time-vs-full-time-employment/

34 цаг хүртэл, заримдаа 40-өөс бага цаг ажиллах ажилтныг цагийн ажилтан гэж үзэх тохиолдол байна. Ажил олгогч нь байгууллагын үйл ажиллагаандаа цагийн ажилтан авч ажиллуулах нөхцөл, журмыг хэрэгжүүлэн ажиллах шаардлага тавигддаг байна.

**Ажилтны тэтгэврийн баталгааны тухай хууль** (Employee Retirement Income Security Act)-д хувийн хэвшлийн салбарт сайн дурын үндсэн дээр бий болгосон тэтгэвэр болон эрүүл мэндийн даатгалын хамгийн доод хэмжээг хуульчилсан бөгөөд эдгээр даатгалд хамрагдсан ажилтнуудын эрхийг хамгаалахаар зохицуулсан байна. Тус хуульд мөн байгууллага, аж ахуйн нэгж нь тодорхой хугацаанд тогтвортой ажилласан цагийн ажилтанд өндөр насны тэтгэвэрт гарахад нь тухайн ажилтны статусыг үл харгалзан тэтгэмжийг тооцон олгохоор хуульчилсан байна.

**Холбооны ажилтнуудын цагийн ажил эрхлэлтийн тухай хууль** (Federal Employees Part-time Career Employment Act)-аар Холбооны Засгийн газар, түүний харьяа яам, агентлагуудын[123] ажилтнуудын хагас цагаар ажиллах эрхийг баталгаажуулсан байна. Холбооны Засгийн газрын хэмжээнд долоо хоногийн 40-өөс доошгүй цагаар хөдөлмөрлөх уламжлалт аргыг халан, хүний нөөц бололцоогоо уян хатнаар, бүрэн гүйцэд ашиглах гэр бүлд ээлтэй бодлогыг хэрэгжүүлээд нэлээдгүй хугацаа өнгөрсөн байна. Холбооны Засгийн газрын хэмжээнд цагийн ажил эрхлэлтийг тодорхой салбар болон ажилтны зэрэглэлээр хязгаарлаагүй бөгөөд ажилтны хүсэлтээр болон ажлын шаардлагаар ямар ч ажлыг богиносгосон цагаар (долоо хоногийн 16-32 цаг) ажилтан дангаар хийгээд шаардлагатай хүний нөөцөөс бүрдсэн баг хуваан (job sharing) гүйцэтгэх боломжтой байна. Энэ нь ажилтанд болон байгууллагад үр өгөөжтэй шийдвэр болсон байна.[124]

**Холбооны Засгийн газрын хэмжээнд мөрдөх Холбооны журмын** 45 дугаар бүлгийн 1176 дугаар хэсэгт цагийн ажил эрхлэлтийн талаар зохицуулсан байна.[125] Тухайлбал, Холбооны Засгийн газар, түүний харьяа яам, агентлагуудын үндсэн ажилтнуудаас гадна тухайн байгууллагад иргэд өөрсдийн хүсэлтээр хагас цагаар буюу долоо хоногийн 16-32 цагийн тогтмол цагийн хөдөлмөр эрхлэх боломжтой байна. Нийгэмд олон тооны мэдлэг, чадвартай иргэд байгаа хэдий ч тодорхой шалтгааны улмаас долоо хоногийн тогтсон бүтэн цагийн ажил эрхлэх боломжгүй байх тохиолдол байдаг. Иймээс нэг талаар эдгээр иргэдийн мэдлэг боловсрол, нөөц чадварыг ашиглах, нөгөө талаар ажлын байраар хангах үүднээс Холбооны Засгийн газраас тогтмол цагийн ажил эрхлэх боломжийг олгодог байна. Тогтмол цагийн ажил нь ахмад настнуудад аажмаар тэтгэвэрт гарах хүртэл, эцэг, эхчүүдэд ажил-гэр бүлээ тэнцвэржүүлэн ажиллах, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон богиносгосон цагаар ажиллах шаардлагатай бусад хүмүүс, тухайлбал, сургалтын төлбөрөө төлөх шаардлагатай оюутнууд, мэргэжлийн дадлагажигч зэрэг хүмүүсийг ажлын байраар хангах боломжийг олгодог байна. Эдгээрийг үндэслэн Хүмүүнлэгийн тусламжийн үндэсний сан (National Endowment for the Humanities) нь чиг үүргийнхээ дагуу Холбооны ажилтнуудын цагийн ажил эрхлэлтийн тухай хууль болон Нийтийн албаны тухай (Public Law) хууль тогтоомжийн дагуу цагийн ажил эрхлэлтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг байна.

***Цагийн ажил эрхлэлт болон Ажил олгогчдыг дэмжих талаар Холбооны Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого***

АНУ-ын Холбооны Засгийн газраас цар тахлын улмаас доройтсон эдийн засгийг сэргээх,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[123] https://uscode.house.gov/view.xhtml?path=/prelim@title5/part3/subpartB/chapter34&edition=prelim
[124] https://www.opm.gov/policy-data-oversight/hiring-information/part-time-and-job-sharing/, https://www.ecfr.gov/current/title-5/chapter-I/subchapter-B/part-340
[125] https://www.law.cornell.edu/cfr/text/45/1176.1

тогтворжуулахад шаардлагатай улс орныг бүхэлд нь хамарсан төрийн бодлогыг шат дараатай хэрэгжүүлсээр байгаа бөгөөд ард иргэдээ хямралаас гаргах санхүүгийн багц тусламжуудыг олгох, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсээр байна.

2021 оны 03 дугаар сард Ерөнхийлөгч Жое Байден 8 жилийн хугацаанд 2 их наяд ам.долларын төсвөөр хэрэгжүүлэх “Америкийн ажлын байр хөтөлбөр”-ийг боловсруулан танилцуулсан байна. Энэ нь АНУ-ын эдийн засгийг сэргээн хөгжүүлэх **“**Илүү сайнаар бүтээе” (Build Back Better)[126] хөтөлбөрийн нэг хэсэг юм. Уг хөтөлбөрөөр АНУ-д ирэх 10 жилийн хугацаанд жил бүр 2 сая ажлын байрыг шинээр бий болгох, дэд бүтцийг шинэчлэх, уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох зэрэг томоохон арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байр нэмэгдүүлэх, сайжруулахтай холбоотой дараах салбаруудад санхүүжилт олгохоор төлөвлөжээ. Үүнд:

- Ажиллах хүчний хөгжил;
- Үйлдвэрлэл, жижиг бизнес;
- Шинэ техник, технологийн судалгаа шинжилгээ, зохион бүтээх, үйлдвэрлэх, ажлын байрны сургалт зэрэг болно.[127]

**Ажилтныг ажилд авахад олгох татварын хөнгөлөлт** (Work opportunity tax credit)[128]

Зорилтот бүлгийн иргэдийг ажилд авсан тохиолдолд ажил олгогчдод Ажилтныг ажилд авахад олгох татварын хөнгөлөлтийг олгодог байна. Зорилтот бүлгийн иргэнийг ажилд авсан болохоо баталгаажуулан, тодорхой хугацаанд (доод тал нь 120 цаг) ажиллуулсны дараа ажил олгогч нь ажилтан тус бүрийн тоогоор 2400-9600 ам.доллар хүртэлх хөнгөлөлтийг орлогын албан татвараасаа суутгуулах болон татвараас чөлөөлөгдсөн ажил олгогчид цалингийн татвараасаа хасан тооцуулдаг байна. Болзол хангасан хувийн хэвшлийн ямар ч аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү татварын хөнгөлөлтөд хамрагдах боломжтой. Зорилтот бүлгийн иргэдэд дараах хүмүүсийг хамруулж байна. Үүнд:

- *IV-A тусламж хүлээн авагч*
  Нийгмийн хамгааллын тухай хуулийн IV бүлгийн А хэсэгт заасны дагуу “Тусламж хэрэгтэй байгаа гэр бүлд түр тусламж үзүүлэх тухай” Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд тусламж авч буй өрхийн гишүүнийг “IV-A шаардлага хангасан хүлээн авагч” гэнэ.

- *Ахмад дайчин*
    - “Нэмэлт хүнс тэжээлийн тусламжийн хөтөлбөр”-т хамрагдан, 15 сарын хугацаанд доод тал нь 3 сарын турш тусламж хүлээн авсан өрхийн гишүүн
    - Нэг жилд 6 сараас доош хугацаанд буюу доод тал нь 4 долоо хоног (дараалсан биш байж болно) ажилгүй байсан иргэн
    - Нэг жилд доод тал нь 6 сарын хугацаанд (дараалсан биш байж болно) ажилгүй байсан иргэн
    - АНУ-ын зэвсэгт хүчинд алба хааж байгаад тахир дутуу болсон бөгөөд тахир дутуугийн тэтгэмжид хамрагдан, доод тал нь 6 сарын хугацаанд (дараалсан биш байж болно) ажилгүй байсан иргэн

- *Өмнө нь гэмт хэрэгт холбогдож байсан иргэн*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[126] https://www.whitehouse.gov/build-back-better/
[127] Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх бодлого, арга хэмжээ ПССХ СТ-21/229
[128] https://www.dol.gov/agencies/eta/wotc

- *Алслагдсан, хүн ам цөөнтэй орон нутгийн оршин суугч болон нэн ядуу өрхийн гишүүн*
    - 18-40 настай
- *Мэргэжлийн нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн*
- *Зуны улирал ажил эрхлэх хүүхэд, залуус*
    - 16-18 настай
    - 05 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны хооронд ажиллах (05 дугаар сарын 01-нээс өмнө ажилд авахыг хориглоно)
    - Нэн ядуу өрхийн гишүүн
- *“Нэмэлт хүнс тэжээлийн тусламжийн хөтөлбөр”-т хамрагдсан иргэн*
    - 18-40 настай
    - “Нэмэлт хүнс тэжээлийн тусламж”-д ажилд орохоос өмнөх 6 сарын хугацаанд, эсхүл өмнөх 5 сарын 3 сард нь хамрагдсан.
- *Нэмэлт нийгмийн хамгааллын тэтгэмжид хамрагддаг амьжиргааны доод түвшинд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн*
- *“Урт хугацааны өрхийн тусламж”-д хамрагдсан айл өрхийн гишүүн*
- *“Урт хугацааны ажилгүйдлийн тэтгэмж”-д хамрагдсан буюу дараалсан 27 долоо хоногийн турш ажилгүй байсан болон дээрх хугацаанд бүхэлд нь, эсхүл зарим үед нь ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэн* зэрэг болно.

**Дагалдан суралцуулах тэтгэлэгт хөтөлбөр** (Apprenticeships Grants program)[129]

Холбооны болон мужийн засгийн газрууд ажил олгогчдод ажилгүй иргэдийг дадлагажуулан, ажилд авахад зориулж Дагалдан суралцуулах тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг байна. Ингэхдээ тодорхой чиглэлээр ажилтан бэлтгэх зорилгоор жил бүр тодорхой тооны мужуудаас сонгон, ажил олгогчдод цалингийн татаас олгох байдлаар хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Ажил олгогчид нь дагалдан суралцагчдыг ажлын байран дээр дадлагажуулахын зэрэгцээ цалинжуулан, цаашид тухайн ажил дээр нь мэргэшүүлэн ажиллуулах бөгөөд 2022 оны байдлаар үндэсний хэмжээнд 171 сая ам.долларыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллагуудаар дамжуулан ажил олгогчдод олгожээ.

**Холбооны бондын хөтөлбөр** (Federal Bonding Program)[130]

Холбооны бондын хөтөлбөрийн дагуу ажилтныг ажилд авснаас хойш 6 сарын хугацаанд тухайн ажилтан ажил олгогчид тодорхой хэмжээний хохирол (5000-25000 ам.доллар хүртэлх мөнгөн болон эд хөрөнгөний) учруулсан тохиолдолд бонд нь хохирлыг ажил олгогчид нөхөн төлнө. Холбооны татвар төлдөг, бүтэн болон хагас цагийн ажилтан цалинжуулдаг аль ч мужийн, ямар ч бизнес эрхэлдэг, ямар ч ажил олгогч энэ хөтөлбөрт хамрагдах боломжтой байна.

Холбооны Засгийн газраас ажил олгогчдыг дэмжин хэрэгжүүлж буй дээрх хөтөлбөрүүдээс гадна бүтэн болон хагас цагийн ажилд нийгмийн халамжид хамрагддаг иргэд ба залуу, өсвөр үеийнхнийг ажлын байраар хангах зорилготой Нью-Йорк мужийн хөдөлмөр эрхлэлтийн

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[129] https://www.dol.gov/newsroom/releases/eta/eta20220707-0
https://www.dol.gov/newsroom/releases/eta/eta20220824
[130] https://bonds4jobs.com/wp-content/uploads/2022/04/FBP-Employers-Job-Seekers-Brochure-update-103.pdf

албанаас хэрэгжүүлж буй зарим хөтөлбөрийг авч үзлээ.

**Нью-Йорк мужийн залуучуудын ажил эрхлэлт хөтөлбөр** (New York Youth Jobs program)[131]

Залуу, өсвөр үеийнхнийг хөдөлмөрийн зах зээлд анх ороход дэмжих үүднээс Нью-Йорк мужийн залуучуудын ажил эрхлэлт хөтөлбөрийг 2012 оноос хэрэгжүүлсэн байна. Тус хөтөлбөрөөр ажилгүй, амьжиргааны доод түвшинд байгаа залуусын ажил эрхлэлтийг дэмждэг байна. Ажил олгогч нь эдгээр бүлэгт хамаарч буй 16-24 насны залуучуудаас бүтэн цагийн ажилд авсан тохиолдолд 7500 ам.доллар хүртэлх, харин хагас цагийн ажилд авсан тохиолдолд 3750 ам.доллар хүртэлх татварын хөнгөлөлтийг ажилтан бүрийн тоогоор авдаг байна. Өнөөг хүртэл энэ хөтөлбөрийн тусламжтайгаар Нью-Йорк мужийн 1500 гаруй аж ахуйн нэгж байгууллага 27.000 залуусыг ажилтай болгосон байна.

**Ажил олгогчид олгох урамшуулал** (Employer Incentive plus)[132]

23.5 сая хүн ам бүхий Нью-Йорк хотын Хөдөлмөр эрхлэлтийн албанаас Ажил олгогчид олгох урамшуулал хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Ажил олгогчид олгох урамшууллаар нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдсан иргэдийг бүтэн болон хагас цагийн ажилд авсан ажил олгогчдод цалингийн татаас олгодог. Ажил олгогчид дээд тал нь гурван сарын хугацаанд ажилтны сарын нийт цалингийн 60 хувьтай тэнцэх хэмжээний (сард 600 ам.доллар хүртэл) цалингийн татаас авах боломжтой байна.

## БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (БНСУ)

Тус улсын хөдөлмөрийн насны буюу 15-аас дээш насны хүн ам 45.284 сая, үүнээс хөдөлмөр эрхэлж буй 29 сая хүн байгаа бол 73.7 хувь (16.426 сая) нь эрэгтэй, 55.1 хувь (12.667 сая) нь эмэгтэй ажилтан байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2022 оны 08 дугаар сарын байдлаар 62.8 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 64.2 хувийн үзүүлэлттэй байна. Харин ажилгүй 704 мянган хүн буюу ажилгүйдлийн түвшин 2.4 хувьтай байна. Эдийн засгийн идэвхгүй хүн ам 16 сая хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.[133]

*Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2022 оны 08 дугаар сарын байдлаар*[134]




UIH.MN СУДАЛГААНЫ САН

131 https://www.ny.gov/programs/urban-youth-jobsnew-york-youth-jobs-program
132 https://www1.nyc.gov/site/businesslink/employers/employer-incentives-plus.page
133 http://kostat.go.kr/portal/eng/pressReleases/5/2/index.board
134 https://tradingeconomics.com/south-korea/employment-rate

Хөдөлмөрийн яамнаас гаргасан 2022 оны эхний хагас жилийн ажиллах хүчний судалгаагаар, нэг буюу түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгжүүдэд нээлттэй ажлын байрны тоо 1.303 мянга, ажилтай иргэдийн тоо 1.128 мянга болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад нээлттэй ажлын байрны тоо 22.3 хувь (23.7000), ажилтай иргэдийн тоо 17.2 хувь (165.000)-аар тус тус өссөн байна.

Долоо хоногт 36-аас доош цаг ажилладаг иргэдийн тоо 2021 оны 03 дугаар сард 5.9 саяд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 16.6 хувь (836 мянга)-аар нэмэгдсэн байна. Ажлын цагаар долоо хоногт 1-17 цаг ажилласан хүмүүсийн тоо 2.2 сая болж, өмнөх оны мөн үеэс 35.5 хувь (565 мянга)-аар өссөн байна.[135]

2020 онд хийсэн судалгаагаар өсвөр насны цагийн ажилчдын 35 хувь нь ресторанд ажилладаг бол 15 хувь нь хүргэлтийн үйлчилгээ үзүүлж байна.

*Өсвөр насныхны цагийн ажлын төрөл*




***Хууль эрх зүйн орчин***

БНСУ-д цагийн ажил эрхлэх асуудлыг дараах хууль тогтоомжоор зохицуулж байна.

- *"Labor Standards Act" "Хөдөлмөрийн жишиг тогтоох тухай хууль"*
- *"Act on the Protection of Fixed-term and Part-time employees" "Тогтсон хугацаанд гэрээгээр ажиллагсад болон цагийн ажил эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль",*
- *"Non-regular Workers Protection Act" "Тогтмол бус ажил эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль",*
- *"The Employment Security Act" "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль",*
- *"Labor Relations Commission Act" "Хөдөлмөрийн харилцааг зохицуулах тухай хууль",*
- *"The Minimum Wage Act" "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай хууль"*

**"Хөдөлмөрийн жишиг тогтоох тухай хууль"**

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[135] https://hrmasia.com/one-of-five-part-timers-in-south-korea-want-to-work-longer/

Энэ хууль нь анх 1953 онд батлагдсан бөгөөд 1997 онд дахин шинэчлэгдэн батлагджээ.

Энэхүү хуулиар тогтоосон хамгийн бага стандарт, хамгаалалтууд нь зөвхөн албан ёсны бичгээр хөдөлмөрийн гэрээ байгуулсан байнгын, эсхүл түр, бүтэн цагийн болон хагас цагийн ажилтнуудад хамаарна.

Тус хуульд цагийн ажил эрхлэхтэй холбоотой дараах зохицуулалтуудыг тусгасан байна.

- Цагийн ажилтан гэдэг нь ажил олгогчтой хийсэн гэрээний дагуу тухайн ажлын байранд үндсэн ажилтнаас бага цагаар буюу тодруулбал, 7 хоногт 35-аас доош цаг ажиллаж буй ажилтныг хэлнэ.
- Ажил олгогч цагийн ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, тус гэрээнд цагийн ажил гүйцэтгүүлэх ажлын нөхцөл, ажиллах цаг, ажлын хөлсийг үндсэн ажилтны ажиллах нөхцөл, цагийн хөлстэй харьцуулан тогтооно.

*Хөдөлмөрийн жишиг тогтоох хуулийн ажлын цагтай холбоотой зохицуулалт*[136]

**Ажлын цагийн хуваарь**

- Ажлын дундаж долоо хоног нь Даваа-Бямба гараг хүртэл үргэлжилнэ. Ням гарагийг амралтын өдөр гэж үздэг.
- Бүтэн цагийн ажилтны долоо хоногт ажиллах цаг (завсарлага тооцохгүй) 40 цагаас хэтрэхгүй.
- Цагийн ажилтны 7 хоногт ажиллах цаг (завсарлага тооцохгүй) 35 цагаас доошгүй.
- Долоо хоногт ажиллах цагийн дээд хязгаар нь 48 цаг байна.
- 15-18 насны ажилтны ажлын цаг нь өдөрт 7 цагаас, долоо хоногт 35 цагаас хэтрэхгүй. Талуудын тохиролцсоноор өдөрт 1 цаг, долоо хоногт 5 цагаар сунгаж болно.
- Усанд шумбах зэрэг өндөр даралтын дор гүйцэтгэх аюултай ажлын цаг нь өдөрт 6 цаг, 7 хоногт 34 цагаас хэтрэхгүй.

Ажил олгогчид эмэгтэйчүүдийг 22.00-06.00 цагийн хооронд, эсхүл амралтын өдрүүдэд ажиллахыг шаардаж болохгүй.

**“Тогтсон хугацаанд гэрээгээр ажиллагсад болон цагийн ажил эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль”**

Энэхүү хууль нь тогтсон хугацаанд гэрээгээр ажилладаг ажилтан болон цагийн ажил эрхлэгчдийг зүй бусаар ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах зорилготой юм. Ялгаварлан гадуурхалтад цалин хөлс, урамшуулал, гүйцэтгэлд суурилсан урамшуулал, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн халамжийн асуудлуудыг хамруулан авч үзнэ. Тус хууль нь 5-аас доошгүй ажилтантай аж ахуйн нэгж, ажлын байранд хамаарна.

- Ажил олгогч цагийн ажилтантай харилцан зөвшилцөөгүй тохиолдолд илүү цагаар ажиллуулахыг хориглоно.
- Тухайн ажилтан зөвшөөрсөн тохиолдолд ажил олгогч цагийн ажилтныг долоо хоногт 12 цагаас хэтрүүлэхгүй илүү цагаар ажиллуулж болно.
- Ажил олгогч цагийн ажилтантай харилцан зөвшилцөөгүй тохиолдолд тухайн ажилтан илүү цагаар ажиллахаас татгалзах эрхтэй. Хэрэв илүү цагаар ажилласан бол илүү цагийн хөлсийг үндсэн цалингаас гадна цалингийн 50 буюу түүнээс дээш хувиар тооцож олгоно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

136 https://www.easylaw.go.kr/CSP/CnpClsMain.laf?popMenu=ov&csmSeq=1347&ccfNo=1&cciNo=1&cnpClsNo=1&search_put=

- Ажил олгогч бүтэн цагаар ажиллах үндсэн ажилд шаардлагатай тохиолдолд цагийн ажилтныг өөрөө хүсвэл нэн түрүүнд үндсэн ажилтнаар авч ажиллуулна.
- Ажил олгогч цагийн ажилтныг тухайн ажлын байран дахь ижил буюу ижил төрлийн ажил гүйцэтгэж буй үндсэн ажилтантай харьцуулан ялгаварлан гадуурхахыг хориглоно.
- Цагийн ажилтан болон тогтсон хугацаанд гэрээгээр ажиллагч нь ажлын байран дээр ялгаварлан гадуурхагдсан тохиолдолд "*Хөдөлмөрийн харилцааг зохицуулах тухай хууль*"-д заасны дагуу Хөдөлмөрийн харилцааг зохицуулах хороонд гомдол гаргах эрхтэй.
- Хөдөлмөрийн харилцааг зохицуулах хорооноос ажил олгогчид шаардлагатай арга хэмжээ аваагүй тохиолдолд цагийн ажилтан Хөдөлмөрийн яаманд хандан гомдлоо барагдуулах эрхтэй.
- Ажил олгогч цагийн ажилтан болон тогтсон хугацаанд гэрээгээр ажиллагчтай байгуулах хөдөлмөрийн гэрээнд:
    - Гэрээний үргэлжлэх хугацаа
    - Ажлын болон амралтын цаг
    - Цалин хөлс болон түүнийг олгох хэлбэр
    - Амралт болон чөлөөний тухай
    - Ажлын байр, тухайн ажилтны гүйцэтгэх үүрэг
    - Ажлын өдөр хэдэн цагаар ажиллах тухай гэх мэт нөхцөлүүдийг зайлшгүй тусгах шаардлагатай.

Дээр дурдсан гэрээний нөхцөлүүдийг зөрчсөн ажил олгогчид 5 сая хүртэлх воноор торгох шийтгэлийг ногдуулна.

**"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль"**

- Төрийн болон төрийн бус түүнчлэн хувийн хэвшлийн байгууллагууд хөдөлмөрт зуучлах үйл ажиллагаа эрхлэх боломжтой. Орон нутгийн захиргааны Хөдөлмөрт зуучлах албад ажлын сул орон тоо болон түүнд тохирох ажилтны тухай мэдээлэх, ажил хайгч тухайн ажилд тохирох эсэх талаар сорилго явуулах, ажил олгогч болон ажил хайгч иргэдийг холбох, ажилгүй иргэдэд ажлын дадлага олгох сургалт зохион байгуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх гэх мэт үйл ажиллагааг үнэ төлбөргүй явуулна.
- Хувийн хэвшлийн байгууллагууд хөдөлмөрт зуучлах үйл ажиллагаа эрхлэх боломжтой. Тухайн орон нутгийн захиргаанд бүртгүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр үйл ажиллагаа эрхлэх боломжтой болох ба энэ нь төлбөртэй байна. Төлбөртэйгөөр хөдөлмөрт зуучлах үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага үйл ажиллагааныхаа явцад санаатай болон санамсаргүй тохиолдлоор ажил хайгч түүнчлэн ажил олгогчид хохирол учруулсан тохиолдолд хохирлыг барагдуулах шаардлагатай байдаг байна.

**"Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай хууль"**

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жил бүрийн 08 дугаар сарын 05-ны дотор Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний комиссоор хэлэлцүүлсний дараа Хөдөлмөрийн сайд баталж, 01 дүгээр сарын 01-нээс эхлэн дагаж мөрддөг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

2022 оны байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ цагт 9160 вон, сарын 1.914.440[137] вон байна.

**“Тогтмол бус ажил эрхлэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль”**

Тогтмол бус ажил эрхлэгч нь ажил олгогчтой 2 хүртэлх жилийн гэрээ байгуулан ажиллах боломжтой. Тухайн байгууллагад гэрээний хугацаанд тогтвортой ажилласан тогтмол бус ажил эрхлэгчийг гэрээний хугацаа дуусгавар болоход үндсэн ажилтнаар тооцох тухай заажээ.

***Төрөөс үзүүлж буй дэмжлэг***

БНСУ-д төрөөс цагийн ажилтанд хуулиар олгосон боломжийг бүрэн эдлүүлэх, ажлын байр шинээр бий болгосон ажил олгогчид татаас олгох зэрэг дэмжлэгийг үзүүлдэг байна.

*Цагийн ажилтныг дэмжих талаар*

Хөдөлмөрийн жишиг тогтоох тухай хуульд заасны дагуу цагийн ажилтнуудад дараах байдлаар дэмжлэг үзүүлнэ.

- **Цалинтай амралтын өдөр.** Ажил олгогч нь цагийн ажилтанд долоо хоногт дунджаар нэгээс доошгүй цалинтай амралт өгөх ёстой. Цагийн ажилтны цалинтай амралтын өдрийн цалингийн хэмжээг өдөр тутмын жишиг цалинг үндэслэн тогтооно.
- **Ээлжийн амралт.** Цагийн ажилтны ээлжийн амралтын өдрийг Хөдөлмөрийн жишиг тогтоох тухай хуулийн 9.1 дэх хэсгийн хавсралтын хүснэгт 2-т заасан журмыг баримтлан тогтооно.
- Цалинтай амралтын өдөр болон ээлжийн амралт нь долоо хоногт тогтоосон ажлын цаг нь 15 цагаас бага буюу богино хугацааны ажилтанд хамаарахгүй.
- **Сарын тэмдгийн болон жирэмсний амралт.** Ажил олгогч нь цагаар ажилладаг эмэгтэй ажилтанд сарын тэмдгийн, жирэмсний болон амаржсаны чөлөө олгох бөгөөд ажил олгогчоос олгох цалинг 1 өдрийн цалинд үндэслэн тооцдог.
- **Илүү цагаар ажиллахыг хязгаарлах.** Ажил олгогч нь цагийн ажилтныг тогтоосон цагаас илүү цагаар ажиллуулах тохиолдолд тухайн ажилтны зөвшөөрлийг заавал авах ёстой бөгөөд долоо хоногт 12 цагаас илүү цагаар ажиллуулахыг хориглоно. Хэрэв илүү цагаар ажилласан бол цалин хөлсийг хөдөлмөрийн хөлсийг 50 ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлж олгоно.

  Цагийн ажилтан нь илүү цагаар ажиллахаас татгалзах эрхтэй бөгөөд хэрэв цагийн ажилтны зөвшөөрөлгүйгээр ажиллуулах, эсхүл долоо хоногт 12-оос дээш цагаар ажиллуулсан бол ажил олгогчийг 10 сая воноос хэтрүүлэхгүйгээр торгох ял шийтгэнэ.
- **Давуу эрх олгох.** Ажил олгогч нь үндсэн ажилтан авах тохиолдолд тухайн аж ахуйн нэгж, ажлын байранд ижил төрлийн ажил эрхэлж буй хагас цагийн ажилтныг давуу эрхтэйгээр авч ажиллуулна. Үндсэн ажилтан хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цагаар ажиллах хүсэлт гаргасан тохиолдолд ажил олгогч нь ажилтныг хагас цагийн *ажилд шилжүүлж болно.*

[137] https://www.minimumwage.go.kr/english/main.do

*Ажил олгогчийг дэмжих талаар*

**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цалингийн татаас:**[138]

Хөдөлмөрийн сайдын баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр (нийт 17 хөтөлбөр)-ийн дагуу дараах ажлын байр бий болгосон ажил олгогчид улсын **төсвөөс татаас** олгохоор заасан.

- Хөдөлмөр эрхлэлтийн төв (worknet)-д ажилд орохоор бүртгүүлсэн ажилгүй иргэнийг ажилд авсан ажил олгогч;
- Ажилд орохоор бүртгүүлснээс хойш нэг сараас дээш хугацаагаар ажилгүй байсан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүлээ тэжээн тэтгэх үүрэгтэй эмэгтэйчүүд, арлын оршин суугчийг ажилд авсан ажил олгогч.

Дээр дурдсан иргэнийг ажилд авсан бөгөөд тухайн ажилтан 6 сараас дээш хугацаагаар ажилласан тохиолдолд 1 жилийн хугацаанд 6 сар тутамд дараах байдлаар татаас олгоно.

| Чиглэл | 1 жилийн дэмжлэгийн хэмжээ | 6 сар тутам олгох хэмжээ |
|---|---|---|
| **Тэргүүлэх чиглэлийн компаниуд** | 720 сая вон | 360 сая вон |
| **Томоохон аж ахуйн нэгжүүд** | 360 сая вон | 180 сая вон |

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС (БНХАУ)**

БНХАУ-д оюутнуудын 15-20 хувь нь л цагийн ажил эрхэлдэг. Ялангуяа гадаад оюутнуудын хувьд зөвшөөрлийн журмаас болоод цагийн ажил эрхлэх нь нэлээд төвөгтэй байдаг. Энэ оны буюу 2022 оны 01 дүгээр сард гадаад оюутнуудын ажил эрхлэлтийн талаар Боловсролын яам, Нийгмийг аюулаас хамгаалах яам, Хүний нөөц, нийгмийн хамгааллын яам, Үндэсний цагаачлалын удирдах газраас хамтарсан удирдамж гаргасан. Энэ удирдамжийн дагуу гадаад оюутан сургуулийнхаа кампусаас гадуур долоо хоногт 8 цаг, сард 40 цагаас илүүгүйгээр, өвөл, зуны амралтаараа долоо хоногт 16, сард 80 цагаас илүүгүйгээр тус тус цагийн ажил эрхэлж болно.

***Хууль эрх зүйн орчин***

БНХАУ-д хөдөлмөрийн харилцааг голчлон дор дурдсан хуулиудаар зохицуулдаг. Үүнд:

- **Хөдөлмөрийн хууль** (1994 онд батлагдаж, 2009 онд шинэчлэн найруулсан) Labor Law 1994;
- **Хөдөлмөрийн гэрээний хууль** (2007 онд батлагдаж, 2012 онд шинэчлэн найруулсан) Labour Contract Law 2007));
- Нийгмийн хамгааллын хууль (2011 онд батлагдаж, 2018 онд шинэчлэн найруулсан) Social Security Law 2011));
- **Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль** (Employment Promotion Law 2007);
- Эмэгтэйчүүдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах хууль (Protection of Women’s Rights and Interests Law 1999).

Гэсэн хэдий ч БНХАУ-ын хөдөлмөрийн хууль тогтоомж нь кодификацлагдаж системчлэгдээгүй учраас хөдөлмөрийн эрх зүйн харилцааны зохицуулалт нь мөн дараах эх сурвалжуудаас бүрддэг. Эдгээр нь:

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[138] https://www.moel.go.kr/policy/policyinfo/create/list7.do

- Төрийн зөвлөлөөс тогтоосон захиргааны хэм хэмжээ;
- Хүний нөөц, нийгмийн хамгааллын сайд болон бусад сайд, хорооноос баталсан дүрэм, журам;
- Ардын дээд шүүх болон ардын дээд прокурорын газраас гаргасан хуулийн тайлбар;
- Муж, өөртөө засах орон, төвд шууд захирагдах хот, засаг захиргааны онцгой бүсүүдийн хэмжээнд мөрдөгдөх орон нутгийн шийдвэр;
- Орон нутгийн прокурорын газар, шүүхийн шийдвэр, үйлдвэр, аж ахуйн газар, хөдөлмөрийн хамт олны хүрээнд мөрдөгддөг дүрэм журам, түүнчлэн зан заншлын хэм хэмжээ.

Тус улсын цагийн ажил эрхлэлтийн эрх зүйн зохицуулалт, цагийн ажилтны статус нь үндсэн ажилтныхтай харьцуулахад боловсронгуй бус байдаг. 1994 оны Хөдөлмөрийн хуульд цагийн ажлын талаар зохицуулалт байгаагүй бөгөөд 2009 оны шинэчилсэн найруулгад анх цагийн ажил, цагийн ажилтны ойлголтыг хуульчилсан.

Хөдөлмөрийн гэрээний хуулийн 3 дугаар хэсэг (*Бүрэн бус цагийн хөдөлмөр*)-ийн 68, 69, 70, 71, 72 дугаар зүйлүүдэд цагийн ажил эрхлэлтийг зохицуулсан байдаг. Тус хуулийн 68 дугаар зүйлд зааснаар “өдөрт дунджаар 4 цагаас ихгүй, долоо хоногт нийтдээ 24 цагаас илүүгүй ажил эрхэлж буй ажилчныг цагийн ажилтан гэнэ” гэжээ.[139] Хэрэв цагийн ажилтан эдгээр тогтоосон цагаас илүү хугацаагаар ажиллавал түүнийг тухайн ажлын байртай холбоотой бүхий л хууль ёсны үүрэг, хариуцлагыг хүлээх үндсэн ажилтан гэж тооцдог байна.

Цагийн ажилтны цалин хөлсийг цагаар тооцож, 15 хоног тутамд заавал олгох ёстой ба цагийн хөдөлмөрийн хөлс нь тухайн орон нутгийн засаг захиргаанаас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж үл болно.

Ажил олгогч цагийн ажилтантай хөдөлмөрийн гэрээг заавал бичгээр байгуулах шаардлагагүй, мөн уг гэрээг аль нэг талын санаачилгаар хэдийд ч цуцлах боломжтой, гэрээ цуцлагдсан тохиолдолд ажил олгогч цагийн ажилтанд ажлаас гэнэт халагдсаны тэтгэмж олгох үүрэг хүлээдэггүй байна. Мөн цагийн ажилд туршилтын хугацаа тогтоох журмыг хэрэглэдэггүй.

Цагийн ажилтнуудын ажлын цаг, илүү цаг, нөхөн олговор, тэтгэмж зэрэг бусад хөдөлмөрийн нөхцөлийн талаар тусгайлсан дүрэм, журам, хориглолт, хязгаарлалт байдаггүй боловч орон нутгийн шийдвэрээс хамааран харилцан адилгүй зохицуулалт байж болдог. Жишээлбэл: Цагийн ажилтан илүү цагийн хөлс авах эсэх талаар хуульд тодорхой зохицуулалт байхгүй, зарим орон нутагт огт олгодоггүй бол зарим орон нутгийн журамд “Цагийн ажилтан нийтээр амрах баярын өдрөөр илүү цагаар ажиллавал 3 дахин их цалин хөлс олгоно” хэмээн заасан байдаг.[140]

***Төрөөс цагийн ажил эрхлэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ***

Цагийн ажлын талаар төрөөс хэрхэн дэмжих тухай тусгайлсан бодлого, зохицуулалт дээрх хууль журмуудаас олдсонгүй. Иймд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх төрийн бодлого, хэрэгжилтийг авч үзлээ.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[139] https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/76384/108021/F755819546/CHN76384%20Eng.pdf
[140] https://uk.practicallaw.thomsonreuters.com/1-503-3245?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true

*БНХАУ-ын хөдөлмөр эрхлэлтийн төсөв[141](100 сая ам.доллароор)*




*Эх сурвалж: БНХАУ-ын Хүний нөөц, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар*

Хөдөлмөр эрхлэлтийн сан анх 2003 онд байгуулагдсан. Тус сан нь улсын эдийн засгийн шинэчлэл, хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний бодлого, хөтөлбөрийн зорилтот бүлгүүд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. 2009 оноос “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт”-ийн шинэ хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн мөн олон улсын санхүүгийн хямралын нөлөөллийг бууруулах чиглэлээр хариу арга хэмжээний зардал зэргээс шалтгаалж сангийн төсөв 2 дахин өссөн. 2014 оноос “Бизнес эрхлэлтийн хөгжүүлэлт”, орон нутгийн ажилчдын асуудлыг хамаарах болсон байна. 2020-2021 оноос Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийн эсрэг бодлого хэрэгжүүлж эхэлсэн.

*Хүснэгт 4. БНХАУ-ын хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хөгжил (2002-2021)[142]*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[141] https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_831186.pdf Box 5.3
[142] https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_613367.pdf table 1

| Бодлогын тэргүүлэх чиглэл, үе шат | Улсын үйлдвэрийн газруудын шинэчлэл (2002-2007) | Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөт өлбөр (2008) | Олон улсын санхүүгийн хямралын хариу арга хэмжээ (2009) | Бизнес эрхлэлтийн хөгжүүлэлт (2015) | Хөдөлмөр эрхлэлтийн цогц бодлого (2017) | Ковид-19 цар тахлын хариу арга хэмжээ (2020-2021)[143] |
|---|---|---|---|---|---|---|
| **Шинээр ажлын байр бий болгох эдийн засгийн бодлого** | Хөдөлмөр зарцуулалт ихтэй, уламжлалт үйлчилгээ | Үйлчилгээний салбар, шинэ үйлдвэрүүд | 4 их наяд юанийн хөрөнгө оруулалт | Макро эдийн засаг ба хөрөнгө оруулалтын бодлогод Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын үзүүлэх нөлөөллийн үнэлгээ; ДНБ ажил эрхлэлттэй холбогдох нь; ажил эрхлэлтийн чанар. | Хөдөлмөр эрхлэлтийн цогц бодлого нь тэгш байдал зэрэг хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн макро эдийн засгийн болон салбарын бодлогуудад төвлөрч байна. | 6.1 их наяд юанийн урамшууллын багц; Хөдөлмөр эрхлэлтийг хөрөнгө оруулалт болон салбарын хөгжилтэй холбох; хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэр, уян хатан хөдөлмөр эрхлэлт. |
| **Бизнес эрхлэлт** | Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт; бичил зээл; санхүүгийн дэмжлэг | | | 100.000 юанийн бичил зээл олгох; засаг захиргааны оролцоог багасгах; бизнес эрхлэх бүсийг өргөжүүлэх; татварын хөнгөлөлт, чөлөөлөлт. | Бодлого нь хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэр, ЖДҮ-ийг дэмжих, ядуурлыг бууруулах чиглэлд өргөжсөн. | Цар тахалд нэрвэгдсэн ажилчдыг дэмжих бодлогыг өргөжүүлэх. Ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжих зорилгоор гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан бичил зээлийн өргөтгөсөн хөтөлбөр |
| **Ажилд орох** | Татварын хөнгөлөлт, нийгмийн хамгааллын тэтгэмж | | | | | Шилжин суурьшигч ажилчдыг орон нутагт ажлын байраар хангах шинэ бодлого. Ядуурлыг бууруулах тусгай сан. Их, дээд сургууль төгсөгчдөд зориулсан цогц бодлого. |
| **Зорилтот бүлгүүд** | Татварын хөнгөлөлт, нийгмийн хамгааллын болон цалингийн тэтгэмж | | Даатгалын төлбөрийн хугацааг хойшлуулах; даатгалын хувь хэмжээг бууруулах; цалингийн тэтгэмж. | | | Их дээд сургууль төгсөгчид, эмзэг бүлгийнхэн; COVID-19-д нэрвэгдсэн аж ахуйн нэгж, бүс нутаг; ЖДҮ. Цагаач ажилчид |
| **Ажлын байр хадгалах** | Үгүй | Үгүй | | | Төмөр, ган, нүүрсний аж үйлдвэрлэлийг онцлох. | Одоогийн хэрэгжүүлж буй бодлого дээр нэмэгдээд ажилгүйдлийн даатгалын санг ажлын байрыг хадгалахад ашиглах |
| **Төрийн үйлчилгээ** | Үнэ төлбөргүй үйлчилгээ; ажлын байрны баталгаа; зорилтот үйл ажиллагаа | | | | | Аж ахуйн нэгжүүдийг сэргээх, шилжин суурьшигч ажилчдад зориулсан иж бүрэн үйлчилгээ; Салбар тус бүрээр өргөн хэмжээний хөдөлмөрийн зах зохион байгуулах; хөдөлмөр эрхлэлтийн цахим үйлчилгээ. |
| **Ур чадвар** | Сургалтын тэтгэлэг; техникийн ажилтнуудад зориулсан ур чадварын сургалт, бизнесээ эхлүүлэх сургалт | | Тусгайлсан сургалтын схем | “Бизнес хөгжил”-ийн боловсрол олгох сургалт; ажлын байранд дагалдан суралцах шинэ схем | Ур чадвар олгох шинэ стратеги, дагалдан суралцагч, техникийн ажилтнуудад зориулсан тэтгэлгийн бодлого | Мэргэжлийн сургалтын схем |
| **Ажилгүйдлээс сэргийлэх** | Ажилгүйдлийн таамаглал, урьдчилан сэрэмжлүүлэх систем. | | | | | |
| **Нийгмийн хамгаалал** | Нийгмийн хамгааллын хамрах хүрээг өргөтгөх; хөдөлмөр эрхлэлтэд таатай нийгмийн хамгааллын бодлого. | | | | | Ажилгүйдлийн даатгал, амьжиргааны баталгаа болон бусад нийгмийн тусламж, үйлчилгээний тогтолцоо. |

[143] https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_752056.pdf table 5

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**<u>ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (ХБНГУ)</u>**

ХБНГУ-д цагийн ажил буюу “part-time job” гэдэг ойлголтонд:

- тогтмол богиносгосон цагийн ажил (“regular” part-time job)
- тогтмол бус цагийн ажил буюу (marginal part-time job эсвэл mini-jobs) гэсэн хоёр ойлголтыг багтаан авч үздэг.

*<u>Тогтмол богиносгосон цагийн ажил</u>* (“regular” part-time job) гэдэг нь ажлын өдөрт богиносгосон цагаар ажиллах, тогтмол ажил эрхэлдэг ажилчидтай адил нийгмийн даатгал болон бусад төрлийн даатгалд хамрагддаг ажлуудыг хэлж байна. Тогтмол богиносгосон цагийн ажилд ихэвчлэн нялх хүүхэдтэй, эсвэл хэн нэгнийг асран хамгаалах шаардлагатай боловч богиносгосон цагаар ажил эрхлэх хүсэлтэй эмэгтэй ажилтнууд хамрагдаж байна.

*<u>Тогтмол бус цагийн ажил</u>* (marginal part-time job эсвэл mini-jobs) гэдэг нь ихэвчлэн тодорхой мэргэжил, ур чадвар шаардахгүй, хөдөлмөрийн хүнд нөхцөлд 7 хоногт нийт 15- 20 цаг ажиллах ажлыг хэлж байна.

Амьжиргааны эх үүсвэр нь тогтмол бус цагийн хөдөлмөр эрхлэлтээс хамааралтай эмзэг, ядуу бүлгийн ажилгүй иргэдээс гадна нийгмийн халамжинд байдаг ахлах сургуулийн сурагчид, их, дээд сургуулийн оюутнууд, 65-аас доош тэтгэврийн насны ахмадууд тогтмол бус цагийн ажил эрхэлдэг. Үүнээс үзэхэд нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй боловч нийгмийн халамжинд байгаа иргэд ихэвчлэн цагийн ажил эрхэлдэг байна.

Тус улсад хагас цагийн ажил эрхлэлт 2022 оны эхний улиралд 11315.30 мянга байсан бол 2022 оны 2 дугаар улиралд 11582.30 мянга болж өссөн байна.

***Хууль эрх зүйн орчин***

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) нь 16 мужаас бүрддэг бөгөөд хөдөлмөрийн харилцааны зарим асуудлууд тус улс даяар мөрдөгдөх Холбооны хуульд хуульчлагдаагүй тохиолдолд тухайн мужийн хуулийг баримтална. Тус улсад цагийн ажил эрхлэлт нь:

- *Цагийн ажил эрхлэлт болон тогтсон хугацаанд гэрээгээр хөдөлмөрлөх тухай хууль (The Act of Part-time and Fixed-term Employment)*
- *Цагийн ажил эрхлэлтийн хуулийг цаашид хөгжүүлэх тухай хууль (On January 1, 2019, the “Act on Further Development of Part-Time Employment Law” (Gesetz zur Weiterentwicklung des Teilzeitrechts))*
- *Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай хууль* болон бусад хууль эрх зүйн актуудаар зохицуулагдаж байна.

**Цагийн ажил эрхлэлт болон тогтсон хугацаанд гэрээгээр хөдөлмөрлөх тухай хууль[144]**

Тус хуулиар Ажил олгогч нь цагийн ажилтантай “Хөлсөөр ажил гүйцэтгүүлэх гэрээ” байгуулж, уг гэрээнд цагийн ажлын нөхцөл, ажлын цаг, гүйцэтгэх ажил, ажлын хөлс зэргийг тодорхой заана. Мөн цагийн ажилтны хөдөлмөрийн хөлсний 30 хувьтай тэнцэхүйц шимтгэлийг төлдөг байна.

Холбооны Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, удаан хугацаагаар ажилгүй байгаа иргэдэд долоо хоногт 15 хүртэлх цагийн ажил хийх боломжийг олгон ажилгүйдлийн тэтгэмжийг хэвээр олгохоор заасан.

Мөн тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд ажил олгогчид ажилчдынхаа ажлын цагийг багасгахыг зөвшөөрөх ёстой.

[144] TzBfG - Act on Part-Time Work and Fixed-Term Employment Contracts (gesetze-im-internet.de)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Тогтмол хугацааны хөдөлмөрийн гэрээгээр ажиллах цагийн ажилтан нь ямар нэгэн объектив шалтгаангүйгээр 2 жил хүртэл хугацаагаар гэрээ байгуулж болно. Мөн хөдөлмөрийн харилцаа үүсэх үед ажилтан нь 52 нас хүрсэн, эсхүл дор хаяж 4 сарын хугацаанд ажилгүй байсан, богино хугацааны хөдөлмөрийн тэтгэмж авдаг бол хөдөлмөрийн гэрээг 5 хүртэл жил хязгаарлахыг зөвшөөрдөг байна.

**Цагийн ажил эрхлэлтийн хуулийг цаашид хөгжүүлэх тухай хууль**[145]

Энэхүү хууль нь 2019 онд батлагдсан бөгөөд ажилтныг хагас цагаар ажиллуулж, дараа нь бүтэн цагаар ажиллах боломжийг бий болгосон. Үүнийг “гүүр цагийн ажил” гэж нэрлэдэг байна. Хуульд зааснаар 45-аас дээш ажилтантай ААН, байгууллагуудад ажилладаг, тухайн ажлын байрандаа дор хаяж 6 сар ажилласан үндсэн ажилтан өөрийн хүсэлтээр цагийн ажилд шилжих өргөдөл гаргах боломжтой. Ингэхдээ ажилтны хүсэлтийн дагуу 1-5 жилийн хугацаагаар цагийн ажлын гэрээг байгуулах ба ажилтан гэрээнд харилцан тохиролцсон хугацаанаас өмнө ажлын цагийг буцаах боломжгүй. Энэ нь ажилтан болон байгууллагын төлөвлөлтийн тогтвортой байдлыг хангахад ач холбогдолтой юм. Харин гэрээний хугацаа дуусмагц, ажилтан бүтэн цагийн ажилдаа буцаж орох нь хуулиар нээлттэй байна. Цагийн ажилд шилжих өргөдөл, хүсэлтийг гэрээ байгуулах хугацаанаас 3 сарын өмнө гаргах ёстой. Гэвч ажилтан бүр ийм өргөдөл гаргах боломжгүй бөгөөд тодорхой хязгаарлалттай байдаг. Тухайлбал, 46-200 ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагуудын 15 ажилтан тутмын 1 нь хүсэлт гаргах эрхтэй байна.

**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль**[146]

Тус хууль нь 2015 оноос хойш үйлчилж эхэлсэн бөгөөд энэхүү хуулиар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох харилцаа, баримтлах хэм хэмжээг хуульчилсан.

ХБНГУ-д 2022 оны байдлаар цалингийн доод хэмжээ **1 цагийн ажлын 12 евро** байна. Зарим үйлдвэрүүдэд хуульд заасан цалингийн доод хэмжээг 1-2 еврогоор давж нэмэгдүүлсэн байна. Барилгын салбарт мэргэшсэн ажилчдын цалингийн доод хэмжээг тогтоосон бөгөөд нийт амьжиргааны доод түвшингээс 50 гаруй хувиар давсан байдаг байна**.**

***Төрөөс цагийн ажил эрхлэлтийг дэмжих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ***

Тус улсад цагийн ажил эрхлэлтийн эрэлт хэрэгцээ их байдгийн зэрэгцээ түүнийг хангах ажлын байрыг бий болгох, цагийн ажил эрхлэгч болон ажил олгогчдыг дэмжих хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн байна. Улмаар тогтмол богиносгосон цагийн ажил эрхлэгч болон тогтмол бус цагийн ажил эрхлэгчдэд бага орлоготой, эсвэл бага цагаар ажилладаг бол нэмэлт тэтгэмж олгох, ажил олгогчдод ажлын байрыг хадгалах татаас, ажил эрхлэлтийн тэтгэмж, санхүүгийн тусламж зэрэг дэмжлэгийг үзүүлдэг байна.

**Ажил олгогчид олгох ажил эрхлэлтийн тэтгэмж** (Eingliederungszuschuss)

Энэ нь ажлын туршлага, мэдлэггүй иргэнийг ажилд сурган авах, хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настныг ажилд авсан ажил олгогчид олгодог тэтгэмж юм.

Тэтгэмжийн хэмжээ нь тухайн ажилтны цалингийн **50 хүртэлх хувьтай тэнцэх бөгөөд 1 жил хүртэлх хугацаанд** сар бүр олгох боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настныг ажиллуулсан тохиолдолд тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж болно. 50-аас дээш

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[145] https://www.clearymawatch.com/2019/03/bridge-part-time-work-in-germany/
[146] https://www.zoll.de/EN/Businesses/Work/Foreign-domiciled-employers-posting/Minimum-conditions-of-employment/Minimum-pay-pursuant-Minimum-Wage-Act/Scope-of-application-of-the-Minimum-Wage-Act/scope-of-application-of-the-minimum-wage-act_node.htm

насны ажилгүй хүнийг ажилд авсан тохиолдолд тэтгэмжийг 3 жил хүртэл хугацаагаар олгож болно.

Тиймээс ажил олгогчид улсаас цалингийн тал болон түүнээс дээш хувийг нь төлөх хүнийг ажилд авах санхүүгийн сонирхолтой байдаг байна. Ажил олгогчид ийм нэмэлт төлбөр олгох шийдвэрийг Хөдөлмөрийн биржийн төлөөлөгч гаргадаг.

Холбооны Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаас, цар тахлын улмаас учирч буй эдийн засгийн хохирол, нийгмийн сөрөг үр дагаврыг бууруулахад чиглэсэн олон чухал шийдвэр гаргасан. Тухайлбал, 5 хүртэл тооны ажилтантай ААН-д 3 сарын хугацаанд 9000 евро хүртэл, 10 хүртэл тооны ажилтантай ААН-д 15.000 евро хүртэл хэмжээтэй нэг удаагийн санхүүгийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэсэн байна.

- Ажлын байр, ажилчдын орлогыг хадгалах зорилгоор богино хугацааны ажлын («Курзарбайт») татаасыг өргөтгөх, бага насны хүүхэдтэй, бага орлоготой эцэг эхчүүдэд хүүхдийн асран хамгаалах мөнгө олгох, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогыг хэвээр үлдээх анхан шатны санхүүгийн дэмжлэгийг авахыг хялбар болгосон.
- Ковид-19 цар тахлын хоёр дахь давлагаатай тэмцэх шинэчилсэн хатуу хөл хориотой зэрэгцэн Засгийн газар нь бизнес эрхлэгчдийг дэмжих үүднээс төсвийн нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлж, одоо хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сайжруулж, тэр дотроо орлогын нөхөн олговор (75 хүртэлх хувь), түүнчлэн улсын зээлийн баталгаа, үндсэн орлогын доод хэмжээний баталгаажуулалтыг оруулсан байна.

## БҮГД НАЙРАМДАХ ФИНЛАНД УЛС (ФИНЛАНД)

Финландад цагийн ажил эрхлэлтийн дийлэнхийг залуучууд, оюутнууд эзэлдэг, нийт оюутнуудын 46.5 хувь нь цагийн ажил давхар эрхэлдэг. Тус улсад 15 наснаас хөнгөн ажил эрхлэхийг зөвшөөрдөг. Оюутнууд 7 хоногт 25 цагийн хөдөлмөр эрхлэх боломжтой, 2022 оны эхээр гадаад оюутнуудын ажил эрхлэх цагийг 30 болгож нэмэгдүүлсэн.

Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн яам (Ministy of Economic Affairs and Employment) /ЭЗХЭЯ/ “TE-service”-Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг Job market Finland цахим платформоор, мөн “TE-office”-ийн орон даяар тархсан 120 гаруй салбаруудаараа үзүүлдэг. Энэхүү ажил хайгчдад зориулсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ нь:

- Ажлын зар;
- Ажил хайх;
- Ажилд орох өргөдлийн профайл үүсгэх;
- Цагаачдад зориулсан лавлагаа, мэдээлэл;
- Хөдөлмөрийн зах зээлийн сургалт;
- Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, ажил мэргэжлийн төлөвлөлт;
- Job market Finland цахим үйлчилгээ гэсэн төрлүүдтэй.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Финланд Улс дахь цагийн ажил эрхлэлтийг сүүлийн 5 жилээр харуулбал:




*Эх сурвалж: Statistics Finland, Statistics on business subsidies*

Графикаас харахад 2019, 2020 онуудад “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн өсөлт саарснаас үүдэн ажил эрхлэлт, түүн дотроо цагийн ажлын тоо буурсан байна. 2021 оноос нөхцөл байдал сайжирч, “Ковид-19”-ийн сөрөг нөлөөллийг хяналтанд авснаар эдийн засгийн үзүүлэлтүүд тогтворжиж, өсөх хандлагатай болжээ.

***Хууль эрх зүйн орчин***

Финланд Улсад хөдөлмөрийн харилцаа дараах хуулиудаар зохицуулагддаг. Үүнд:

- **Хөдөлмөрийн гэрээний хууль /Employment Contracts Act 2001/**
- Ажлын цагийн хууль /Working Hours Act 2019/
- Жилийн амралтын өдрийн хууль /Annual Holidays Act 2005/
- Ялгаварлан гадуурхлын эсрэг хууль /Non-discrimination Act/
- Хөдөлмөрийн харилцаанд хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль /Act on the Protection of Privacy in Working Life/
- Хамтын гэрээний хууль /Collective Agreements Act/
- Ээлжийн ажлын чөлөөний хууль /Act on Job Alternation Leave (partially within the purview of the Ministry of Social Affairs and Health, MSAH)/
- Сургалтын чөлөөний хууль /Study Leave Act/
- Төлбөрийн аюулгүй байдлын хууль /Pay Security Act/
- Талуудын оролцооны механизмын хууль тогтоомж /The legislation on the personnel involvement systems (co-operation within undertakings, representation in administrative organs and personnel funds)/ гэх мэт.

Цагийн ажил эрхлэлтийн хувьд ажлын үргэлжлэх хугацаанаас бусдаар дээрх холбогдох хууль тогтоомжоор тогтоосон хөдөлмөрийн нөхцөл, журмыг дагаж мөрдөх шаардлага тавьдаг бөгөөд хуулиас гадуур ямар нэг үндэслэлгүй шаардлага, нөхцөл тавихыг хориглодог байна.

Цагийн ажил эрхлэлттэй холбоотой асуудлыг Хөдөлмөрийн гэрээний хуулиар зохицуулсан байна. Тухайлбал,

*Хуулийн Ялгаварлан гадуурхахыг хориглох, тэгш хандах 2-р хэсэг (1331/2014)2-т:* “…Хугацаатай (fixed-term) болон цагийн ажил (part-time)-ын хөдөлмөрийн харилцаанд холбогдох хөдөлмөрийн нөхцөлийг зөвхөн хөдөлмөрийн гэрээний хугацаа, ажлын цагаас бусдаар тодорхой үндэслэл, шалтгаангүйгээр дордуулж болохгүй…” гэж заасан.

*Мөн Цагийн ажилтанд нэн тэргүүнд ажил санал болгох ажил олгогчийн үүрэг 5-р хэсэгт:* “Хэрэв ажил олгогчид цагийн ажилтан ажиллуулдаг ажлын байранд нь байнгын ажилтан шаардлагатай болбол тэдгээр цагийн ажилтанд эхний ээлжинд ажлын санал тавина…”

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Ажлын сул орон тооны мэдээлэл 6-р хэсэг (10/2012)-т:* "Ажил олгогч нь ажлын сул орон тооны талаар тухайн аж ахуйн нэгжийн тогтсон журмын дагуу мэдээлэл гаргах, эсхүл тухайн ажлын байран дахь хугацаатай болон цагийн ажилтанд үндсэн ажилтнаар өргөдөл гаргах боломжийг олгох ёстой. Үүнтэй адил хөлсөөр ажиллаж буй ажилчдад /Хөдөлмөрийн товчооны/ ажлын сул орон тооны талаар мөн мэдэгдэх ёстой." гэж тус тус заажээ.

***Төрөөс үзүүлж буй дэмжлэг***

Финландын Эдийн засаг, хөдөлмөр эрхлэлтийн яам (Ministy of Economic Affairs and Employment) /ЭЗХЭЯ/-аас шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчид цалингийн нөхөн төлбөр олгодог. Цалингийн нөхөн төлбөрийн хэмжээ нь цалингийн зардлын 30-50 хувь хүртэл байж болох ба 2022 оны байдлаар, сард олгох дээд хэмжээг 1400 еврогоор тогтоосон байна. Цалингийн нөхөн төлбөрийг гол төлөв удаан хугацаагаар ажилгүй байсан, хөгжлийн бэрхшээлтэй, 25-аас доош насны залуучууд, бусад зорилтот бүлгийн хүмүүсийг ажилд авахад олгодог бөгөөд үүнд байнгын, тогтмол ажлын байр мөн ажил хайгчийг цаашид байнгын ажлын байраар хангах боломжтой цагийн ажлууд хамаардаг байна.

Түүнчлэн ЭЗХЭЯ нь хөгжлийнхөө янз бүрийн үе шатанд байгаа ажил олгогч аж ахуйн нэгжүүдэд, тэдгээрийн санхүүгийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, бизнесийн санхүүжилтийг зохицуулдаг үндэсний болон олон улсын дүрэм, журмын хүрээнд дотоодын ба экспортын санхүүжилтийн дараах дэмжлэг, туслалцааг үзүүлдэг байна. Үүнд:

- **Зээл, зээлийн баталгаа:** Финнвера (Finnvera plc) нь төрийн өмчит, мэргэшсэн санхүүгийн компани бөгөөд бизнес эхлүүлэх, хөгжүүлэх, олон улсын зах зээлд гарах, экспорт хийхэд зориулж аж ахуйн нэгжүүдэд эрсдэлээс хамгаалах санхүүжилт олгодог. Түүнчлэн холбогдох эрсдэлийг бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хуваалцдаг байна.
- **Венчур капиталын хөрөнгө оруулалт**: Төрийн венчур хөрөнгө оруулалтын зорилго нь венчурын хөрөнгө оруулалтын зах зээлийн хөгжлийг дэмжиж, хувийн хөрөнгөөр эрсдэл хийхэд хүндрэлтэй орон зайд санхүүжилт хийхэд анхаарахад оршино.
  Одоогоор Финландын ЭЗХЭЯ-ны дэргэд Industry Investment Ltd ба Business Finland Venture Capital Ltd гэсэн хоёр төрийн өмчийн венчур хөрөнгө оруулалтын компани ажиллаж байна.
- **Европын стратегийн хөрөнгө оруулалтын сан:** ЕСХОС нь Европын холбооноос байгуулсан, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх зорилготой, Европын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нэг хэсэг. Европын Хөрөнгө оруулалтын Банктай хамтран ажилладаг бөгөөд эдийн засгийн хувьд ашигтай төслүүдийг л санхүүжүүлдэг.
- **Аж ахуйн нэгжийн хөгжлийг дэмжих болон гарааны бизнесийн тэтгэлэг:** Аж ахуйн нэгжийн хөгжлийн тэтгэлэг, аж ахуйн нэгжийн хөгжлийн үйлчилгээ, гарааны бизнесийн тэтгэлэг зэрэг нь шинэ бизнесээ эхлүүлэх, одоогийн бизнесээ хөгжүүлэх болон бизнестээ шинэ боломж, бололцоог нээн хөгжүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд чиглэгддэг.
- **Олон улсын түвшинд гарахад (Internationalisation) нь туслах:** Аж ахуйн нэгжүүдийг олон улсын түвшинд гарахад нь туслах санхүүгийн буцалтгүй дэмжлэг үзүүлэхээс эхлэн зээл олгох, зээлийн баталгаа гаргах хүртэл өргөн хүрээтэй төрийн санхүүгийн үйлчилгээ юм.
- **Олон нийтийн судалгаа, хөгжүүлэлт, инновацын (RDI) санхүүжилт:**
  "Бизнес Финланд" (Business Finland), Финландын инновацын санхүүжилтийн агентлаг нь эрсдэлтэй хэдий ч ирээдүйд эдийн засагт шинэ түлхэц болохуйц

UIH.MN СУДАЛГААНЫ САН

төслүүдийг санхүүжүүлдэг. Санхүүжилт нь буцалтгүй тэтгэлэг, зээл хэлбэрээр байдаг бөгөөд компани, судалгааны байгууллага, нийтийн үйлчилгээний байгууллага аль аль нь санхүүжилт авах боломжтой. Хөгжиж буй компаниудыг бэхжүүлэх, төрөлжүүлэн хөгжүүлэх зорилготой венчур хөрөнгө оруулалтын “Бизнес Финланд Венчур Капитал” (Business Finland Venture Capital Ltd)-ыг 2014 онд байгуулсан.

- **Бүс нутгийн хөнгөлөлт:** Ажиллах хүч, бусад нөөцийн жигд бус байдлаас болоод бүс нутаг бүрд бизнес эрхлэх боломж, бололцоо нь харилцан адилгүй байдаг. Иймд Засгийн газраас сул хөгжилтэй бүс нутгуудыг “дэмжих бүс”-ээр зарладаг. Тухайлбал: Дэмжих бүс нутгийн бизнес эрхлэгч улс орны бусад хэсгийнхээс хамаагүй өндөр хөрөнгө оруулалтын дэмжлэг авах боломжтой байдаг. Хүн ам сийрэг суурьшсан бүс нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгч холын тээврийн зардлын нөхөн олговор авах боломжтой байдаг.
- **Бизнесийн нөхөн олговор (business subsidies) олгох:** Бизнесийн тэтгэмж нь хүүгийн төлбөр, түүнчлэн зээл, зээлийн баталгаа, өмчийн санхүүжилт, татварын төлбөр болон эдийн засгийн үр өгөөж агуулсан бусад зохицуулалтыг тодорхой хуваарийн дагуу эсвэл хуваарьгүйгээр нөхөн төлбөр болгон олгодог.

Үндэсний хэмжээнд бизнесийн нөхөн олговрын ерөнхий шалгуурууд нь:

- Нийгэм, эдийн засгийн маш тодорхой зорилготой байх. Хэрэв эдийн засгийн зорилготой гэж үзвэл зах зээлийн тодорхой нэг алдаа, доголдлыг арилгахад чиглэгдэх ёстой;
- Зохистой, зардал, үр ашгийн нөлөөтэй байх;
- Өрсөлдөөнд аль болох хамгийн бага гажуудал үүсгэх;
- Хугацаатай;
- Урамшуулах нөлөөлөл;
- Урьдчилсан байдлаар ашигтай байх;
- Үр нөлөөний үнэлгээ.

Финландын аж ахуйн нэгжүүдэд олгосон бизнесийн буцалтгүй тэтгэмжийн хэмжээг сүүлийн 3 жилээр харуулбал: */мянган еврогоор/*




*Эх сурвалж: Statistics Finland, Statistics on business subsidies*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


- Working conditions in a global perspective https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms_696174.pdf
- Global Employment Trends for Youth 2022 https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms_853321.pdf
- Non-standard forms of employment https://www.ilo.org/global/topics/non-standard-employment/lang--en/index.htm

АНУ

- Working conditions in a global perspective https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---dcomm/---publ/documents/publication/wcms_696174.pdf
- Fair Labor Standards act https://uscode.house.gov/view.xhtml?path=/prelim@title29/chapter8&edition=prelim
- US Department of Labor Minimum wage https://www.dol.gov/agencies/whd/minimum-wage
- State minimum wage laws https://www.dol.gov/agencies/whd/minimum-wage/state
- Part-time vs. Full-time Employment: Determining the Status of Your Employees https://www.patriotsoftware.com/blog/payroll/part-time-vs-full-time-employment/
- Part-time Employee Rules https://smallbusiness.chron.com/part-time-employee-rules-2965.html
- Part-Time employment https://www.dol.gov/general/topic/workhours/parttimeemployment
- OPM https://www.opm.gov/policy-data-oversight/hiring-information/part-time-and-job-sharing/
- Full-time and Part-time Employment: A deeper look https://www.advisorperspectives.com/dshort/updates/2022/08/09/full-time-and-part-time-employment-a-deeper-look
- Work opportunity tax credit https://www.dol.gov/agencies/eta/wotc
- Employment and Unemployment Among Youth-Summer 2022 https://www.bls.gov/news.release/pdf/youth.pdf
- Build back better framework https://www.whitehouse.gov/build-back-better/
- Employer tax incentives available from the Federal Government https://askearn.org/page/federal-government-employer-tax-incentives
- Federal Bonding Program https://bonds4jobs.com/wp-content/uploads/2022/04/FBP-Employers-Job-Seekers-Brochure-update-103.pdf
- Employer Incentive Plus https://www1.nyc.gov/site/businesslink/employers/employer-incentives-plus.page
- New York youth jobs program https://www.ny.gov/programs/urban-youth-jobsnew-york-youth-jobs-program

ФИНЛАНД

- https://tem.fi/en/frontpage
- https://finlex.fi/en/laki/kaannokset/
- https://stat.fi/index_en.html

БНСУ

- Цагийн хөдөлмөр эрхлэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба эрх зүйн орчин, бусад орнуудын туршлага (ХБНГУ, БНСУ-ын жишээн дээр хийсэн лавлагаа) (СТ-13/222),


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Statistics Korea http://kostat.go.kr/portal/eng/pressReleases/5/2/index.board
- https://elaw.klri.re.kr/kor_service/lawView.do?hseq=59932&lang=ENG
- https://data.worldbank.org/indicator/SL.TLF.PART.ZS?end=2021&locations=KR&start=2011

БНХАУ

- http://www.lawinfochina.com
- https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/37357/108026/
- https://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/76384/108021/F755819546/CHN76384%20Eng.pdf
- https://uk.practicallaw.thomsonreuters.com/1-503-3245?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true
- https://knowledge.leglobal.org/wp-content/uploads/sites/2/LEG-Employment-Law-Overview-2021-2022_China_27.03.21.pdf
- https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_831186.pdf
- https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_752056.pdf
- https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_613367.pdf
- http://www.stats.gov.cn/tjsj/ndsj/2019/indexeh.htm
- https://www.statista.com/topics/1317/employment-in-china/

ХБНГУ

- TzBfG - Act on Part-Time Work and Fixed-Term Employment Contracts (gesetze-im-internet.de)
- https://www.shrm.org/resourcesandtools/legal-and-compliance/employment-law/pages/global-germany-temporary-part-time-employment.aspx
- https://www.zoll.de/EN/Businesses/Work/Foreign-domiciled-employers-posting/Minimum-conditions-of-employment/Minimum-pay-pursuant-Minimum-Wage-Act/Scope-of-application-of-the-Minimum-Wage-Act/scope-of-application-of-the-minimum-wage-act_node.html

МОНГОЛ УЛС

- Хөдөлмөрийн тухай хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751
- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2016-2020 оны хэрэгжилтийн үнэлгээ https://projects.mlsp.gov.mn/api/uploads/public/20220413/a63dd58f-830c-4128-b08d-440db05d2725.pdf
- https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---dgreports/---stat/documents/publication/wcms_422424.pdf
- https://www.lorinetfoundation.org/wp-content/uploads/2022/06/MN_Youth-Employability-Landscape-Study_-Summary_Lorinet_Foundation_06_2022.pdf
- http://catalog.naog.gov.mn/cgi-bin/koha/opac-retrieve-file.pl?id=5e34ea60fc5c5299e3f5a33b0f4ebaea


UIH.MN СУДАЛГААНЫ САН

# ЭМИЙН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИ БА ЭМИЙН ЧАНАР, СТАНДАРТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ: ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш, О.Нарантуяа, Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Э.Дашзэгвэ*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ.ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ

1.1. Эмийн зохицуулалтын олон улсын хамтын ажиллагаа

1.2. ЭЗХАХБ-ын “Сайн лабораторийн туршлага” (Good Laboratory practice-GLP)-ын стандарт

1.3. Эмийн аюулгүй байдал, эмийн хяналт шинжилгээний зөвлөмж (фармаковижиланс хөтөлбөр)

ХОЁР.ЭМИЙН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИ, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФЫН ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

2.1. МАЛАЙЗ УЛС

2.2. ИСЛАМЫН БҮГД НАЙРАМДАХ ПАКИСТАН УЛС (ПАКИСТАН)

2.3. ФИНЛАНД УЛС

2.4. АНУ

2.5. ДАНИ УЛС

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИ, ЭМИЙН ЧАНАР, СТАНДАРТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЭЗХАХБ | Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага |
| СЛТ (GLP) | Сайн лабораторийн туршлага (Good Laboratory practice) |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| ЭЗУГ | Эмийн зохицуулалтын удирдах газар |
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| ЕХ | Европын холбоо |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭЭХХЗГ | Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар |
| МХЕГ | Мэргэжлийн хяналтын ерөнхий газар |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Судалгаанд хамрагдсан орнуудын эмийн хяналтын лабораторийн талаарх туршлага ба эмийн чанар, стандартад хийгддэг шинжилгээний үнэ тарифын талаарх харьцуулсан мэдээлэл
Хүснэгт 2.Лабораторийн үнэ тариф
Хүснэгт 3.Эмийн төв лабораторийн үнэ тариф
Хүснэгт 4.Биологийн хяналтын үндэсний лабаортори
Хүснэгт 5.Тусгайлан захиалсан тайлан мэдээ, мөрдөн шалгалт, хяналт, дүн шинжилгээ
Хүснэгт 6.Тусгайлан захиалсан лабораторийн ажил үйлчилгээ
Хүснэгт 7.2023 оны санхүүгийн жилд Нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эмийг шинжлэн баталгаажуулах төлбөр
Хүснэгт 8.2023 оны санхүүгийн жилд Жороор олгох эмийг шинжлэн баталгаажуулах төлбөр
Хүснэгт 9.2023 оны санхүүгийн жилд эм төст бүтээгдэхүүнийг шинжлэн баталгаажуулах төлбөр
Хүснэгт 10.2023 оны санхүүгийн жилд Хүний эмийн орц найрлагад орох бүтээгдэхүүнийг шинжлэн баталгаажуулах төлбөр
Хүснэгт 11.Эмийн бүтээгдэхүүн болон API-ийн туршилт хийсэн тоо
Хүснэгт 12.Шинэ маркетингийн зөвшөөрөл болон компанийн бүртгэлийн хураамжийн тойм (2022):
Хүснэгт 13.Компанид зөвшөөрөл олгох, бүртгүүлэх өргөдлийн хураамж

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгын дагуу “Эмийн хяналтын лаборатори ба эмийн чанар, стандартын шинжилгээний үнэ, тариф: зарим орны туршлага” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны зорилго**

Эмийн чанар, стандартад хяналт тавих тогтолцооны олон улсын жишиг, бусад орнуудын эмийн хяналтын лаборатори болон эмийн хяналтын шинжилгээний үнэ тарифын мэдээллийг харьцуулан судлах.

**Судалгааны хамрах хүрээ**

Судалгаанд эмийн чанар, хяналтын тогтолцооны талаар олон улсын байгууллагуудаас гаргасан зөвлөмж, гарын авлага, судалгааны үр дүнгийн мэдээллийг оруулснаас гадна Малайз, Пакистан, Финланд, Дани, АНУ зэрэг орнуудын эмийн хяналтын лаборатори, эмийн хяналтын шинжилгээний үнэ тарифын мэдээллийг харьцуулан судалсан. Мөн Монгол Улсын эмийн хяналтын лаборатори, эмийн чанар, стандартын шинжилгээний үнэ тарифын мэдээллийг оруулав.

**Судалгааны тайлангийн бүтэц:** Судалгаа нь 3 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт эмийн чанар, хяналтын тогтолцооны талаарх олон улсын байгууллагын зөвлөмж, гарын авлага, судалгааны үр дүнгийн мэдээллийн тойм, Хоёрдугаар хэсэгт судалгаанд авагдсан орнуудын эмийн хяналтын лаборатори болон эмийн хяналтын шинжилгээний үнэ тарифын мэдээлэл, Гуравдугаар хэсэгт Монгол Улсын эмийн хяналтын эрх зүйн орчин, эмийн хяналтын лаборатори, эмийн чанар, стандартын шинжилгээний үнэ тарифын талаарх мэдээллүүдийг тус тус оруулсан болно.

***Түлхүүр үг:*** *Эмийн чанарын хяналтын лаборатори*

***Keyword:*** *pharmaceutical quality control laboratories*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

***Олон улсын чиг хандлага***

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын тогтолцоо: Судалгаанаас үзэхэд, дэлхийн болон бүс нутгийн хүрээнд эмийн хяналт, зохицуулалтын олон улсын хамтын ажиллагааны олон загварыг хэрэгжүүлж байна.

ДЭМБ-аас Европын эмийн зохицуулалтын тогтолцоог бусад бүс нутаг, улс орнуудад энэ чиглэлээр хамтран ажиллах, харилцан итгэлцлийг бий болгоход үлгэр жишээ болохуйц хэмээн дүгнэсэн бол Азийн бүс нутагт эмийн бүтээгдэхүүний хяналт, зохицуулалтыг уялдуулах чиглэлээр Зүүн Өмнөд Азийн орнуудын холбоо (Association of Southeast Asian Nations- ASEAN), Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (APEC) ба Персийн булангийн эмийн бүртгэлийн төв хороо (Gulf Central Committee for Drug Registration GCC-DR) зэрэг байгууллагууд ажиллаж байна.

Евразийн эдийн засгийн комисс 2016 оноос эхлэн гишүүн орнуудынхаа хүрээнд эм, эмийн хэрэгслийн нэг зах зээлтэй болох зөвшилцөлд хүрсэн бөгөөд эмийн бүртгэлээс эхлээд түгээлт хүртэлх процессыг үе шаттайгаар явуулж эхлээд байна. Үүнд Армени, Беларусь, Казахстан, Киргиз, ОХУ зэрэг орнууд нэгдсэн байна. Монгол Улсын хувьд иймэрхүү олон улсын ямар нэгэн зохицуулалтын сүлжээнд одоогоор ороогүй байна.

Эмийн хяналтын лабораторийн тухайд, дэлхийн улс орнууд ЭЗХАХБ(OECD)-ын “Сайн лабораторийн туршлага” (Good Laboratory practice-GLP) зарчмыг мөрдлөг болгодог байна. GLP стандартыг дагаж мөрдөх нь эмийн аюулгүй байдлын мэдээллийг бүртгэлийн байгууллагад үнэн зөвөөр мэдээлэх баталгаа болдог. Одоогийн байдлаар 30 улс GLP стандартыг дагаж мөрдөх гэрээнд гарын үсэг зурсан байна.

Эмийн аюулгүй байдлыг хангах ДЭМБ-ын фармаковижиланс хөтөлбөр нь эмийн хэрэглээтэй холбоотой өвчтөний аюулгүй байдлыг хангах зорилготой бөгөөд эмийн гаж нөлөөний эрсдэл, үр нөлөөг үнэлэх найдвартай мэдээллийн санг үүсгэж, нийгэмд чиглэсэн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр хэрэгждэг байна. Тус хөтөлбөрийн үндсэн гишүүн 123 орон байдаг ба Монгол Улс үндсэн гишүүнчлэлд орохоор хүлээгдэж буй 28 орнуудын нэг юм.

Энэ хөтөлбөрөөс дэмжлэг авахын тулд:

1. Эмийн аюулгүй байдлыг хянах аргачлалыг эзэмшсэн байх;
2. Эрүүл мэндийн яам, түүнтэй адилтгах байгууллагаас Эмийн хяналтын үндэсний төвийг томилж, ажиллуулах;
3. ДЭМБ-д гаргаж өгөх тайлангийн шаардлагыг биелүүлэх техникийн чадвартай байх зэрэг шалгууруудыг хангасан байх шаардлагатай.

***Судалгаанд авагдсан орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтын талаар:***

Малайз Улсад эмийн чанар, стандарт, аюулгүй байдалтай холбоотой харилцааг Эм худалдах тухай хууль, Аюултай эмийн тухай хууль, Хордлогын тухай хууль, Эмийн зар сурталчилгааны тухай хууль, Эм, гоо сайхны бүтээгдэхүүний хяналтын тухай хууль, Эм зүйчдийн бүртгэлийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг байна. Мөн Эм зүйн үйлчилгээний алба (The Pharmacy Services Programme), Үндэсний эмийн зохицуулах агентлаг (National Pharmaceutical Regulatory Agency NPRA), Хяналтын алба зэрэг агентлаг, нэгжүүд ажилладаг байна. Малайз нь GLP (Good Laboratory Practice) чанарын стандартыг хэрэгжүүлсэн байна.

Пакистан Улсад Эмийн тухай хууль, Пакистаны Эмийн зохицуулалтын удирдах газрын тухай хууль гэсэн хоёр гол хуулиар зохицуулж байна. Пакистаны эмийн зохицуулалтын удирдах газар (Drug Regulatory Authority of Pakistan-DRAP) нь хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд Холбооны Засгийн газрын зөвшөөрлийн дагуу, тухайлсан тодорхой харилцааг нарийвчлан зохицуулах дүрэм, журам батлан гаргах эрхтэй байдаг бөгөөд энэхүү эрхийнхээ хүрээнд эмийн шошго, сав баглаа, боодол, эмийн тусгай зөвшөөрөл, эмийн судалгааны дүрэм, эмийн шинжээчдийн ажиллах дүрэм, эмийн экспорт, импортын дүрэм, эмийн тодорхойлолтын дүрэм, эмийн зөвлөлийн дүрэм, эмнэлгийн хэрэгслийн дүрэм, био судалгааны дүрэм, эрүүл мэндийн ажилтны ёс зүйн дүрэм, эмийн үнийн бодлого, фармаковижилансийн дүрэм зэрэг дүрэм, журмуудыг батлан хэрэгжүүлж байна. Пакистаны эмийн зохицуулалтын удирдах газар (Drug Regulatory Authority of Pakistan-DRAP), Эмийн хяналтын газар (Drug Control Organization), Эмийн төв лаборатори (Central Drug Laboratory), Биологийн хяналтын үндэсний лаборатори (National Control Laboratory for Biologicals) зэрэг албан нэгжүүд эмийн чанар, стандартад хяналт тавьж ажиллахын зэрэгцээ муж бүрд эмийн чанарын лабораториуд ажилладаг байна.

Финланд Улсад Эмийн тухай хууль, Эмийн агентлагийн тухай хууль, Эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төрийн үндсэн төлбөрийн тухай хууль, Эмийн агентлагийн төлбөрийн тухай хууль зэрэг хуулиудаар уг асуудлыг зохицуулж байна. Финландын Эмийн агентлаг (The Finnish Medicines Agency-Fimea) нь эмийн чанар, стандартад хяналт тавих асуудлыг хариуцан ажилладаг. Тус агентлаг нь Финланд Улсын хэмжээнд эмтэй холбоотой аливаа

UIH.MN СУДАЛГААНЫ САН

зөвшөөрөл, лиценз, олгох, эмийн үйлдвэрлэлийн чанар, стандартыг хангах, зах зээлд нэвтрүүлэх эмийн чанар, үр нөлөөний талаар мэдээлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна. Эмийн хяналтын лаборатори (The Official Medicines Control Laboratory-OMCL)-тай бөгөөд уг лаборатори нь Европын эмийн хяналтын лабораторийн сүлжээ байгууллага юм. Мөн “Сайн лабораторийн туршлага” (Good Laboratory Practice-GLP)-ын чанарын стандартыг баримтлан ажилладаг. Тиймээс эдгээр үйл ажиллагааг явуулахдаа дотоодын хууль, дүрэм журмыг мөрдөхөөс гадна Европын холбооны эмийн чанар, стандартыг тодорхойлдог стандарт, дүрэм журмыг баримталдаг байна.

АНУ-д эмийн чанар, стандарт, аюулгүй байдалтай холбоотой харилцааг Холбооны улсын Хүнс, эм, гоо сайхны бүтээгдэхүүний тухай хууль, Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай хууль, Эмийн чанар, аюулгүй байдлын тухай хууль, Эмийн зүй бус хэрэглээнээс сэргийлэх, хяналт тавих тухай хууль, Эмийн бүтэц найрлагын хяналтын тухай хууль, Жороор олгох эмийн худалдааны тухай хууль, Эмийн үнийн өрсөлдөөн болон патентын хугацааг шинэчлэх тухай хууль зэрэг хууль тогтоомжуудаар зохицуулдаг. Эмийн чанар, стандартын хяналтыг Хүнс болон Эмийн захиргаа (Food and Drug Administration) хариуцан ажилладаг бөгөөд уг байгууллагын харьяанд байдаг Эмийн үнэлгээ, судалгааны төв (Center for Drug Evaluation and Research) нь үндэсний хэмжээнд эм, эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээнд хяналт тавьж ажилладаг. АНУ-ын бусад орнуудаас ялгаатай нь Сайн үйлдвэрлэлийн практик (Good Manufacturing Practice) буюу эм үйлдвэрлэх журам, эмийн найрлага, орцонд тавигдах хяналтын стандартыг мөрдөж ажилладаг байна.

Дани Улсад Эмийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмийн бүтээгдэхүүний эмнэл зүйн туршилтын тухай хуулиудыг мөрдөхөөс гадна Европын эмийн агентлагаас баталсан журмуудыг баримталдаг байна.

Дани Улсад хүний болон малын эмнэлгийн хэрэгцээнд зориулагдсан эм, түүний дотор биологийн эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтыг Эрүүл мэндийн яамны харьяа Данийн эмийн агентлаг (Danish Medicines Agency) хариуцан ажилладаг. Тус агентлаг нь улсын хэмжээнд эмтэй холбоотой аливаа зөвшөөрөл, лиценз олгох, эмнэлзүйн туршилтыг батлах, олгосон зөвшөөрөл, эм зүй, эмийн зар сурталчилгаанд хяналт тавих, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх, хууль бус эм, эмийн бүтээгдэхүүнийг хураан авах зэрэг үйл ажиллагааг хариуцдаг. Тус агентлаг нь эмийн бүтээгдэхүүний чанар, стандартыг шинжлэх албан ёсны лаборатори (Laboratory)-тай бөгөөд тус лаборатори нь биологи, хими, микробиологийн шинжилгээ болон ионжуулагч цацраг, радиохимийн шинжилгээ хийдэг.

Дани Улс нь Европын эмийн агентлагийн гишүүн орон бөгөөд олон улсын “Сайн лабораторийн туршлага” (Good laboratory practice-GLP)-ын чанарын стандартыг баримтлан ажилладаг орнуудын нэг юм.

***Монгол Улсын эмийн хяналтын лаборатори, эмийн чанарын стандартын талаар:***

Монгол Улсад Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Засгийн газрын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого (зорилт 2.2. Эрүүл мэнд), Төрөөс эмийн талаар баримтлах бодлого зэрэг бодлого, эрх зүйн орчны хүрээнд эм, эмийн хяналтын лаборатори, эмийн чанарын стандарттай холбоотой асуудлыг зохицуулж байна. Мөн эрүүл мэндийн яам болон Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас гаргасан холбогдох дүрэм, журмуудыг дагаж мөрддөг.

Энэ асуудлыг Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны харьяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар (ЭЭХХЗГ) хариуцаж байгаа бөгөөд эмчилгээ оношилгооны идэвхтэй, аюулгүй байдлыг хангах, хүн амыг чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, хүн эмнэлэг, мал эмнэлэг болон эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын

UIH.MN СУДАЛГААНЫ САН

хэрэгжилтийг хангах, эм, эмнэлгийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээнд хяналт, зохицуулалт хийх үйл ажиллагааг хариуцдаг. Тус газар нь Чанарын хяналтын газар, Захиргаа удирдлагын газар, Лиценз зөвшөөрлийн зохицуулалтын газар, Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар, Эм хангамжийн газар, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар, Эм шинжлэх лаборатори гэсэн 7 салбар нэгжтэй.

Монгол Улсад эмийн чанарын хяналтын лабораторид тавигдах шаардлагыг Стандартчиллын зөвлөлийн 2016 оны 44-р тогтоолоор баталсан “Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага” стандартаар зохицуулдаг.

Энэхүү стандарт нь ISO 9001, ISO 17025 стандартын шаардлагад нийцүүлэн эмийн хяналтын лабораторийн үйл ажиллагаанд тавигдах нарийвчилсан шаардлагыг тогтоох зорилготой бөгөөд эмийн чанарын лабораторийн бүтэц, зохион байгуулалт, чанарын удирдлагын тогтолцоо, боловсон хүчин, ажлын байр, тоног төхөөрөмж, урвалж материал, баримтжуулалтын шаардлагыг тогтоох зорилготой. Энэхүү стандартыг эмийн чанарын хяналтын лабораторийн шинжилгээнд дээж хүлээн авах, хуваарилах, шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, тайлагнах үйл ажиллагаанд мөрддөг байна.

*(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.)*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 1.Судалгаанд хамрагдсан орнуудын эмийн хяналтын лаборатори ба эмийн чанарын хяналтын шинжилгээний үнэ тарифын харьцуулсан мэдээлэл*

| Улсын нэр | Хууль, эрх зүйн орчин | Эмийн хяналтын лабораторийн туршлага | Шинжилгээний үнэ, тариф |
|---|---|---|---|
| **Малайз** | -Эм худалдах тухай хууль (The Sale of Drugs Act);<br>-Аюултай эмийн тухай хууль (Dangerous Drugs Act);<br>-Хордлогын тухай хууль (Poisons Act);<br>-Эмийн зар сурталчилгааны тухай хууль (Medicines Advertisement&Sale Act);<br>-Эм, гоо сайхны бүтээгдэхүүний хяналтын тухай хууль (Control of Drugs and Cosmetics Regulations);<br>-Эмзүйчдийн бүртгэлийн тухай хууль (Registration of Pharmacists Act) зэрэг хууль болон холбогдох дүрэм журмаар зохицуулж байна.<br>**Үндэсний эмийн зохицуулах агентлаг** (National Pharmaceutical Regulatory Agency NPRA) нь Малайзын эмийн чанар, аюулгүй байдал, үр нөлөөг хангах үүрэгтэй агентлаг. | **Эмийн чанарын лаборатори** (Allied Chemists Laboratory Sdn Bhd) нь 1998 онд байгуулагдсан. Бүтээгдэхүүний чанар стандарт, эмийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх хүрээнд өндөр чанарын лабораторийн шинжилгээ, үйлдвэрлэлийн хяналт, сургалт, зөвлөх үйлчилгээ явуулдаг. Малайзын Эрүүл Мэндийн Яамны Хүнсний аюулгүй байдлын чанарын хэлтэс, Үндэсний эмийн зохицуулах агентлаг болон Малайзын Стандартын газраас гаргасан MS ISO/IEC 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн лаборатори юм. Тус лаборатори нь шингэн эм, капсултай эм, нунтаг эм, тос бальзам, эмийн тос, антисептик уусмал гэх төрлөөр шалгалтын өмнөх үе, шалгалтын үе, шалгалтын дараах гэсэн 3 үндсэн үе шатны процессоор эмийг лабораторид шинжилдэг байна. | - Шинэ эмийн бүтээгдэхүүн 850-1050 ам.доллар<br>- Эм 450-650 ам.доллар<br>- Уламжлалт болон байгалийн гаралтай бүтээгдэхүүн 250 ам.доллар |
| **Пакистан** | -Эмийн тухай хууль(Drug Act, 1976);<br>-Пакистаны Эмийн зохицуулалтын удирдах газрын тухай хууль (ЭЗУГХ),(Drug Regulatory Autority Act, 2012) хэмээх хоёр гол хуулиар зохицуулж байна.<br><br>**Пакистаны эмийн зохицуулалтын удирдах газар** (Drug Regulatory Authority of Pakistan-DRAP) нь ЭЗУГХуулийн 23 дугаар зүйлд зааснаар тус хуулийг хэрэгжүүлэх зорилгоор, Холбооны Засгийн газрын зөвшөөрлийн дагуу, тухайлсан тодорхой харилцааг нарийвчлан зохицуулсан дүрэм батлан гаргах эрхтэй байдаг байна.<br>ПЭЗУГ-ыг үндсэн чиглэл, ерөнхий удирдлага, хяналтаар хангах чиг үүрэг бүхий, 15 гишүүнээс бүрдэх Бодлогын зөвлөл ажиллана. Бодлогын зөвлөлийн дарга | ПЭЗУГ-ын бүтцэд Эмийн төв лаборатори, Биологийн хяналтын үндэсний лаборатори гэсэн хоёр лаборатори үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээр нь тус бүрийн харьяалсан эмийн ангилалд зориулагдсан, үндэсний хэмжээний чанарын хяналтын лабораторийн үүрэг гүйцэтгэдэг.<br>**-Эмийн төв лаборатори** (**Central Drug Laboratory**) нь анх 1953 онд эм, эмийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийх зорилгоор байгуулагдсан. 4 салбар лаборатори байдаг. Үүнд:<br>• Химийн лаборатори<br>• Физикийн лаборатори<br>• Микробиологийн лаборатори<br>• Гэрэлд мэдрэг эмийн лаборатори | - Эмийн төв лаборатори 2-45 ам.доллар<br>- Биологийн хяналтын үндэсний лаборатори 90-135 ам.доллар |

| | | | |
|---|---|---|---|
| | нь Холбооны Засгийн газрын холбогдох нарийн бичгийн дарга байх ба гишүүд нь мужуудын Засгийн газрын холбогдох нарийн бичгийн дарга нар, Холбооны захиргааны нэгжийн төлөөлөгч болон төр, хувийн хэвшлийн тэнцүү тооны эмийн үйлдвэрлэл, эмийн чанарын хяналт, эмийн зохицуулалт, нийгмийн эрүүл мэнд, эмийн сангийн үйлчилгээ, эрүүл мэндийн санхүү, эрүүл мэндийн эдийн засаг, эрүүл мэндийн менежмент, фармакологи, биотехнологийн салбар чиглэлийн 6 шинжээч нараас тус тус бүрддэг. | ***-Биологийн хяналтын үндэсний лаборатори (National Control Laboratory for Biologicals)*** нь 2000 онд байгуулагдсан. Энэхүү төрөлжсөн лабораторийг байгуулах эрх зүйн үндэс нь ЭЗУГХ-ийн I хавсралтын 7-р хэсэг, Эмийн тухай хуулийн 14-р хэсгийн заалтууд мөн ДЭМБ-ын өмнө хүлээсэн дотооддоо үйлдвэрлэсэн болон импортоор авсан вакцин, хүн, малын цуснаас гаргаж авсан цусан бүтээгдэхүүний чанарт хяналт тавих зэрэг үүрэгтэй.<br>**-Мужуудын чанарын хяналтын лабораториуд** Пакистаны Үндэсний магадлан итгэмжлэх зөвлөлийн мэдээлснээр 2022 оны байдлаар тус улсад магадлан итгэмжлэгдсэн, эмийн чанарын хяналтын 42 лаборатори үйл ажиллагаагаа явуулж байна. | |
| **Финланд** | -Эмийн тухай хууль (395/1987)<br>-Эмийн тухай тогтоол (693/1987) The Medicines Decree<br>-Эмийн агентлагийн тухай хууль (593/2009)<br>-Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (1224/2004)<br>-Эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (629/2010)<br>-Төрийн үндсэн төлбөрийн тухай хууль (Valtion maksuperustelaki 150/1992)<br>-Эмийн агентлагийн төлбөрийн тухай тогтоол (Decree of the Ministry of Social Affairs and Health on fees chargeable by the Finnish Medicines Agency (798/2022)) … зэрэг хууль болон холбогдох дүрэм журмаар зохицуулж байна.<br>**Финландын Эмийн агентлаг** нь эм зүйг зохицуулах үндэсний эрх бүхий байгууллага юм. Эмийн тухай хууль, Эмийн агентлагийн тухай хууль болон холбогдох бусад хууль эрх зүйн актуудын хүрээнд ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг дэмжих зорилгоор эмийн салбарын үйл ажиллагаа зохицуулдаг. Ингэхдээ эмийн салбарыг хөгжүүлэх, хяналт тавих, шаардлагатай | Финландын албан ёсны **Эмийн хяналтын лаборатори** (The Official Medicines Control Laboratory-OMCL) нь Финландын зах зээл дээрх эмийн салбарын лиценз эзэмшигчдийн үйл ажиллагаа хянах, эмийн чанар, стандарт, аюулгүй байдлыг шинжлэн шалгах чиг үүрэгтэй. Хүний болон мал эмнэлгийн эмийн чанарын стандарт, аюулгүй байдлыг хангах үүднээс уг чанарын хяналтыг хийдэг.<br>Лабораторийн гол үүрэг нь Финланд Улсын зах зээлд худалдаалагдаж байгаа болон хэрэглэгдэж байгаа эмийн бүтээгдэхүүний үр нөлөө, аюулгүй байдал нь чанарын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах явдал юм. Үүнд:<br>• Микробиологи: эндотоксин (кинетик ба бүлэгнэлт), ариун чанарын шинжилгээ, омог тодорхойлох;<br>• Биологи: ELISA[147] болон Western blot-ийн аргаар холбох/дархлаа судлалын шинжилгээ, | - Дотоодын аль нэг лабораторийн үйл ажиллагаа шалгаж зөвшөөрөл олгох ажлын төлбөр - 1 өдөрт €4000, илүү өдрүүдэд €2000, харин 4 цагаас хэтрэхгүй тухайлсан нэг үйл ажиллагаа хянах ажлын төлбөр €2000 байна.<br>- Гадаад улс дахь лабораторийн үйл ажиллагаа шалгаж зөвшөөрөл олгоход 1 өдрийн €6000, илүү хоногийн хувьд тухайн газарт очиж ажилласан багийн гишүүн бүрд €3000 байна. |

[147] ELISA нь дээж дэх эсрэг бие эсвэл эсрэг төрөгчийг илрүүлэхэд ашигладаг дархлааны сорил юм. Western blot нь холимогоос уураг ялгах, илрүүлэхэд өргөн хэрэглэгддэг аналитик арга юм.
https://byjus.com/biology/difference-between-elisa-and-western-blot/

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | | |
|---|---|---|---|
| | лиценз олгох, судалгаа шинжилгээ хийх, эмийн талаар мэдээлэх үүрэгтэй. | ферментийн шинжилгээ, эсэд суурилсан шинжилгээ гэх мэт | |
| **АНУ** | - Холбооны Хүнс, Эм, Гоо сайхны бүтээгдэхүүний тухай хууль (Federal Food, Drug and Cosmetic Act)<br>- Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай хууль (Public Health Service Act)<br>- Эмийн чанар, аюулгүй байдлын тухай хууль (Drug Quality and Security Act)<br>- Эмийн зүй бус хэрэглээнээс сэргийлэх, хяналт тавих тухай хууль (Comprehensive Drug Abuse Prevention and Control Act)<br>- Эмийн бүтэц найрлагын хяналтын тухай хууль (Controlled Substances Act)<br>- Жороор олгох эмийн худалдааны тухай хууль (Prescription Drug Marketing Act)<br>- Эмийн үнийн өрсөлдөөн болон патентын хугацааг шинэчлэх тухай хууль (Drug Price Competition and Patent Term Restoration Act) … зэрэг хууль болон холбогдох дүрэм журмаар зохицуулж байна.<br>**Хүнс болон Эмийн Захиргаа** (Food and Drug Administration) нь АНУ-д үйлдвэрлэгдэж, худалдаалагдаж буй хүн ба амьтны хоол хүнс, эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны бүтээгдэхүүн, биологийн бүтээгдэхүүнд хяналт тавих үүрэгтэй Засгийн газрын агентлаг юм. | Хүнс болон Эмийн захиргааны харьяа **Шинжлэх Ухаан Зохицуулалтын Алба** (Office of Regulatory Science) нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор **АНУ даяар 16 сүлжээ лаборатори** ажиллуулдаг байна.<br>Эдгээрийн 8 нь Хүн ба амьтны хоол хүнсний лаборатори, үлдсэн 8 нь Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, тамхи, тусгай мэргэшсэн лаборатори гэж төрөлждөг байна. Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, тамхи, тусгай мэргэшлийн лабораториуд нь эм, эмнэлгийн хэрэгсэл, тамхи, радио идэвхт бодис болон хүний биед сөрөг нөлөөтэй хорт бодисын шинжилгээг хийж гүйцэтгэдэг байна. Үүнд:<br>- Детройт Лаборатори (Detroit Laboratory);<br>- Шүүхийн шинжилгээний төв (Forensic Chemistry Center);<br>- Зүүн хойд хэсгийн эмнэлгийн бүтээгдэхүүний лаборатори (Northeast Medical Products Laboratory);<br>- Номхон Далайн Баруун Өмнөд хэсгийн Эмнэлгийн Бүтээгдэхүүний Лаборатори (Pacific Southwest Medical Products Laboratory);<br>- Филадельфи Лаборатори (Philadelphia Laboratory);<br>- Сан Хуан Лаборатори (San Juan Laboratory);<br>- Зүүн Өмнөд хэсгийн Тамхины Лаборатори (Southeast Tobacco Laboratory);<br>- Винчестерийн Инженерийн Шинжилгээний Төв *(Winchester Engineering Analytical Center).* | АНУ нь шинэ эм, нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эм (generic drug), эм тест бүтээгдэхүүнд олгодог зөвшөөрөл нь дэлхийд хамгийн өндөр стандарттайд тооцогддог байна.<br>2023 оны санхүүгийн жилд<br>-Нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эмтэй ижил орц найрлага, үр нөлөө бүхий эмийг шинжлүүлэн баталгаажуулах төлбөр (Abbreviated New Drug Application) 240 мянган ам.доллар байхаар төлөвлөжээ. |
| **Дани** | - Эмийн тухай хууль 1975 (The Medicines Act)<br>- Эрүүл мэндийн тухай хууль 2005 (Health Act)<br>- Эмийн бүтээгдэхүүний эмнэлзүйн туршилтын тухай хууль 2016 (Act on Clinical Trials of Medicinal Products)<br>- Эмийн бүтээгдэхүүний зөвшөөрөл, хяналтын Европын эмийн агентлаг байгуулах тухай журам (Regulation (EC) 726/2004 on the authorisation and | **Данийн эмийн агентлагийн лаборатори** нь эмийн хяналтын компаниудын эм, эмийн бүтээгдэхүүнд тавьж буй хяналт шалгалтын дүнг шалгах, компаниудын хийсэн дүн шинжилгээгээр илрүүлээгүй аливаа асуудлыг илрүүлэх зорилгоор нэмэлт шинжилгээ хийж болдог. | Данийн Эмийн агентлаг төрийн байгууллага хэдий ч үйл ажиллагааны зардлаа өөрөө санхүүжүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, тус агентлагаас үзүүлж буй үйлчилгээний төлбөр, |

| | | | |
|---|---|---|---|
| | supervision of medicinal products and establishing a European Medicines Agency)<br>- Хүүхдэд зориулсан эмийн бүтээгдэхүүний тухай журам (Regulation (EC) 1901/2006 on medicinal products for paediatric use)<br>- Амьтанд зориулсан эмийн бүтээгдэхүүний журам (141/2000 on orphan medicinal products, and Regulation (EC))<br>- Дэвшилтэт эмчилгээний эмийн бүтээгдэхүүний тухай журам (1394/2007 on advanced therapy medicinal products) … зэрэг хууль болон холбогдох дүрэм журмаар зохицуулж байна.<br>**Данийн Эмийн агентлаг** нь эмийн компаниуд болон бусад дистрибьютерүүдэд зөвшөөрөл олгох, шалгах, эмнэлзүйн туршилт хийх зөвшөөрөл олгох, эмийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох, эмийн бүтээгдэхүүн нөхөн төлбөр авах боломжтой эсэхийг шийдэх, сөрөг нөлөөний тайланд хяналт тавих, эмнэлгийн хэрэгсэлд хяналт тавих үүрэгтэй. | Данийн Эмийн агентлагийн лаборатори нь өөрийн шинжилгээнд чанарын хатуу шаардлага тавьдаг бөгөөд ISO 17025 стандартаар итгэмжлэгдсэн байдаг. Тус лаборатори нь эмийн чанарыг хянадаг Европын албан ёсны эмийн хяналтын лабораторийн (OMCL) сүлжээний гишүүн юм.<br>Энэхүү лаборатори нь Агентлагийн даргын шууд удирдлага дор Хяналт, эмнэлгийн төхөөрөмж, хүртээмжийн төвийн Нийлүүлэлтийн хяналт, аюулгүй байдлын хэлтэст харьяалагддаг. Тус лаборатори нь биологи, хими, микробиологийн шинжилгээ болон ионжуулагч цацраг, радиохимийн шинжилгээ хийдэг. | хураамж (эмийн зөвшөөрөл авах хураамж, лабораторийн хяналт, шалгалт, эмийн гаж нөлөө зэрэгтэй холбоотой хяналтын зардал)-аар санхүүждэг.<br>- Эмийн бүтээгдэхүүн 28-273 мянган Дани кронн (4.6-45 мянган ам.доллар)<br>- Байгалийн гаралтай эмийн бүтээгдэхүүн 26-97 мянган Дани кронн (4.3-16 мянган ам.доллар) |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

# СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

## НЭГ.ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ

### 1.1. Эмийн зохицуулалтын олон улсын хамтын ажиллагаа

Орчин үед эм үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа улам бүр даяаршиж байгаа энэ үед эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал болж, дэлхийн бүх бүс нутагт зохицуулалтын хамтын ажиллагааны олон загварыг хэрэгжүүлж байна. ДЭМБ-аас Европын эмийн зохицуулалтын тогтолцоо нь бусад бүс нутгийн улс орнуудад энэ тал дээр хамтран ажиллах, харилцан итгэлцлийг бий болгоход үлгэр жишээ болохоор хэмээн дүгнэсэн ба Европын эмийн хамтын ажиллагаа нь 1965 оноос эхэлсэн. Гэхдээ бусад бүс нутаг ч албан ёсны ба албан бус байдлаар эмийн зохицуулалтын хамтын ажиллагаатай байна. Америкийн бүс нутагт 55 орны гишүүнчлэлтэй Пан Америкийн эмийн зохицуулалтын сүлжээ (“Pan American Network for Drug Regulatory Harmonization-PANDRH) форум нь улс орнуудын эмийн удирдамж, зохицуулалтын үйл явцын уялдаа холбоог дэмжих зорилготой ба Карибын тэнгисийн нийгэмлэг (Caribbean Community-CARICOM) нь уг бүс нутгийн зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэх төсөл хэрэгжүүлдэг.

Африк тивд хамтын ажиллагааны механизмыг хөгжүүлэх хэд хэдэн бүс нутгийн нийгэмлэг, төслүүд хэрэгжиж байна. Үүнд Дорнод Африкийн хамтын нийгэмлэг (East African Community-EAC), Өмнөд Африкийн хөгжлийн нийгэмлэг (Association of Southern African Development Community-SADC) ZaZiBoNa дөрвөн улсын (Замби, Зимбабве, Ботсвана, Намиби) зохицуулалтын системийг холбосон төсөл, Африкийн вакцины зохицуулах форум (The African Vaccine Regulatory Forum-AVAREF) байгууллагууд орж байна.[148] Мөн энэ онд Африкийн нэгдсэн эмийн агентлаг байгуулах гэрээ хийгдсэн байна.[149]

Харин Азид эмийн бүтээгдэхүүнийг уялдуулах чиглэлээр Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо (Southeast Asian Nations- ASEAN), Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (APEC) ба Персийн булангийн эмийн бүртгэлийн төв хороо (Gulf Central Committee for Drug Registration GCC-DR) санаачилга гаргадаг.

Евразийн эдийн засгийн комисс 2016 оноос эм, эмийн хэрэгслийн нэг зах зээлтэй болохоор зөвшилцөлд хүрсэн бөгөөд эмийн бүртгэлээс эхлээд түгээлт хүртэлх процессыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд Армени, Беларусь, Казахстан, Киргиз, ОХУ-ууд нэгдсэн байна.[150]

Монгол Улс одоогоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад гишүүнчлэлтэйгээс өөрөөр эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын олон улсын болон бүс нутгийн ямар нэгэн холбоонд элсэн орсон талаарх мэдээлэл байхгүй байна. Судалгаанаас үзэхэд, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааны ийм байгууллага, холбоодод нэгдсэнээр гишүүн орнууд зохицуулалтын нэгдсэн дүрмээ тогтох, хамтын ажиллагааг хялбаршуулах, хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой нь харагдаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[148] https://www.who.int/medicines/publications/druginformation/WHO-DI_30-4_RegCollaboration.pdf
[149] https://au.int/en/pressreleases/20200205/african-medicine-agency-ama-treaty
[150]https://www.bnt.eu/en/news/legal-news/2602-launch-of-eurasian-economic-union-eaeu-medicines-registration procedure

### 1.2. ЭЗХАХБ-ын “Сайн лабораторийн туршлага” (Good Laboratory practice-GLP)-ын стандарт[151]

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)[152]-аас 1981 онд “Сайн лабораторийн туршлага” (Good Laboratory practice-GLP)-ын стандартыг баталсан. Одоогийн байдлаар 30 улс GLP стандартыг дагаж мөрдөх гэрээнд гарын үсэг зурсан байна. GLP-ийн зорилго нь эм (химийн болон биохимийн бодис)-ийн аюулгүй байдлын туршилт дээр ажиллаж буй эрдэмтдийн туршлагыг бусадтай хуваалцах явдал юм. GLP стандартыг дагаж мөрдөх нь аюулгүй байдлын мэдээллийг бүртгэлийн байгууллагад үнэн зөвөөр мэдээлж байгаагийн баталгаа болдог.

**GLP-ийн суурь ойлголт**

GLP стандарт нь сайн туршлагын дүрмийг тогтоож бусдад өөрсдийн урьдчилан боловсруулсан төлөвлөгөө, стандарт журмын дагуу ажлаа гүйцэтгэхэд жишиг болдог. Дараах 5 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. **Нөөц:** байгууллага ба хүний нөөц, байгууламж ба тоног төхөөрөмж
2. **Тодорхойлолт**: шинжилгээний төрөл, шинжилгээний онцлог байдал
3. **Дүрэм:** заавар, дүрэм, журам
4. **Үр дүн:** анхдагч дата мэдээлэл, тайлан, архив
5. **Чанарын баталгаа.**

ДЭМБ-ын GLP-ийн тухай сургалтын гарын авлагад эдгээр 5 үндсэн хэсгийг тусгаж, тухайн хэсэг бүрд шаардлагыг хангасан байхыг үүрэгжүүлдэг.

**Нөөц**

Байгууллага ба хүний нөөц

GLP-ийн журамд судалгаа, хөгжүүлэлт (R&D)[153]-ийн бүтэц, ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон байхыг шаарддаг. Мөн хангалттай хүний нөөц болон ажилтнуудын мэргэжлийн сургалтын бодлогыг тодорхойлсон байхыг шаарддаг.

Байгууламж ба тоног төхөөрөмж

Судалгаа, шинжилгээ явуулахад шаардлагатай барилга байгууламж, тоног төхөөрөмжтэй байхыг тусгасан. Тоног, төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг байнга хангахын тулд тохируулга, засвар үйлчилгээний төлөвлөгөө, хөтөлбөрийг гаргасан байх шаардлагыг мөн тусгасан.

**Тодорхойлолт**

Судалгаа, шинжилгээг зөв хийхийн тулд эмнэлзүйн туршилтын системийн талаар урьдчилсан мэдээлэлтэй байхыг шаарддаг.

**Дүрэм**

Заавар ба дүрэм журам

Шинжилгээний үндсэн үе шатуудыг төлөвлөгөө, эсхүл зааварт тусгасан байх шаардлагатай. Үүнийг стандарт үйлдлийн журам (SOP)[154]-д нарийвчлан зохицуулсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[151] https://apps.who.int/iris/bitstream/handle/10665/66894/TDR_PRD_GLP_01.2.pdf?sequence=1&isAllowed=y
[152] OECD-The Organization for Economic Cooperation and Development
[153] R&D- Research & Development: судалгаа, хөгжүүлэлт
[154] SOP- Standard operating procedure: стандарт үйлдлийн журам

**Үр дүн**

Анхдагч дата мэдээлэл

Шинжилгээ, судалгааны анхдагч мэдээлэл, түүхий өгөгдлийн талаар журам, нөхцөлийг тусгасан байх шаардлагатай.

Тайлан

Тайланд шинжилгээг хэрхэн гүйцэтгэсэн тухай судалгааны үр дүнг нэгтгэж, тайлбарыг багтаасан байна.

Архив

Баримт бичгийг он удаан жил хадгалах, мөн дахин судлахад хялбар байдлаар хадгалах боломжоор хангах ёстой байна.

**Чанарын баталгаа**

GLP-ийн шинжилгээг шаардлага хангасан хүмүүсээс бүрдсэн баг хийнэ. Судалгаа, шинжилгээ хийж буй эмнэлзүйн шинжээчдээс хараат бусаар ажиллах ёстой байдаг.

### 1.3. Эмийн аюулгүй байдал, эмийн хяналт шинжилгээний зөвлөмж (фармаковижиланс хөтөлбөр)

ДЭМБ-ын фармаковижиланс хөтөлбөрийн үндсэн гишүүн 123 орон байдаг ба Монгол Улс үндсэн гишүүнчлэлд орохоор хүлээгдэж буй 28 орнуудын нэг юм.[155] Энэ хөтөлбөрт гишүүнээр элссэнээр эмийн хэрэглээтэй өвчтөний аюулгүй байдлыг хангах зорилготой ба эмийн эрсдэл, үр нөлөөг үнэлэх найдвартай мэдээллийн сан үүсгэж, нийгэмд чиглэсэн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн дэмжлэг авдаг.
Үндсэн гишүүнчлэлд орох шалгуур:[156]

**1. Эмийн аюулгүй байдлыг хянах аргачлалыг эзэмшсэн байх**

ДЭМБ-ын энэ хөтөлбөрт нэгдэхийн тулд эмийн аюулгүй байдлын тайланг (individual case safety reports -ICSR) тогтмол гаргадаг байх ёстой. Энэ тайланг гаргах хөтөлбөр нь үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах боловсон хүчин, техникийн санхүүжилттэй байна. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлснээр удирдах ажилтнууд эмийн гаж нөлөөний хяналтын системээс ирсэн мэдээллийг тайлбарлах чадвартай болсон байна. Энэ тогтолцоо нь тухайн улсын бүх газар нутаг, эрүүл мэндийн бүх салбарыг хамарсан байх албагүй.

**2. Эрүүл мэндийн яам, түүнтэй адилтгах байгууллагаар Эмийн хяналтын үндэсний төвийг томилж, ажиллуулах**

Энэ хөтөлбөрт зөвхөн ДЭМБ-ын гишүүн орнууд нэгдэж болно. Улс бүрийг Эмийн хяналтын үндэсний төв төлөөлнө. Үндэсний төвийн захиргааны харьяалал улс орнуудад харилцан адилгүй байдаг. Ихэнх тохиолдолд Үндэсний төв нь эмийн зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагын харьяа байдаг ба их сургууль, эмнэлэгт харьяалагдах, эсвэл эмийн мэдээллийн үйлчилгээний байгууллагатай нэгдсэн байж болно. Тайланг үнэлэх, зохих арга хэмжээний талаар зөвлөгөө өгөх мэргэжлийн зөвлөх хороотой бол давуу тал болно.

**3. ДЭМБ-д гаргаж өгөх тайлангийн шаардлагыг биелүүлэх техникийн чадвартай байх**

ДЭМБ-ын эмийн бодисын хяналт шинжилгээний хөтөлбөрийн үндсэн баялаг нь гишүүн орнуудаас ирүүлсэн гаж нөлөөний тохиолдлын нэгдсэн мэдээллийн сан юм. ДЭМБ-ын Эмийн хяналт шинжилгээний үндэсний хөтөлбөрт гаж нөлөөний тохиолдлын тайланг тогтсон загварын дагуу хүргүүлэх ёстой байдаг. Олон улсын энэхүү схемд орохоосоо өмнө

LEH.MN СУДАЛГААНЫ САН

[155] https://www.who.int/medicines/areas/quality_safety/safety_efficacy/National_PV_Centres_Map/en/
[156] https://www.who.int/medicines/areas/quality_safety/safety_efficacy/Joining_the_WHO_Programme.pdf?ua=1

тухайн орны Эмийн хяналтын үндэсний төвөөс удирдамжид заасан форматын дагуу өгөгдөл оруулах чадвартай гэдгээ харуулах ёстой.
ДЭМБ-аас тогтоосон журмын дагуу ДЭМБ-ын мэдээллийн санд ирүүлсэн эмийн аюулгүй байдлын тайланг гишүүн орны шинжээч боловсруулалт хийж ашиглах боломжтой болдог.

## ХОЁР.ЭМИЙН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИ БА ЭМИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНЭ, ТАРИФЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

### 2.1. МАЛАЙЗ УЛС

Малайз Улс нь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн тогтолцоогоо илүү үр дүнтэй болгон бэхжүүлж, ард иргэдэд чанартай, аюулгүй эмээр үйлчлэх, эмийн зөв зохистой хэрэглээг хангахын тулд 2006 онд Засгийн газрын албан ёсны баримт бичиг болох Үндэсний эмийн бодлого (Malaysian National Medicines Policy)[157]-ыг боловсруулж, эм, эмнэлгийн байгууллагууд төрөөс дэвшүүлж байгаа дунд болон урт хугацааны стратегийн бодлого зорилтыг тодорхойлж, нэгдсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа системтэй хэрэгжүүлэн одоо 3 дахь удаагийн стратегийн зорилтын хүрээнд эмийн чанар, аюулгүй байдал, эмийн хүртээмж, эмийн зөв зохистой хэрэглээ, эрүүл мэндийн салбарын түншлэл, хамтын ажиллагаанд анхааран ажиллаж байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг татвараас санхүүжүүлдэг бөгөөд эрүүл мэндийн жилийн зардал нь 933 тэрбум ам.доллар буюу ДНБ-ийн 4.25%-тай тэнцэж байна. Эмийн зах зээлийн орлого 2022 оны байдлаар 503.40 сая ам.доллар байна.

1. **Эмийн хяналт, зохицуулалтын хууль эрх зүйн орчин:**

Эмийн чанар, стандарт, аюулгүй байдал, эмийн үйлдвэрлэл, эм худалдаалахтай холбоотой харилцааг:

- Эм худалдах тухай хууль (The Sale of Drugs Act);[158]
- Аюултай эмийн тухай хууль (Dangerous Drugs Act);[159]
- Хордлогын тухай хууль (Poisons Act);[160]
- Эмийн зар сурталчилгааны тухай хууль (Medicines Advertisement&Sale Act);[161]
- Эм, гоо сайхны бүтээгдэхүүний хяналтын тухай хууль (Control of Drugs and Cosmetics Regulations);[162]
- Эмзүйчдийн бүртгэлийн тухай хууль (Registration of Pharmacists Act)[163] … зэрэг хууль болон холбогдох дүрэм журмаар зохицуулж байна.

1974 онд байгуулагдсан Эрүүл мэндийн яамны хэрэгжүүлэгч агентлаг болох **Эм зүйн үйлчилгээний алба** (The Pharmacy Services Programme)[164] нь үр дүнтэй, чанар стандартын шаардлага хангасан эмээр ард иргэдэд үйлчлэх, холбогдох хууль дүрмийг дагаж мөрдөж, хэрэгжүүлэх замаар ард иргэдийн эрх ашгийг хамгаалах мөн зохистой хэрэглээг хангах чиг үүрэгтэй ажилладаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[157] Malaysian National medicines Policy file:///Users/uurtsaikh/Desktop/malaysian-national-medicines-policy-3rd-edition-2017-2021.pdf
[158] Sale of Drugs Act 1952 https://leap.unep.org/countries/my/national-legislation/sale-drugs-act-1952-act-368
[159] Dangerous Drugs Act 1952 http://www.paclii.org/pg/legis/consol_act/dda1952180/
[160] Poisons Act 1952 http://www.commonlii.org/my/legis/consol_act/pa19521989196/
[161] Medicines (Advertisement&Sale) Act https://www.pharmacy.gov.my/v2/en/documents/medicines-advertisement-sale-act-1956-and-regulations.html
[162] Control of Drugs and Cosmetics Regulations https://www.yumpu.com/en/document/view/36236491/control-of-drugs-and-cosmetics-regulations-1984-revised-2009
[163] Registration of Pharmacists Act https://www.pharmacy.gov.my/v2/en/documents/registration-pharmacists-act-1951-and-regulations.html
[164] The Pharmacy Services Programme https://www.pharmacy.gov.my/v2/en/content/about-us.html




**Үндэсний эмийн зохицуулах агентлаг** (National Pharmaceutical Regulatory Agency-NPRA)[165] нь 1978 онд байгуулагдсан Малайзын эмийн чанар, аюулгүй байдал, үр нөлөөг хангах үүрэгтэй агентлаг юм. Тус агентлаг нь ДЭМБ-ын Олон Улсын эмийн хяналт шинжилгээний Хөтөлбөрийн гишүүн, ДЭМБ-ын эм зүйн зохицуулалтын хамтын ажиллагааны хяналтын төв болон томилогдсон агентлаг юм.

*Тус агентлагийн чиг үүрэг:*

- Олон улсын агентлагуудаас хүлээн авсан техникийн мэдээлэл, лабораторийн шинжилгээ судалгааг үнэлж дүгнэн, мэдээлэх;
- Эм болон гоо сайхны бүтээгдэхүүний чанарын зохицуулалтын схемийг түүвэрлэн, аналитик туршилт хийж зах зээлд нэвтрүүлэх;
- Эмнэлзүйн туршилт хийх эм үйлдвэрлэгч, импортлогч, бөөний худалдаа эрхлэгчдэд зориулсан тусгай зөвшөөрөл олгох;
- ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу дотоодын эм үйлдвэрлэлийг дэмжиж ажиллах;
- Эмийн гаж нөлөөг хянах хөтөлбөрийг удирдаж, хэрэгжүүлэх;
- ДЭМБ-ын олон улсын эмийн сөрөг хариу урвалын хөтөлбөрт оролцох;
- Чанаргүй, эсхүл хүний бие махбодод аюултай гэсэн эмийг эргүүлэн татах;
- Хар тамхитай тэмцэх газрын бодлого зорилтыг олон нийтэд түгээх;
- Эм болон гоо сайхны бүтээгдэхүүний чанар, үр ашиг болон аюулгүй байдлыг үнэлэх зорилгоор судалгаа шинжилгээ тогтмол явуулах;
- Эм зүйн зохицуулалтын ажилтан болон бусад мэргэжлийн хүмүүсийг олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу сургалт олгох, мэдлэгжүүлж дадлагажуулах үндсэн чиг үүрэгтэй ажилладаг байна.

**GLP (Good Laboratory Practice) Хяналтын алба** нь GLP чанарын системийн дагуу Малайз Улсын эрүүл мэнд, хүрээлэн буй орчны аюулгүй байдлын эмнэлзүйн бус судалгааг

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[165] National Pharmaceutical Regulatory Agency NPRA https://www.npra.gov.my/index.php/en/

төлөвлөх, гүйцэтгэх, хянах, бүртгэх, архивлах, тайлагнах, чанарын мэдээллийн хөгжлийг дэмжих зорилготой.

**Эмийн хяналтын газар** (Drug Control Authority) – Малайз Улсад худалдаалагдаж буй эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн зэрэг хосолсон бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, үр нөлөө, эмийн гаж нөлөөнд хяналт тавьдаг.

**Эмийн сөрөг хариу урвалын зөвлөх хороо** (Adverse Drug Reaction Advisory Committee) - Тус улсад бүртгэлтэй эмд фармакологийн хяналт хийх, эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд эмийн аюулгүй байдлын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх үүрэгтэй.

**2. Эмийн чанар, стандартын шинжилгээний үнэ тариф:**

Үндэсний эмийн зохицуулах агентлаг 2017 оноос эм, гоо сайхны бүтээгдэхүүнүүдийг нь зах зээлд нэвтрүүлэхээс өмнө шинжлэх ухааны судалгаа шинжилгээ, лабораторийн туршилтыг үнэлж дүгнэн, хянах зорилгоор QUEST3+[166] гэсэн онлайн бүртгэлийн системийг нэвтрүүлсэн. Энэхүү бүртгэлийн систем нь ДЭМБ-аас тогтоосон олон улсын заавартай нийцэж байдаг. QUEST3+ системд бүртгэгдсэн эмийн мэдээллээс Идэвхтэй эмийн найрлага (Active Pharmaceutical Ingredient-API)-д лабораторийн 3 түвшний шинжилгээг хийдэг.

Үндэсний эмийн зохицуулах агентлагаас API-г хянах журам:

- Үйлдвэрлэгчийн үйлдвэрлэл, чанарын хяналтын үйл ажиллагааны мэдээлэл;
- Бүтээгдэхүүн эзэмшигчийн API үйлдвэрлэгчээс оруулсан өөрчлөлт өгөгдөл, мэдээллийн үнэлгээ (үйлдвэрлэх явц, материалын тодорхойлолт, туршилтын явц, үр дүн зэрэг бүгдийг хамааруулна);
- Үйлдвэрлэлийн сайн туршлага (Good manufacturing practice)-д нийцсэн эсэх үнэлгээ;
- Маркетингийн дараах тандалтын хяналт;
- Эмийг зах зээлээс эргүүлэн татах болон гомдол шийдвэрлэх процессын хяналт;
- Бусад агентлагаас ирсэн өргөдөл гомдлын дагуу хяналтын үйл ажиллагааг явуулна.

**Эмийн чанарын лаборатори** (Allied Chemists Laboratory Sdn Bhd)[167] нь 1998 онд байгуулагдсан үйлчлүүлэгчид бүтээгдэхүүний чанар стандарт, эмийн аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах нийгмийн өмнө хүлээсэн үүргийн дагуу өндөр чанарын лабораторийн шинжилгээ, аж үйлдвэрийн хяналтын үйлчилгээ, сургалт зөвлөгөө явуулдаг Малайзын Эрүүл Мэндийн Яамны Хүнсний аюулгүй байдлын чанарын хэлтэс, Үндэсний эмийн зохицуулах агентлаг болон Малайзын Стандартын газраас гаргасан MS ISO/IEC 17025 стандартын магадлан итгэмжлэгдсэн лаборатори юм. Тус лаборатори нь шингэн эм, капсултай эм, нунтаг эм, тос бальзам, эмийн тос, антисептик уусмал гэх төрлөөр шалгалтын өмнөх үе, шалгалтын үе, шалгалтын дараах гэсэн 3 үндсэн процессоор эмийг лабораторид шинжилдэг байна.

*Хүснэгт 2. Лабораторийн үнэ тариф*

| д/д | Бүтээгдэхүүний ангилал (Category of Product) | Боловсруулалтын төлбөр (Processing fees) | Лаборатори/Шинжилгээний төлбөр (Laboratory/Analysis fees) | Нийт хураамж (Total fees) |
|---|---|---|---|---|
| 1. | **Эм**<br>1. Шинэ эмийн бүтээгдэхүүн<br>2. Биологи | 212.38 $ | Нэг идэвхтэй бодис: 637.15 $ | 849.53 $ |
| | | | Хоёр ба түүнээс дээш идэвхтэй найрлага: 849.53 $ | 1,061.91 $ |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[166] QUEST3+ https://www.npra.gov.my/index.php/en/regulation-basic.html
[167] Allied Chemists Laboratory Sdn Bhd https://alliedchemists.com.my/company/laboratory-in-johor-bahru/

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. | **Эм**<br>1. Хортой<br>2. Хоргүй<br>3. Эрүүл мэндийн нэмэлт | 212.38 $ | Нэг идэвхтэй бодис: 254.86 $ | 467.24 $ |
| | | | Хоёр ба түүнээс дээш идэвхтэй найрлага: 424.76 $ | 637.15 $ |
| 3. | Уламжлалт/Байгалийн бүтээгдэхүүн | 106.19 $ | 148.67 $ | 254.86 $ |

*Эх сурвалж: https://pharmaboardroom.com/legal-articles/regulatory-pricing-and-reimbursement-malaysia/*

## 2.2. ИСЛАМЫН БҮГД НАЙРАМДАХ ПАКИСТАН УЛС (ПАКИСТАН)

Пакистаны хүн амын өсөлтийн хурд 2% байгаа нь дэлхийн дундаж(1%)-аас хамаагүй өндөр үзүүлэлт бөгөөд нас баралтын түвшин 2000 онд мянган төрөлтөд 84.3 байсан бол 2019 онд 55.6 болж буурсан, дундаж наслалт 1990 онд 62 байсан бол 2020 онд 70 болж өссөн зэргээс шалтгаалсан хүн амын ерөнхий өсөлт нь тус улсын эрүүл мэндийн тогтолцооны эрэлт, хэрэгцээ, ачааллыг жил ирэх бүр улам өсгөн нэмэгдүүлж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар Пакистаны эмийн зах зээлийн нийт орлого[168] 453 тэрбум пакистан рупи хүрч, ДНБ-д эзлэх хувь 1.17%, эмийн импорт 158 тэрбум пакистан рупи, эмийн экспорт 33 тэрбум пакистан рупи байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал 2019 оны санхүүгийн жилд 422 тэрбум пакистан рупи болж, ДНБ-ийн 1.08%-ийг эзэлж, нэг хүнд ногдох эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал[169] 165.55 ам.доллар болжээ.

### 1. Эмийн хяналт, зохицуулалтын эрх зүйн орчин, тогтолцоо:

Эмийн чанар, түүний аюулгүй, баталгаат байдал нь дэлхий нийтийн болоод нийгмийн эрүүл мэндийн асар том асуудал бөгөөд нэн ялангуяа Пакистан шиг бага, дунд орлоготой улс орнуудын хувьд бүр хүндрэлтэй байдаг.

Пакистанд 2011, 2012 онд чанаргүй, хуурамч эмийн улмаас олон зуун хүний амь нас хохирсон аймшигтай хэрэг явдал (The Fake Drug Crisis) гарсан. Энэ үйл явдал дотооддоо олон нийтийн эрс шүүмжлэлд өртсөн төдийгүй олон улсын анхаарлыг зүй ёсоор татаж, улмаар тус улсын эмийн хяналт, зохицуулалтын тогтолцоог боловсронгуй, үр дүнтэй болгох зайлшгүй нөхцөл, шаардлага үүссэн байна.

Эхний тохиолдол буюу 2011 оны 12-р сард Пунжаби мужид зүрх, судасны эмийн улмаас 230 хүн эндсэн явдал нь Пакистаны эмийн зохицуулалтын удирдах газар гэж бие даасан, хараат бус байгууллага байгуулагдах, холбооны болон мужийн түвшинд хяналт, зохицуулалтын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах гол түлхэц болсон. Дараагийн тохиолдол нь 2012 оны 11-р сард ханиалгын ханд уусан олон зуун хүн нас барсан. Эдгээрийн аль алинд нь улсын лабораториуд зүрх судасны эмд алдаатай бодис (пириметамин), мөн ханиалгын ханданд их хэмжээний хорт бодис (левометорфан) агуулагдаж байгааг цаг тухайд нь илрүүлж чадаагүй байна. Энэхүү хэрэг явдлууд Пакистаны эмийн хяналтын тогтолцооны хангалтгүй, үр дүнгүй байдлыг маш тодоор илрүүлсэн тул цаашид тус улсын эрүүл мэндийн тогтолцооны тулгамдсан гол асуудал нь эмийн чанарын хяналт болсон байна. Энэ хүрээнд сүүлийн 10 жилд Пакистаны Холбооны

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[168] https://www.pacra.com/sector_research/PACRA%20Research%20-%20Pharmaceutical%20-%20May%2721.pdf
[169] https://data.worldbank.org/indicator/SH.XPD.CHEX.PP.CD?locations=PK
https://data.worldbank.org/indicator/SH.XPD.GHED.GD.ZS?locations=PK

Засгийн газраас эмийн хяналт, зохицуулалтын эрх зүйн орчныг шинэчлэх, боловсронгуй болгох мөн олон улсын жишигт нийцүүлэх, ойртуулах чиглэлээр онцгой анхаарч иржээ.[170]

Пакистанд “эмчилгээний бүтээгдэхүүн” (therapeutic goods)-ийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, тэдгээрт тусгай зөвшөөрөл олгох, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг:

- Эмийн тухай хууль (Drug Act, 1976);[171]
- Пакистаны Эмийн зохицуулалтын удирдах газрын тухай хууль -ЭЗУГХ (Drug Regulatory Autority Act, 2012)[172] … хэмээсэн хоёр гол хуулиар зохицуулж байна.

***“эмчилгээний бүтээгдэхүүн”*** *гэдэгт эм, уламжлалт эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн бүтээгдэхүүн болон Удирдах газраас хамааруулж тогтоосон бусад холбогдох бүтээгдэхүүнийг хамааруулж ойлгоно.* (ЭЗУГХуулийн 2(XXXVI) заалт)

Пакистаны эмийн зохицуулалтын удирдах газар (Drug Regulatory Authority of Pakistan-DRAP) нь ЭЗУГХуулийн 23 дугаар зүйлд зааснаар тус хуулийг хэрэгжүүлэх зорилгоор, Холбооны Засгийн газрын зөвшөөрлийн дагуу, тухайлсан тодорхой харилцааг нарийвчлан зохицуулсан дүрэм батлан гаргах эрхтэй байдаг бөгөөд энэхүү эрхийнхээ хүрээнд дор дурдсан дүрмүүдийг батлан мөрдүүлж байна. Үүнд:

- Эмийн зохицуулалтын хүрээнд:
  - Эмийн шошго, сав, баглаа боодлын дүрэм (The Drugs (Labeling and Packing) Rules) 1986;
  - Эмийн тусгай зөвшөөрөл, бүртгэл, сурталчилгааны дүрэм (The Drugs (Licensing, Registering And Advertising) Rules 1976;
  - Эмийн судалгааны дүрэм (The Drugs (Research) Rules) 1978;
  - Холбооны улсын эмийн байцаагч, эмийн лаборатори, Холбооны Засгийн газрын эмийн шинжээчийн дүрэм The Drugs (Federal Inspectors, Federal Drug Laboratory and Federal Government AnalystRules) 1976;
  - Эмийн экспорт, импортын дүрэм (The Drugs (Import and Export) Rules)1976;
  - Эмийн тодорхойлолтын дүрэм (The Drugs (Specifications) Rules) 1978;
  - Эмийн давж заалдах зөвлөлийн дүрэм (The Drugs (Appellate Board) Rules, )1976.
- Эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын хүрээнд:
  - Эмнэлгийн хэрэгслийн дүрэм (The Medical Device Rules) 2017
- Уламжлалт эм, жоргүй олгодог эм (OTC), эрүүл мэндийн бүтээгдэхүүний зохицуулалтын хүрээнд:
  - Уламжлалт эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүний бүртгэлийн дүрэм (The Alternative Medicines and Health Products (Enlistment) Rules) 2017
- Эмнэл зүйн сорилт, туршилтын зохицуулалтын хүрээнд:
  - Био судалгааны дүрэм (The Bio Study Rules) 2017
- Ёс зүйн хүрээнд:
  - Эрүүл мэндийн мэргэжилтний ёс зүйн дүрэм (The Ethical Marketing to Healthcare Professionals Rules) 2017

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[170] https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC6737614/
[171] https://www.dra.gov.pk/wp-content/uploads/2022/10/Drugs-Act-1976.pdf
[172] https://www.dra.gov.pk/wp-content/uploads/2022/10/DRAP-2012-_As-Amended-till-Feb-2022.pdf

- Үнийн бодлого, зохицуулалтын хүрээнд:
  - Эмийн үнийн бодлого (Drug Pricing policy) 2018
- Фармаковижилансийн хүрээнд:
  - Фармаковижилансийн дүрэм (The Pharmacovigilance Rules) 2022

Анх 1976 онд байгуулагдан Эрүүл мэндийн яамны харьяанд байсан **Эмийн хяналтын газар** (Drug Control Organization)-ыг 2012 оны ЭЗУГХуулийн 3 дугаар зүйлд заасан ёсоор, Холбооны Засгийн газрын шууд удирдлага дор тухайн хуулийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй, хараат бус, бие даасан байгууллага ПЭЗУГ болгон шинэчлэн зохион байгуулжээ.

ПЭЗУГ[173]нь Гүйцэтгэх захирал болон бусад 13 захирлаас бүрддэг. Эдгээр Гүйцэтгэх захирал, захирлуудыг Бодлогын зөвлөлийн санал болгосноор Холбооны Засгийн газраас томилж, чөлөөлдөг. Гүйцэтгэх захирал нь ЭЗУГХуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд Бодлогын зөвлөлийн бодлого, зохицуулалт, чиглэлийн дагуу ПЭЗУГ-ын үйл ажиллагааг өдөр тутам удирдан чиглүүлнэ. Харин Захирал тус бүр нь хуулиар харьяалуулсан чиг үүргийн хүрээнд ПЭЗУГ-ын хамаарах хэлтэс, албадыг удирдана.

ПЭЗУГ-ыг үндсэн чиглэл, ерөнхий удирдлага, хяналтаар хангах чиг үүрэг бүхий 15 гишүүнээс бүрдэх Бодлогын зөвлөл ажиллана. Бодлогын зөвлөлийн дарга нь Холбооны Засгийн газрын холбогдох нарийн бичгийн дарга байх ба гишүүд нь мужуудын Засгийн газрын холбогдох нарийн бичгийн дарга нар, Холбооны захиргааны нэгжийн төлөөлөгч болон төр, хувийн хэвшлийн тэнцүү тооны, эмийн үйлдвэрлэл, эмийн чанарын хяналт, эмийн зохицуулалт, нийгмийн эрүүл мэнд, эмийн сангийн үйлчилгээ, эрүүл мэндийн санхүү, эрүүл мэндийн эдийн засаг, эрүүл мэндийн менежмент, фармакологи, биотехнологийн салбар чиглэлийн 6 шинжээч нараас тус тус бүрддэг.[174]

*Пакистаны Эмийн зохицуулалтын удирдах газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг*




Эмийн хяналт, зохицуулалтын бие даасан, хараат бус байгууллагын үзэл баримтлалыг нэвтрүүлснийхээ дараа буюу 2018 оны 11-р сард Пакистан ДЭМБ-ын Олон улсын эмийн хяналт, шинжилгээний Хөтөлбөр (Programme for International Drug Monitoring (WHO-PIDM))-ийн жинхэнэ гишүүнээр элссэн. Энэхүү хөтөлбөр 1968 онд үүсгэн байгуулагдсан ба гол зорилго нь гишүүн орнууддаа эмийн хяналт, сэрэмжлүүлгийн тогтолцоо (pharmacovigilance

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[173] https://www.dra.gov.pk/about-us/organization/organogram/
[174] https://www.dra.gov.pk/wp-content/uploads/2022/10/DRAP-2012-_As-Amended-till-Feb-2022.pdf

system)-г хөгжүүлэх, эмийн аюулгүй байдлын мэдээ, мэдээллийг үндэсний болон олон улсын түвшинд цаг тухайд нь түргэн шуурхай хүргэх ажлыг уялдуулан зохицуулах явдал юм.

**2. Эмийн чанарын хяналтын лабораториуд:**

ПЭЗУГ-аас эмийн тандалт, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нэн чухал хүчин зүйл нь эмийн чанарын хяналтын лабораториудын тогтолцоо, тэдгээрийн хүчин чадал, чадавх юм.

ПЭЗУГ-ын бүтцэд Эмийн төв лаборатори, Биологийн хяналтын үндэсний лаборатори гэсэн хоёр лаборатори үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээр нь тус бүрийн харьяалсан эмийн ангилалд зориулагдсан, үндэсний хэмжээний чанарын хяналтын лабораторийн үүрэг гүйцэтгэдэг.

- **Эмийн төв лаборатори** (**Central Drug Laboratory**):[175]

Эмийн төв лаборатори нь анх 1953 онд Карачи хотод 1940 оны "Эм, гоо сайхны бүтээгдэхүүний хууль"-ийн дагуу эм, эмийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийх зорилгоор байгуулагдсан. Эмийн төв лабораторийн чиг үүрэг 1976 оны Эмийн тухай хууль, 2012 оны ЭЗУГХууль батлагдсанаар улам өргөжин тэлсэн.

2011, 2012 оны дээр дурдсан хэрэг явдлын дараа ДЭМБ-аас тус улсын чанарын хяналтын лабораториудад хөндлөнгийн аудит хийж, тэдгээр нь эрсдэлт тохиолдлыг илрүүлэх чадамжгүй, стандарт шаардлагаас доогуур түвшинд ажиллаж байгааг илрүүлэн дүгнээд цаашид лабораториудаа, нэн ялангуяа Эмийн төв лабораторийг зэрэглэл ахиулж, бэхжүүлэхийг зөвлөсөн.

Тус зөвлөмжийн дагуу Эмийн төв лабораторийн зэрэглэлийг ахиулах, бэхжүүлж чадавхжуулах чиглэлээр ISO 17025:2017 стандарт болон ДЭМБ-ын TRS957-ын хавсралт-1 "Эмийн чанарын хяналтын лабораторийн сайн туршлага" зэрэг шалгуур, шаардлагыг тус тус хангасан бүс нутгийн тэргүүлэх зэргийн лаборатори болгохоор төлөвлөн ажилласан. Үүний үр дүнд Пакистаны эмийн төв лаборатори нь ДЭМБ-ын чанарын хяналтын лабораторийн урьдчилсан шалгаруулалт (WHO for prequalification of quality control laboratory)-ын үнэлгээнд амжилттай хамрагдаж, ISO 17025:2017 стандартын шаардлагыг бүрэн хангаж, магадлан итгэмжлэгдсэн байна. Эмийн төв лаборатори дараах 4 салбар лабораторитой, шинэчлэлийн хүрээнд тэдгээрийг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан байна.

- Химийн лаборатори
- Физикийн лаборатори
- Микробиологийн лаборатори
- Гэрэлд мэдрэг эмийн лаборатори

UIH.MN СУДАЛГААНЫ САН

- **Биологийн хяналтын үндэсний лаборатори** (**National Control Laboratory for Biologicals**):[176]

Биологийн хяналтын үндэсний лаборатори нь 2000 оны 07-р сарын 10-нд байгуулагдсан. Энэхүү төрөлжсөн лабораторийг байгуулах эрх зүйн үндэс нь ЭЗУГХуулийн I хавсралтын 7-р хэсэг, Эмийн тухай хуулийн 14-р хэсгийн заалтууд мөн ДЭМБ-ын өмнө хүлээсэн дотооддоо үйлдвэрлэсэн болон импортын вакцин, хүн, малын цуснаас гаргаж авсан цусан

[175] https://www.dra.gov.pk/therapeutic-goods/quality-controls-labs/central-drugs-laboratory/
[176] https://www.dra.gov.pk/therapeutic-goods/quality-controls-labs/national-control-laboratories-for-biologicals/

бүтээгдэхүүний чанарт хяналт тавих зэрэг үүрэгтэй. Биологийн хяналтын үндэсний лаборатори дараах 8 хэсэгтэй:

- Микробиологийн хэсэг (Microbiology block)
- Эсийн өсгөвөрлөх хэсэг (Cell culture Block)
- Вирусийн шинжилгээний хэсэг (Virology testing block)
- Бактерологийн хэсэг (Bacteriology block)
- Химийн хэсэг (Chemistry block)
- Чанарын баталгаажуулалт ба Архивын хэсэг (Quality assurance & Archive block)
- Амьтан, ургамал шинжлэх хэсэг (Animal & Plant testing rooms)
- Захиргааны хэсэг (Administration block)

Нийтдээ 19 нэр төрлийн шинжилгээ хийх хүчин чадалтай, орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, вакцин, альбумин, эсрэг бие, антитоксин, плазм, цитокин, даавар зэрэг өргөн хүрээний бүтээгдэхүүнд сорилт, туршилт, шинжилгээ хийх чадавхтай.

Тус лаборатори 2021 оны 12-р сард ДЭМБ-ын "Биологийн хяналтын үндэсний лабораториудын сүлжээ" (National Control Laboratories Network for Biologicals (WHO-NNB)-нд гишүүнээр элссэн. Энэхүү сүлжээ нь гишүүн орнуудын биологийн чанарын хяналтын лабораториудын хооронд чанарын болон техник-арга зүйн мэдээлэл солилцох талбар болдог бөгөөд дэлхий даяар нийт 43 лаборатори гишүүний статустай.

**Мужуудын чанарын хяналтын лабораториуд:**

Нийт хүн амыг чанартай эмчилгээний бүтээгдэхүүнээр аюулгүй, баталгаатай хангахын тулд чанарын хяналтын лабораторийн үндэсний сүлжээг хөгжүүлж байна. Эмийн холбогдох дүрэм, журмын дагуу мужууд нутаг дэвсгэрийнхээ хүрээнд эмийн хадгалалт, худалдаа, түгээлтийг зохицуулах үүрэг хүлээдэг. Энэхүү үүргээ үр дүнтэй гүйцэтгэхийн тулд муж бүр өөрсдийн чанарын хяналтын лабораторийг байгуулж, шаардлагатай үед зөвшөөрөгдсөн, эсхүл сэжиг бүхий эмийг шинжлэхэд оролцдог.

Пакистаны Үндэсний магадлан итгэмжлэлийн зөвлөлийн мэдээлснээр 2022 оны байдлаар тус улсад магадлан итгэмжлэгдсэн, эмийн чанарын хяналтын 42 лаборатори[177] үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээрээс 3 лаборатори нь ДЭМБ-ын чанарын хяналтын лабораторийн урьдчилсан шалгаруулалтад тэнцэж, чанарын баталгаажуулалт хийгдсэн. 2020 оны 9 сарын байдлаар дэлхий даяар нийт 57 лаборатори[178] ДЭМБ-ын уг шалгуурт тэнцсэн байдаг ажээ.

**3. Эмийн чанарын хяналтын лабораторийн шинжилгээний үнэ, тариф:**

ЭЗУГХуулийн 7(n) заалтын дагуу ПЭЗУГ нь өөрийн болон салбар, нэгжээсээ үзүүлж буй ажил, үйлчилгээндээ төлбөр, хураамж авах эрхтэй ба төлбөр, хураамжийн хувь, хэмжээг мөн хуулийн 11(1)(d), 20 дугаар зүйлд зааснаар ПЭЗУГ-ын Бодлогын зөвлөл тогтоодог. Энэхүү төлбөр, хураамжийн зорилго нь байгууллагын санхүүгийн бие даасан, хараат бус, үр ашигтай байдлыг хангах, үйл ажиллагааны зардлаа нөхөх явдал байдаг.

2021 оны 11-р сарын 08-наас мөрдөгдөж буй лабораторийн төлбөр, хураамжийн хэмжээг хүснэгтээр харуулбал[179]:

[177] https://www.pnac.gov.pk/TestingCalibrationLaboratoies
[178] https://extranet.who.int/pqweb/medicines/information/quality-control-laboratories
[179] https://www.dra.gov.pk/wp-content/uploads/2022/01/Fee-for-regulatory-operations.pdf

*Хүснэгт 3.Эмийн төв лабораторийн үнэ, тариф*

| Бүрдэл | | Fee RKR ($) |
|---|---|---|
| Description (General) | Тодорхойлолт (Ерөнхий) | 400(1.8) |
| Identification (General) | Таних (Ерөнхий) | 400(1.8) |
| Identification (TLC) | Таних (TCL) | 1,200(5.4) |
| Identification (FTIR) | Таних (FTIR) | 1,600(7.2) |
| Assay (Spectrophotometric) | Шинжилгээ (Spectrophotometric) | 2,000(9.0) |
| Assay (HPLC) | Шинжилгээ (HPLC) | 5,000(22.6) |
| Assay Titration (Simple) | Титрийн шинжилгээ (Энгийн) | 1,000(4.5) |
| Assay Titration (Potentiometric) | Титрийн шинжилгээ (Potentiometric) | 2,000(9.0) |
| Bio Assay | Био шинжилгээ | 3,000(13.5) |
| Weight variation / Mass variation | Жин/массын хэлбэлзэл | 600(2.7) |
| Content Uniformity | Дүүргэлт | 10,000(45.1) |
| Dissolution Test (spectrophotometric) | Уусалт (spectrophotometric) | 5,000(22.6) |
| Dissolution Test (Chromatographic) | Уусалт (Chromatographic) | 7,000(31.6) |
| Disintegration Test (uncoated /film coated /sugar coated tablet and capsule) | Задралт (бүрээгүй / хальсаар бүрсэн / элсэн чихрээр бүрсэн шахмал ба капсул) | 800(3.6) |
| Disintegration Test (Enteric coated tablet/capsule) | Задралт (бүрмэлтэй шахмал/ капсул) | 1,200(5.4) |
| Disintegration Test (Sustained Release tablet/capsule) | Задралт (SR шахмал/капсул) | 3,200(14.4) |
| pH Test | PH шинжилгээ | 800(3.6) |
| Melting Point | Хайлах температур | 800(3.6) |
| Loss on drying | Хуурай үлдэгдэл | 1,000(4.5) |
| Sulphated Ash | Сульфатын үнслэг | 800(3.6) |
| Sterility Test (direct) | Ариун чанар тодорхойлох (Шууд) | 2,500(11.3) |
| Sterility Test (Filter) | Ариун чанар тодорхойлох (Филтерь) | 3,000(13.5) |
| Endotoxin Test (Gel Clot method ) | Эндотоксины шинжилгээ (Gel Clot арга) | 3,000(13.5) |
| Endotoxin Test (Chromogenic method) | Эндотоксины шинжилгээ (Chromogenic арга) | 4,000(18.0) |
| Gravimetric Assay | Гравиметрийн шинжилгээ | 2,000(9.0) |
| Appearance of solution (syringes) | Уусмалын харагдах байдал (тариур) | 400(1.8) |
| Acidity or Alkalinity | Хүчиллэг, шүлтлэг | 800(3.6) |
| Absorbance (Syringes) | Шингээгч (тариур) | 1,000(4.5) |
| Reducing Substances | Ангижруулагч бодис | 1,200(5.4) |
| Fiber Identification Test | Эслэг таних шинжилгээ | 500(2.2) |
| Absorbency (cotton) | Шингээгч (хөвөн) | 500(2.2) |
| Color of aqueous extract | Уусмалын өнгө | 1,000(4.5) |
| Fluorescence Test | Флюресценцийн туршилт | 800(3.6) |
| Water soluble substance | Усанд уусдаг бодис | 2,000(9.0) |
| Warp thread and weft thread test (Bandage) | Нэхмэл утасны шинжилгээ (боолт) | 500(2.2) |
| Weight per unit area (bandage) | Нэгж талбайн жин (боолт) | 500(2.2) |
| Elasticity Test (crepe bandage) | Уян байдал (нимгэн боолт) | 1,000(4.5) |
| Clarity Test (parenterals) | Тунгалагшилт (парентерал) | 600(2.7) |
| Optical Rotation | Оптик нягт ба гэрэл шингээгч хольц / Оптик эргэлт | 2,000(9.0) |
| Specific Gravity | Хувийн жин | 1,500(6.8) |
| Refractive Index | Хугарлын индекс | 1,200(5.4) |
| Limit Test (Trace elements) | Хязгаарлалтын туршилт (Мөр элемент) | 2,500(11.3) |
| Acid Value | Хүчиллэгийн утга | 2,000(9.0) |
| Iodine Value | Йодын утга | 2,000(9.0) |
| Sponification Value | Саванжих утга | 2,000(9.0) |
| Acetyl Value | Ацетил утга | 2,000(9.0) |
| Hydroxyl Value | Гидроксил утга | 2,000(9.0) |
| Viscosity Test | Зуурамтгай байдал | 1,500(6.8) |
| Friability Test | Уян хатан байдал | 1,500(6.8) |
| Alcohol determination Test | Спиртийн хэмжээ | 3,000(13.5) |
| Others | Бусад | 1,000(4.5) |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 4.Биологийн хяналтын үндэсний лаборатори*

| Бүрдэл | | Fee RKR ($) |
|---|---|---|
| Tetanus Toxoid (Locally Manufactured) | Татрангийн токсоид (Орон нутагт үйлдвэрлэсэн) | 30,000(135.3) |
| Anti Tetanus Sera (Locally Manufactured) | Татрангийн эсрэг сера (Орон нутагт үйлдвэрлэсэн) | 30,000(135.3) |
| Oral Polio Vaccine (Locally Manufactured) | Саагийн эсрэг амны хөндийн вакцин (орон нутагт үйлдвэрлэсэн) | 20,000(90.3) |
| Measles Vaccine (Locally Manufactured) | Улаанбурхны эсрэг вакцин (орон нутагт үйлдвэрлэсэн) | 20,000(90.3) |
| Rabies Vaccine (Locally Manufactured) | Галзуугийн эсрэг вакцин (орон нутагт үйлдвэрлэсэн) | 30,000(90.3) |
| Hepatitis-B Vaccine (Locally Manufactured) | Гепатит-В-гийн вакцин (орон нутагт үйлдвэрлэсэн) | 20,000(90.3) |
| Snake Venom Anti Sera (Locally Manufactured) | Могойн хорны эсрэг сера (орон нутагт үйлдвэрлэсэн) | 30,000(135.3) |
| Interferon (Locally Manufactured) | Интерферон (орон нутагт үйлдвэрлэсэн) | 20,000(90.3) |
| Any other Biological Drug (Imported or Locally Manufactured) | Бусад биологийн эм (дотоодод үйлдвэрлэсэн эсвэл импортын) | 20,000(90.3) |

**Тайлбар: Пакистаны мөнгөн тэмдэгт рупи (Rs./PKR) нь 2022.11.09-ний байдлаар 221,5: 1 ам.доллар харьцаатай байна.*[180]

### 2.3. ФИНЛАНД УЛС

Финланд Улсад эмийн чанар, стандартад хяналт тавих асуудлыг Финландын Нийгмийн асуудал, эрүүл мэндийн яамны харьяа Финландын Эмийн агентлаг (The Finnish Medicines Agency-Fimea) хариуцан ажилладаг. Тус агентлаг нь Финланд Улсын хэмжээнд эмтэй холбоотой аливаа зөвшөөрөл лиценз олгох, эмийн үйлдвэрлэлийн чанар, стандартыг хангах, зах зээлд нэвтрүүлэх эмийн чанар, үр нөлөөний талаар мэдээлэх, хяналт тавих зэрэг үйл ажиллагаа явуулдаг байна.

Финландын эмийн агентлаг нь эмийн чанар, стандартыг шинжлэх албан ёсны Эмийн хяналтын лаборатори (The Official Medicines Control Laboratory-OMCL)-той. Тус лаборатори нь Европын эмийн хяналтын лабораторийн сүлжээ байгууллага юм.

Мөн Финланд Улс нь Европын эмийн агентлагийн гишүүн орон бөгөөд олон улсын “Сайн лабораторийн туршлага” (Good Laboratory Practice-GLP)-ын чанар стандартыг баримтлан ажилладаг орнуудын нэг юм. Тиймээс эдгээр үйл ажиллагааг явуулахдаа дотоодын хууль, дүрэм журмыг мөрдөхөөс гадна Европын эмийн чанар, стандартыг тодорхойлдог стандарт, дүрэм журмыг баримталдаг байна.

#### 1. Хууль эрх зүйн орчин

Финланд Улсад эм үйлдвэрлэл, эмийг зах зээлд нэвтрүүлэх, эмийн чанар стандартыг тогтоох, хяналт тавих, зөвшөөрөл олгох зэрэг харилцааг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна.[181] Тухайлбал,

- *Эмийн тухай хууль (395/1987)*
- *Эмийн тухай тогтоол (693/1987)* The Medicines Decree (693/1987)
- *Эмийн агентлагийн тухай хууль (593/2009)*
- *Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (1224/2004)*
- *Эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (629/2010)*

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[180] https://www.forbes.com/advisor/money-transfer/currency-converter/usd-pkr/
[181] Medicinal product regulation and product liability in Finland: overview https://ca.practicallaw.thomsonreuters.com/3-500-4529?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true

- *Төрийн үндсэн төлбөрийн тухай хууль (Valtion maksuperustelaki 150/1992)*
- *Эмийн агентлагийн төлбөрийн тухай тогтоол (Decree of the Ministry of Social Affairs and Health on fees chargeable by the Finnish Medicines Agency (798/2022))*

**Эмийн тухай хууль болон Эмийн тухай тогтоолоор** бүтээгдэхүүнийг (эм) зохистой үйлдвэрлэх, импортлох, зөвшөөрөл олгох, түгээх, борлуулах, хүртээмжийг хангах үйл ажиллагааг зохицуулдаг. Эмийн тухай хуульд зааснаар Финландын Эмийн агентлаг (Fimea) нь эмтэй холбоотой аливаа захиргааны шийдвэрийг гаргах эрхтэй.

**Эмийн агентлагийн тухай хуулиар** тус агентлагийн бүтэц, үйл ажиллагаа, зохион байгуулалт, зохицуулалтын хамрах хүрээ зэргийг тодорхойлсон.

**Төрийн үндсэн төлбөрийн тухай хуулиар** төрөөс үзүүлж буй аливаа үйл ажиллагаа, үйлчилгээнд зохих төлбөрийг хэрхэн нэхэмжлэх, тухайлан ямар үйлчилгээнүүдэд гүйцэтгэлийн төлбөр тооцох зэргийг зохицуулсан. Жишээлбэл, хуулийн 2-р бүлгийн 6-р зүйлд зааснаар эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн шударга ёсыг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, боловсролын болон соёлын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай зарим төлбөрийг авч болно. Энэ нь олон нийтийн төлөө төрийн үйлчилгээнд авч буй төлбөрийн хэмжээ нь тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулсан зардлын хэмжээтэй тохирч байх ёстой гэж заажээ.

**Эмийн агентлагийн төрийн үйлчилгээнд төлбөр авах тогтоолыг** дээрх хуулийн хүрээнд Нийгмийн асуудал, эрүүл мэндийн яамнаас баталсан. Уг тогтоолд Эмийн агентлагаас олгох аливаа зөвшөөрөл, хяналт шалгалт, эмийг зах зээлд нэвтрүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаанд шаардагдах төлбөр хураамжийг авах тухай зохицуулсан.

**2. Финландын Эмийн Агентлаг** (Fimea)[182]

Fimea нь эм зүйг зохицуулах үндэсний эрх бүхий байгууллага юм. Нийгмийн асуудал, эрүүл мэндийн яамны харьяанд үйл ажиллагаа явуулдаг тус агентлаг нь Эмийн тухай хууль, Эмийн агентлагийн тухай хууль болон бусад холбогдох хууль эрх зүйн актуудын хүрээнд ард иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг дэмжих зорилгоор эмийн салбарын үйл ажиллагааг зохицуулдаг. Ингэхдээ эмийн салбарыг хөгжүүлэх, хяналт тавих, шаардлагатай лиценз олгох, судалгаа шинжилгээ хийх, эмийн талаар мэдээлэх үүрэгтэй.

Мөн Финландын эмийн зах зээл дээр байгаа хүн болон мал эмнэлгийн хэрэгцээнд зориулагдсан бүх эмийн бүтээгдэхүүнийг аюулгүй байдал, үр нөлөө, чанарын шаардлагад нийцүүлэн хангах зорилготой. Энэ зорилгын хүрээнд эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, бөөний худалдаачид болон эмийн сангуудад лиценз болон бусад зөвшөөрлийг олгох, эмийн бүтээгдэхүүнийг зөв үйлдвэрлэж, түгээх, хэрэглэхэд аюулгүй эсэхийг шалгах зорилгоор хяналт шалгалт хийдэг.

Тус агентлаг нь зөвхөн эмийн чанар, аюулгүй байдалд хяналт тавихаас гадна Эмийн бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх тухай хууль (979/2008)-ийн дагуу эм үйлдвэрлэгчид, эм импортлогчид, эрүүл мэндийн байгууллагууд болон Финландын эрүүл мэнд, халамжийн хүрээлэнгийн[183] эмийн нөөц бүрдүүлэлтийн үүргээ биелүүлж байгаа эсэхэд мөн хяналт тавьж ажилладаг. Эмийн салбарын хөгжлийг тодорхойлоход үндэсний болон олон улсын хэмжээнд идэвхтэй үүрэг гүйцэтгэж, Европын эмийн зохицуулалтын үйл ажиллагаанд оролцдог байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[182] https://www.fimea.fi/web/en/about_us/organisation
[183] https://www.fimea.fi/web/en/supervision/pharmaceutical_industry

### 3. Финландын Эмийн агентлагийн лабораторийн мэдээлэл[184]

Тус агентлаг нь Финландын зах зээл дээрх эмийн салбарын лиценз эзэмшигчдийн үйл ажиллагааг хянах, эмийн чанар, стандарт, аюулгүй байдлыг шинжлэн шалгах зорилгоор Финландын албан ёсны Эмийн хяналтын лаборатори (The Official Medicines Control Laboratory-OMCL)-ийг ажиллуулдаг. Энэ нь хүний болон мал эмнэлгийн эмийн зохих чанар, аюулгүй байдлыг хангах үүднээс чанарын хяналтыг хийдэг. Лабораторийн эрхэм зорилго нь Финланд Улсын зах зээлд худалдаалагдаж байгаа болон хэрэглэгдэж байгаа эмийн бүтээгдэхүүний үр нөлөө, аюулгүй байдал, чанарын шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах явдал юм.

Финландын албан ёсны эмийн хяналтын лаборатори (The Official Medicines Control Laboratory-OMCL) нь Европын OMCL сүлжээнд харьяалагддаг. Энэхүү сүлжээг Европын Эм, эрүүл мэндийн зөвлөл (EDQM) / Европын Зөвлөл зохицуулдаг.

Лаборатори нь ISO/IEC 17025:2017 стандартын дагуу ажилладаг ба үндэсний магадлан итгэмжлэлийн байгууллагаас (FINAS) магадлан итгэмжлэгдсэн төдийгүй Европын эмийн чанар, эрүүл мэндийн газар (EDQM)-ын аудиторуудын зөвшөөрөлтэй (MJA status) байна.

Финландын албан ёсны Эмийн хяналтын лаборатори нь эм, хими, биологи, микробиологийн шинжилгээний аргыг сонгон ашигладаг. Эм тус бүрийн үр нөлөө, аюулгүй байдалд нөлөөлж буй чухал шинж чанаруудыг тогтоох зорилгоор эмнэлзүйн туршилтуудыг хийдэг. Мөн вакцин, цус, сийвэнгийн гаралтай эмийн багцын ялгаралтыг зохицуулдаг байна. Тухайлбал,

- Микробиологи: эндотоксин (кинетик ба бүлэгнэлт), ариун чанарын шинжилгээ, омог тодорхойлох;
- Биологи: ELISA[185] болон Western blot-ийн аргаар холбох/дархлаа судлалын шинжилгээ, ферментийн шинжилгээ, эсэд суурилсан шинжилгээ.

Албан ёсны Эмийн хяналтын лаборатори (OMCL) нь төвийг сахисан, ялгаварлан гадуурхахгүй, хараат бус зарчмаар үйл ажиллагаа явуулна. Үйл ажиллагаа нь ерөнхийдөө эмийн аюулгүй байдал, үр нөлөө, чанарыг хангахад чиглэгдэх бөгөөд чанарын хяналт шалгалтын хөтөлбөрүүд нь эрсдэлийн шинжилгээнд суурилдаг байна. Үйл ажиллагааныхаа хүрээнд олон янзын аргыг хэрэглэдэг байна.

Лаборатори нь 17 ажилтантай. Лабораторийн мэргэжилтнүүд нь эмийн чанарын хяналтын нийтлэг стандартыг боловсруулахын тулд Европын фармакопейн[186] боловсруулах ажилд оролцдог. Эдгээр мэргэжилтнүүд нь хяналт шалгалт, маркетингийн зөвшөөрлийн үнэлгээний чиглэлээр давхар мэргэшсэн байдаг.

Тус лаборатори нь гааль, цагдаагийн байгууллага, хүнсний асуудал хариуцсан газар зэрэг үндэсний бусад байгууллагуудтай хамтран ажилладаг бөгөөд энэхүү хамтын ажиллагаа нь хуурамч эм, допингийн бодис, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнтэй холбоотой асуудлыг хамаардаг.[187]

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[184] Finnish Medicines Agency Laboratory https://www.casss.org/docs/default-source/bioassays/2019-bioassays-speaker-presentations/vesterinen-jaana-finnish-medicines-agency-2019.pdf?sfvrsn=39f17aef_10
[185] ELISA нь дээж дэх эсрэг бие эсвэл эсрэгтөрөгчийг илрүүлэхэд ашигладаг дархлааны сорил юм. Western blot нь холимогоос уураг ялгах, илрүүлэхэд өргөн хэрэглэгддэг аналитик арга юм. https://byjus.com/biology/difference-between-elisa-and-western-blot/
[186] Фармакопей нь эмийн түүхий эд, бодис, эмийн бэлдмэл зэрэг эмчилгээний чанарын стандартыг тодорхойлсон албан ёсны баримт бичиг юм. https://mn.unansea.com/
[187] https://www.fimea.fi/web/en/supervision/the-laboratory-of-fimea/national-and-international-collaboration

**Финландын Эмийн агентлагийн лабораторийн үйл ажиллагааны төлбөр[188]**

Финландын эмийн агентлаг нь хуульд заасан чиг үүргийн дагуу тусгай зөвшөөрлийн болон бусад гүйцэтгэлийн нөхцөлөөр хийсэн үзлэг, эсхүл өөрийн санаачилгаар хийсэн хяналт шалгалтын төлбөрийг авах эрхтэй талаар Эмийн тухай хууль болон Эмийн агентлагийн тухай хуулиар зохицуулсан. Төлбөрийн хэмжээ болон төрлийг Нийгмийн асуудал, эрүүл мэндийн яамнаас баталдаг.

2022 онд Нийгмийн асуудал, эрүүл мэндийн яамнаас Финландын эмийн агентлагаас ногдуулах төлбөрийн тухай 798/2022 тогтоолыг шинэчлэн баталсан байна. Үүнийг “Нийгмийн асуудал, эрүүл мэндийн яам”-ны шийдвэр, “Улсад төлөх төлбөрийн шалгуурын тухай” хуулийн (348/1994) 8 дугаар хэсэг, “Эмийн тухай” хуулийн (773/2009) 28 дугаар хэсэг, “Финландын Эмийн агентлагийн тухай” хуулийн (1480/2019) 6 дугаар хэсгүүдэд тус тус үндэслэжээ.

Энэхүү тогтоолын “Албан ёсоор төлбөртэй гүйцэтгэх үйл ажиллагааны тухай” 1 дүгээр хэсгийн 6-д (нийт 17 үйл ажиллагааг зааж өгсөн):

- “Химийн бүтээгдэхүүний тухай хуулийн (599/2013) 24 дүгээр хэсэгт заасанчлан лабораторийн албан ёсны шинжилгээний зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан боловсруулахад” (processing the application for approval of an authorised test laboratory as referred to in section 24 of the Chemicals Act (599/2013)) төлбөр төлнө гэж заажээ. Өөрөөр хэлбэл, албан ёсны лабораторийн шинжилгээтэй холбогдох улсад төлөх төлбөрийн тухай зохицуулсан байна.

Харин төлбөргүй гүйцэтгэх үйл ажиллагааны тухай тогтоолын 2 дугаар хэсгийн 3-т дараах байдлаар зохицуулсан байна:

- цагдаа, гаалийн байгууллага, эсхүл гаалийн лабораторийн албан үүргийн дагуу шаардагдах наркотикийн лиценз, эсхүл эмийн бүтээгдэхүүнийг ангилахтай холбоотой шийдвэр;
- энэ хэсгийн 1-т Их сургуулийн тэнхим, Их сургуулийн эмнэлэг, Финландын эмнэлэг, Финландын эрүүл мэндийн хүрээлэн зэрэг газруудад гадаадаас санхүүжилтгүй, эсхүл ТББ-ын санхүүжилттэй хийгдэж буй эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, эмнэлгийн төхөөрөмжийн клиникийн туршилт зэргийн албан ёсны зөвшөөрлийг хянан шалгахтай холбоотой үйл ажиллагаа;
- 2-т Төслийн албаны зөвлөлөөс хэрэгжүүлж буй мал, амьтанд хийх туршилттай холбоотой наркотикийн лицензийн зөвшөөрөл зэргийг төлбөргүй хянан боловсруулна гэжээ.

Мөн 2а хэсэгт төлбөр шаардахгүйгээр, эсхүл өртгөөс нь бага хэмжээгээр төлбөр ногдуулах нөхцөлүүдийг заасан байна. Үүнд:

- цар тахал болон бусад онцгой нөхцөл байдал үүссэний улмаас Финланд Улсад урьдчилан тооцоолоогүй гэнэтийн их эрэлт үүссэн, байгалийн гамшгийн улмаас ханган нийлүүлэлтийн урсгал тасалдсан, төрийн шийдвэрээр маркетингийн албаныхны урьдчилан тооцоолоогүй өргөн цар хүрээтэйгээр хангалтыг татаж авах, өрсөлдөх бүтээгдэхүүний хомстол үүссэн зэрэг нөхцөл байдлуудыг дурдсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

188 Decree of the Ministry of Social Affairs and Health on fees chargeable by the Finnish Medicines Agency 798/2022 https://www.fimea.fi/documents/542809/841791/Maksuasetus+798_2022_EN_final_12102022.pdf/d6960ae1-96c4-03de-77c8-a06803d95da5?t=1665565952582

Улмаар Засгийн газрын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээ материал хувилах, хэвлэж өгөх зэрэг мэдээллээр хангахтай холбоотой үйл ажиллагаандаа төлбөр тооцохыг тус тус заажээ.

Энэхүү тогтоолын хавсралтаар эмийн бүтээгдэхүүнийг бүртгүүлэх болон зах зээлд нийлүүлэх зөвшөөрлийн өргөдлийг боловсруулах, хяналт шалгалт явуулах зэрэг олон төрлийн ажил үйлчилгээний төлбөрийг үйл ажиллагаа тус бүрээр нарийвчлан баталсан бөгөөд лабораторийн үйл ажиллагааг хянан шалгах ажлын төлбөрийг дараах байдлаар тогтоожээ. Тухайлбал:

- Дотоодын аль нэг лабораторийн үйл ажиллагааг шалгаж зөвшөөрөл олгох ажлын төлбөр - 1 өдөрт €4000, илүү өдрүүдэд €2000, харин 4 цагаас хэтрэхгүй тухайлсан нэг үйл ажиллагааг хянах ажлын төлбөр €2000 байна.
- Гадаад улс дахь лабораторийн үйл ажиллагааг шалгаж зөвшөөрөл олгоход 1 өдрийн €6000, илүү хоногийн хувьд тухайн газарт очиж ажилласан багийн гишүүн бүрд €3000 байна.

Финландын эмийн агентлаг нь 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр гаргасан Ref. no.FIMEA/2022/001982 шийдвэрээрээ “Арилжааны шалгуураар гаргасан ажил үйлчилгээний үнийн жагсаалт”-ыг[189] баталсан байна. Тус жагсаалтаар лабораторийн үйл ажиллагаатай холбоотой төлбөрийг тогтоосон байна. Тухайлбал:

**Лабораторийн үйл ажиллагаатай холбоотой төлбөр**

*Хүснэгт 5.Тусгайлан захиалсан тайлан мэдээ, мөрдөн шалгалт, хяналт, дүн шинжилгээ*

| *Үнийн жагсаалт: Тусгайлан захиалсан тайлан мэдээ, мөрдөн шалгалт, хяналт, дүн шинжилгээ* | | |
|---|---|---|
| Татваргүй болон татвар шингэсэн үнэ | НӨАТ 0% | НӨАТ 24% |
| Лабораторийн мэргэжилтэн | Цагт €180.00 | Цагт € 223.20 |
| Лабораторийн туслах | Цагт €90.00 | Цагт € 111.60 |

*Хүснэгт 6.Тусгайлан захиалсан лабораторийн ажил үйлчилгээ*

| *Үнийн жагсаалт: Тусгайлан захиалсан лабораторийн ажил үйлчилгээ* | | |
|---|---|---|
| Татваргүй болон татвар шингэсэн үнэ | НӨАТ 0% | НӨАТ 24% |
| Sterility test (membrane filtration) – Ариун чанарын тест (мембрамын шүүлтүүр) | 1 дээж нь € 351.00 | € 435.24/дээж |
| Sterility test (direct inoculation)- Ариун чанарын тест (шууд ургуулах замаар) | € 202.00/дээж | € 250.48/дээж |
| Total viable count-нийт микро организмын тоо | € 216.00/дээж | € 267.84/дээж |
| Specific microorganisms-тухайлсан микро организмууд | € 338.00*/дээж | € 419.12/дээж |
| Bacterial endotoxins: gel-clot-бактерын эндотоксин: | € 358.00/дээж | € 443.92/дээж |
| Bacterial endotoxins: Kinetic chromogenic - бактерын эндотоксин: | € 271.00**/дээж | € 336.04/дээж |
| Bacterial endotoxins: Kinetic turbidimetric - бактерын эндотоксин: | € 279.00/дээж | € 345.96/дээж |
| Particle count (Subvisible particles, LO method) | € 191.00***/дээж | € 236.84/дээж |

Эмийн агентлаг нь зөвхөн Европын стандартад (EN 16931) нийцсэн нэхэмжлэхийг хүлээн авна. Хэрэв тодорхой шалтгааны улмаас компани Европын стандартын дагуу нэхэмжлэхийг шаардлагатай хугацаанд илгээх боломжгүй бол захиалга бэлтгэхтэй холбогдуулан тухайн байгууллагатай шилжилтийн хугацааны талаар тусдаа гэрээ байгуулсан байх ёстой. Гэсэн хэдий ч бүх нэхэмжлэх нь Нэмэгдсэн өртгийн албан татварын

[189]https://www.fimea.fi/documents/542809/841791/Price+list+for+services+priced+according+to+commercial+criteria+2022.pdf/ed7324c4-7444-dccb-923f-32c5abfe70fd?t=1652861105622

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тухай хуульд заасан нэхэмжлэхийн өгөгдлийн агуулгын заавал дагаж мөрдөх шаардлагыг хангасан байх ёстой.

### 2.4. АНУ

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Эрүүл мэндийн яам (Department of Health and Human Services)-ны харьяа 9 агентлагийн нэг болох Хүнс болон эмийн захиргаа (Food and Drug Administration)[190] нь АНУ-д үйлдвэрлэгдэж, худалдаалагдаж буй хүн ба амьтны хоол хүнс, эм, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, эмнэлгийн хэрэгсэл, гоо сайхны бүтээгдэхүүн, биологийн бүтээгдэхүүнд хяналт тавих үүрэгтэй Засгийн газрын агентлаг юм.

**Хууль, эрх зүйн орчин**

АНУ нь эм, эмнэлгийн бүтээгдэхүүний стандартыг шинжлэн тогтоох, зөвшөөрөл олгох үйл ажиллагаандаа Холбооны Хүнс, Эм, Гоо сайхны бүтээгдэхүүний тухай хууль (Federal Food, Drug and Cosmetic Act), Нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний тухай хууль (Public Health Service Act), Эмийн чанар, аюулгүй байдлын тухай хууль (Drug Quality and Security Act), Эмийн зүй бус хэрэглээнээс сэргийлэх, хяналт тавих тухай хууль (Comprehensive Drug Abuse Prevention and Control Act), Эмийн бүтэц найрлагын хяналтын тухай хууль (Controlled Substances Act), Жороор олгох эмийн худалдааны тухай хууль (Prescription Drug Marketing Act), Эмийн үнийн өрсөлдөөн болон патентын хугацааг шинэчлэх тухай хууль (Drug Price Competition and Patent Term Restoration Act) болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрддөг байна.

Хүнс болон эмийн захиргаанаас шинэ эм, нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эм (generic drug), эм төст бүтээгдэхүүнд олгодог зөвшөөрөл нь дэлхийд хамгийн өндөр стандарттайд тооцогддог байна. Тухайн эмийг хаана үйлдвэрлэснээс үл хамааран АНУ-д мөрдөгдөж буй эмийн найрлага, орцонд тавигдах стандарт (US pharmacopeia)-д нийцсэн, чанарын шаардлага хангасан байх шаардлагатай бөгөөд Хүнс болон эмийн захиргаанаас зөвшөөрөл авахын өмнө бусад лабораториудаар шинжлэн, баталгаажуулсан байх шаардлагатай байна. Хүнс болон эмийн захиргааны Эмийн үнэлгээ, судалгааны төв нь эмийн чанарт тавигдах хяналтын цогц хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна. Ингэхдээ үйлдвэрлэгдсэн шинэ эм болон эмнэлгийн бүтээгдэхүүн, худалдаанд байгаа эм, бүтээгдэхүүнүүдээс сонгон Хүнс болон эмийн захиргааны лабораториудад шинжилнэ. Ингэхдээ эмийн идэвхтэй найрлага (active pharmaceutical ingredients) болон бусад бүтцийг судлан, стандартад нийцэж буй эсэхийг тодорхойлно.[191]

**1. Эмийн үнэлгээ, судалгааны төв**

Хүнс болон эмийн захиргааны Эмийн үнэлгээ, судалгааны төв (Center for Drug Evaluation and Research) нь үндэсний хэмжээнд эм, эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээнд хяналт тавьдаг байна. Тус төв нь ерөнхий, худалдаанд зарагддаг эмийн бүртгэлд бүртгүүлэх шинэ эмийн өргөдлийг хянах, АНУ-ын одоогийн мөрдөгдөж байгаа Сайн үйлдвэрлэлийн практик (Good Manufacturing Practice) эм үйлдвэрлэлийн журмын хэрэгжилтийг хангах, Эмийн найрлага, орцонд тавигдах стандартыг мөрдөх, эмчийн жор шаардлагатай эмийг тодорхойлж, шаардлага хангаж худалдаалах зөвшөөрөл авсан эмийн сурталчилгаанд хяналт тавих, зах зээлд борлуулагдаж байгаа эмийн аюулгүй байдлын талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

Тус төв нь шинэ эмийн үр нөлөөг судлан үнэлэх болон баталгаажуулах 1300 гаруй ажилтнуудаас бүрдсэн “Хяналтын баг” (Review team), түүнчлэн шинэ эмийн хүний эрүүл

[190] FDA is an agency within the Department of Health and Human Services.
[191] https://www.fda.gov/drugs/science-and-research-drugs/drug-quality-sampling-and-testing-programs

мэндэд учруулж болохуйц хор нөлөө, эсвэл гарч болохуйц эрсдэлийн талаар эмийн заавар дээр тусгасан, сэрэмжлүүлсэн эсэхийг тодорхойлох 72 ажилтнаас бүрдсэн “Аюулгүй байдлыг хангах баг” (Safety team) бүхий 2 хэсгээс бүрддэг байна. Эмийг баталгаажуулах, заавар, тэмдэглэгээ, хаяг шошгыг баталгаажуулах, хяналт тавих үйл ажиллагаанд Хүнс болон эмийн захиргааны төсвөөс жилдээ ойролцоогоор 290 сая ам.доллар зарцуулдаг байна. Аюулгүй байдлыг хангах баг нь жилдээ 3000 гаруй жороор олгодог эмийн үр нөлөөний хяналт шинжилгээг хийхэд ойролцоогоор 15 сая ам.долларыг төсвөөс зарцуулдаг байна.

Эмийн стандартыг шалгах, хянан баталгаажуулах үйл явц нь дараах 12 үе шатаас бүрдэж байна. Үүнд:

1. Эм үйлдвэрлэгч нь үйлдвэрлэсэн эмээ амьтан дээр турших
2. Эм үйлдвэрлэгч нь тухайн эмийн бүтэц, найрлага, үйлдвэрлэлийн талаарх анхны шинжилгээний мэдээлэлд үндэслэн шинэ эмийг судлуулах хүсэлтээ (Investigational New Drug Application) Хүнс болон эмийн захиргаанд гаргана. Мөн хүний бие дээр турших төлөвлөгөө гаргана. Хүнс болон эмийн захиргаа хүсэлтийн дагуу эмийг шинжлэн судалж, хүний биед хор хохирол учруулахгүй гэж үзвэл цаашдын туршилтад оруулахыг зөвшөөрнө.
3. Хүний бие дээр турших 1-р үе (20-80 хүнийг багтаана). Тухайн эмийн аюулгүй, найдвартай байдлыг туршин, хүний биед үзүүлэх сөрөг үр дагаврыг илрүүлнэ.
4. Хүний бие дээр турших 2-р үе (100-300 орчим хүнийг багтаана). Тухайн эмийн үр нөлөөг туршина.
5. Хүний бие дээр турших 3-р үе (хэдэн зуугаас 3000 орчим хүнийг багтаана). Тухайн эмийн аюулгүй байдал, үр нөлөө, сөрөг үр дагаврыг өөр өөр бүлгийн хүмүүс дээр туршина. Ингэхдээ янз бүрийн тунгаар, бусад эмтэй хамт гэх мэтээр туршин шинжилнэ.
6. Хүнс болон эмийн захиргаанаас дээрх эм үйлдвэрлэгчтэй Шинэ эм баталгаажуулах хүсэлт (New Drug Application) гаргахаас өмнө уулзалт хийнэ.
7. Эм үйлдвэрлэгч нь тухайн эмийн талаарх орц найрлага, бүхий л шатны туршилт, үйлдвэрлэлийн мэдээлэл зэргийг агуулсан Шинэ эм баталгаажуулах хүсэлтийг Хүнс болон эмийн захиргаанд гаргана.
8. Хүнс болон эмийн захиргаа нь дээр дурдсан эмийн мэдээллүүдтэй танилцана.
9. Хүнс болон эмийн захиргааны Хяналтын баг нь эм үйлдвэрлэгчийн эмийн аюулгүй байдал, үр нөлөөний шинжилгээ, судалгаан дээр үндэслэн 60 хоногийн хугацаанд тухайн эмийг судлан, чанар, үр нөлөөг шинжлэн тогтооно.
10. Хүнс болон эмийн захиргаа нь эмийн бүтэц, орц найрлагын танилцуулга бүхий шошгыг хянан шинжилнэ.
11. Хүнс болон эмийн захиргаа нь тухайн эмийг худалдаалах эрхийг олгохдоо үйлдвэр, тоног төхөөрөмжийн хяналт шалгалтыг мөн хийнэ.
12. Хяналт шинжилгээ явуулсны эцэст Хүнс болон эмийн захиргаа нь тухайн эмийг хэрэглээнд нэвтрүүлэх эрхийг олгох, эсхүл татгалзсан хариуг хүсэлт гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

Эмийг хэрэглээнд нэвтрүүлэх, худалдаалах эрх олгосны дараа Хүнс болон эмийн захиргаа нь эмийн хэрэглээнд мөн үргэлжлүүлэн хяналт тавина. Үүнд Хүнс болон эмийн захиргаа нь эм үйлдвэрлэгчээс тухайн эмийн аюулгүй байдал, сөрөг үр дагавар гарсан эсэх мэдээллийг

UIH.MN СУДАЛГААНЫ САН

тогтмол хугацаанд авч байх шаардлагатай байна. Шаардлагатай тохиолдолд эмийг худалдаанаас эргүүлэн татдаг байна.[192]

Хүнс болон эмийн захиргаанд шинэ эм, нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эм, жороор олгох эм, эм төст бүтээгдэхүүний чанар стандартыг шалгах, хянан баталгаажуулах болон худалдаалах, хэрэглэх үйл явцад хяналт тавихад шаардагдах санхүүжилтийн тодорхой хувийг эм үйлдвэрлэгчид болон хэрэглээнд нэвтрүүлэхээр хүсэлт гаргасан этгээдээс гаргуулах эрхийг тодорхой хуулиудаар олгосон байна. Тухайлбал, 1992 онд Жороор олгох эм үйлдвэрлэгчийн төлбөрийн тухай хууль[193], 2012 онд Эм төст бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн төлбөрийн тухай хууль (Biosimilar User Fee Act)[194], 2017 онд Нийтийн хэрэглээний эм үйлдвэрлэгчийн төлбөрийн тухай хууль (Generic Drug User Fee Act)[195] зэрэг болно.

Хүнс болон эмийн захиргаанаас хүн ба мал, амьтны эмийн чанар, стандартыг шинжлэх болон үйлдвэрлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, худалдаалах, импортлох, экспортлох зэрэг зөвшөөрөл олгоход эм, эмнэлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болон баталгаажуулах хүсэлт гаргасан этгээдээс тодорхой төлбөрийг дараах эм, бүтээгдэхүүнд ногдуулдаг байна. Үүнд:

- Нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эм;
- Жороор олгох эм;
- Эм төст бүтээгдэхүүн;
- Хүний эмийн орц найрлагад орох бүтээгдэхүүн;
- Экспортын эм;
- Импортын эм;
- Мал, амьтны эм;
- Мал амьтны нийтлэг хэрэглээний эм;
- Эмнэлгийн тоног төхөөрөмж зэрэг багтана. Эдгээрээс онцлон дараах төлбөрүүдийг авч үзлээ.

*Хүснэгт 7. 2023 оны санхүүгийн жилд Нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эмийг шинжлэн баталгаажуулах төлбөр[196]*

| **Төлбөрийн төрөл** | **Төлбөрийн хэмжээ** |
|---|---|
| Нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эмтэй ижил орц найрлага, үр нөлөө бүхий эмийг шинжлүүлэн, баталгаажуулах төлбөр (Abbreviated New Drug Application) | 240.582 $ |
| Эмийн үйлдвэрлэл, савлагаа, хадгалалт, бүтэц найрлагын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хянан баталгаажуулах төлбөр (Drug Master File)[197] | 78.293 $ |
| Эмийн идэвхтэй найрлагын шинжилгээ –дотоод (Active Pharmaceutical Ingredient) | 37.544 $ |
| Эмийн идэвхтэй найрлагын шинжилгээ –гадаад | 52.544 $ |
| Эмийн хэлбэр, тунгийн хэмжээ-дотоод (Finished dosage form) | 213.134 $ |
| Эмийн хэлбэр, тунгийн хэмжээ-гадаад | 228.134 $ |
| Эм үйлдвэрлэгчтэй гэрээлсний дагуу эм үйлдвэрлэх байгууллагыг шалгуулах-дотоод (Contract Manufacturing Organization) | 51.152 $ |
| Эм үйлдвэрлэгчтэй гэрээлсний дагуу эм үйлдвэрлэх байгууллагыг шалгуулах-гадаад | 66.152 $ |
| Нийтийн хэрэглээнд нэвтэрсэн эмийг шинжлэн баталгаажуулах хөтөлбөр | 1.620.556 $ |

[192] https://www.fda.gov/drugs/information-consumers-and-patients-drugs/fda-drug-approval-process-infographic-vertical https://www.fda.gov/drugs/information-consumers-and-patients-drugs/fdas-drug-review-process-continued
[193] https://phrma.org/policy-issues/Research-and-Development/PDUFA
[194] https://www.fda.gov/media/157299/download
[195] https://www.fda.gov/media/157298/download
[196] https://www.federalregister.gov/documents/2022/10/12/2022-22099/generic-drug-user-fee-rates-for-fiscal-year-2023
[197] https://www.fda.gov/drugs/guidances-drugs/drug-master-files-guidelines

UIHMN СУДАЛГААНЫ САН

| | |
|---|---|
| (том аж үйлдвэр) | |
| (дунд зэргийн аж үйлдвэр) | 648.222 $ |
| (жижиг үйлдвэр) | 162.056 $ |

*Хүснэгт 8. 2023 оны санхүүгийн жилд Жороор олгох эмийг шинжлэн баталгаажуулах төлбөр*[198]

| Төлбөрийн төрөл | Төлбөрийн хэмжээ |
|---|---|
| Эмнэлзүйн туршилтын мэдээлэл шаардлагатай эм | 3.242.026 $ |
| Эмнэлзүйн туршилтын мэдээлэл шаардлагагүй эм | 1.621.013 $ |

*Хүснэг 9. 2023 оны санхүүгийн жилд эм төст бүтээгдэхүүнийг шинжлэн баталгаажуулах төлбөр*

| Төлбөрийн төрөл | Төлбөрийн хэмжээ |
|---|---|
| Шинээр бий болгосон эм төст биологийн бүтээгдэхүүнийг шинжлэх төлбөр (Анхан) Biosimilar Biological Product Development Fee (Initial) | 47.325 $ |
| Эм төст биологийн бүтээгдэхүүнийг шинжлэх төлбөр (дахин баталгаажуулах) | 94.650 $ |
| Эмнэлзүйн туршилтын мэдээлэл шаардагдах | 1.746.745 $ |
| Эмнэлзүйн туршилтын мэдээлэл шаардагдахгүй | 873.373 $ |

*Хүснэгт 10. 2023 оны санхүүгийн жилд Хүний эмийн орц найрлагад орох бүтээгдэхүүнийг шинжлэн баталгаажуулах төлбөр*

| Төлбөрийн төрөл | Төлбөрийн хэмжээ |
|---|---|
| Жижиг бизнес эрхлэгчдийг хянан шалгах | 5824 $ |
| Жижиг бус бизнес эрхлэгчдийг хянан шалгах | 18.999 $ |
| Дахин хяналт явуулах | 17.472 $ |

### 2. Хүнс болон эмийн захиргааны лабораториуд

Хүнс болон Эмийн захиргааны 9 төвийн нэг болох Зохицуулалтын Газар (Office of Regulatory Affairs)-ын Шинжлэх Ухаан Зохицуулалтын Алба (Office of Regulatory Science) нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор АНУ даяар 16 сүлжээ лаборатори ажиллуулдаг байна. Эдгээрийн 8 нь Хүн ба амьтны хоол хүнсний лаборатори, үлдсэн 8 нь Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, тамхи, тусгай мэргэшсэн лаборатори гэж төрөлждөг байна. Эрүүл мэндийн бүтээгдэхүүн, тамхи, тусгай мэргэшлийн лабораториуд нь эм, эмнэлгийн хэрэгсэл, тамхи, радио идэвхт бодис болон хүний биед сөрөг нөлөөтэй хорт бодисын шинжилгээг хийж гүйцэтгэдэг байна.[199] Эдгээр лабораториуд нь Америкийн Үндэсний Стандартын Хүрээлэн (American National Standards Institute) –ийн Үндэсний Магадлан Итгэмжлэлийн Зөвлөл (National Accreditation Board)-өөс ISO/IEC 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байдаг.[200] Үүнд:

- Детройт Лаборатори (Detroit Laboratory);
- Шүүхийн шинжилгээний төв (Forensic Chemistry Center);
- Зүүн хойд хэсгийн эмнэлгийн бүтээгдэхүүний лаборатори (Northeast Medical Products Laboratory);

[198] https://www.fda.gov/industry/fda-user-fee-programs/prescription-drug-user-fee-amendments#:~:text=The%20Prescription%20Drug%20User%20Fee%20Act%20(PDUFA)%20was%20created%20by,of%20certain%20prescription%20drug%20products.
[199] https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories
[200] https://anab.ansi.org/about-anab

- Номхон Далайн Баруун Өмнөд хэсгийн Эмнэлгийн Бүтээгдэхүүний Лаборатори (Pacific Southwest Medical Products Laboratory);
- Филадельфи Лаборатори (Philadelphia Laboratory);
- Сан Хуан Лаборатори (San Juan Laboratory);
- Зүүн Өмнөд хэсгийн Тамхины Лаборатори (Southeast Tobacco Laboratory);
- Винчестерийн Инженерийн Шинжилгээний Төв (Winchester Engineering Analytical Center)… эдгээрээс эмийн чанар, стандартын шинжилгээг хийж гүйцэтгэдэг лабораториудын талаар тоймлон авч үзье.

**Детройт лаборатори[201]**

Детройт лаборатори нь ISO/IEC 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн эмийн шинжилгээний лаборатори юм. Тус лаборатори нь олон төрлийн химийн бодис болон эмийн найрлага дахь идэвхтэй орцыг задлан шинжлэх боломжтой. Түүнчлэн Импортын эмийг шинжлэх хөтөлбөр, Эмийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хуурамч эм, өвчний тархалт, хэрэглэгчдийн санал гомдол, байнгын, давтамжтай хийгддэг хяналт шинжилгээний зорилгоор хүнсний нэмэлт бүтээгдэхүүнд шинжилгээ хийдэг байна. Тус лаборатори нь мөн Эмийн хүчинтэй хугацааг уртасгах хөтөлбөр (Shelf-Life Extension Program)-т хамрагдаж хугацаа нь дууссан болон дуусах дөхсөн эм, эмийн бүтээгдэхүүнд шинжилгээ хийн, Батлан Хамгаалах Яам, Стратегийн Үндэсний Нөөцийн Газартай хамтран тэдгээр эмийн орц, найрлага болон зааврыг судлан, эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орц, найрлагаа эмийн заавар дээр бүгдийг оруулсан хийгээд эдгээр нь АНУ-д зөвшөөрөгдсөн химийн бодис мөн эсэхийг тогтоодог байна.

**Шүүхийн шинжилгээний төв[202]**

Тус төв нь Хүнс болон эмийн захиргааны хяналтад байдаг эм, эмийн бүтээгдэхүүн, хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүн, мал амьтны хоол тэжээл, эмнэлгийн хэрэгсэл болон тамхи зэрэг бараа бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдвэрлэсэн эсэхийг тодорхойлох химийн задлан шинжлэх, молекул, микробиологийн чиглэлээр тусгайлсан лабораторийн үйлчилгээ үзүүлдэг үндэсний шүүхийн шинжилгээний лаборатори юм. Төв нь хэрэглэгчдийг хуурамч, хортой бүтээгдэхүүн хэрэглэхээс хамгаалахын тулд Хүнс болон эмийн захиргааны Гэмт хэргийг илрүүлэх албанд мэргэжлийн техникийн дэмжлэг туслалцаа, лабораторийн шинжилгээний үйлчилгээ үзүүлдэг байна. Төв нь шүүхийн шинжилгээний чиглэлээр ISO/IEC 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байна.

Төв нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр голлох үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тухайлбал, эм болон хүнсний бүтээгдэхүүний хүний эрүүл мэндэд хохирол учруулахуйц химийн бодисыг шинжилж, тодорхойлох зэрэг болно. Шүүхийн шинжилгээний төвийн эрдэмтэн судлаачид дэлхийн бусад улс орнуудын ижил төрлийн байгууллагуудтай хамтран стандартын бус, чанарын шаардлага хангахгүй, хуурамч бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

**Зүүн хойд хэсгийн эмнэлгийн бүтээгдэхүүний лаборатори[203]**

Тус лаборатори нь олон төрлийн эмийн шинжилгээг хийх боломжтой бөгөөд ISO/IEC 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн байна. Лаборатори нь Хими болон Микробиологийн хэсэгтэй бөгөөд хэсэг тус бүр олон тооны химийн бодис болон өвчин үүсгэгч, эсхүл өвчин үүсгэдэггүй бичил биетүүдийг шинжлэн тогтоох боломжтой байна. Дээрх шинжлэх ухааны нарийвчилсан шинжилгээнүүдээс гадна тус лаборатори нь

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[201] https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories/detroit-laboratory-detl
[202] https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories/forensic-chemistry-center-fcc
[203] https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories/northeast-medical-products-laboratory-nmpl

урьдчилсан буюу тандан судалгаа, шинжилгээ түүнчлэн тодорхой шалтгааныг олж тогтоох зорилгоор шинжилгээ хийдэг байна.

**Номхон далайн Баруун өмнөд хэсгийн эмнэлгийн бүтээгдэхүүний лаборатори**[204]

Номхон далайн Баруун өмнөд хэсгийн эмнэлгийн бүтээгдэхүүний лаборатори нь дээрх (Зүүн хойд хэсгийн эмнэлгийн бүтээгдэхүүний лаборатори) лабораторийн нэг адил Хими болон Микробиологийн хэсэгтэй бөгөөд ижил төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

- **Химийн шинжилгээ**
  Эмнэлгийн бүтээгдэхүүний химийн шинжилгээ нь эмийн найрлагад агуулагдаж буй идэвхтэй бодис, тухайн эмд байх ёстой бодисын агууламж, эмийн тунгийн хэмжээ, хольц болон биед уусах байдал зэргийг шинжлэх боломжтой байна. Түүнчлэн бүтээгдэхүүнийг (эм, хүнсний нэмэлт тэжээл, ургамлын гаралтай бүтээгдэхүүн) олон тоогоор шинжлэх, хуурамч хольцыг илрүүлэх богино хугацааны, өндөр хүчин чадалтай шинжилгээг хийдэг байна.
- **Микробиологи**
  Тус лаборатори нь АНУ-ын эмийн стандартын аргачлалын дагуу эмнэлгийн бүтээгдэхүүнийг шинжлэх микробиологийн тусгай шинжилгээг гүйцэтгэдэг байна. Тогтмол гүйцэтгэдэг шинжилгээнд, ариутгалын шинжилгээ, эндотоксины шинжилгээ, ариутгал хийгдээгүй бүтээгдэхүүний микробиологийн шинжилгээ, бичил биетний шинжилгээ болон нянгийн эсрэг үйлчлэлийн шинжилгээ зэрэг ордог байна.

**Филадельфи лаборатори**[205]

Филадельфи лаборатори нь даралттай/нягтруулсан амьсгалын аэрозоль, хэмжсэн тун бүхий аэрозоль, хуурай-нунтаг амьсгал тэтгэх бэлдмэл болон тус бэлдмэлийг хэмжих хэмжигдэхүүн зэргийг шинжлэн тогтоох хүчин чадалтай байна. Түүнчлэн тус лаборатори нь хүний биеийн гадаргуу/арьсаар дамжуулан биед шимэгдэх эмийн шинжилгээний арга зүйг оновчтой болгохоор ажиллаж байна. ISO/IEC 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн тус лаборатори нь бусад лабораториудын нэг адил Эмийн хүчинтэй хугацааг уртасгах хөтөлбөр, Импортын эмийг шинжлэх хөтөлбөр, Эмийн судалгааны хөтөлбөр зэргийг хэрэгжүүлэн, АНУ-ын эмийн лавлах төрийн бус байгууллага (US pharmacopeia)-тай хамтарсан Судалгаа, хөгжлийн гэрээний дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байна.

**Сан Хуан Лаборатори**[206]

ISO/IEC 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн Сан Хуан эмийн лаборатори нь шахмал, капсул, тосон, уусмал болон хэмжсэн тун бүхий аэрозоль, хуурай-нунтаг амьсгал тэтгэх бэлдмэл, хамрын цацлага, хүний биеийн гадаргуу/арьсаар дамжуулан биед шимэгдэх эм зэрэг олон төрлийн эм, эмийн бүтээгдэхүүнийг шинжлэх хүчин чадалтай байна. АНУ-ын эмийн лавлах ТББ-тай хамтран ажиллахаас гадна хэрэглэгчдийн гомдлын дагуу, түүнчлэн Эмийн хүчинтэй хугацааг уртасгах хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хугацаа нь дууссан болон дуусах дөхсөн эм, эмийн бүтээгдэхүүнийг шинжилдэг байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 2.5. ДАНИ

Дани Улсад хүний болон мал эмнэлгийн хэрэгцээнд зориулагдсан эм, түүний дотор биологийн эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтыг Эрүүл мэндийн яамны харьяа Данийн эмийн агентлаг (Danish Medicines Agency) хариуцан ажилладаг. Тус агентлаг нь улсын хэмжээнд

[204] https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories/pacific-southwest-medical-products-laboratory-psmpl
[205] https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories/philadelphia-laboratory-phil
[206] https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories/san-juan-laboratory-sjnl

эмтэй холбоотой аливаа зөвшөөрөл, лиценз олгох, эмнэлзүйн туршилтыг батлах, олгосон зөвшөөрөл, эм зүй, эмийн зар сурталчилгаанд хяналт тавих, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх, хууль бус эм, эмийн бүтээгдэхүүнийг хураан авах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

Данийн эмийн агентлаг нь эмийн бүтээгдэхүүний чанар, стандартыг шинжлэх албан ёсны лаборатори (Laboratory)-той. Тус лаборатори нь биологи, химичи, микробиологийн шинжилгээ болон ионжуулагч цацраг, радиохимийн шинжилгээ хийдэг.

Дани Улс нь Европын эмийн агентлагийн гишүүн орон бөгөөд олон улсын “Сайн лабораторийн туршлага” (Good laboratory practice-GLP)-ын чанар стандартыг баримтлан ажилладаг орнуудын нэг юм. Тиймээс эдгээр үйл ажиллагааг явуулахдаа дотоодын хууль, дүрэм журмыг мөрдөхөөс гадна Европын эмийн чанар, стандартыг тодорхойлдог стандарт, дүрэм журмыг баримталдаг бөгөөд Европын холбооны зах зээлд хууль ёсны дагуу худалдаанд гарсан бүтээгдэхүүнийг зэрэгцээ импортлох, зэрэгцээ түгээх боломжтой.

**Хууль, эрх зүйн орчин**

Дани Улсад эм үйлдвэрлэл, худалдах, эмийн чанар стандартыг тогтоох, хяналт тавих, зөвшөөрөл олгох зэрэг харилцааг дараах хууль тогтоомжуудаар зохицуулж байна. Үүнд:

- Эмийн тухай хууль, 1975 (The Medicines Act)[207]
- Эрүүл мэндийн тухай хууль, 2005 (Health Act)
- Эмийн бүтээгдэхүүний эмнэлзүйн туршилтын тухай хууль, 2016 (Act on Clinical Trials of Medicinal Products)[208]

Мөн Европын эмийн агентлагаас баталсан дараах журмуудыг баримталдаг.

- Эмийн бүтээгдэхүүний зөвшөөрөл, хяналтын Европын эмийн агентлаг байгуулах тухай журам, (Regulation (EC) 726/2004 on the authorisation and supervision of medicinal products and establishing a European Medicines Agency)
- Хүүхдэд зориулсан эмийн бүтээгдэхүүний тухай журам, (Regulation (EC) 1901/2006 on medicinal products for paediatric use)
- Амьтанд зориулсан эмийн бүтээгдэхүүний журам, (141/2000 on orphan medicinal products, and Regulation (EC))
- Дэвшилтэт эмчилгээний эмийн бүтээгдэхүүний тухай журам, (1394/2007 on advanced therapy medicinal products)

***Эмийн тухай хууль:*** Энэ хуулиар иргэдийг өндөр чанартай, аюулгүй, үр дүнтэй эмээр хангах, эмийн талаар бодитой, хангалттай мэдээлэл авах болон эм бэлдмэлийг төөрөгдүүлсэн сурталчилгаа, түүнчлэн хууль бус сурталчилгаанаас хамгаалах зорилготой бөгөөд хүн, амьтанд зориулсан эмийн бүтээгдэхүүнийг хамаарна.

***Эрүүл мэндийн тухай хууль:*** Энэ хуулиар өвчтөний эрх зүйн байдал, сэхээн амьдруулах, эмнэлгийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх талаар, эм, эмнэлгийн тусламж үйлчилгээний хөнгөлөлт болон төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг, хариуцлагын талаар зохицуулсан.

***Эмийн бүтээгдэхүүний эмнэлзүйн туршилтын тухай хууль:*** Энэ хуулиар хүн, амьтанд хийсэн эмнэлзүйн туршилтыг Данийн эмийн агентлаг, эмийн судалгааны ёс зүйн хороод үнэлж, хянах асуудлыг зохицуулдаг.

[207] https://wipolex-res.wipo.int/edocs/lexdocs/laws/en/dk/dk158en.html
[208] https://www.dataguidance.com/sites/default/files/danish_act_on_clinical_trials_of_medicinal_products_en.pdf



UIH.MN СУДАЛГААНЫ САН

Тус улс нь эмийн зөвшөөрөл олгохоос өмнө чанар, аюулгүй байдал, үр дүнгийн талаарх маш нарийн шаардлага хангасан байхыг шаарддаг. Аливаа эмийг Дани Улсад худалдан борлуулахын өмнө Данийн эмийн агентлаг, эсхүл Европын комиссоос зөвшөөрөл авсан байх ёстой. Өөрөөр хэлбэл, компаниуд маркетингийн зөвшөөрөл авах бөгөөд дараах 4 аргаар гаргана. Үүнд:

- Үндэсний журам (уг эм зөвхөн Европын холбоо, эсхүл Европын эдийн засгийн бүсийн гишүүн орнууд (EEA)-ын аль нэг улсад зөвшөөрдөг)
- Төвлөрсөн журам (Энэ эм нь Европын холбооны бүх оронд нэгэн зэрэг зөвшөөрөгдсөн. Энэ аргыг Европын эмийн агентлаг хариуцдаг)
- Төвлөрсөн бус журам (Компаниуд ЕХ, эсхүл ЕЭЗБ-ийн хэд хэдэн оронд нэгэн зэрэг зөвшөөрөл авах хүсэлт гаргадаг)
- Харилцан хүлээн зөвшөөрөх журам (ЕХ, эсвэл ЕЭЗБ-ийн нэг улсад эмийн үндэсний маркетингийн зөвшөөрөл нь ЕХ, эсвэл ЕЭЗБ-ийн бусад улсад зөвшөөрлийн үндэс болдог)

***Данийн эмийн агенлаг (***Danish Medicines Agency (DMA))

Эрүүл мэндийн яамны харьяа Данийн Эмийн агентлаг нь эмийн компаниудаас шинэ эм нийлүүлэхээр гаргасан хүсэлтийг үнэлэх, тухайн эмийг олон нийтэд хүргэх боломжтой эсэхийг шалгадаг. Тус улс нь Европын эмийн агентлаг (EMA)[209]-д мэргэжилтнүүдээ оруулдаг бөгөөд энэ нь Дани зэрэг Европын холбооны бүх гишүүн орнуудад худалдаалах эмийн зөвшөөрөл олгох өргөдлийг үнэлдэг. Данийн эмийн агентлаг, эсхүл EMA-д эмийн бүтээгдэхүүний талаарх мэдээлэл хүргүүлсний дараа нарийн мэргэжлийн эмч, эм зүйч болон бусад мэргэжилтнүүдээс бүрдсэн баг компанийн баримт бичиг болон хэрэглэгчийн мэдээллийг хянадаг.

Данийн Эмийн агентлаг нь эмийн компаниуд болон бусад дистрибьютерүүдэд зөвшөөрөл олгох, шалгах, эмнэлзүйн туршилт хийх зөвшөөрөл олгох, эмийн бүтээгдэхүүнд зөвшөөрөл олгох, эмийн бүтээгдэхүүн нөхөн төлбөр авах боломжтой эсэхийг шийдэх, сөрөг нөлөөний тайланд хяналт тавих, эмнэлгийн хэрэгсэлд хяналт тавих үүрэгтэй.

Эмийн тухай хууль нь Данийн эмийн агентлагаас гаргасан олон тооны гүйцэтгэх тушаал, удирдамжаар хэрэгждэг. Түүнчлэн, Дани Улс нь Европын холбооны гишүүн орны хувьд Европын холбооноос гаргасан дүрэм, журмыг дагаж мөрдөх шаардлагатай.

Тус агентлаг нь 500 ажилтантай бөгөөд эм зүйч, захиргааны туслах ажилтан, эмч, хуульч, нийгмийн ухааны магиструуд гэсэн таван том мэргэжлийн багаас бүрддэг.
Агентлаг нь дараах ажлуудыг хариуцдаг. Үүнд:

- Үндэсний болон төвлөрсөн бус журмын дагуу шинэ эмүүдэд маркетингийн зөвшөөрөл олгох;
- Үйлдвэрлэх, импортлох, түгээх зөвшөөрөл олгох;
- Нөхөн төлбөрийн шийдвэр гаргах;
- Эмнэлзүйн туршилтыг батлах;
- Бүх олгосон зөвшөөрөл, эм зүйн удирдлагад хяналт тавих;
- Эмийн талаарх сурталчилгааны үйл ажиллагаанд хяналт тавих;

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Мөн бүтээгдэхүүний зөвшөөрөл авсны дараа тэдгээр бүтээгдэхүүний талаарх мэдээллийг баталдаг. Бүтээгдэхүүний мэдээлэл нь дараах хэсгээс бүрдэнэ.

- Эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд зориулсан бүтээгдэхүүний шинж чанарын хураангуй;

[209] **E**MA (European Medicines Agency)

- Эм хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл;
- Шошго (эмийн талаарх бүтээгдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл).

Тус агентлаг нь Эмийн тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Хяналт шалгалт хийх (төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус);
- Эм, бүтээгдэхүүний дээж шаардах, эсхүл авах;
- Тодорхой нэг байгууллага, ажлын зохион байгуулалт болон үйл ажиллагааны удирдлагыг өөрчлөх;
- Хууль бус байж болзошгүй үндэслэл бүхий эм, бүтээгдэхүүнийг хураан авах.

Эмийн агентлаг нь 14-өөс доошгүй хоногийн өмнө хяналт шалгалтын талаар мэдэгдэх боловч урьдчилан мэдэгдэлгүйгээр шалгалт явуулж болно. Хяналт шалгалтын явцад агентлаг нь эмийн чанар, дүрэм журам, ажлын явцыг холбогдох журмын дагуу хянан шалгах бөгөөд шалгалтын дараа тайлан гаргана. Зөрчлийн хэр хэмжээ, түүний дотор өвчтөний аюулгүй байдалд үзүүлэх хор нөлөө зэргээс шалтгаалан агентлаг торгууль ногдуулах, зах зээлээс эмийг эргүүлэн татах, зөвшөөрлийг түдгэлзүүлэх зэрэг саналыг холбогдох байгууллагад санал болгож болно.

***Данийн эмийн агентлагийн лаборатори***

Тус лаборатори нь эмийн компаниудын эм, эмийн бүтээгдэхүүнд тавьж буй хяналтыг шалгах зорилгоор компаниудын хийсэн дүн шинжилгээгээр илрүүлээгүй аливаа асуудлыг илрүүлэх шаардлагын дагуу нэмэлт шинжилгээ хийж болно. Данийн Эмийн агентлагийн лаборатори нь өөрийн шинжилгээнд чанарын маш хатуу шаардлага тавьдаг бөгөөд ISO 17025 стандартаар итгэмжлэгдсэн байдаг. Тус лаборатори нь эмийн чанарыг хянадаг Европын албан ёсны эмийн хяналтын лабораторийн (OMCL) сүлжээний гишүүн юм.

Энэхүү лаборатори нь Агентлагийн даргын шууд удирдлага дор Хяналт, эмнэлгийн тоног төхөөрөмж, хүртээмжийн төвийн Нийлүүлэлтийн хяналт, аюулгүй байдлын хэлтэст харьяалагддаг.

*Данийн эмийн агентлагийн бүтцээс*[210]




Тус лаборатори нь DS/EN ISO/IEC 17025 стандартын дагуу 2011 онд анх магадлан итгэмжлэгдсэн. Магадлан итгэмжлэлийг “Данийн игэмжлэл, хэмжил зүйн сан” (Danish

[210] https://laegemiddelstyrelsen.dk/en/about/organisation/

Accreditation and Metrology Fund) олгодог. Өөрөөр хэлбэл, лаборатори нь эм бэлдмэлийн шинжилгээг тогтоосон зааврын дагуу хийж, лабораторийн хяналтыг Данийн итгэмжлэл, хэмжил зүйн сан хийдэг байна. Тус лаборатори нь биологи, хими, микробиологийн шинжилгээ болон ионжуулагч цацраг, радиохимийн шинжилгээ хийдэг.

Энэхүү лаборатори нь хэлтсийн дарга 1, багийн ахлагч 2, эрдэм шинжилгээний ажилтан 14, 11 лабораторийн техникч, нарийн бичиг болон дэмжлэг үзүүлэх 3 ажилтан, нийт 31 ажилтнаас бүрддэг. [211]

*Хүснэгт 11. Эмийн бүтээгдэхүүн болон API[212]-ийн туршилт хийсэн тоо*

| Он | 2015 | 2016 | 2017 | 2019 | 2020 |
|---|---|---|---|---|---|
| **Жилийн тоо** | 279 | 266 | 265 | 158 | 201 |

<u>*Европын лабораторийн хамтын ажиллагаа:*</u> Европ дахь эмнэлгийн байгууллагууд албан ёсны эмийн хяналтын лаборатори (OMCL)-ийн сүлжээтэй хамтран ажилладаг. Тус сүлжээний зорилго нь мэдлэг, туршлага солилцох, эмийн бүтээгдэхүүний лабораторийн хяналтын чиглэлээр шинэ нийтлэг стандартуудыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх явдал юм.

***Данийн эмийн зөвлөл (Danish Medicines Council (DMC)):*** Энэхүү зөвлөл нь Данийн эмнэлгийн салбарт хэрэглэх шинэ эмийн талаар зааварчилгаа өгөх, тодорхой өвчтэй өвчтөнд хэрэглэх эмийн нэн тэргүүний жагсаалт бүхий зөвлөмж өгөх асуудлыг хариуцсан бие даасан зөвлөл юм.

***Эмийн үйлдвэрийн Ёс зүйн хороо (ENLI)*** нь Данийн Эмийн Холбооноос байгуулсан өөрийгөө зохицуулах байгууллага бөгөөд эмийн компаниудын үйл ажиллагаа нь Данийн хууль тогтоомж, салбарын ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөж буй эсэхэд хяналт тавьдаг. ENLI нь энэ чиглэлээр илүү хатуу, нарийвчилсан дүрмийг (жишээлбэл, бэлэг өгөхийг бүхэлд нь хориглох) тогтоодог.

***Данийн эмийн хяналтын зөвлөл***[213] нь дээд тал нь 11 гишүүнээс бүрддэг. Данийн Эмийн агентлаг Данийн эмийн хяналтын зөвлөлийн гишүүдийг олон нийтэд зарласны дагуу томилдог бөгөөд зөвлөлийн гишүүнд хэн ч нэрээ дэвшүүлэх боломжтой. Энэхүү зөвлөл нь эмийн гаж нөлөө, бусад эрсдэлийн талаар Данийн эмийн агентлагт зөвлөгөө өгдөг бөгөөд дараах чиг үүрэгтэй. Үүнд:

- Гаж нөлөөний тайланг цуглуулах үйл явцыг хэрхэн зохион байгуулах талаар Данийн Эмийн агентлагт зөвлөмж өгөх, гаж нөлөөний талаарх мэдлэгийг ашиглах;
- эм хэрэглэгчдэд эмийн гаж нөлөөний мэдээллийн талаар Данийн Эмийн агентлагт зөвлөмж гаргах;
- эмийн гаж нөлөөнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийн талаар Данийн Эмийн агентлагт зөвлөмж өгөх.

Мөн Данийн Эмийн агентлагт хуурамч эмийн тархалттай тэмцэх тодорхой санаачилга гаргахыг зөвлөж болно.

***Данийн эмийн агентлагийн эмийн хяналтын лабораторийн үйл ажиллагааны төлбөр***

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[211] Danish Medicines agence-annual OMCL report, 2019-2020 https://laegemiddelstyrelsen.dk/da/nyheder/senest-opdaterede-indhold/~/media/3BD7D043F46A4A8686106C4FB0A45297.ashx
[212] Active pharmaceutical ingredients
[213] https://laegemiddelstyrelsen.dk/en/sideeffects/pharmacovigilance-council/

Данийн эмийн агентлаг нь төрийн байгууллага хэдий ч үйл ажиллагааны зардлаа өөрөө санхүүжүүлдэг байна. Өөрөөр хэлбэл, тус агентлагаас үзүүлж буй үйлчилгээний төлбөр, хураамж (эмийн зөвшөөрөл авах хураамж, лабораторийн хяналт, шалгалт, эмийн гаж нөлөө зэрэгтэй холбоотой хяналтын зардал)-аар санхүүждэг. Тус агентлагийн мөрдөж буй үйл ажиллагааны үнийн тариф:[214]

**Эмийн бүтээгдэхүүн**

*Хүснэгт 12. Шинэ маркетингийн зөвшөөрөл болон компанийн бүртгэлийн хураамжийн тойм (2022):*

| **Бүтээгдэхүүний төрөл** | **Журам** | **Хязгаарлалт** | **Төлбөр (дкк)** |
|---|---|---|---|
| Энгийн эмийн бүтээгдэхүүн (мөн витамин, эрдэс бодис) | Үндэсний | Бүрэн баримтжуулсан өргөдөл | 196,559 |
| | Төвлөрсөн бус | Бүрэн баримтжуулсан өргөдөл | 273,346 |
| | Бие биенээ хүлээн зөвшөөрөх | Шинэ маркетингийн зөвшөөрөл авах өргөдөл | 28,096 |
| Байгалийн гаралтай эмийн бүтээгдэхүүн (мөн ургамлын гаралтай эм) | Үндэсний | | 83,605 |
| | Төвлөрсөн бус | | 97,029 |
| | Бие биенээ хүлээн зөвшөөрөх | | 26,904 |

*Хүснэгт 13. Компанид зөвшөөрөл олгох, бүртгүүлэх өргөдлийн хураамж*

| **Компанийн зөвшөөрөл, бүртгэл** | **Өргөдлийн хураамж (DKK)** | **Жилийн хураамж (DKK)** |
|---|---|---|
| Эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох зөвшөөрөл | 50,350 | 50,350 |
| Бөөний худалдаа эрхлэх зөвшөөрөл | 15,538 | 15,538 |
| ОТС эмийн бүтээгдэхүүнийг жижиглэн худалдаалах зөвшөөрөл | 950 | 950 |
| Үйлдвэрлэлийн малын эмийн бүтээгдэхүүнийг жижиглэн худалдаалах зөвшөөрөл | 48,425 | борлуулагчийн нийт борлуулалтын 0.065% |

**Эмнэлгийн хэрэгсэл**

Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэдэг, импортолдог, түгээдэг компаниуд (түүнчлэн ЕХ-ны төлөөлөгч болон эмнэлгийн хэрэгслийн чиглэлээр мэргэшсэн дэлгүүрүүд) хоёр төрлийн хураамжтай.

- Үйлдвэрлэгчид болон итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн бүртгэлийн хураамж: 1.188 DKK
- Импортлогч болон дистрибьютерийн бүртгэлийн хураамж: 1192 канад долларын

Бүртгэлийн хураамжаас гадна жилийн хоёр удаагийн хураамжийг мөн авна. Эдгээр жилийн төлбөр нь тухайн компанийн ажилчдын тооноос хамаарна.

## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЭМИЙН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИ, ЭМИЙН ЧАНАР, СТАНДАРТЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хууль, эрх зүйн орчин**

Эм, эмийн хяналтын лабораторийн талаар "Монгол Улсын Үндсэн Хууль"[215]-ийн 16 дугаар зүйлийн 2 болон 6-д Монгол Улсын иргэн эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ

[214] https://laegemiddelstyrelsen.dk/en/licensing/fees/~/media/A5C15A5D14D24EB7845111BEA6B2AD1E.ashx
[215] МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ (legalinfo.mn)https://legalinfo.mn/mn/detail/85

хамгаалуулах эрхтэй гэж заасанаас эхлээд Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2010)[216], Эрүүл мэндийн тухай хууль (2011)[217] зэрэг хуулиуд байна. Мөн Засгийн газрын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого (зорилт 2.2. Эрүүл мэнд)[218], Төрөөс эмийн талаар баримтлах бодлого (2014)[219], Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого (2017)[220] зэрэг төрөөс баримтлах бодлогуудыг баталсан.

Дээрх хууль, тогтоомжуудаас гадна Эрүүл мэндийн сайдын:

- Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг (2013 №А/145);[221]
- Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн мэдээлэх журам (2013, №415);[222]
- Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмжинд шалгалт, тохируулга хийх аргачлал (2018, №345)[223]... зэрэг журмууд;

  Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар[224]-ын даргын:
- Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт бүртгэх, эрх түдгэлзүүлэх тухай (2022 №А/228);[225]
- Эмнэлгйин хэрэгсэлд олгох импорт, экспортын лицензийг цахимаар хүлээн авах үйл ажиллагааг эхлүүлэх тухай (2022 №А/191);[226]
- Фармакопей боловсруулах, батлах болон фармакопейн хорооны ажиллах журмыг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн батлах тухай (2022 №А/205);[227]
- Эм, биобэлдмэлийн үйлдвэрүүдэд GMP шаардлагын хэрэгжилтийн үнэлгээ хийх тухай” (2022 №А/127)[228] ... зэрэг тушаал, журмууд үйлчилж байна.

**Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар (ЭЭХХЗГ)**

Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны харьяа Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар (ЭЭХХЗГ) нь 2021 онд байгуулагдсан бөгөөд эмчилгээ оношилгооны идэвхтэй, аюулгүй, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслийг хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, хүн эмнэлэг, мал эмнэлэг мөн хүн амыг шаардлагатай эмээр хангах нөхцөл бүрдүүлэх, эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж, эм, эмнэлгийн бүтээгдэхүүний зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилготой байна.

Тус газар нь Чанарын хяналтын газар, Захиргаа удирдлагын газар, Лиценз зөвшөөрлийн зохицуулалтын газар, Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар, Эм хангамжийн

[216] ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ (legalinfo.mn)
[217] Эрүүл мэндийн тухай хууль, https://legalinfo.mn/mn/detail/49
[218] Алсын хараа-2050 урт хугацааны бодлогын баримт бичиг, https://legalinfo.mn/mn/detail?lawId=211057&showType=1
[219] Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, https://moh.gov.mn/uploads/files/d30366ffb7ffb6922091690377c80e44.pdf
[220] Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодого, https://health.acc.hdc.gov.mn/main/detail/16306567978033?type=act
[221] Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт, бичиг (mmra.gov.mn)
[222] Эмийн гаж нөлөө болон аюулгүй байдлын мэдээллийг бүртгэн мэдээлэх журам батлах тухай https://legalinfo.mn/mn/detail/10638/2/206527
[223] Эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмжинд шалгалт, тохируулга хийх аргачлал (mmra.gov.mn)
[224] ЭЭХХЗГ-Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар https://mmra.gov.mn/
[225] А228- Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт бүртгэх, түдгэлзүүлэх тухай А/228 (mmra.gov.mn)
[226] Эм, эмнэлгийн хэрэгсэлд олгох импорт, экспортын лицензийн хүсэлтийг цахимаар хүлээн авах үйл ажиллагааг эхлүүлэх тухай А/191 (mmra.gov.mn)
[227] Фармакопей боловсруулах, батлах болон фармакопейн хорооны ажиллах журмыг боловсруулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулах тухай А/205 (mmra.gov.mn)
[228] Эм, биобэлдмэлийн үйлдвэрүүдэд GMP шаардлагын хэрэгжилтийн үнэлгээ хийх тухай А/127 (mmra.gov.mn)

UIH.MN СУДАЛГААНЫ САН

газар, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар, Эм шинжлэх лаборатори гэсэн 7 салбар нэгжээс бүрддэг нийтдээ 132 ажилтантай.

Яамны төсвөөс жилд ойролцоогоор 4.4 тэрбум төгрөгийг тус газрын урсгал зардал болох ажилчдын цалин, урамшуулал, бараа үйлчилгээний зардлуудыг багтаан зарцуулахаар төсөвлөдөг байна.

*Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бүтэц, зохион байгуулалт*




**Эмийн хяналтын лаборатори**

Эмийн хяналтын лаборатори нь Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа, лабораторийн харьяанд бусад (Нян судлалын лаборатори, Хими, хор судлалын лаборатори, Цацрагийн хяналтын лаборатори, Таримал ургамлын үр, хорио цээрийн лаборатори) лабораториудын хамт харьялагдаж байна.

Эмийн хяналтын лаборатори нь шинжлэх ухааны хамгийн орчин үеийн аргуудыг ашиглан эмийн хими, микробиологи, эм зүйн шинжилгээг гүйцэтгэх замаар эмийн чанарын баталгааг гаргаж, хүн амыг чанартай, үр дүнтэй, аюулгүй эмээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

Түүхэн замнал:

- 1965 он Ардын Эрүүлийг Хамгаалах Яамны Эм шалгах лаборатори
- 1989 он ЭХЯ-ны Эм биобэлдмэлийн улсын хяналтын төв лаборатори
- 1994 он ЭМЯ-ны Эм биобэлдмэлийн хяналтын төвийн Эм биобэлдмэлийн улсын хяналтын төв лаборатори
- 1996 он ЭМЯ-ны Эм биобэлдмэл, эмчилгээний чанарын хяналтын албаны Эм биобэлдмэлийн хяналтын лаборатори
- 2001 он ЭМЯ-ны Эрүүл мэндийн хяналтын албаны Эм биобэлдмэлийн хяналтын лаборатори
- 2003 он УМХГ-ын Нэгдсэн төв лабораторийн Эм биобэлдмэлийн лаборатори
- 2015 он МХЕГ-ын ХАБҮЛЛ-ийн Эмийн хяналтын лаборатори

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн бүтцийн бүдүүвч*




### Эмийн чанарын хяналтын лабораторид тавигдах шаардлага

Монгол Улсад эмийн чанарын стандартын лабораторид тавигдах шаардлагыг Стандартчиллын зөвлөлийн 2016 оны 44-р тогтоолоор баталсан **“Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага**”[229] стандартаар зохицуулдаг.

Энэхүү стандарт нь ISO 9001, ISO 17025 стандартын шаардлагад нийцүүлэн эмийн хяналтын лабораторийн үйл ажиллагаанд тавих нарийвчилсан шаардлагыг тогтоох зорилготой бөгөөд эмийн чанарын лабораторийн бүтэц, зохион байгуулалт, чанарын удирдлагын тогтолцоо, боловсон хүчин, ажлын байр, тоног төхөөрөмж, урвалж материал, тэдгээрийн баримтжуулалтын шаардлагыг тогтоох зорилготой. Эмийн чанарын хяналтын лабораторийн шинжилгээнд дээж хүлээн авах, хуваарилах, шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, тайлагнах үйл ажиллагаанд мөрддөг байна.

### Эмийн хяналтын лабораторид хийх шинжилгээний үнэ

Эмийн хяналтын лабораторид хийх шинжилгээний үнэ, тарифын талаар Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 253 дугаар “Хэмжилт, шинжилгээ халдваргүйжүүлэлтийн үнийг батлах тухай”[230] тушаалын 3 дугаар хавсралтаар[231] баталсан байна. Үүнд:

- Эм, эмийн түүхийн эдийн шинжилгээ
    - Галены бэлдмэл
    - Капсултай эм
    - Лаа эм

[229] Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага https://estandard.gov.mn/standard/reader/4361
[230] Хэмжилт, шинжилгээ, халдаргүйжүүлэлтийн үнийг батлах тухай https://legalinfo.mn/mn/detail?lawId=14741
[231] Эмийн хяналтын лабораторид хийх шинжилгээний үнэ https://legalinfo.mn/mn/detail?lawId=14741

UIH.MN СУДАЛГААНЫ САН

  - Нүд, чих, хамрын дусал, төрөл бүрийн шингэн эмүүд
  - Сироп эм
  - Тарилгын шингэн
  - Тосон түрхлэг, тосон бэлдмэл
  - Тун шилтэй эм
  - Үрэл эм
  - Шахмал эм
  - Флакон эм, антибиотик
  - Эмийн түүхий эд /эмийн үндсэн үйлчлэгч ба туслах бодис/
  - Эмийн санд бэлтгэгдсэн нийлмэл нунтаг эм
  - Эмийн санд бэлтгэсэн усан эм
- Ороох боох материал, эмнэлгийн хэрэгсэл
  - Ороох боох материал
  - Эмнэлгийн жижиг багаж хэрэгсэл, сав баглаа боодол
- Уламжлалт эм, эмийн ургамлын шинжилгээ
  - Уламжлалт тан, талх, үрэл эм
  - Ургамал, эрдэс, амьтны гаралтай түүхий эд
- Чанарын шинжилгээ-таних урвал
- Тооны шинжилгээ
- Микробиологи, биологийн шинжилгээ… зэрэг нийт 6 үндсэн бүлгийн 515 нэр төрлийн эм, эмнэлгийн бүтээгдэхүүний шинжилгээний үнийг тогтоожээ.

*Хавсралтад дэлгэрэнгүй байдлаар оруулав.*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

- https://www.paho.org/hq/dmdocuments/2011/Ingles.pdf

МАЛАЙЗ

- Malaysian National medicines Policy file:///Users/uurtsaikh/Desktop/malaysian-national-medicines-policy-3rd-edition-2017-2021.pdf
- Sale of Drugs Act 1952 https://leap.unep.org/countries/my/national-legislation/sale-drugs-act-1952-act-368
- Dangerous Drugs Act 1952 http://www.paclii.org/pg/legis/consol_act/dda1952180/
- Poisons Act 1952 http://www.commonlii.org/my/legis/consol_act/pa19521989196/
- Medicines (Advertisement&Sale) Act https://www.pharmacy.gov.my/v2/en/documents/medicines-advertisement-sale-act-1956-and-regulations.html
- Control of Drugs and Cosmetics Regulations https://www.yumpu.com/en/document/view/36236491/control-of-drugs-and-cosmetics-regulations-1984-revised-2009
- Registration of Pharmacists Act https://www.pharmacy.gov.my/v2/en/documents/registration-pharmacists-act-1951-and-regulations.html
- The Pharmacy Services Programme https://www.pharmacy.gov.my/v2/en/content/about-us.html
- National Pharmaceutical Regulatory Agency NPRA https://www.npra.gov.my/index.php/en/
- QUEST3+ https://www.npra.gov.my/index.php/en/regulation-basic.html
- Allied Chemists Laboratory Sdn Bhd https://alliedchemists.com.my/company/laboratory-in-johor-bahru/

ПАКИСТАН

- Medicines Act https://www.fimea.fi/documents/160140/765540/18580_Laakelaki_englanniksi_paivitetty_5_2011.pdf
- Health Insurance Act https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/2004/en20041224_20110911.pdf
- Pharmaceuticals Pricing board https://www.hila.fi/en/operations-and-organisation/#PharmaceuticalsPricingBoard
- Анхан шатны эмийн нөхөн олговор https://www.kela.fi/laakkeet#alkuomavastuu
- 10 Тусгай эмийн нөхөн олговор https://finlex.fi/fi/laki/ajantasa/2013/20130025
- https://en.wikipedia.org/wiki/Pakistan
- https://tradingeconomics.com/pakistan/gdp-per-capita
- https://statisticstimes.com/demographics/country/pakistan-population.php
- https://www.pacra.com/sector_research/PACRA%20Research%20-%20Pharmaceutical%20-%20May%2721.pdf
- https://data.worldbank.org/indicator/SH.XPD.CHEX.PP.CD?locations=PKhttps://data.worldbank.org/indicator/SH.XPD.GHED.GD.ZS?locations=PK
- https://www.dra.gov.pk/wp-content/uploads/2022/10/Drugs-Act-1976.pdf
- https://www.dra.gov.pk/wp-content/uploads/2022/10/DRAP-2012-_As-Amended-till-Feb-2022.pdf


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC6737614/
- https://www.dra.gov.pk/about-us/organization/organogram/
- https://www.dra.gov.pk/therapeutic-goods/quality-controls-labs/central-drugs-laboratory/
- https://www.dra.gov.pk/therapeutic-goods/quality-controls-labs/national-control-laboratories-for-biologicals/
- https://www.pnac.gov.pk/TestingCalibrationLaboratoies
- https://extranet.who.int/pqweb/medicines/information/quality-control-laboratories
- https://www.dra.gov.pk/wp-content/uploads/2022/01/Fee-for-regulatory-operations.pdf
- https://www.forbes.com/advisor/money-transfer/currency-converter/usd-pkr/

ФИНЛАНД

- https://www.fimea.fi/documents/160140/9269353/Fimea_Laboratory_MJA+Scope+2015/9b9d976a-edaa-86d7-470c-39a1cd848ee5
- https://www.fimea.fi/web/en/about_us/organisation
- https://www.fimea.fi/documents/542809/841791/Price+list+for+services+priced+according+to+commercial+criteria+2022.pdf/ed7324c4-7444-dccb-923f-32c5abfe70fd?t=1652861105622
- https://ca.practicallaw.thomsonreuters.com/3-500-4529?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true
- https://www.fimea.fi/web/en/-/the-new-decree-on-fees-chargeable-by-the-finnish-medicines-agency-entering-into-force-on-1-september-2022
- https://www.finlex.fi/fi/laki/ajantasa/1992/19920150#L2P4-Төрийн үндсэн төлбөрийн тухай хууль
- https://www.fimea.fi/web/en/supervision/the-laboratory-of-fimea
- Decree of the Ministry of Social Affairs and Health on fees chargeable by the Finnish Medicines Agency 798/2022 https://www.fimea.fi/documents/542809/841791/Maksuasetus+798_2022_EN_final_12102022.pdf/d6960ae1-96c4-03de-77c8-a06803d95da5?t=1665565952582

АНУ

- FDA User Fee Programs https://www.fda.gov/industry/fda-user-fee-programs
- Drug Quality Sampling and Testing Programs https://www.fda.gov/drugs/science-and-research-drugs/drug-quality-sampling-and-testing-programs
- Generic Drug User Fee rates https://www.federalregister.gov/documents/2022/10/12/2022-22099/generic-drug-user-fee-rates-for-fiscal-year-2023
- FDA Drug approval process https://www.fda.gov/drugs/information-consumers-and-patients-drugs/fdas-drug-review-process-continued
- Prescription Drug User Fee Act https://phrma.org/policy-issues/Research-and-Development/PDUFA
- Prescription Drug User Fee https://www.fda.gov/drugs/guidances-drugs/drug-master-files-guidelines
- Biosimilar User Fee Act https://www.fda.gov/media/157299/download
- Generic Drug User Fee rates https://www.federalregister.gov/documents/2022/10/12/2022-22099/generic-drug-user-fee-rates-for-fiscal-year-2023
- Drug Master Files https://www.fda.gov/drugs/guidances-drugs/drug-master-files-


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- Field Science and Laboratories https://www.fda.gov/science-research/field-science-and-laboratories

ДАНИ

- Danish medicines agency, Annual OMCL report 2019-2020 https://laegemiddelstyrelsen.dk/da/nyheder/senest-opdaterede-indhold/~/media/3BD7D043F46A4A8686106C4FB0A45297.ashx
- Danish medicines agency, Annual OMCL report 2015-2017
- https://laegemiddelstyrelsen.dk/en/licensing/supervision-and-inspection/medicines-control/european-laboratory-cooperation/
- https://laegemiddelstyrelsen.dk/en/licensing/fees/
- https://www.healthcaredenmark.dk/media/ykedbhsl/healthcare-dk.pdf
- https://legemiddelverket.no/Documents/English/Public%20funding%20and%20pricing/Documentation%20for%20STA/Guidelines%20151018.pdf
- https://pharmaboardroom.com/legal-articles/regulatory-pricing-and-reimbursement-denmark/
- https://www.sundhedsstyrelsen.dk/en/English/Expertise-and-guidance
- https://wipolex-res.wipo.int/edocs/lexdocs/laws/en/dk/dk158en.html
- https://pharmaboardroom.com/legal-articles/regulatory-pricing-and-reimbursement-denmark/
- https://uk.practicallaw.thomsonreuters.com/5-618-0667?originationContext=document&transitionType=DocumentItem&contextData=(sc.Default)&ppcid=92b8ab45e860445584b129fc66dc0c96
- https://uk.practicallaw.thomsonreuters.com/6-500-5513?transitionType=Default&contextData=(sc.Default)&firstPage=true#co_anchor_a250593
- https://pharmaboardroom.com/legal-articles/regulatory-pricing-and-reimbursement-denmark/


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ХАВСРАЛТ

Сангийн сайдын 2018 оны 11
сарын 02-ны өдрийн 253 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

## ЭМИЙН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИД ХИЙХ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНЭ

| № | Шинжлэх үзүүлэлт | Нэг сорьцонд хийгдэх үнэлгээ /төгрөг/ |
|---|---|---|
| 1.Эм, эмийн түүхий эдийн шинжилгээ | | |
| 1.1 Галены бэлдмэл | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвал-тус бүрд/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дүүргэлт | 1000 |
| | Хувийн жин | 1000 |
| | Спиртийн хэмжээ | 5000 |
| | Хуурай үлдэгдэл | 5000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга-элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт: Флавонойд тодорхойлох | 7000 |
| | Тооны тодорхойлолт: Алкалойд тодорхойлох | 40000 |
| | Тооны тодорхойлолт: Сапонин тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Аргаах бодис тодорхойлох | 10000 |
| | Тооны тодорхойлолт: Кумарин тодорхойлох | 30000 |
| | Тооны тодорхойлолт: Антрогликозид тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Эфирийн тос тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Арбутин тодорхойлох | 20000 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli/* | 7000 |
| | Энтеробактерийн бүлгийн нян тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Salmonella species* | 7000 |
| Капсултай эм | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвал-тус бүрд/ | 5000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дундаж жин, жингийн хэлбэлзэл | 1500 |
| | Задралт | 2500 |
| | Уусалт /СФМ-ийн аргаар/ | 18500 |
| | Уусалт /ӨИШХ-ийн аргаар/ | 75000 |
| | Тугналт /СФМ-ийн аргаар/ | 20000 |
| | Тугналт /ӨИШХ-ийн аргаар/ | 70000 |
| | Жингийн алдагдал | 5000 |
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн ээзлхүүний арга/ | 30000 |
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн кондуктометрийн арга/ | 40000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга-элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli*/ | 7000 |
| 1.3 | Лаа эм | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвал-тус бүрд/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дундаж жин, жингийн хэлбэлзэл | 1500 |
| | Задралт | 2500 |
| | Геометрийн хэмжээсүүд: урт,өргөн, зузаан гм | 1000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Агаартан бактерийн тоо  тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli*/ | 7000 |
| | Энтеробактерийн бүлгийн нян тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | Staphylococcus aureus | 7000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Pseudomonos aeruginosa | 7000 |
| 1.4 | Нүд, чих, хамрын дусал, төрөл бүрийн шингэн эмүүд | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвал- тус бүрд/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дүүргэлт | 1000 |
| | Уусмалын орчин | 1000 |
| | Уусмалын өнгө | 3000 |
| | Тунгалаг чанар | 2000 |
| | Механик хольц | 600 |
| | Хувийн жин | 1000 |
| | Зуурамхай чанар | 3000 |
| | Эмийн бодисын жижиг хэсэг, үл уусах хэсгийн хэмжээ | 5000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд// | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Ариун чанар тодорхойлох | 10500 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli*/ | 7000 |
| | Энтеробактерийн бүлгийн нян тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonos aeruginosa* | 7000 |
| 1.5 | Сироп эм | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвал- тус бүрд/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дүүргэлт | 1000 |
| | Хувийн жин | 1000 |
| | Уусмалын орчин | 1000 |
| | Зуурамхай чанар | 3000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli*/ | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Salmonella species* | 7000 |
| 1.6 Тарилгын шингэн | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дүүргэлт | 1000 |
| | Уусмалын орчин | 1000 |
| | Уусмалын өнгө | 3000 |
| | Уусмалын тунгалаг чанар | 2000 |
| | Механик хольц | 600 |
| | Зуурамхай чанар | 3000 |
| | Гэрлийн хугарлын илтгэгч | 1500 |
| | Оптик нягт ба гэрэл шингээгч хольц | 1500 |
| | Эргэлтийн өнцөг | 1500 |
| | Хлоридын хольц | 1500 |
| | Сульфатын хольц | 1500 |
| | Хар тугалганы хольц | 1500 |
| | Цайрын хольц | 1500 |
| | Төмрийн хольц | 1500 |
| | Кальцийн хольц | 1500 |
| | Аммонийн хольц | 1500 |
| | Эмийн бодисын жижиг хэсэг, үл уусах хэсгийн хэмжээ | 5000 |
| | Уургийн тогтворжилт | 5000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт /Биологийн арга/ | 40000 |
| | Халууруулах чанар тодорхойлох /ЛАЛ тест, Rabbit test/ | 25000 |
| | Ариун чанар тодорхойлох | 15000 |
| | Хорон чанар тодорхойлох | 40000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| 1.7 | Тосон түрхлэг, тосон бэлдмэл | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвал- тус бүр/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дүүргэлт | 1000 |
| | Нэгэн төрөл чанар | 1500 |
| | Жижиг хэсгийн хэмжээ | 2000 |
| | Исэлдүүлэгч нэгдэл | 3000 |
| | Ангижруулагч нэгдэл | 3000 |
| | Уусмалын орчин | 1000 |
| | Хүчлийн тоо | 5000 |
| | Иодын тоо | 5000 |
| | Саванжилтийн тоо | 5000 |
| | Хэт ислийн тоо | 5000 |
| | Эфирийн тоо | 5000 |
| | Гидроксилын тоо | 5000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга-элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Агаартан бактерийн тоо  тодорхойлох | 7000 |
| | Энтеробактерийн бүлгийн нян тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonos aeruginosa* | 7000 |
| 1.8 | Тун шилтэй эм | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дүүргэлт | 1000 |
| | Механик хольц | 600 |
| | Уусмалын өнгө | 3000 |
| | Тунгалаг чанар | 2000 |
| | Уусмалын орчин | 1000 |
| | Эмийн бодисын жижиг хэсэг, үл уусах хэсгийн хэмжээ | 5000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга-систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга-элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Тооны тодорхойлолт /Биологийн арга/ | 40000 |
| | Халууруулах чанар тодорхойлох /ЛАЛ тест, Rabbit test/ | 25000 |
| | Ариун чанар тодорхойлох | 15000 |
| | Хорон чанар тодорхойлох | 40000 |
| 1.9 Үрэл эм | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дундаж жин, жингийн хэлбэлзэл | 1500 |
| | Задралт | 2500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга-элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Агаартан тоо тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli*/ | 7000 |
| | Энтеробактерийн бүлгийн нян тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonos aeruginosa* | 7000 |
| 1.10 Шахмал эм | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Дундаж жин, жингийн хэлбэлзэл | 1500 |
| | Механик бат бөх чанар | 1500 |
| | Үрэлтийн дараах бүтэн шахмалын хэмжээ | 1800 |
| | Задралт | 2500 |
| | Уусалт /СФМ-ийн аргаар/ | 18500 |
| | Уусалт /ӨИШХ-ийн аргаар/ | 70000 |
| | Тугналт /СФМ-ийн аргаар/ | 20000 |
| | Тугналт /ӨИШХ-ийн аргаар/ | 70000 |
| | Геометрийн хэмжээсүүд: урт,өргөн, зузаан г.м | 1000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Жингийн алдагдал | 5000 |
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн эзлэхүүний арга/ | 30000 |
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн кондуктометрийн арга/ | 40000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /E.Coli/ | 7000 |
| 1.8 Флаконтой эм, антибиотик | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Таних урвал /Хайлах температур/ | 15000 |
| | Дундаж жин, жингийн хэлбэлзэл | 1500 |
| | Уусах чанар | 1000 |
| | Уусмалын өнгө | 2500 |
| | Уусмалын тунгалаг чанар | 2000 |
| | Уусмалын орчин | 1000 |
| | Хүчиллэг, шүлтлэг чанар | 1000 |
| | Хлоридын хольц | 1500 |
| | Сульфатын хольц | 1500 |
| | Хүнд металлын хольц | 1500 |
| | Гэрэл шингээгч хольц | 1500 |
| | Эргэлтийн өнцөг | 1500 |
| | Жингийн алдагдал | 5000 |
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн эзлэхүүний арга/ | 30000 |
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн кондуктометрийн арга/ | 40000 |
| | Органик нэгдэлд азот тодорхойлох | 20000 |
| | Тугналтын нэгэн төрөл чанар | 2000 |
| | Үлдэгдэл уусгагч / хийн хроматографийн арга/ | 52500 |
| | Хольц тодорхойлох /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Хольц тодорхойлох / ӨИШХ-ийн арга- систем тус бүрд / | 70000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга-элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Антибиотикийн идэвх микробиологийн аргаар | 40000 |
| | Халууруулах чанар тодорхойлох /ЛАЛ тест, Rabbit test/ | 25000 |
| | Ариун чанар тодорхойлох | 15000 |
| | Хорон чанар тодорхойлох | 40000 |
| 1.8 Эмийн түүхий эд /эмийн үндсэн үйлчлэгч ба туслах бодис/ | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /НУТ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Таних урвал /Хайлах температур/ | 15000 |
| | Уусах чанар | 1500 |
| | Хувийн жин | 1000 |
| | Гэрлийн хугарлын илтгэгч | 1500 |
| | Оптик нягт ба гэрэл шингээгч хольц | 1500 |
| | Хайлах температур | 15000 |
| | Буцлах температур | 5000 |
| | Уусмалын өнгө | 2500 |
| | Уусмалын тунгалаг чанар | 2000 |
| | Хүчиллэг, шүлтлэг чанар | 1000 |
| | Хлоридын хольц | 1500 |
| | Сульфатын хольц | 1500 |
| | Хүнд металлын хольц | 1500 |
| | Цайрын хольц | 1500 |
| | Төмрийн хольц | 1500 |
| | Кальцийн хольц | 1500 |
| | Хөнгөнцагааны хольц | 1500 |
| | Аммонийн хольц | 1500 |
| | Үнслэг, сульфатын үнслэг | 5000 |
| | Эргэлтийн өнцөг | 1500 |
| | Жингийн алдагдал, чийглэг, хуурай үлдэгдэл | 5000 |
| | Органик нэгдэлд азот тодорхойлох | 25000 |
| | Зуурамхай чанар | 2000 |
| | Хольц тодорхойлох /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Хольц тодорхойлох / ӨИШХ-ийн арга- систем тус бүрд / | 70000 |
| | Хүчлийн тоо | 5000 |
| | Иодын тоо | 5000 |
| | Саванжилтийн тоо | 5000 |
| | Хэт ислийн тоо | 5000 |
| | Эфирийн тоо | 5000 |
| | Гидроксилын тоо | 5000 |
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн эзлэхүүний арга/ | 30000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Усны хэмжээ / Карль-Фишерийн кондуктометрийн арга/ | 40000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга-элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli*/ | 7000 |
| | Энтеробактерийн бүлгийн нян тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonos aeruginosa* | 7000 |
| | *Salmonella species* | 7000 |
| | Бактерийн эсрэг үйлчлэл | 35000 |
| | Антибиотикийн идэвх тодорхойлох | 40000 |
| | Ариун чанар | 15000 |
| | Нянгийн эндотоксин | 25000 |
| | Халдваргүйжүүлэх идэвх | 27000 |
| 1.1 Эмийн санд бэлтгэсэн нийлмэл нунтаг эм | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Механик хольц | 600 |
| | Дундаж жин, жингийн хэлбэлзэл | 1500 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн аргаар/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Рефрактометрийн аргаар/ | 2000 |
| | Тооны тодорхойлолт /СФМ-ийн аргаар/ | 12500 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /E.Coli/ | 7000 |
| 1.2 Эмийн санд бэлтгэсэн усан эм | | |
| | Гадна байдал | 500 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Механик хольц | 500 |
| | Дүүргэлт | 1000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн аргаар/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Рефрактометрийн аргаар/ | 2000 |
| | Тооны тодорхойлолт /СФМ-ийн аргаар/ | 12500 |
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох */E.Coli/* | 7000 |
| Ороох боох материал, эмнэлгийн хэрэгсэл | | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| 2.1 Ороох боох материал | | |
| | Гадна байдал, өнгө, үнэр | 1000 |
| | Дундаж жин | 1000 |
| | Жингийн хэлбэлзэл | 500 |
| | Флуоресценци | 1000 |
| | Хүчиллэг, шүлтлэг чанар | 1000 |
| | Усанд уусах чанар | 1500 |
| | Гадаргуугийн идэвхт бодис | 2000 |
| | Будагч бодис | 4000 |
| | Урт, өргөний хэмжээ | 1000 |
| | Цардуул, декстрины хольц | 1000 |
| | Эфирт уусах бодис | 3000 |
| | Нягтрал | 1000 |
| | 10 см дахь утасны тоо | 1000 |
| | Гадны ширхэг хольц | 1000 |
| | Чийглэг | 5000 |
| | Хлоридын хольц | 1500 |
| | Кальцийн хольц | 1500 |
| | Сульфатын хольц | 1500 |
| | Ус шингээх чадвар | 500 |
| | Ангижруулагч бодис | 3000 |
| | Ариун чанар тодорхойлох | 15000 |
| 2.2 Эмнэлгийн жижиг багаж хэрэгсэл, сав баглаа боодол | | |
| | Гадна байдал | 1000 |
| | Диаметр,урт, өргөн, зузаан | 1000 |
| | Хандлагдах будагч бодис | 1500 |
| | Нүдэнд харагдах байдал | 300 |
| | Хүчиллэг, шүлтлэг чанар | 1000 |
| | Уусмалын өнгө, тунгалаг чанар | 2500 |
| | Уусмалын гэрэл нэвтрүүлэлт | 2000 |
| | Уусмалын гэрэл шингээлт | 1500 |
| | Үлдэгдэл нэгдэл | 4000 |
| | Силиконы агууламж | 5500 |
| | Уусдаг хромын нэгдэл | 1500 |
| | Исэлдүүлэгч нэгдэл | 3000 |
| | Тэсрэх эзлэхүүн | 6000 |
| | Үлдэгдэл нэгдэл | 5000 |
| | Үлдэгдэл уусгагч / хийн хроматографийн аргаар | 52500 |
| | Тасрах хүч | 5000 |
| | Халууруулах чанар тодорхойлох /ЛАЛ тест, Rabbit test/ | 25000 |
| | Ариун чанар тодорхойлох | 15000 |
| | Хорон чанар тодорхойлох | 40000 |
| | Агаартан | |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Агаартан бактерийн тоо тодорхойлох | 7000 |
| | *Enterobacteraceae* бүлгийн бактер | 7000 |
| | Хөгц мөөгөнцрийн тоо | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonas aeruginosa* | 7000 |
| | *Salmonella* | 7000 |
| | *E.coli* | 7000 |
| III. Уламжлалт эм, эмийн ургамлын шинжилгээ | | |
| 3.1 Уламжлалт тан, талх, үрэл эм | | |
| | Гадна байдал /өнгө, үнэр, төлөв байдал | 1000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /СФМ-ын спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Органик хольц | 1500 |
| | Дундаж жин, жингийн хэлбэлзэл | 1500 |
| | Задралт | 2500 |
| | Нунтаглалтын зэрэг | 1500 |
| | Чийглэг | 5000 |
| | Тооны тодорхойлолт: Хандлагдах бодисын хэмжээг тодорхойлох | 10000 |
| | Тооны тодорхойлолт: Флавонойд тодорхойлох | 7000 |
| | Тооны тодорхойлолт: Алкалойд тодорхойлох | 40000 |
| | Тооны тодорхойлолт: Сапонин тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Аргаах бодис тодорхойлох | 10000 |
| | Тооны тодорхойлолт: Кумарин тодорхойлох | 30000 |
| | Тооны тодорхойлолт: Антрогликозид тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Эфирийн тос тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Арбутин тодорхойлох | 20000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 15000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Агаартан бактерийн нийт тоо | 7000 |
| | *Enterobacteraceae* бүлгийн бактер | 7000 |
| | Хөгц мөөгөнцрийн тоо | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonas aeruginosa* | 7000 |
| | *Salmonella* | 7000 |
| | *E.coli* | 7000 |
| 3.2 Ургамал, эрдэс, амьтны гаралтай түүхий эд | | |
| | Гадна байдал /Мэдрэхүй, микроскоп/ | 1000 |
| | Ургамлын бүтэц тодорхойлох | 3000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Нэрийн дүйц тодорхойлох | 5000 |
| | Таних урвал /Эм таних ерөнхий урвалаар/ | 5000 |
| | Таних урвал /Нимгэн үет хроматографийн арга/ | 10000 |
| | Таних урвал /Спектрофотометрийн арга/ | 5000 |
| | Эрдэс хольц | 1000 |
| | Бусад ургамлын хольц | 1000 |
| | Органик хольц | 1000 |
| | Харлаж, шарласан, өнгөө алдсан | 1000 |
| | Хортон шавьжид идэгдсэн | 1000 |
| | Хөгцөрч ялзарсан | 1000 |
| | Хөгширсөн | 1000 |
| | Бөөгнөрч наалдсан | 1000 |
| | Дарагдаж бяцарсан | 1000 |
| | Жижиглэлтийн зэрэг | 1500 |
| | Чийглэг ба дэгдэмхий бодис | 5000 |
| | Тооны тодорхойлолт: Хандлагдах бодисын хэмжээг тодорхойлох | 10000 |
| | Тооны тодорхойлолт: Флавонойд тодорхойлох | 7000 |
| | Тооны тодорхойлолт: Алкалойд тодорхойлох | 40000 |
| | Тооны тодорхойлолт: Сапонин тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Аргаах бодис тодорхойлох | 10000 |
| | Тооны тодорхойлолт: Кумарин тодорхойлох | 30000 |
| | Тооны тодорхойлолт: Антрогликозид тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Эфирийн тос тодорхойлох | 15000 |
| | Тооны тодорхойлолт: Арбутин тодорхойлох | 20000 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 15000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| | Агаартан бактерийн тоо  тодорхойлох | 7000 |
| | *Enterobacteraceae* бүлгийн бактер | 7000 |
| | Хөгц мөөгөнцрийн тоо | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonas aeruginosa* | 7000 |
| | *Salmonella* | 7000 |
| | *E.coli* | 7000 |
| | Бактерийн эсрэг үйлчлэл | 35000 |
| | Хорон чанар | 20000 |
| IV. Чанарын шинжилгээ-таних урвал | | |
| | Эм таних ерөнхий урвалууд | 5000 |
| | ХЯТ-ны спектрофотометрийн арга | 10000 |
| | НУТ-ын спектрофотометрийн арга | 5000 |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

| | | |
|---|---|---|
| | Хийн хроматографийн арга | 30000 |
| | Нимгэн үет хроматографийн арга | 10000 |
| | Хайлах температур | 15000 |
| | ӨИШХ-ийн арга | 40000 |
| Тооны шинжилгээ | | |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Спектрофотометрийн арга/ | 12500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /Хийн хроматографийн аргаар/ | 52500 |
| | Таних урвал, тооны тодорхойлолт /ӨИШХ-ийн арга- систем тус бүрд/ | 70000 |
| | Тооны тодорхойлолт /АШС-ийн арга- элемент тус бүрд/ | 16500 |
| | Тооны тодорхойлолт /Жингийн арга/ | 5000 |
| | Тооны тодорхойлолт /Электрофорезын арга/ | 25000 |
| | Тооны тодорхойлолт /Къелдалийн арга/ | 20000 |
| | Тооны тодорхойлолт /Титрийн арга/ | 10000 |
| Микробиологи, биологийн шинжилгээ | | |
| | Антибиотикийн идэвх тодорхойлох | 40000 |
| | Агаартан бактерийн тоо  тодорхойлох | 7000 |
| | Энтеробактерийн бүлгийн нян тодорхойлох | 7000 |
| | Хөгц, мөөгөнцөр тодорхойлох | 7000 |
| | Халууруулах чанар тодорхойлох /ЛАЛ тест, Rabbit test/ | 25000 |
| | Ариун чанар тодорхойлох | 15000 |
| | Хорон чанар тодорхойлох | 40000 |
| | Биологийн шинжилгээ | 40000 |
| | Эмгэг төрөгч нян тодорхойлох /*E.Coli*/ | 7000 |
| | *Staphylococcus aureus* | 7000 |
| | *Pseudomonos aeruginosa* | 7000 |
| | *Salmonella species* | 7000 |
| | Бактерийн эсрэг идэвх | 35000 |
| | Халдваргүйжүүлэх идэвх | 27000 |
| | Үл уусах жижиг хэсгийн хэмжээ | 5000 |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

# ЭМИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ТОГТОЛЦОО, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТАЛААРХ БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА БА МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЭМИЙН ХУДАЛДААНЫ СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D), Д.Аюуш,*
*Б.Батцэцэг, С.Золжаргал, Б.Баянмөнх*

## АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ.ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ

- 1.1. Эмийн зохицуулалтын олон улсын хамтын ажиллагаа
- 1.2. Эмийн үнийн хөнгөлөлтийн талаарх зөвлөмж

ХОЁР.ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

- 2.1. Бүгд Найрамдах Солонгос Улс
- 2.2. Бүгд Найрамдах Финланд Улс
- 2.3. Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)
- 2.4. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)
- 2.5. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ГУРАВ. МОНГОЛ УЛСАД ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХУДАЛДААЛЖ БУЙ ЭМИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ /2018-2022/

- 3.1. Эмийн үнийн хөнгөлөлт 2018-2019 он
- 3.2. Эмийн үнийн хөнгөлөлт 2020 он
- 3.3. Эмийн үнийн хөнгөлөлт 2021 он
- 3.4. Эмийн үнийн хөнгөлөлт 2022 оны эхний 8 сар

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман Улс |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| НҮБ | Нэгдсэн Үндэстний Байгууллага |
| НД | Нийгмийн даатгал |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.Судалгаанд хамрагдсан орнуудын эмийн хөнгөлөлтийн талаарх эрх зүйн зохицуулалт ба туршлага
Хүснэгт 2.PPRI *(EECA) сүлжээний орнуудын эрүүл мэндийн тогтолцоо ба санхүүжилтийн систем, 2018 он*[257]
Хүснэгт 3. PPRI *(EECA) сүлжээний орнуудын эмийн үнийн бодлого, зохицуулалт, 2018 он*[258]
Хүснэгт 4.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймаг, нийслэлээр
Хүснэгт 5.Нийслэлийн дүүргүүдийн эмийн сангуудад олгосон санхүүжилт
Хүснэгт 6.Өндөр дүнтэй санхүүжилт авсан аймгууд
Хүснэгт 7.ЭМДС-аас хөнгөлөлттэй олгосон эмийг өвчний бүлгээр
Хүснэгт 8.0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан халдварын эсрэг эмийн тоо болон олгосон санхүүжилт
Хүснэгт 9.0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан уналт, таталтын эмийн тоо болон олгосон санхүүжилт
Хүснэгт 10.0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан вирусийн эсрэг эмийн хэрэглээ
Хүснэгт 11.0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан окстоцин ба түүний эсрэг эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 12.0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 13.20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан зүрх судасны өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 14.20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 15.20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан халдварын эсрэг эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 16.20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 17. 40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан зүрх судасны өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 18.40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 19.40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан цусанд нөлөөлөх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 20.40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 21.40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 22.60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан зүрх судасны өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 23.60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 24.60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 25.60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан цусанд нөлөөлөх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 26.60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ
Хүснэгт 27.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймаг, нийслэлээр
Хүснэгт 28.Нийслэлийн дүүргүүдийн эмийн сангуудад олгосон санхүүжилт
Хүснэгт 29.ЭМДС-аас хөнгөлөлттэй олгосон эмийн бүлгээр
Хүснэгт 30.Хамгийн их санхүүжилт авсан эм /худалдааны нэрээр/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1.Нэг хүнд ногдох эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шимтгэл /2011-2016 он/
График 2.Эмийн хөнгөлөлтийн дундаж хувь
График 3.Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон эмийн төрөл
График 4.Эмийн үнийн хөнгөлөлт авсан эмийн тоо ширхэг /ерөнхий бүлгээр/
График 5.0-19 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 6.20-24 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 7.25-29 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 8.30-34 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 9.35-39 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 10.40-44 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 11.45-49 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 12.50-54 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 13.55-59 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 14.60-64 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 15.65-аас дээш насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/
График 16.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймгаар
График 17.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, сараар
График 18.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт даатгуулагчийн төрлөөр
График 19.Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчид, насны бүлгээр
График 20.0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ, эмийн өвчний бүлгээр
График 21.20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ
График 22.40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ
График 23.60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ
График 24.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймгаар
График 25.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, дүүргээр
График 26.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт даатгуулагчийн төрлөөр
График 27.Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчид, насны бүлгээр
График 28.Хөнгөлөлттэй эм олгосон эмийн сангийн салбар, санхүүжилт
График 29.Хөнгөлөлттэй эм олгосон эмийн сангийн салбар, эмийн тоо

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгын дагуу “Эмийн хөнгөлөлтийн тогтолцоо, эрх зүйн орчны талаарх бусад орнуудын туршлага ба Монгол Улс дахь хөнгөлөлттэй эмийн худалдааны статистик мэдээлэл” сэдэвт харьцуулсан судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

**Судалгааны зорилго**

Эмийн хөнгөлөлтийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын талаарх бусад орнуудын туршлагыг харьцуулан судлах, Монгол Улсад худалдаалагдаж буй хөнгөлөлттэй эмийн талаарх мэдээлэл лавлагаа гаргах.

**Судалгааны хамрах хүрээ**

Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу БНСУ, БНХАУ, АНУ, ХБНГУ, Финланд зэрэг орнуудыг хамруулан эмийн хөнгөлөлтийн тогтолцоо болон эрх зүйн зохицуулалт, практик туршлагыг харьцуулан судалсан. Мөн Монгол Улсын хөнгөлөлттэй эмийн жагсаалтанд орсон эмийн худалдааны статистик мэдээ, мэдээллийг сүүлийн 5 жил (2018-2022.08 сар)-ийн байдлаар гаргав.  Судалгаанд эмийн хөнгөлөлтийн бодлого, зохицуулалтын талаар олон улсын байгууллагуудаас гаргасан зарим томоохон судалгааны үр дүн, харьцуулсан мэдээлэл, зөвлөмжийг  ашигласан болно.

**Судалгааны тайлангийн бүтэц:** Судалгаа нь 3 хэсэгтэй. Нэгдүгээр хэсэгт эмийн үнийн зохицуулалт, хөнгөлөлттэй эм олгох тогтолцооны талаарх олон улсын чиг хандлага ба харьцуулсан судалгааны үр дүн, зөвлөмжийн талаарх мэдээлэл, Хоёрдугаар хэсэгт судалгаанд авагдсан орнуудын эмийн үнийн хөнгөлөлтийн тогтолцоо болон эрх зүйн зохицуулалт, практик туршлагын талаарх мэдээлэл, Гуравдугаар хэсэгт Монгол Улс дахь хөнгөлөлттэй эм олголтын талаарх статистик мэдээллийг тус тус оруулсан болно.

***Түлхүүр үг:*** *эмийн нөхөн төлбөр, эмийн үнийн хөнгөлөлт*

***Keyword:*** *pharmaceutical reimbursement, reimbursement for medicine*

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

***Олон улсын чиг хандлага***

Эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны зохицуулалтын талаар: Сүүлийн үед олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд эм, эмнэлгийн хэрэгслийн эргэлттэй холбоотой асуудлыг нэгдсэн зохицуулалтанд оруулах, хамтын ажиллагааны хүрээнд тулгамдаж буй  асуудлуудаа зохицуулах, улс орон бүр зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ гишүүнчлэл бүхий олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудаас гаргасан зөвлөмж, стандартуудыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн байдаг байна.  Монгол Улс ДЭМБ-ын гишүүний хувьд тус байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу эмийн зохицуулалтын тогтолцоогоо иж бүрэн, зөв бүрдүүлж, эмийн импорт, нэгдсэн худалдан авалт, төрийн оролцоо зэрэг зарим чухал асуудлуудаар гаргасан зөвлөмжүүдийг дагаж мөрдөх шаардлагатай болж байна.

Судалгаанаас үзэхэд, эмийн зохицуулалтын олон улсын хамтын ажиллагааны хүрээнд дэлхийн  болон бүс нутгийн хүрээнд  зохицуулалтын хамтын ажиллагааны олон загварууд хэрэгжүүлж байна. Тухайлбал, ДЭМБ-аас Европын эмийн зохицуулалтын тогтолцоог бусад бүс нутгийн улс орнуудад энэ чиглэлээр хамтран ажиллах, харилцан итгэлцлийг бий болгоход үлгэр жишээ болохуйц сайн загвар хэмээн дүгнэсэн байдаг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Ази тивд эмийн бүтээгдэхүүний худалдаа, хамтын ажиллагааг уялдуулах чиглэлээр Зүүн Өмнөд Азийн орнуудын холбоо (Association of Southeast Asian Nations-ASEAN), Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (Asia-Pacific Economic Cooperation-APEC) болон Персийн булангийн эмийн бүртгэлийн төв хороо (Gulf Central Committee for Drug Registration GCC-DR) зэрэг байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Тухайлбал, Евразийн эдийн засгийн комисс (Eurasian Economic Commission-EEC) нь 2016 оноос эхлэн эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын нэг зах зээлтэй болохоор зөвшилцөлд хүрсэн бөгөөд эмийн бүртгэлээс эхлээд түгээлт хүртэлх процессыг нэг стандартаар явуулах асуудлыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд: Армени, Беларусь, Казахстан, Киргиз, ОХУ зэрэг улс орнууд нэгдэн орсон байна. Манай улс энэ чиглэлээр бүс нутгийн болон олон улсын ямар нэгэн зохицуулалтын тогтолцоонд ороогүй байна.

Эмийн аюулгүй байдлыг хангах ДЭМБ-ын фармаковижиланс[232] хөтөлбөрийн үндсэн гишүүн 123 орон байдаг ба Монгол Улс үндсэн гишүүнчлэлд орохоор хүлээгдэж буй 28 орнуудын нэг юм. Энэ хөтөлбөрөөс дэмжлэг авахын тулд дараах шалгууруудыг хангахыг шаарддаг:

4. Эмийн аюулгүй байдлыг хянах аргачлалтай байх;
5. Эрүүл мэндийн яам, түүнтэй адилтгах байгууллага нь Эмийн хяналтын үндэсний төвийг томилж, ажиллуулах;
6. ДЭМБ-д гаргаж өгөх тайлангийн шаардлагыг биелүүлэх техникийн чадвартай байх зэрэг шалгууруудыг хангадаг байна.

Эмийн үнийн хөнгөлөлтийн талаар: Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дэргэд Эмийн үнийн хөнгөлөлтийн мэдээллийн сүлжээ (Pharmaceutical Pricing and Reimbursement Network,PPRI) байгуулагдсан бөгөөд эгнээндээ Европын 50 томоохон орнууд, олон улсын болон Европын институтуудыг багтаасан ба эмийн үнийн хөнгөлөлт, нөхөн төлбөрийн чиглэлээр мэдээлэл солилцох, туршлага хуримтлуулах чиглэлээр эрх бүхий байгууллагуудыг хамруулсан сүлжээ хэлбэрээр ажилладаг. Тухайлбал, Зүүн Европ ба Төв Ази (EECA) дэд бүлэгт Армени, Азербайжан, Беларусь, Гүрж, Казахстан, Киргиз, Молдова, ОХУ, Тажикистан, Туркменистан, Украин, Узбекистан зэрэг орнууд багтдаг байна. Манай улс энэ сүлжээнд одоогоор ороогүй байна.

Энэ сүлжээ байгууллагын гол зорилго нь эмийн бодлогын асуудлаар шинжлэх ухаанд суурилсан нэгдмэл нэг ойлголттой болох, эмийн үнийн хөнгөлөлтийн талаарх төрийн бодлогын асуудлаар мэдээлэл солилцох, хэлэлцүүлэг хийх зэргээр хамтын ажиллагааны нэгдсэн байдлыг хангахад чиглэгдэх ба ерөнхий удирдлага, зохион байгуулалтыг PPRI-ийн нарийн бичгийн дарга нарын газар хариуцдаг байна.

2018 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага( ДЭМБ)-ын Европын бүсийн газраас Зүүн Европ ба Төв Азийн эмийн үнэ тогтоох тогтолцоо болон эмийн үнийн хөнгөлөлтийн системүүдийг харьцуулан судалсны үндсэн дээр **“Зүүн Европ ба Төв Азийн эмийн үнийн болон хөнгөлөлтийн систем”** сэдэвт харьцуулсан судалгааны тайланг гаргажээ.

Уг судалгаанд хамрагдсан Зүүн Европ ба Төв Азийн 11 орны (Армени, Азербайжан, Беларусь, Гүрж, Казахстан, Киргиз, Молдова, Тажикистан, Туркменистан, Украин, Узбекистан) эмийн зах зээл дээрх үнэ тогтоох, худалдах-худалдан авах, санхүүжилтийн систем болон эмийн хөнгөлөлт үзүүлэх системийг харьцуулан судалсан байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас үзэхэд, нэр бүхий 7 оронд амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх эмчилгээний үед эмийн үнэд зохицуулалт хийдэг бөгөөд үүнээс 5 оронд

[232] Эмийн хяналт шинжилгээний хөтөлбөр

UIH.MN СУДАЛГААНЫ САН

эмийн худалдааны бүх шатанд (бөөний болон жижиглэнгийн худалдаа), зарим оронд зөвхөн хэвтэн эмчлүүлэх эмчилгээнд үнэ төлбөргүй эм хэрэглэх бөгөөд хөнгөлөлттэй эмийн жагсаалтанд ороогүй эмийг иргэд өөрсдийн мөнгөөр худалдан авах зохицуулалттай байна. Эмийн худалдан авалтыг төвлөрсөн худалдан авалтаар, тендерээр нийлүүлэх бөгөөд гадаад болон дотоод зах зээл дэх эмийн үнийн судалгаа хийж, лавлагаа гаргах шаардлагатай. Улс орнууд эмийн худалдан авалт, санхүүжилт, эмийн үнийн хөнгөлөлтийн янз бүрийн аргуудыг хэрэглэдэг байна.

***Гадаадын зарим орны туршлага, эрх зүйн зохицуулалтын талаар:***

БНСУ-д эмийн харилцааг Эмийн тухай хууль болон Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, түүнд холбогдох дүрэм, журмаар зохицуулдаг. Үндэсний эрүүл мэндийн даатгалаас амбулатори болон хэвтэн эмчлүүлэгчдийн 30-60%, эмийн 20%-д нөхөн олговор олгогддог. БНСУ нь *“нэг төлөгчийн систем”*-тэй бөгөөд иргэн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг бүрэн төлснөөр Үндэсний эрүүл мэндийн даатгалын систем (NHI system)-ээс нөхөн төлбөр авах эрхтэй болдог. NHI системийг Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Үндэсний эрүүл мэндийн даатгалын алба, Эрүүл мэндийн даатгалын үнэлгээний алба хамтран удирддаг. Даатгалын тэтгэмж нь бүх шимтгэл төлөгчдөд ижил хэмжээтэй олгогддог. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахад “*хамтарсан төлбөр*”-ийн схемийг ашиглаж болох ба тодорхой хувийн төлбөрийг иргэн өөрөөсөө төлдөг. Хамтарсан төлбөр нь хаанаас, ямар төрлийн тусламж үйлчилгээ авч байгаагаас хамааран өөр өөр байдаг боловч дундаж үзүүлэлтээр хэвтэн эмчлүүлэх үйлчилгээнд 20%, амбулаторийн үйлчилгээнд 30-50%, хорт хавдрын үзлэгт 90%, эмийн сангийн төлбөрийн хөнгөлөлтөд 35-40% байна. Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох нөхөн олговрын дээд хэмжээг Ерөнхийлөгчийн зарлигаар 5 жил тутам нэг удаа тогтоож үнэ бууруулах арга хэмжээ аван ажилладаг. Эрүүл мэнд, нийгэм хамгааллын сайд эмийн хөнгөлөлтийн нөхөн олговрыг 40/100-аас хэтрүүлэхгүй хэмжээгээр хэсэгчлэн тогтоох эрхтэй байна.

Финланд Улсад Эмийн тухай хуулиар хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалт, Эрүүл мэндийн тухай хуулиар эмийн хөнгөлөлтийн нөхөн олговрын харилцааг хуульчилж өгчээ. Эрүүл мэндийн даатгал төлсөн даатгуулагч нь эм, эмийн нэмэлт бүтээгдэхүүн, зарим төрлийн тосон түрхлэгт хөнгөлөлтийн нөхөн олговор авна. Анхан, үндсэн, тусгай гэсэн 3 ангиллын дагуу эмийн хөнгөлөлтийн нөхөн олговор олгох асуудлыг Нийгэм хамгаалал, Эрүүл мэндийн яамнаас томилсон Эмийн үнийн зөвлөл шийдвэрлэдэг байна. Эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу дээрх 3 ангиллын эмийн үнийн хөнгөлөлтийн нөхөн олговроос гадна эмнэлзүйн хоол тэжээлийн бүтээгдэхүүний нөхөн олговрыг үнээний сүүний харшилтай бага насны хүүхэд, төрөлхийн бодисын солилцооны эмгэгтэй, шим тэжээл боловсруулах эмгэгтэй, хоол тэжээлийн дутагдалтай зэрэг өвчтөнд 65%-ийн хөнгөлөлтийн нөхөн олговор олгодог байна.

БНХАУ нь дэлхийн эмийн зах зээлд тэргүүлэх байр суурь эзэлдэг бөгөөд улсынхаа эрүүл мэндийн зардлын 40 хувийг эм бэлдмэлд зарцуулдаг байна. БНХАУ-д эм болон эмийн хөнгөлөлттэй холбоотой эрх зүйн харилцааг “БНХАУ-ын Эмийн хяналтын тухай хууль”-аар зохицуулж, “Үндэсний нөхөн олговор олгох эмийн жагсаалт”[233]-ын дагуу нийт хүн амын 98 хувийг хамруулан төрөөс хөнгөлөлттэй эм олгож байна.

Хятадын хөнгөлөлттэй эмийн жагсаалт 2021 онд шинэчлэгдэж, 2022 онд 74 эм шинээр нэмэгдэж, эрэлт багатай 11 эм хасагдсан байх ба нийт 2860 нэр төрлийн эм тус жагсаалтад багтсан байна. Үүнээс 1486 нь барууны буюу импортын эм, 1374 нь Хятадын дотоодод

[233] https://www.pharmexec.com/view/china-2021-national-reimbursement-drug-list-outlook

үйлдвэрлэсэн эм байна. Уг жагсаалтад багтсан нийт эмийн дүнгээр авч үзвэл зах зээл дээр худалдаалж буй үнийн дунджаас 62%-аар хөнгөлдөг байна.

АНУ нь төрийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нэгдсэн тогтолцоогүй орон юм. Эрүүл мэндийн даатгалд хамрагдахын тулд иргэд даатгалын компанид тогтмол төлбөр төлж эмчилгээний төлбөрийн зарим хэсгийг, эсвэл бүгдийг төлүүлнэ. Эрүүл мэндийн даатгалыг зохицуулах хуулийн дагуу эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хүрээнд хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримталдаг байна.

2010 онд "Obamacare" хэмээн нэрлэгддэг Хүртээмжтэй тусламж үйлчилгээний тухай хууль[234] (Affordable Care Act-ACA) батлагдсан. Энэ хуулийн хүрээнд хөнгөлөлттэй эмийг эмчийн жорын дагуу олгох дараах хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Тухайлбал, Medicare[235] хөтөлбөр нь АНУ-ын Холбооны засгийн газрын эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр бөгөөд 65 наснаас дээш насныхан, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хүнд өвчтэй хүмүүс уг хөтөлбөрт хамрагддаг.

Medicaid хөтөлбөр нь эмийн хөнгөлөлтийн хөтөлбөр (MDRP) юм. Medicare болон Medicaid үйлчилгээний төвүүд (CMS) нь муж улсын Medicaid агентлагууд болон эм үйлдвэрлэгчдийг хамруулсан хөтөлбөр бөгөөд Medicaid-ийн өвчтөнүүдэд амбулаторийн жороор олгодог ихэнх эмийг хөнгөлөлттэй үнээр олгодог байна.

ХБНГУ -ын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь албан журмын эрүүл мэндийн даатгал (*Gesetzliche Krankenversicherung*) болон сайн дурын эрүүл мэндийн даатгал (*Private Krankenversicherung*) гэсэн хосолсон системтэй. Албан журмын эрүүл мэндийн даатгалын сан нь Allgemeine Ortskrankenkassen (AOK)[236] бөгөөд 24 сая гишүүнтэй 11 жижиг сангаас бүрддэг бол сайн дурын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь даатгуулагч болон хувийн эрүүл мэндийн даатгалын компани хооронд байгуулсан гэрээний дагуу эмчилгээний зардлыг (эмийг оролцуулан) нөхөн төлүүлэх үндэслэл болдог. Даатгалын гэрээнд компанийн даатгалын ерөнхий нөхцөл, тодорхой зардал болон нөхөн олговор, түүнийг олгох журам болон бусад зардлын үнэ тарифыг тусгасан байдаг. Герман Улсын нийт хүн амын 11 орчим хувь нь хувийн даатгалын системд хамрагдаж эрүүл мэндийн асуудлаа зохицуулдаг байна.

***Монгол Улс дахь эмийн үнийн хөнгөлөлтийн талаар:*** Монгол Улсад эмийн үнийн хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хууль[237]-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлах бөгөөд хөнгөлөлттэй эмийн нэр төрөл, хөнгөлөлтийн хэмжээ, үнийн батлагдсан дээд хязгаарыг баримтлан эрүүл мэндийн даатгалын сангаас гэрээт эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтийг олгож ирсэн.

Одоогийн байдлаар 574 худалдааны нэршлийн, 174 ерөнхий нэршлийн эмийг хөнгөлөлттэй эмийн сангуудаар дамжуулан иргэдэд олгож байна.[238]

Статистикаас үзвэл, 2018 онд 333 худалдааны нэршлийн эмэнд 25.9 тэрбум төгрөг, 2019 онд 176 худалдааны нэршлийн эмэнд 33.4 тэрбум төгрөг, 2020 онд 36.6 тэрбум төгрөг, 2021 онд 510 худалдааны нэршлийн эмэнд 60.4 тэрбум төгрөг тус тус зарцуулсан бол 2022 оны эхний 8 сарын байдлаар 410 худалдааны нэршлийн эмэнд 64.6 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. *(Дэлгэрэнгүй мэдээллийг судалгааны хэсгээс үзнэ үү.)*

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[234] Affordable Care Act https://www.hhs.gov/healthcare/about-the-aca/index.html
[235] Medicare https://www.medicare.gov/what-medicare-covers
[236] Allgemeine Ortskrankenkassen https://www.aok.de/pk/
[237] Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, 2015.01.29, https://legalinfo.mn/mn/detail/10922
[238] Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай, ЭМД-ын ҮЗ-ийн тогтоол, 2022.07.04, дугаар 11 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530818499541

*Хүснэгт 1.Судалгаанд хамрагдсан орнуудын эмийн хөнгөлөлтийн нөхөн олговрын тогтолцоо ба эрх зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан мэдээлэл*

| Улсын нэр | Хууль, эрх зүйн орчин | Эмийн хөнгөлөлтийн нөхөн олговрын тогтолцоо |
|---|---|---|
| **БНСУ** | БНСУ-д эм болон эмийн бүтээгдэхүүний нөхөн олговрын харилцааг Эмийн тухай хууль болон Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудаар зохицуулж байна.<br>*1.Эмийн тухай хууль* (Act on the Promotion of Korea medicine and pharmaceuticals)[239] нь бүх ард түмний эрүүл мэндийг дэмжих, БНСУ-ын анагаах ухаан, эм зүй технологийг хөгжүүлэх зорилготой. Тус хуульд Засгийн газар эмийн технологийг хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргааны нэгж нь холбогдох бодлого шийдвэрийг үндэслэн эмийн технологи болон хангамжийг бүрдүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна гэж заажээ.<br>*2.Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль* (National Health Insurance Act)[240] нь Нийт ард иргэдийг өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, оношлох, нөхөн сэргээх, төрөлт, нас баралт, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт үзүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалах зорилготой. | Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамны эмийн менежментийн хэлтэс нь эмийн нөхөн олговрын асуудлыг хариуцан ажилладаг байна. Нөхөн олговор олгодог эмийн үнийн хөнгөлөлтийн зардлын дээд хэмжээг Ерөнхийлөгчийн зарлигаар 5 жил тутам нэг удаа тогтоодог. Эрүүл мэнд, нийгэм хамгааллын сайд эмийн нөхөн олговрыг 40/100-аас хэтрүүлэхгүй хэмжээгээр хэсэгчлэн тогтоох буюу үнийг буулгах эрхтэй байна. Эм болон эмийн бүтээгдэхүүний үнийн хөнгөлөлтийн нөхөн олговрыг:<br>• Эрүүл мэндийн даатгалын үнэлгээний газар;<br>• Үндэсний эрүүл мэндийн даатгалын газар;<br>• Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамны шийдвэрийг үндэслэн олгодог байна. |
| **Финланд** | *1.Эмийн тухай хууль* (Medicines Act)[241]-ийн зорилго нь эмийн аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, эм хадгалах, сурталчлах, эм бэлдмэлийг стандартын дагуу чанартай үйлдвэрлэх, эмийн хүртээмжтэй байдлыг хангахад чиглэгдэнэ. Эмийн хөнгөлөлтийн нөхөн олговор олгох асуудлыг тус хуулиар зохицуулсан байдаг.<br>*2.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль* (Health Insurance Act)[242]-ийн 5 дугаар бүлэг: "Эмийн нөхөн олговор" хэсэгт эмийн үнийн | 19 нас хүрсэн иргэн Нийгмийн даатгалын байгууллагаас Кела карт авснаар тус байгууллагаас нөхөн олговор, халамж авах эрх нээгддэг байна.<br>Анхан шатны эмийн нөхөн олговор[244]- Энэ ангилалд астма, цусны даралт зэрэг 10-аад төрлийн өвчний эм хамаарна. Иргэд эхлээд эмийн нөхөн олговор олгох жагсаалтад багтсан эмнээс 50 евро хүртэлх эмийг өөрөө худалдан авах ба үүнээс илүү гарсан үнийн дүнд эмийн нөхөн олговор авах эрхтэй болдог байна. Жишээ нь 80 еврогийн эм худалдан |

[239] Act on the Promotion of Korea medicine and pharmaceuticals https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=PHARMACEUTICAL&x=0&y=0#liBgcolor0
[240] National Health Insurance Act https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=59574&type=sogan&key=10
[241] Medicines Act https://www.fimea.fi/documents/160140/765540/18580_Laakelaki_englanniksi_paivitetty_5_2011.pdf
[242] Health Insurance Act https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/2004/en20041224_20110911.pdf
[244] Анхан шатны эмийн нөхөн олговор https://www.kela.fi/laakkeet#alkuomavastuu

| | | |
|---|---|---|
| | хөнгөлөлттэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна. Эрүүл мэндийн даатгал төлсөн даатгуулагчид эм, эмийн нэмэлт бүтээгдэхүүн, зарим төрлийн тосон түрхлэгт нөхөн олговор авах эрхтэй. Анхан, үндсэн, тусгай гэсэн 3 ангиллын дагуу эмийн нөхөн олговор олгох бөгөөд уг асуудлыг Нийгэм хамгаалал, Эрүүл мэндийн яамнаас томилсон Эмийн үнийн зөвлөл[243] хариуцан шийдвэрлэдэг байна. | авсан тохиолдолд 50 еврог анхан шатны эм худалдан авах шаардлагын дагуу өөрөө төлөх ба зөрүү 30 евроД нөхөн төлбөр авах боломжтой болно. 2022 онд тухайн жилд иргэн өөрөө төлөх эмийн үнийн дээд хязгаарыг 592.16 евро гэж тогтоосон байна. Хэрэв энэ дүнгээс хэтэрвэл жилийн үлдсэн хугацаанд нөхөн олговор авах эм тус бүрд 2.50 еврогийн нөхөн төлбөр төлнө. Нийгмийн даатгалын байгууллагад эмийн нөхөн олговор авах эрхтэй иргэний мэдээлэл бүртгэгдсэн байх бөгөөд эмийн сангууд цахимаар шалгасны үндсэн дээр эмийн нөхөн олговор олгоно. Эмийн нөхөн олговрыг олгохдоо жишиг эмийн үнийн жагсаалтаар баталсан үнийг баримтлан олгоно. |
| **БНХАУ** | Эмийн хяналтын тухай хуулийг 2019 оны 12-р сарын 01-нээс эхлэн дагаж мөрдсөн. Тус хууль нь 12 бүлэг, 155 зүйлтэй байна.<br>Эмийн хяналтын тухай шинэчилсэн хуулиар хүүхдийн эм, хомстолтой байгаа эм, хүнд халдварт өвчний эм, ховор өвчний эм зэргийг нэн тэргүүнд хянан зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна. Түүнчлэн эмийн үйлдвэрүүдэд тавигдах шаардлага, хүлээлгэх хариуцлага, эм үйлдвэрлэлийн салбар дахь авлигыг зогсоох хуулийн хориг арга хэмжээг зааж, эмийн үйлдвэрүүдэд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог онцлон зохицуулсан байна. | Хятад Улсад “Үндэсний нөхөн олговор олгох эмийн жагсаалт”[245] гэх нэртэй хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг баталдаг. Энэ нь Хятад Улсын нийт хүн амын 98 хувийг хамарсан төрөөс олгож буй эмийн нөхөн олговор юм. Тус хөнгөлөлттэй эмийн жагсаалт нь 2017 оноос хойш жил бүр шинэчлэгдэж 2017 онд 2.588 эм багтаж байсан бол 2022 онд хөнгөлөгдөх эмийн жагсаалт нь 2.860 болж нэмэгдсэн байна. 2017 оноос өмнө хөнгөлөлттэй, жороор олгодог эмнүүд нь ихэвчлэн дотоодын үйлдвэрийн эм байсан бол 2017 оноос эхлэн тус эмийн жагсаалтыг жил бүр шинэчилж байхаар тогтсон байна. |
| **АНУ** | 2003 онд АНУ-ын Конгресс “Жороор олгодог эмийн чанарыг сайжруулах, шинэчлэх тухай” хууль (Medicare Prescription Drug, Improvement, and Modernization Act) баталж Medicare эрүүл мэндийн хөтөлбөрийн хүрээнд жороор олгодог эмийн тэтгэмж болох Medicare Part D буюу АНУ-ын Холбооны засгийн газрын нэмэлт хөтөлбөрийг 2006 оноос эхлэн хэрэгжүүлсэн.<br><br>2010 онд Обамacare буюу ”Хүртээмжтэй тусламж үйлчилгээний тухай хууль’’ (Affordable Care Act (ACA) гэж нэрлэгддэг ‘’Өвчтөнийг хамгаалах, хүртээмжтэй тусламж үйлчилгээний тухай” хууль батлагдсан. Мөн ’’Эрүүл мэндийн тусламж ба эрүүл мэндийн | Medicare нь АНУ-ын Холбооны Засгийн газрын эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр бөгөөд 65 наснаас дээш насныхан, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хүнд өвчтэй хүмүүст зориулагдсан. Medicare Part D нь АНУ-ын Холбооны засгийн газрын жороор эм олгох нэмэлт хөтөлбөр юм.<br>’’Хүртээмжтэй тусламж үйлчилгээний тухай хууль’’-аар эмийн зардлаа тодорхой хэмжээгээр хариуцдаг хүмүүст 250 ам.долларын хөнгөлөлт үзүүлэхээр болж, Эрүүл мэнд, Хүний үйлчилгээний Яам [247] (United States Department of Health and Human Services) нь хөнгөлөлтийн чекийг шуудангаар илгээж эхэлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2017 онд 95 хувь, 2018 онд 94 хувь, 2019 онд 93 хувь нь хамрагдсан. Medicare |

243 Pharmaceuticals Pricing board https://www.hila.fi/en/operations-and-organisation/#PharmaceuticalsPricingBoard
245 https://www.pharmexec.com/view/china-2021-national-reimbursement-drug-list-outlook
247 United States Department of Health and Human Services https://www.usa.gov/federal-agencies/u-s-department-of-health-and-human-services

| | | |
|---|---|---|
| | боловсролын зохицлын тухай хууль[246] (Health Care and Education Reconciliation Act of 2010)-ийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан нь АНУ-ын эрүүл мэндийн зохицуулалтын шинэчлэлийн хүрээнд чухал алхам болсон. | эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрийг өргөжүүлэх бүх зардлыг Холбооны Засгийн газар хариуцах ба насанд хүрсэн хүүхэдгүй хүмүүсийг (Medicaid эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр нь орлого багатай хүмүүст чиглэгдсэн) хүмүүсийг нэмэлтээр хамруулсан бөгөөд зарим мужуудад илүү санхүүжилт олгохоор төлөвлөгдсөн.<br>340B эмийн үнийн хөтөлбөр нь иргэдийн амь насыг аврах үйлчилгээг татвар төлөгчдөд үнэ төлбөргүйгээр үзүүлэх боломжийг олгодог бөгөөд санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрийг ажил олгогч (үйлдвэрлэгчид)-оос бүрдүүлдэг. Эмнэлгүүд авсан хуримтлалаараа орлого багатай, даатгалгүй өвчтөнүүдэд үйлчилгээ үзүүлдэг. |
| **ХБНГУ** | Эмийн бүтээгдэхүүнтэй холбоотой харилцааг <u>Эмийн бүтээгдэхүүний тухай хууль</u>[248] (Arzneimittelgesetz (AMG))-аар зохицуулдаг. Хуулийн зорилго нь хүн, амьтныг эрүүл ахуйн шаардлага хангасан эмээр хангах зорилгоор эмийн худалдаа, ялангуяа эмийн чанар, үр ашиг, аюулгүй байдлыг баталгаажуулахад чиглэгдэнэ.<br>Нийгмийн тухай хуулийн тавдугаар дэвтэр- <u>Эрүүл мэндийн даатгалын тухай хууль</u> (Sozialgesetzbuch (SGB) - Fünftes Buch (V) - Gesetzliche Krankenversicherung)-д эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг зохицуулах цогц зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэтгэмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт болон хууль зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулах санкцтай. Даатгалын компаниуд мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх үүрэгтэй. | Герман Улсын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь Албан журмын эрүүл мэндийн даатгал (*Gesetzliche Krankenversicherung*) ба Сайн дурын эрүүл мэндийн даатгал (*Private Krankenversicherung*) гэсэн хосолсон системтэй.<br>Албан журмын эрүүл мэндийн даатгалын сан (Allgemeine Ortskrankenkassen (AOK))[249] нь 24 сая гишүүнтэй, 11 жижиг сангаас бүрддэг бол Сайн дурын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь даатгуулагч болон хувийн эрүүл мэндийн даатгалын компанийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр эмчилгээний зардлыг (эмийг оролцуулан) нөхөн төлүүлэх тогтолцоотой. Уг гэрээнд эрүүл мэндийн даатгалын ерөнхий нөхцөл, тодорхой зардал болон нөхөн олговор олгох нөхцөл, бусад зардлын тарифыг тусгасан байдаг. Герман Улсын нийт хүн амын 11 орчим хувь нь хувийн даатгалын системээр үйлчлүүлдэг. |

[246] Health Care and Education Reconciliation Act of 2010https://mffh.org/wp-content/uploads/2016/04/ReconciliationSummary.pdf
[248] *Arzneimittelgesetz* (AMG)https://www.gesetze-im-internet.de/englisch_amg/
[249] Allgemeine Ortskrankenkassen https://www.aok.de/pk/

## СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

## НЭГ.ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ТАЛААРХ ОЛОН УЛСЫН ЗӨВЛӨМЖ

### 1.1. Эмийн зохицуулалтын олон улсын хамтын ажиллагаа

Орчин үед эм үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа улам бүр даяаршиж байгаа энэ үед эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний зохицуулалтын асуудал эрхэлсэн байгууллагуудын хамтын ажиллагаа нэн чухал болж, дэлхийн бүх бүс нутагт зохицуулалтын хамтын ажиллагааны олон загварыг хэрэгжүүлж байна. ДЭМБ-аас Европын эмийн зохицуулалтын тогтолцоо нь бусад бүс нутгийн улс орнуудад энэ тал дээр хамтран ажиллах, харилцан итгэлцлийг бий болгоход үлгэр жишээ болохоор хэмээн дүгнэсэн ба Европын эмийн хамтын ажиллагаа нь 1965 оноос эхтэй. Гэхдээ бусад бүс нутаг ч албан ёсны ба албан бус байдлаар эмийн зохицуулалтын хамтын ажиллагаатай байна. Америкийн бүс нутагт 55 орны гишүүнчлэлтэй Пан Америкийн эмийн зохицуулалтын сүлжээ ("Pan American Network for Drug Regulatory Harmonization-PANDRH) форум нь улс орнуудын эмийн удирдамж, зохицуулалтын үйл явцын уялдаа холбоог дэмжих зорилготой ба Карибын тэнгисийн нийгэмлэг (Caribbean Community-CARICOM) нь уг бүс нутгийн зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэх төсөл хэрэгжүүлдэг.

Африк тивд хамтын ажиллагааны механизмыг хөгжүүлэх хэд хэдэн бүс нутгийн нийгэмлэг, төслүүд хэрэгжиж байна. Үүнд Дорнод Африкийн хамтын нийгэмлэг (East African Community-EAC), Өмнөд Африкийн хөгжлийн нийгэмлэг (Southern African Development Community-SADC) ZaZiBoNa дөрвөн улсын (Замби, Зимбабве, Ботсвана, Намиби) зохицуулалтын системийг холбосон төсөл, Африкийн вакцины зохицуулах форум (The African Vaccine Regulatory Forum-AVAREF) байгууллагууд орж байна.[250] Мөн энэ онд Африкийн нэгдсэн эмийн агентлаг байгуулах гэрээ хийгдсэн байна.[251]

Харин Азид эмийн бүтээгдэхүүнийг уялдуулах чиглэлээр Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо (Association of Southeast Asian Nations- ASEAN), Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа (APEC) ба Персийн булангийн эмийн бүртгэлийн төв хороо (Gulf Central Committee for Drug Registration GCC-DR) санаачилга гаргадаг.

Евразийн эдийн засгийн комисс 2016 оноос эм, эмийн хэрэгслийн нэг зах зээлтэй болохоор зөвшилцөлд хүрсэн бөгөөд эмийн бүртгэлээс эхлээд түгээлт хүртэлх процессыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд Армени, Беларусь, Казахстан, Киргиз, ОХУ-ууд нэгдсэн байна.[252]

Монгол Улс одоогоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагад гишүүнчлэлтэйгээс өөрөөр эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын олон улсын болон бүс нутгийн ямар нэгэн холбоонд элсэн орсон талаарх мэдээлэл байхгүй байна. Судалгаанаас үзэхэд, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааны ийм байгууллага, холбоодод нэгдсэнээр гишүүн орнууд зохицуулалтын нэгдсэн дүрмээ тогтох, хамтын ажиллагааг хялбаршуулах, хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой нь харагдаж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[250] https://www.who.int/medicines/publications/druginformation/WHO-DI_30-4_RegCollaboration.pdf
[251] https://au.int/en/pressreleases/20200205/african-medicine-agency-ama-treaty
[252] https://www.bnt.eu/en/news/legal-news/2602-launch-of-eurasian-economic-union-eaeu-medicines-registration-procedure

### 1.2. Эмийн үнийн хөнгөлөлтийн талаарх зөвлөмж

2018 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага( ДЭМБ)-ын Европын бүсийн газраас Зүүн Европ ба Төв Азийн эмийн үнэ тогтоох болон эмийн үнийн хөнгөлөлтийн системүүдийг харьцуулан судалсны үндсэн дээр **"Зүүн Европ ба Төв Азийн эмийн үнийн болон хөнгөлөлтийн систем"** сэдэвт харьцуулсан судалгааны тайланг гаргажээ. (Pharmaceutical pricing and reimbursement systems in eastern europe and central asia, WHO)[253]

Уг судалгаанд Зүүн Европ ба Төв Азийн 11 улсын эмийн үнийн болон хөнгөлөлтийн системийг харьцуулан авч үзсэн бөгөөд үүнд Армени, Азербайжан, Беларусь, Гүрж, Казахстан, Киргиз, Молдова, Тажикистан, Туркменистан, Украин, Узбекистан улсуудыг хамруулсан байна. Судалгаанд авагдсан орнуудын эмийн үнэ тогтоох, худалдах -худалдан авах, санхүүжилтийн систем, энэ талаар баримталж буй бодлогыг харьцуулан судалсан байна.

Энэ бүс нутагт Эмийн үнийн хөнгөлөлтийн мэдээллийн сүлжээ (Pharmaceutical Pricing and Reimbursement Network,PPRI)[254] байгуулагдсан бөгөөд эгнээндээ Европын 50 томоохон орнууд, олон улсын болон Европын институтуудыг багтаасан, эмийн үнийн хөнгөлөлт, нөхөн төлбөрийн чиглэлээр мэдээлэл солилцох, туршлага хуримтлуулах эрх бүхий байгууллагуудын сүлжээ хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Зүүн Европ ба Төв Ази (EECA) дэд бүлэгт Армени, Азербайжан, Беларусь, Гүрж, Казахстан, Киргиз, Молдова, ОХУ, Тажикистан, Туркменистан, Украин, Узбекистан зэрэг орнууд багтдаг байна.

Энэхүү сүлжээний гол зорилго нь эмийн бодлогын асуудлаар шинжлэх ухаанд суурилсан нэгдмэл нэг ойлголттой болох, төрийн бодлогын асуудлаар мэдээлэл солилцох, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэх ба ерөнхий удирдлага, зохион байгуулалтыг PPRI-ийн нарийн бичгийн дарга нарын газар хариуцан хэрэгжүүлнэ.[255]

Уг сүлжээний шугамаар ихэвчлэн ХДХВ, элэгний болон сүрьеэгийн эмийн хүртээмжийн талаарх мэдээллийг ихэвчлэн цуглуулдаг байна. Дээрх судалгаанд авагдсан орнуудаас 7 оронд амбулатори болон хэвтэн эмчлүүлэх үед, мөн амбулаторийн зарим эмэнд үнийн зохицуулалт хийдэг байна. Үүнээс 5 оронд эмийн худалдааны бүх түвшинд (бөөний худалдаа болон аптекийн жижиглэнгийн үнэ) гадаад дахь эмийн үнийн судалгаа, лавлагаа гаргасны нэмэгдлийг шингээх бодлоготой байна. Хэвтэн эмчлүүлэх тасагт шаардлагатай эмийг ихэвчлэн төвлөрсөн худалдан авалтын горимын дагуу тендэр зарлаж худалдан авах бөгөөд эмчилгээнд үнэгүй хэрэглэнэ. Халдварт өвчний эмчилгээнд хэрэглэх эмийг мөн төрөөс үнэгүй нийлүүлнэ. Бусад тохиолдолд гадуур эмчилгээнд хэрэглэгдэж буй эмийг иргэд өөрсдөө худалдан авах ба Засгийн газрын эмийн хөнгөлөлтийн жагсаалтад орсон зарим нэр төрлийн эмийг хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжтой. Улс орнууд эмийн худалдан авалт, санхүүжилт, эмийн үнийн хөнгөлөлтийн янз бүрийн аргуудыг хэрэглэж байна.

Энэхүү тайланд ихэвчлэн PPRI[256] (EECA) гишүүн орнуудын үндэсний сүлжээгээр дамжуулан авч, PPRI-ийн Нарийн бичгийн дарга нарын газрын загвараар боловсруулсан мэдээллийг тусгасан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[253] Drug reimbursement systems: international comparison and policy recommendations https://kce.fgov.be/sites/default/files/2021-11/KCE_147C_Drug_reimbursement_systems_4.pdf
[254] Мөн тэнд
[255] (https://ppri.goeg.at/supporting networks).
[256] Эмийн үнийн хөнгөллөлтийн мэдээллийн сүлжээ.

***Судалгааны тайлангийн гол үр дүн***

- Тайланд хамрагдсан орнууд нь ихэвчлэн эрүүл мэндийн нэгдсэн даатгалын системтэй байх бөгөөд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хамрах хүрээгээ улам өргөжүүлэхийн төлөө ажиллаж байна.
- Тайланд хамрагдсан орнуудаас Молдова, Узбекистан зэрэг улсууд эмийн үндэсний нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж байна. Украинаас бусад орнууд эмийн худалдан авалтыг тендерээр хийдэг бол Украин улс нэгдсэн худалдан авалтын системтэй.
- Тайланд хамрагдсан 11 улсын 7 нь (Азербайжан, Беларусь, Казахстан, Молдова, Туркменистан, Украин, Узбекистан) эмийн худалдааны бүх түвшинд эмийн хөнгөлөлт үзүүлэх зохицуулалттай бол зарим орнуудад хөнгөлөлттэй эмийн жагсаалтаар, зарим оронд бүх эмэнд хөнгөлөлт үзүүлдэг байна.
- Беларусь, Гүрж, Киргиз зэрэг улсуудад эмийг НӨАТ-аас чөлөөлдөг бол Армени, Азербайжан, Тажикистанд бусад бүтээгдэхүүний адилаар эмэнд татвар ногдуулдаг байна.
- Эмийн бүрэн үнийн зохицуулалттай улс орнуудад эмийн үнийг тогтоохдоо гадаад (ERP) болон дотоод (IRP) дахь үнийн лавлагаа, харьцуулалтыг хийдэг байна.

*Хүснэгт 2. PPRI[257] (EECA) сүлжээний орнуудын эрүүл мэндийн тогтолцоо ба санхүүжилтийн систем, 2018 он*

| Д/д | Улс | ЭМД/НД | Тогтолцоо | Хамрах хүрээ | Санхүүжилтийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| 1 | Армени | Холимог: ЭМД, НД | Төвлөрсөн бус | 99.9% | Холимог: Татвар, НД |
| 2 | Азербайжан | ЭМД | Төвлөрсөн | Нийтийн | Татвар |
| 3 | Беларусь | ЭМД | Мэдээлэл байхгүй | Нийтийн | Татвар |
| 4 | Гүрж | ЭМД | Төвлөрсөн бус | Нийтийн /гэхдээ улсын төсвөөс санхүүждэг жижиг багцад зориулсан/ | Татвар |
| 5 | Казахстан | ЭМД | Төвлөрсөн бус | Нийтийн | Татвар |
| 6 | Киргиз | Холимог: ЭМД, НД | Төвлөрсөн | Нийтийн | НД, Татвар |
| 7 | Молдова | НД | Төвлөрсөн | 87% | НД,Татвар |
| 8 | Тажикистан | ЭМД | Төвлөрсөн | Нийтийн | Татвар |
| 9 | Туркменистан | ЭМД | Төвлөрсөн | Нийтийн | Татвар |
| 10 | Украин | ЭМД | Төвлөрсөн бус төвлөрсөн | Нийтийн | Татвар |
| 11 | Узбекистан | ЭМД | Төвлөрсөн бус | Нийтийн | Татвар |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

[257] Эмийн үнийн хөнгөлөлтийн мэдээллийн сүлжээ.

*Хүснэгт 3.PPRI[258] (EECA) сүлжээний орнуудын эмийн үнийн бодлого, зохицуулалт, 2018 он.*

| Д/д | Улс | Үнэ зохицуулдаг эсэх | Хөнгөлөлттэй эмийн бүртгэл | Бодлого | | Хяналт |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Гадаад үнийн лавлагаа (ERP) | Дотоод үнийн лавлагаа (IRP) | |
| 1 | Армени | *Үнийн зохицуулалт байхгүй* | | | | |
| 2 | Азербайжан | Бүрэн зохицуулалттай | Бүртгэлтэй бүх эм | Тийм | Тийм | Жил бүр |
| 3 | Беларусь | Бүрэн зохицуулалттай (2019 оноос) | Олон улсын өмчийн бус 37 эм | 2019 оноос хойш 2 бүлгийн эмэнд туршилтаар | Үгүй | Мэдээлэл байхгүй |
| 4 | Гүрж | *Үнийн зохицуулалт байхгүй* | | | | |
| 5 | Казахстан | Бүрэн зохицуулалттай | Бүх эм (2019 оноос) | Тийм | Үгүй | Жил бүр |
| 6 | Киргиз | *Үнийн зохицуулалт байхгүй* | | | | |
| 7 | Молдова | Бүрэн зохицуулалттай | Бүртгэлтэй бүх эм | Тийм | Тийм | Жил бүр |
| 8 | Тажикистан | *Үнийн зохицуулалт байхгүй* | | | | |
| 9 | Туркменистан | Түгээлтийн зохицуулалттай | Бүх эм | Үгүй | Үгүй | Мэдээлэл байхгүй |
| 10 | Украин | Бүрэн зохицуулалттай | Нөхөн төлөгдөх эм | Тийм | Тийм | Хагас жил бүр |
| 11 | Узбекистан | Бүрэн зохицуулалттай | Нийгмийн ач холбогдолтой 112 эм | Тийм | Үгүй | Улирал бүр |

## ХОЁР.ЭМИЙН ҮНИЙН ХӨНГӨЛӨЛТИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

### 2.1. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

2020 оны байдлаар БНСУ-ын иргэдийн 97.2% нь Үндэсний эрүүл мэндийн даатгал (NHI)-д[259] хамрагдсан байна. Эмийн үнийн дүнгийн 60%-ийг Засгийн газрын эмийн санхүүжилтээс, эрүүл мэндийн сайн дурын даатгалаас 1%, өвчтөний халааснаас 39% нь гардаг байна. Үндэсний эрүүл мэндийн даатгалаас амбулатори болон хэвтэн эмчлүүлэгчдийн 30-60%, эмийн 20% орчим нөхөн олговор олгогддог байна. Тус улс нь *“нэг төлөгчийн систем”*-тэй бөгөөд энэ нь бүх шимтгэлийг төлснөөр нөхөн төлбөрийг Үндэсний эрүүл мэндийн даатгалын систем (NHI system)-ээр төлдөг гэсэн үг юм. NHI системийг Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яам, Үндэсний эрүүл мэндийн даатгалын алба, Эрүүл мэндийн даатгалын үнэлгээний алба хамтран удирддаг байна. Даатгалын тэтгэмж нь бүх шимтгэл төлөгчдөд ижил хэмжээтэй байдаг. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авахдаа тухайн иргэн “*хамтарсан төлбөр*” буюу тодорхой хувийн төлбөрийг халааснаасаа төлдөг. Хамтарсан төлбөр нь хаана ямар тусламж үйлчилгээ авч байгаа болон тусламж үйлчилгээний төрлөөс хамааран өөр өөр байдаг боловч дундаж үзүүлэлтээр хэвтэн эмчлүүлэх үйлчилгээ 20%, амбулаторийн үйлчилгээ 30-50%, хорт хавдрын үзлэг 90%, эмийн сангийн төлбөрийн 35-40% байна.

[258] Эмийн үнийн хөнгөлөлтийн мэдээллийн сүлжээ.
[259] NHI https://www.nhis.or.kr/nhis/index.do

*График 1. Нэг хүнд ногдох эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шимтгэл /2011-2016 он/*




*Эх сурвалж:* *https://www.mohw.go.kr/eng/hs/hs0110.jsp?PAR_MENU_ID=1006&MENU_ID=100610*

**Хууль эрх зүйн орчин**

БНСУ-д эм болон эмийн бүтээгдэхүүний нөхөн олговрын харилцааг Эмийн тухай хууль болон Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудаар зохицуулж байна.

*1.Эмийн тухай хууль* (Act on the Promotion of Korea medicine and pharmaceuticals)[260] нь бүх ард түмний эрүүл мэндийг дэмжих, БНСУ-ын анагаах ухаан, эм зүй технологийг хөгжүүлэхэд үндэс суурь болох зорилготой байна. Тус хуульд Засгийн газар нь эмийн технологийг хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх, орон нутгийн засаг захиргааны нэгж нь холбогдох бодлого шийдвэрийг үндэслэн эмийн технологи болон хангамжийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулна гэж заажээ.

*2.Үндэсний эрүүл мэндийн даатгалын тухай хууль* (National Health Insurance Act)[261] нь Нийт ард иргэдийг өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, оношлох, нөхөн сэргээх, төрөлт, нас баралт, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлт үзүүлэх замаар нийгмийн эрүүл мэндийг сахин хамгаалах зорилготой байна.

Эм болон эмийн бүтээгдэхүүнийг эрүүл мэндийн даатгалын тогтолцоогоор санхүүжүүлдэг бөгөөд эмийн үнэ, нөхөн төлбөртэй холбоотой асуудлыг Үндэсний эрүүл мэндийн даатгалын газар (NHIS)[262] хариуцан ажилладаг байна.

Тус улсын эм, эмнэлгийн хэрэгсэлд Хүнс, эмийн аюулгүй байдлын яам болон Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам хяналт тавьдаг.

*Хүнс, эмийн аюулгүй байдлын яамны чиг үүрэг:*

- Эмийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, импортлох, борлуулах;
- Шинэ эмийн аюулгүй байдал, үр дүнгийн үнэлгээ;
- Эмнэлзүйн туршилт;
- Эмийн бүтээгдэхүүний ангилал, стандартыг тогтоох;
- Захиргааны захирамж, торгууль ногдуулах;
- Эм болон эмийн бүтээгдэхүүний шошго, сурталчилгаанд хяналт тавих.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[260] Act on the Promotion of Korea medicine and pharmaceuticals https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=PHARMACEUTICAL&x=0&y=0#liBgcolor0

[261] National Health Insurance Act https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=59574&type=sogan&key=10

[262] NHIS https://www.nhis.or.kr/english/wbheaa02200m01.do

*Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамны чиг үүрэг:*

- Эмийн үнийн журмыг мөрдүүлэх;
- Эрүүл мэндийн байгууллагад хяналт тавих.

*Үндэсний эрүүл мэндийн даатгалын алба нь:*

- Эрүүл мэндийн даатгалын шимтгэл ногдуулах, нөхөн олговор олгох;
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэтгэмжийг зохицуулах;
- Тэтгэмжийн зардлыг төлөх;
- Эрүүл мэндийн даатгалтай холбоотой судалгаа шинжилгээ хийх;
- Эмнэлгийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх хөтөлбөр боловсруулах зэрэг ажлын цогц төлөвлөгөөг боловсруулах чиг үүрэгтэй ажилладаг байна.

Эрүүл мэндийн даатгалын цогц төлөвлөгөөний дагуу эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн урт болон дунд хугацааны хэтийн төлөвлөлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалтай холбоотой асуудлын талаар Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх эрүүл мэндийн даатгалын бодлогын зөвлөл шийдвэрлэдэг.

**Эмийн нөхөн олговор**

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамны эмийн менежментийн хэлтэс нь эмийн нөхөн олговрын асуудлыг хариуцан ажилладаг байна. Нөхөн олговор олгодог эмийн үнийн зардлын дээд дүнг Ерөнхийлөгчийн зарлигаар 5 жил тутам нэг удаа бууруулдаг. Эрүүл мэнд, нийгэм хамгааллын сайд эмийн нөхөн олговрыг 40/100-аас хэтрүүлэхгүй хэмжээгээр хэсэгчлэн үнийг буулгах эрхтэй байна.

Эм болон эмийн бүтээгдэхүүний үнэ, нөхөн олговрын талаар

- Эрүүл мэндийн даатгалын тойм, үнэлгээний үйлчилгээний газар;
- Үндэсний эрүүл мэндийн даатгалын газар;
- Эрүүл мэнд, нийгэм хамгааллын яамны шийдвэрийн дагуу эмийн нөхөн олговрыг олгодог байна.

Үйлдвэрлэгч, эсхүл импортлогч нь үнийн болон нөхөн төлбөр олгохыг хүссэн тохиолдолд Эрүүл мэндийн даатгалын тойм, үнэлгээний үйлчилгээний газар нь бүтээгдэхүүний нөхөн төлбөрийн түвшинг тодорхойлж, хамгийн их нөхөн олговрын хэмжээг Үндэсний эрүүл мэндийн даатгалын газар санал болгож, нөхөн төлбөрийн хамрах хүрээг шийдвэрлэдэг. Эм болон эмийн бүтээгдэхүүний бодит гүйлгээний үнийг жил бүр харьцуулж дундаж үнийг гаргадаг. Харин шинэ эм болон эмийн бүтээгдэхүүний үнэ, нөхөн олговрыг фармако-эдийн засгийн үнэлгээний дагуу тодорхойлдог.

Шинэ эмийн нөхөн олговрыг олгох үед:

- Үндэсний эрүүл мэндийн даатгалын газраас тухайн эмийн ач холбогдол, зардлын үр ашгийг үнэлэх аргаар нөхөн олговор олгох боломжтой эсэхийг тодорхойлно;
- Бусад улс, улс хоорондын болон орон нутгийн эмийн үнийг Үндэсний эрүүл мэндийн даатгалын төсөвт үзүүлэх нөлөө зэргийг судлан эмийн нөхөн олговрын хэмжээг тодорхойлно.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

## 2.2.БҮГД НАЙРАМДАХ ФИНЛАНД УЛС

Финланд Улсын эрүүл мэндийн зардлын санг нь ажил олгогч, ажилтны шимтгэл болон засгийн газраас санхүүжүүлдэг. Нийгмийн даатгалын байгууллага болох Кела[263] нь гэр бүлийн тэтгэмж, эрүүл мэндийн даатгал, ажилгүйдлийн тэтгэмж, нийгмийн суурь тусламж, орон сууцны тэтгэмж, оюутнуудад зориулсан тэтгэмж, тахир дутуу хүмүүсийн тэтгэмж зэрэг тэтгэмжийн асуудал хариуцсан бие даасан байгууллага бөгөөд ажлаа парламентад тайлагнадаг байна. Келагийн

[263] Kela https://www.kela.fi/yhteistyokumppanit-laakeyritykset-laake-sai-korvattavuuden

удирдлага, үйл ажиллагааг УИХ-аас томилогдсон 12 итгэмжлэгдсэн төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөөлөгчдийн сонгосон 8 аудитор удирддаг. Нийгмийн даатгалын байгууллага нь амбулаторийн эм бэлдмэлийг санхүүжүүлдэг бол хотын захиргаа нь эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эмийг санхүүжүүлдэг байна. Гэхдээ амбулаторийн эмчилгээнээс эмнэлэгт шилжих, эсхүл эмнэлгээс амбулатори руу шилжих зэргээс хамааран хотын захиргаа болон нийгмийн даатгалын байгууллагын хооронд эмийн зардал шилжих боломжтой байдаг. Тус улсад эмийн жорыг цахимаар өгдөг буюу эмч нар цаасан дээр эмийн жор бичиж өгдөггүй байна.

**Хууль эрх зүйн орчин**

*1.Эмийн тухай хууль* (Medicines Act)[264] Тус хуулиийн зорилго нь эмийн аюулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ, эм хадгалах, эм сурталчлах, эм бэлдмэлийг чанартай стандартын дагуу үйлдвэрлэх, хүртээмжтэй байдлыг хангах явдал юм. Нөхөн олговор олгох эмийг тус хуулиар зааж өгсөн байдаг.

*2.Эрүүл мэндийн даатгалын тухай хууль* (Health Insurance Act)[265]-ийн 5 дугаар бүлэгт “Эмийн нөхөн олговор” гэсэн бүлгээр хөнгөлөлттэй эмийн харилцааг зохицуулж байна. Эрүүл мэндийн даатгал төлсөн даатгуулагч нь эм, эмийн нэмэлт бүтээгдэхүүн, зарим төрлийн тосон түрхлэгт нөхөн олговор авна. Анхан, үндсэн, тусгай гэсэн 3 ангиллын дагуу эмийн нөхөн олговор олгох асуудлыг Нийгэм хамгаалал, Эрүүл мэндийн яамнаас томилсон Эмийн үнийн зөвлөл[266] шийдвэрлэдэг байна.

*Эмийн үнийн зөвлөлийн чиг үүрэг:*

- Нөхөн олговор олгох эмийг жагсаалтыг батлах;
- Нөхөн олговрын үнийн дүнг тогтоох, баталгаажуулах;
- Нөхөн олговор олгох эмийн хугацааг баталгаажуулах, цуцлах;
- Шинээр нэмэгдсэн эм болон эмийн түүхий эдийг бүртгэх, үнийн хязгаар болон хөнгөлөлт үзүүлэх хэмжээг тодорхойлох;
- Орлуулах эмийг сонгох, ижил төстэй эмийн жагсаалтыг батлах;
- Эм ханган нийлүүлэх бөөний үнийг тогтоох;
- Эмийн сав баглаа, боодлын стандартыг батлах;
- Тусгай зөвшөөрлөөр нийлүүлсэн эмийн нөхөн олговрын хувь хэмжээг тогтоох;
- Эм экспортлох зөвшөөрөл олгох;
- Эмийн импортод хяналт тавих, жишиг үнэ тогтоох зэрэг ажлыг зохион байгуулж хариуцан ажилладаг.

**Эмийн зардлын нөхөн олговор**

19 нас хүрсэн иргэн Нийгмийн даатгалын байгууллагаас Кела карт авснаар тус байгууллагын нөхөн олговор, халамж авах эрх нээгддэг байна.

*Анхан шатны эмийн нөхөн олговор*[267] - Тус ангилалд астма, цусны даралт зэрэг 10-аад төрлийн өвчний эм хамаарна. Иргэд эхлээд эмийн нөхөн олговор олгох жагсаалтад багтсан эмнээс 50 евро хүртэлх эмийг өөрөө худалдан авснаар илүү гарсан дүнгээс эмийн нөхөн олговор авах эрхтэй болдог байна. Жишээ нь, 80 еврогийн эм худалдан авсан тохиолдолд 50 евро анхан шатны эм худалдан авах шаардлагыг хангаж, үлдсэн 30 еврогоос төлбөр авах боломжтой болно. 2022 оны байдлаар тухайн жилийн иргэний халааснаас гарах зардлын дээд хязгаарыг 592.16 евро гэж тогтоосон байна. Хэрэв энэ хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд энэ жилийнхээ үлдсэн хугацаанд нөхөн олговор авах эм тус бүрд 2.50 еврогийн нөхөн төлбөр төлнө. Нийгмийн даатгалын байгууллагад эмийн нөхөн олговор авах эрхтэй иргэний мэдээлэл бүртгэгдсэн байх бөгөөд эмийн сангууд цахимаар шалгасны үндсэн дээр эмийн нөхөн олговор олгоно. Эмийн нөхөн олговрыг олгохдоо жишиг эмийн үнийн жагсаалтаар баталсан үнийн

[264] Medicines Act https://www.fimea.fi/documents/160140/765540/18580_Laakelaki_englanniksi_paivitetty_5_2011.pdf
[265] Health Insurance Act https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/2004/en20041224_20110911.pdf
[266] Pharmaceuticals Pricing board https://www.hila.fi/en/operations-and-organisation/#PharmaceuticalsPricingBoard
[267] Анхан шатны эмийн нөхөн олговор https://www.kela.fi/laakkeet#alkuomavastuu

дүнгийн дагуу олгоно. Эхний эмийн худалдан авалтыг хийсний дараа дараагийн эмийн багцаас нөхөн олговрыг:

- Өмнөх багц дуусахаас 1 долоо хоногийн өмнө, 1 сарын хугацаатай эмчилгээний төлбөр төлсөн үед;
- Өмнөх багц дуусахаас 2 долоо хоногийн өмнө, 2 сарын хугацаатай эмчилгээний төлбөр төлсөн үед;
- Өмнөх багц дуусахаас 3 долоо хоногийн өмнө, 3 сарын хугацаатай эмчилгээний төлбөр төлсөн үед авна.

*Үндсэн эмийн нөхөн олговор* - Анхан шатны эмийн нөхөн олговор авсан иргэд дараагийн шатны үндсэн эмийн нөхөн олговор болох эмийн 40%-ийн нөхөн олговор авна.
*Тусгай эмийн нөхөн олговор*[268]- Тус ангилалд зүрхний архаг дутагдал, холбогч эдийн өвчин, титэм судасны өвчин зэрэг 12 өвчний заалтад уух эмийг 65%, чихрийн шижин, хорт хавдар зэрэг амь насанд аюултай 34 өвчний заалтаар урт хугацааны турш уух, хүнд хэлбэрийн өвчтөнд зориулсан тусгай жорын эмэнд 100% нөхөн олговор олгож, 4.50 еврогийн тусгай нэмэлт төлбөр төлнө.




*Эх сурвалж: https://www.kela.fi/medicine-expenses*

*Эмнэлзүйн хоол тэжээлийн бүтээгдэхүүний нөхөн олговор*- Эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу дээрх 3 ангиллын эмийн нөхөн олговроос гадна эмнэлзүйн хоол тэжээлийн бүтээгдэхүүний нөхөн олговрыг үнээний сүүний харшилтай бага насны хүүхэд, төрөлхийн бодисын солилцооны эмгэгтэй, шим тэжээл боловсруулах эмгэгтэй, хоол тэжээлийн дутагдалтай зэрэг өвчтөнд 65%-ийн эмнэлзүйн бүтээгдэхүүний нөхөн олговор олгодог.

### 2.3.БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС (БНХАУ)

Хятад Улсын эмийн зах зээл нь дэлхийд АНУ-н дараагаар буюу II-т эрэмбэлэгдэж байна. Хятад Улс нь эрүүл мэндийн зардлынхаа 40 хувийг эм бэлдмэлд зарцуулдаг байна. Эмийн салбарт дотоодын 5000 гаруй үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

[268] Тусгай эмийн нөхөн олговор https://finlex.fi/fi/laki/ajantasa/2013/20130025

UIH.MN СУДАЛГААНЫ САН

**Хууль эрх зүйн орчин**

БНХАУ-д эм болон хөнгөлөлттэй эм, түүнтэй холбоотой эрх зүйн харилцааг “БНХАУ-ын Эмийн хяналтын тухай хууль”-аар зохицуулж байна.

Тус хуулийг 2019 оны 08-р сарын 26-ны өдөр БНХАУ-н Ардын Их Хурлын Байнгын хорооны 12-р хурлаар 2 дахь удаагаа шинэчлэн найруулж баталсан байна. Уг шинэчлэн баталсан хуулийг 2019 оны 12-р сарын 01-нээс эхлэн дагаж мөрдсөн. БНХАУ-н Эмийн хяналтын тухай хууль нь 12 бүлэг, 155 зүйлтэй байна. Хуулийг ерөнхий бүлгээр нь авч үзвэл дараах 12 бүлэгт хувааж байна.

1. Ерөнхий заалтууд
2. Судалгаа, хөгжил, бүртгэл
3. Маркетингийн зөвшөөрөл эзэмшигч
4. Үйлдвэрлэл
5. Түгээлт
6. Эмнэлгийн байгууллага дахь эмийн сангийн удирдлага
7. Маркетингийн дараах менежмент
8. Үнэ ба сурталчилгаа
9. Нөөц ба хангамж
10. Дүрэм
11. Хуулийн хариуцлага
12. Нэмэлт заалтууд

Эмийн хяналтын тухай шинэ хуульд хүүхдийн эм, хомстолтой байгаа эм, хүнд халдварт өвчний эм, ховор өвчний эм зэргийг нэн тэргүүнд хянах, зохицуулах тухай эрх зүйн орчныг бүрдүүлэн байна. Мөн эмийн үйлдвэрүүдэд хүлээлгэх хариуцлага, эм үйлдвэрлэлийн салбар дахь авлигыг зогсоох тухай хуулийн хориг арга хэмжээг зааж, эмийн үйлдвэрүүдийн үүрэг хариуцлагыг онцолсон байна.

**Эмийн нөхөн олговор**

Хятад Улсад “Үндэсний нөхөн олговор олгох эмийн жагсаалт”[269] гэх нэртэй хөнгөлөлттэй эмийн жагсаалт байна. Энэ нь Хятад Улсын нийт хүн амын 98 хувийг хамарсан төрөөс олгож буй эмийн нөхөн олговор юм. Тус хөнгөлөлттэй эмийн жагсаалт нь 2017 оноос хойш жил бүр шинэчлэгдэж 2017 онд 2.588 эм багтаж байсан бол 2022 онд хөнгөлөгдөх эмийн жагсаалт нь 2.860 болж нэмэгдсэн байна. 2017 оноос өмнө хөнгөлөлттэй, жороор олгодог эмнүүд нь ихэвчлэн дотоодын үйлдвэрийн эм байсан бол 2017 оноос эхлэн тус эмийн жагсаалтыг жил бүр шинэчилж байхаар болсон.

Хятадын хөнгөлөлттэй эмийн 2021 оны жагсаалт шинэчлэгдэж, 2022 онд 74 эм шинээр нэмэгдэж, эрэлт багатай 11 эм хасагдсан ба нийт 2.860 нэр төрлийн эм тус жагсаалтад байна. Үүнээс 1.486 нь барууны буюу импортын эм, 1.374 нь Хятадын дотоодод үйлдвэрлэсэн эм байна. Уг жагсаалтын нийт эмийг авч үзвэл худалдаалагдах зах зээлийн үнээс дунджаар 62% хөнгөлсөн байна. Энэ нь 2017 оноос хойш хамгийн өндөр үзүүлэлт юм.[270]

Хөнгөлөлттэй эмийн үнийн хөнгөлөлтийн дундаж хувь нь 2020 онд 51% байсан бол 2021 онд 62% болж өссөн байна. Доорх зурагт 2017-2021 оны хөнгөлөлтийн хувийг дундажлан харуулав.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[269] https://www.pharmexec.com/view/china-2021-national-reimbursement-drug-list-outlook
[270] https://globalpricing.com/articles/china-issues-2021-national-reimbursement-drugs-list/

*График 2.Эмийн хөнгөлөлтийн дундаж хувь*




Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон 74 эм нь эмчилгээний 21 чиглэлийг хамарсан бөгөөд үүнд цусны даралт ихсэх зэрэг архаг өвчний эм, чихрийн шижин, сэтгэцийн эм, вирусын халдварын эсрэг эм, ховор өвчний эм зэрэг орсон байна.

*График 3. Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон эмийн төрөл*




Хятадын эмийн зах зээлд 3 үндсэн чиглэл байна.

1. Хувийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээ
2. Хөнгөлөлтөөс гадуур бусад эм
3. Хөнгөлөлттэй эм

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хятад Улсад эмийн зах зээлийн 60%-ийг хөнгөлөлттэй эм, 40%-ийг хөнгөлөлтөөс гадуур бусад эм бүрдүүлж байна.

Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсноор тухайн эм нь бүтэн, эсвэл хэсэгчлэн хөнгөлөгдөж, улсын эмнэлгүүдэд жороор олгогддог болох юм. Гэвч хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орох нь шууд улсын эмнэлгийн эмийн жагсаалтад орох гэсэн үг биш юм. Учир нь эмнэлгүүд дотооддоо хийдэг сонгон шалгуураар эмнэлгийн эмийн жагсаалтад шинэ эмийг нэмж оруулдаг. Тус шалгуур нь эмнэлэг бүр харилцан адилгүй байх бөгөөд зарим нь жил бүр байхад зарим нь хэдэн жилд ганц удаа хөнгөлөлттэй эмийн жагсаалтаа шинэчилдэг байна. 800-аас дээш ортой улсын эмнэлгүүдэд 1500-аас илүүгүй хөнгөлөлттэй эмийг эмийн жагсаалтад оруулахыг

зөвшөөрдөг байна. Энэ нь "Үндэсний хөнгөлөлттэй эмийн жагсаалт"-д орсон нийт 2.860 нэр бүхий эм байхад улсын эмнэлэгт 1500-г зөвшөөрч байгаа нь салбарын мэргэжилтнүүдийн шүүмжлэлийг дагуулж байна.

Эмнэлэг нь хөнгөлөлттэй эмийн жагсаалтаа шинэчилж шинэ эм бүртгэхийн тулд одоо жагсаалтад байгаа зарим эмийг хасах шаардлагатай болж байгаа юм. Энэ нь жижиг, шинэ эмийн үйлдвэрүүдэд хүндхэн шалгуур болдог байна.

Асуудлыг шийдвэрлэхийн тулд Хятадын эрх баригчид "Үндэсний хөнгөлөлттэй эмийн жагсаалт"-д багтсан эмийг хувь эмийн сангуудад зарахыг зөвшөөрсөн боловч эмийг авахын тулд эмийн жороор өгөх шаардлагатай бөгөөд эмнэлгүүд жагсаалтаас гадуур жор өгөхөөс татгалздаг байна.

Эмийн үйлдвэрлэгчид нь эмийг "Үндэсний хөнгөлөлттэй эмийн жагсаалт"-д оруулах тухай хүсэлт гаргах эрхтэй. Жил бүр сонгон шалгаруулалт явуулж 6-р сараас 12-р сард дараа жилийн хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг шинэчлэн гаргадаг байна. Дараах зурагт хөнгөлөлттэй эмийн сонгон шалгаруулалтын үйл явцыг ерөнхийд нь харуулсан байна.




## 2.4. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС (АНУ)

АНУ нь бүх нийтийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоо байдаггүй. Харин эрүүл мэндийн даатгалд хамрагдахын тулд даатгалын компанид тогтмол төлбөрийг төлж эмчилгээний төлбөрийн зарим хэсэг, эсвэл бүгдийг төлүүлнэ. Эрүүл мэндийн даатгалыг зохицуулах хуулийн дагуу эрүүл мэндийн хөтөлбөрүүдээр хөнгөлөлттэй эмийг хүртээмжтэй түгээх бодлогыг барьдаг.

### Хууль эрх зүйн орчин

2010 онд "Obamacare" буюу Хүртээмжтэй тусламж үйлчилгээний тухай хууль[271] (Affordable Care Act-ACA) хэмээн нэрлэгддэг Өвчтөнийг хамгаалах, хүртээмжтэй тусламж үйлчилгээний тухай хууль (албан ёсоор) АНУ-ын 111 дүгээр Конгрессоор батлагдаж, 03 дугаар сарын 23-ны өдөр Ерөнхийлөгч Барак Обама гарын үсэг зурсан бөгөөд 2010 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Эрүүл мэнд, боловролын зохицуулалтын тухай хууль (Health Care and Education Reconciliation Act of 2010)-аар нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус хуулиар Medicare эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрийг өргөжүүлэх бүх зардлыг Холбооны Засгийн газар төлөхөөр оруулсан бөгөөд (Medicaid-ийн орлого багатай хүмүүсийн эрүүл мэндийн зардлыг хариуцдаг хөтөлбөрийн дагуу) нэмэлтээр зарим мужуудад санхүүжилт илүү өгөхөөр тусгасан. Хөнгөлөлттэй эмийг эмийн жорын дагуу олгох даатгалын дараах хөтөлбөрүүд байна.

Medicare[272] хөтөлбөр нь АНУ-ын Холбооны Засгийн газрын эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр бөгөөд 65 наснаас дээш насныхан, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад хүнд өвчтэй хүмүүс хамрагддаг. Өвчтөнүүд эмнэлгийн болон бусад зардлын суутгалаар зардлынхаа тодорхой хэсгийг төлдөг.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[271] Affordable Care Act https://www.hhs.gov/healthcare/about-the-aca/index.html
[272] Medicare https://www.medicare.gov/what-medicare-covers

Тус хөтөлбөр нь A,B,C,D гэсэн дөрвөн хэсэгт хуваагддаг.

- A хэсэг нь эмнэлэг, сувилахуйн тусламж;
- B хэсэг нь амбулаторийн үйлчилгээ;
- C хэсэг нь өвчтөнд A болон B хэсэгтэй ижил үйлчилгээ үзүүлдэг боловч нэмэлт ашиг тустай төлөвлөгөөг сонгох боломжийг олгодог хувилбар;
- D хэсэг нь жороор олгодог эмийн зохицуулалт болно.

2003 онд Конгресс эмийн жороор олгодог эм, эмийн сайжруулалт, шинэчлэлийн тухай хууль (Medicare Prescription Drug, Improvement, and Modernization Act)-д[273] Medicare Part D[274] хэсгийг нэмж оруулсан.

Энэхүү тэтгэмжийг авахын тулд Medicare-тэй хүн бие даасан жороор олгодог эмийн төлөвлөгөө (PDP), эсвэл олон нийтийн C хэсгийн эрүүл мэндийн төлөвлөгөөнд хамрагдах ёстой. Эдгээр төлөвлөгөөг Medicare хөтөлбөр баталж, зохицуулдаг боловч үнэндээ буяны байгууллага, эрүүл мэндийн нэгдсэн систем, холбоо, эрүүл мэндийн даатгалын компаниуд зэрэг янз бүрийн ивээн тэтгэгчид боловсруулж удирддаг. Medicare (A ба B хэсэг) -ээс ялгаатай нь D хэсгийн хамрах хүрээ стандартчлагдаагүй байна. Төлөвлөгөө нь аль эмийг хамрахаа сонгоно (гэхдээ дор хаяж хоёр эмийг 148 өөр ангилалд багтаасан байх ёстой бөгөөд дараах хамгаалагдсан бүлгийн эмүүдийг хамрах ёстой. Жишээ нь: хорт хавдрын эсрэг, сэтгэцийн эмгэгийн эсрэг, таталтын эсрэг, дархлаа дарангуйлагч, ХДХВ, ДОХ-ын эсрэг эм г.м).

Medicare[275] бол тусламжийн хөтөлбөр бөгөөд бүх насны орлого багатай хүмүүст үйлчилдэг. Өвчтөнүүд ихэвчлэн эмчилгээний зардлын зарим хэсгийг төлдөггүй. Medicaid бол холбооны муж улсын хөтөлбөр юм. Энэ нь муж бүрд өөр өөр байдаг. Үүнийг Холбооны хүрээнд муж, орон нутгийн засаг захиргаа удирддаг.

<u>Medicaid хөтөлбөр</u> нь эмийн хөнгөлөлтийн хөтөлбөр (MDRP) юм. Medicare болон Medicaid үйлчилгээний төвүүд (CMS), муж улсын Medicaid агентлагууд болон эм үйлдвэрлэгчдийг багтаасан хөтөлбөр бөгөөд Medicaid-ийн өвчтөнүүдэд олгодог амбулаторийн жороор олгодог ихэнх эмийн Холбооны болон муж улсын зардлыг нөхөхөд тусалдаг. Энэ хөтөлбөрт одоогоор 780 орчим эм үйлдвэрлэгч оролцож байна. Бүх тавин муж болон Колумбийн дүүрэг нь Нийгмийн хуулийн тухай хууль[276] (Compilation Of The Social Security Laws)-ийн 1927 дугаар зүйлд зөвшөөрөгдсөн MDRP-ийн дагуу жороор олгодог эм хамаарагдана.

Хөтөлбөр нь эм үйлдвэрлэгчээс Эрүүл мэнд, халамж үйлчилгээний газрын (HHS) нарийн бичгийн даргатай Эмийн хөнгөлөлтийн үндэсний гэрээ (NDRA) байгуулж, үйлдвэрлэгчийн ихэнх эмийг улсын Medicaid-д хамруулахыг шаарддаг. Үйлдвэрлэгч амбулаторийн шинэ эмийг (COD) зах зээлд гаргахдаа эмийн талаарх бүтээгдэхүүн, үнийн мэдээллийг Medicaid Drug Programs (MDP) системээр дамжуулан CMS-д өгөх ёстой. Эм үйлдвэрлэгчид улсын төлөвлөгөөний дагуу төлбөрийг хийсэн эмэнд хөнгөлөлт үзүүлэх үүрэгтэй. Эдгээр хөнгөлөлтийг эм үйлдвэрлэгчид улирал бүр муж улсуудад төлдөг бөгөөд Medicaid хөтөлбөрийн дагуу жороор олгодог эмийн нийт зардлыг нөхөх зорилгоор муж улсууд болон Холбооны Засгийн газар хооронд хуваарилдаг.

NDRA-д гарын үсэг зурахаас гадна эм үйлдвэрлэгчид эмээ Medicaid-д хамруулахын тулд Холбооны дараах хоёр хөтөлбөртэй гэрээ байгуулах шаардлагатай.

1. Эрүүл мэндийн нөөц, үйлчилгээний газраас удирддаг Эмийн үнийн 340B (340B drug Pricing Program) хөтөлбөрийн үнийн гэрээ;

UILMN СУДАЛГААНЫ САН

[273] Medicare Prescription Drug, Improvement, and Modernization Act https://en.wikipedia.org/wiki/Medicare_Prescription_Drug,_Improvement,_and_Modernization_Act https://www.congress.gov/bill/108th-congress/house-bill/1
[274] Medicare Part D https://en.wikipedia.org/wiki/Medicare_Part_D
[275] Medicaid https://www.medicaid.gov/medicaid/prescription-drugs/medicaid-drug-rebate-program/index.html
[276] Compilation Of The Social Security Laws https://www.ssa.gov/OP_Home/ssact/title19/1927.htm

2. Холбооны хангамжийн хуваарийн ахмад дайчдын асуудал эрхэлсэн нарийн бичгийн даргатай хийсэн гэрээнүүд болно.

340B[277] (340B drug Pricing Program)- Конгресс 1992 онд 340B (340B drug Pricing Program) Эмийн үнийн хөтөлбөрийг бий болгож, аюулгүй байдлын сүлжээтэй эмнэлгүүдийг эмийн үнэ өсөхөөс хамгаалахын тулд амбулаторийн эмийг үйлдвэрлэгчдээс хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжийг олгосон.

**Харьяалах байгууллага**

АНУ-ын Холбооны Засгийн газрын агентлаг болох Medicare & Medicaid Services[278] (CMS) төвөөс эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрүүдийг удирддаг. Тус төв нь Эрүүл мэнд, халамж үйлчилгээний яам (HHS)-ны харьяа холбооны агентлаг бөгөөд Medicare хөтөлбөр, мөн хүүхдийн эрүүл мэндийн даатгалын хөтөлбөр болон бусад нэмэлт тусламжийн хөтөлбөрийг багтаасан Medicaid-ийг удирдах байдлаар мужуудтай хамтран ажилладаг.

**2.5.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС (ХБНГУ)**

Германы эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь албан журмын эрүүл мэндийн даатгал (*Gesetzliche Krankenversicherung* ) (SHI) болон сайн дурын эрүүл мэндийн даатгал ( *Private Krankenversicherung*) (PHI) гэсэн хоёр системээр тодорхойлогддог. ЭМД нь нийтэд хүртээмжтэй байдаг ч сайн дурын эрүүл мэндийн даатгалд хамрагдах хүмүүс байдаг. ХБНГУ-ын хуулийн дагуу хууль ёсны оршин суугч хүн бүр эрүүл мэндийн даатгалд хамрагдах ёстой. Тэдний дийлэнх нь албан журмын эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрт хамрагддаг.

Германы албан журмын эрүүл мэндийн даатгалын сан нь (Allgemeine Ortskrankenkassen (AOK))[279] 24 сая гишүүнтэй 11 жижиг сангаас бүрддэг. Barmer GEK, Techniker Krankenkasse нар тус бүрдээ 7.5 сая гишүүнийг даатгуулдаг. 2008 оноос бүх албан журмын эрүүл мэндийн даатгалын сангуудыг үндэсний тэргүүн байгууллага болох Германы эрүүл мэндийн даатгалын сангуудын холбоо[280] (*GKV-Spitzenverband*) нэгтгэдэг. Албан журмын эрүүл мэндийн даатгалын санд даатгуулагчид шимтгэл төлдөг байна.

Харин хүн амын 11 орчим хувь нь ашигладаг сайн дурын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо нь арай өөрөөр ажилладаг (*Private Krankenversicherung*). Даатгуулагч болон хувийн эрүүл мэндийн даатгалын компани хооронд байгуулсан гэрээ нь эмчилгээний зардлыг (эмийг оролцуулан) нөхөн төлүүлэх үндэслэл болно. Сайн дурын эрүүл мэндийн даатгалын ихэнх гэрээнд компанийн даатгалын ерөнхий нөхцөл, тодорхой зардал болон нөхөн олговор олгох бусад зүйлсийн тарифыг тусгасан байдаг.

**Хууль эрх зүйн орчин**

Германд эмийн бүтээгдэхүүнтэй холбоотой Эмийн бүтээгдэхүүний тухай хууль[281] *(*Arzneimittelgesetz-*AMG)* нь Бундестагаас 2005 оны 12-р сарын 12-ны өдөр хүн, амьтныг эрүүл ахуйн шаардлага хангасан эмээр хангах зорилгоор эмийн худалдаа, ялангуяа эмийн чанар, үр ашиг, аюулгүй байдлыг баталгаажуулах зорилготой батлагдсан.

2011 онд шинэчлэгдсэн Эмийн зах зээлийг шинэчлэх тухай хууль[282] "AMNOG" (Arzneimittelmarkt-Neuordnungsgesetz) нь Германы Бундестагаас 2010 оны 11-р сарын 11-нд баталж, үндсэн хэсгүүд нь 2011 оны 01-р сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[277] 340B drug Pricing Program https://www.aamc.org/news-insights/340b#:~:text=Congress%20created%20the%20340B%20Drug,at%20a%20discount%20from%20manufacturers.
[278] Medicare & Medicaid Services https://www.cms.gov/
[279] Allgemeine Ortskrankenkassen https://www.aok.de/pk/
[280] *GKVSpitzenverband* https://www.bundesgesundheitsministerium.de/themen/gesundheitswesen/selbstverwaltung/spitzenverband-bund-der-krankenkassen-gkv-spitzenverband.html
[281] *Arzneimittelgesetz* (AMG)https://www.gesetze-im-internet.de/englisch_amg/
[282] Arzneimittelmarkt-Neuordnungsgesetz https://dip.bundestag.de/vorgang/.../28830

Тус хууль нь шинэ, патентаар хамгаалагдсан жороор олгох эмийн бөөний борлуулалтын үнийг, тогтоосон үнэ бүхий эмийн бүлэгт хамааруулснаас бусад тохиолдолд эм үйлдвэрлэгч тогтоохоор заасан. 2011 оноос хойш энэ нь зах зээлд зөвшөөрөл авснаас хойших эхний жилд хамаарна.

Мөн Нийгмийн тухай хуулийн тавдугаар дэвтэрт Эрүүл мэндийн даатгал[283], эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулсан. Тухайлбал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэтгэмж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, даатгалын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалтыг гаргаж, хуулийг зөрчсөн тохиолдолд торгууль ногдуулдаг. Даатгуулагчид эрүүл мэндээ хэсэгчлэн хариуцаж урьдчилан сэргийлэх эмчилгээнд идэвхтэй оролцон "эрүүл мэнддээ ухамсартай" амьдрах ёстой гэж заасан. Даатгалын компаниуд мэдээлэл өгөх, урьдчилан сэргийлэх эмийн хүртээмжтэй байх ёстой. Ямар хүмүүс даатгалд хамрагдах ёстойг тодорхойлсон. 44-ээс 51-р зүйлд өвчлөлийн тэтгэмж, түүний дотор хүүхэд өвдсөний улмаас ажил таслах шаардлагатай тохиолдолд мөнгөн тэтгэмж олгодог.

**Харьялах байгууллага**

Эрүүл мэндийн даатгалаар олгогдох хөнгөлөлттэй эмийн зохицуулалтыг Германы эрүүл мэндийн яаманд харьяалагддаг бие даасан байгууллага болох Эм, эмнэлгийн хэрэгслийн хүрээлэн[284] (Bundesinstitut *für Arzneimittel und Medizinprodukte* (BfArM)) нь хийдэг. Тус хүрээлэн нь Эмийн хуулийн үндсэн дээр эм бэлдмэлийн чанар, аюулгүй байдал, үр нөлөөг шалгаж, эмийн тусгай зөвшөөрөл олгох, эмийг бүртгэх, эмийн хяналт үнэлгээ, эрсдэлээс урьдчилан сэргийлэх үндсэн үүрэгтэй ажлыг гүйцэтгэдэг.

## ГУРАВ. МОНГОЛ УЛСАД ХӨНГӨЛӨЛТТЭЙ ХУДАЛДААЛЖ БУЙ ЭМИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ /2018-2022/[285]

Монгол Улсад эмийн хөнгөлөлтийг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор[286] баталсан жагсаалтын дагуу эмийн нэр төрөл, хөнгөлөх хэмжээ, үнийн дээд хязгаарыг баримтлан эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эм олгох эрх бүхий гэрээт эмийн сангуудаар дамжуулан олгож ирсэн.

### 3.1. Эмийн үнийн хөнгөлөлт 2018-2019 он

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 08 дугаар тогтоолоор 17 бүлгийн 145 нэршлийн 333 худалдааны нэршлийн эмэнд 2018 онд 25.9 тэрбум төгрөг, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 10 дугаар тогтоолын дагуу 2019 онд 176 худалдааны нэршлийн эмэнд 33.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гэрээ бүхий эмийн сангуудад олгосон байна.

### 3.2. Эмийн үнийн хөнгөлөлт 2020 он

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-г шинэчлэн баталсан. Уг тогтоол хэрэгжсэнээр улсын хэмжээнд Эрүүл мэндийн даатгалын сангаас 2020 онд нийт 36.6 тэрбум төгрөгийн эмийн үнийн хөнгөлөлтийн зайлшгүй шаардлагатай эмийг санхүүжүүлсэн байна.

Эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын 38 хувь нь халдварын эсрэг бэлдмэл, 36 хувь нь зүрх судасны эм, 10 хувь нь ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, 4 хувь нь даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс хамгаалах бэлдмэл, 3 хувь нь уналт,

UIH.MN СУДАЛГААНЫ САН

[283] Эрүүл мэндийн даатгал https://www.ilo.org/dyn/natlex/natlex4.detail?p_isn=43202&p_lang=en
[284] Bundesinstitut *für Arzneimittel und Medizinprodukte* (BfArM)) https://reimbursement.institute/glossar/bfarm/
[285] Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2022.09.29-ний өдрийн ТГ-06/1093 дугаартай албан бичгээр ирүүлсэн мэдээлэл.
[286]Эмийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай, ЭМД-ын ҮЗ-ийн тогтоол, 2022.07.04, дугаар 11 https://legalinfo.mn/mn/detail?lawId=16530818499541

таталтын эсрэг эм, 3 хувь нь сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм, 3 хувь нь цусанд нөлөөлөх эм, 2 хувь нь өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм, 1 хувь нь бөөр, шээсний замд нөлөөлөх эм, харин нүдний өвчинд хэрэглэх бэлдмэл, амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм, харшлын ба анафилаксын эсрэг эм, дархлалын системд нөлөөлөх бэлдмэл, хавдрын эсрэг, дархлал дарангуйлах, хөнгөвчлөх эмчилгээний эм, булчин сулруулах ба холинэстеразийн эсрэг бэлдмэл, салга өвчнийг эмчлэх эм, арьсны өвчнийг эмчлэх бэлдмэл, окситоцин ба түүний эсрэг бэлдмэлүүд, амин дэм, эрдэс бодис, мигрень эмчлэх эмийг 1 хувиас бага даатгуулагч авсан байна.

*График 4. Эмийн үнийн хөнгөлөлт авсан эмийн тоо ширхэг /ерөнхий бүлгээр/*




UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийг насны бүлгээр нь:*

*График 5.0-19 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




0-19 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 17 хувь нь флемоксин солютаб /антибиотик/, 6 хувь нь амоксициллин /антибиотик/, 6 хувь нь хиконцил /үрэвслийн эсрэг/, 6 хувь нь оспамокс 500 */өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг/*, 4 хувь нь кмоксилин /өвдөлт намдаах, халуун бууруулах/, 2 хувь нь карбамазепин /таталтын эсрэг, сэтгэл санааны байдлыг тогтворжуулах/, 2 хувь нь зирекс /үрэвсэл намдаах/, 2 хувь нь макропен /бага тунтай антибиотик/, 2 хувь нь эпилиптор СР /халуун бууруулж, өвчин намдаах/, 2 хувь нь синглон /амьсгалын замын өвчинүүдэд хэрэглэх/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

*График 6. 20-24 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




*20-24 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн* 6 хувь нь панто-денк /ходоод хамгаалж, хүчил бууруулах/, 5 хувь нь ярина /жирэмслэлтээс хамгаалах эм/, 4 хувь нь эпилиптор СР /халуун бууруулж, өвчин намдаах/, 4 хувь нь карбамазепин /таталтын эсрэг, сэтгэл санааны байдлыг тогтворжуулах/, 4 хувь нь протоцид 40 /бөөлжилт намдаах/, 3 хувь нь урсофальк /цөс хөөх бэлдмэл/, 2 хувь нь кларитромицин /антибиотик нян вирусийн эсрэг бэлдмэл/, 2 хувь нь оспамокс 500 /өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг/, 2 хувь нь брайнакт /тархины үйл ажиллагаа сэргээх/, 2 хувь нь цераксон /тархи мэдрэлийн/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*График 7.* 25-29 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/




25-29 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 6 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 5 хувь нь ярина /жирэмслэлтээс хамгаалах/, 4 хувь нь протоцид 40 /бөөлжилт намдаах/, 3 хувь нь урсофальк /цөс хөөх бэлдмэл/, 3 хувь нь карбамазепин /таталтын эсрэг, сэтгэл санааны байдлыг тогтворжуулах эм/, 3 хувь нь урса / цөс хөөж элэгний үйл ажиллагааг дэмжих/, 3 хувь нь эпилиптор СР /халуун бууруулж, өвчин намдаах/, 2 хувь нь брайнакт /тархины үйл ажиллагаа сэргээх/, 2 хувь нь цераксон /тархи мэдрэлийн/, 2 хувь нь кларитросицин /нянгийн эсрэг өргөн хүрээний үйлчилгээтэй/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

*График 8. 30-34 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




30-34 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 5 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 4 хувь нь ярина / жирэмслэлтээс хамгаалах/, 4 хувь нь протоцид 40 /бөөлжилт намдаах/, 3 хувь нь  урсофальк /цөс хөөх бэлдмэл/, 3 хувь нь урса /цөс хөөж элэгний үйл ажиллагааг дэмжих/, 2 хувь нь брайнакт /тархины үйл ажиллагаа сэргээх/, 2 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/, 2 хувь нь цераксон /тархи мэдрэл/, 2 хувь нь карбамазепин /таталтын эсрэг, сэтгэл санааны байдлыг тогтворжуулах/, 2 хувь нь даприл /зүрх судас цусны системд нөлөөлөх/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*График 9. 35-39 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




35-39 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 4 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 3 хувь нь урсофальк /цөс хөөх бэлдмэл/, 3 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/, 3 хувь нь протоцид 40 /бөөлжилт намдаах/, 3 хувь нь диротон /даралт бууруулах/, 3 хувь нь даприл /зүрх судас цусны системд нөлөөлөх, 2 хувь нь урса /цөс хөөж элэгний үйл ажиллагааг дэмжих/, 2 хувь нь ярина /жирэмслэлтээс хамгаалах эм/, 2 хувь нь предизен /зүрх судасны/, 2 хувь нь экватор /даралт бууруулах/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

*График 10. 40-44 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




40-44 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 4 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/, 3 хувь нь диротон /даралт бууруулах/, 4 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 3 хувь нь даприл /зүрх судас цусны системд нөлөөлөх/, 3 хувь нь экватор /даралт бууруулах/, 3 хувь нь предизен /зүрх судасны/, 3 хувь нь урсофальк /цөс хөөх бэлдмэл/, 3 хувь нь протоцид 40 /бөөлжилт намдаах/, 2 хувь нь тенокс /өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг, стеройд бус эм/, 2 хувь нь урса /цөс хөөж элэгний үйл ажиллагааг дэмжих/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*График 11. 45-49 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




45-49 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 4 хувь нь экватор /даралт бууруулах/, 4 хувь нь диротон /даралт бууруулах/, 4 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/, 4 хувь нь даприл /зүрх судас цусны системд нөлөөлөх/, 3 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 3 хувь нь предизен /зүрх судасны/, 3 хувь нь тенокс /өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг, стеройд бус эм/, 2 хувь нь лориста /даралт бууруулах/, 2 хувь нь урсофальк /цөс хөөх бэлдмэл/, 2 хувь нь протоцид 40 /бөөлжилт намдаах/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

*График 12. 50-54 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




50-54 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 5 хувь нь экватор /даралт бууруулах/, 4 хувь нь диротон /даралт бууруулах/, 4 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/, 4 хувь нь даприл /зүрх, судас, цусны системд нөлөөлөх/ 4 хувь нь тенокс /өвдөлт намдаах, халуун бууруулах/, 3 хувь нь предизин /зүрх судасны/, 3 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 3 хувь нь лориста /даралт бууруулах/, 2 хувь нь амлесса /даралт бууруулах/, 2 хувь нь цероз эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

*График 13. 55-59 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




55-59 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 5 хувь нь экватор /даралт бууруулах/, 4 хувь нь тенокс /өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг, стеройд бус эм/, 4 хувь нь диротон /даралт бууруулах/, 4 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/, 4 хувь нь даприл /даралт бууруулах/, 3 хувь нь предизин /зүрх судасны/, 3 хувь нь лориста /даралт бууруулах/, 3 хувь нь амлесса /даралт бууруулах/, 3 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 3 хувь нь амлотоп /даралт бууруулах/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

*График 14. 60-64 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




60-64 насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 4 хувь нь экватор /даралт бууруулах/, 4 хувь нь тенокс /зүрх судасны/, 4 хувь нь предизин /зүрх судасны/, 3 хувь нь диротон /даралт бууруулах/ эм, 3 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/, 3 хувь нь даприл /даралт бууруулах/, 3 хувь нь амлесса /даралт бууруулах/, 3 хувь нь лориста /даралт бууруулах/, 3 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 3 хувь нь амлотоп /даралт бууруулах/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

*График 15. 65 дээш насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчдын тоо /эмийн худалдааны нэршлээр/*




65-аас дээш насны эмийн үнийн хөнгөлөлт авсан даатгуулагчийн 6 хувь нь экватор /даралт бууруулах/, 5 хувь нь тенокс /зүрх судасны/, 4 хувь нь предизин /зүрх судасны/, 3 хувь нь амлотоп /даралт бууруулах/, 3 хувь нь панто-денк 20 /ходоод хамгаалж хүчил бууруулах/, 3 хувь нь амлесса /даралт бууруулах/, 3 хувь нь диротон /даралт бууруулах/, 3 хувь нь даприл /даралт бууруулах/, 3 хувь нь лориста /даралт бууруулах/, 2 хувь нь аторис /цусан дахь өөх тосны хэмжээг бууруулах/ эмийн үнийн хөнгөлөлт авсан байна.

### 3.3.Эмийн үнийн хөнгөлөлт 2021 он

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад багтсан 141 ерөнхий нэршлийн 574 худалдааны нэрийн эмэнд эрүүл мэндийн даатгалын сангаас 30-70 хувийн үнийн хөнгөлөлт олгож, гэрээ бүхий эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилт олгосон байна.

Өнгөрсөн оны байдлаар 510 нэрийн эмэнд 60.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ байгуулсан эмийн сангуудад олгосон байна.

*Хүснэгт 4. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймаг, нийслэлээр*

| № | Аймаг, нийслэл | Санхүүжилт /сая төг/ | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар | 30.582.4 | 50.6% |
| 2 | Аймаг, орон нутаг | 29.817.6 | 49.4% |
| **Нийт** | | **60.400.0** | **100.0%** |

Эндээс харахад эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлт үзүүлсэн санхүүжилт нь нийслэл болон орон нутагт ойролцоо байна.

*Хүснэгт 5. Нийслэлийн дүүргүүдийн эмийн сангуудад олгосон санхүүжилт*

| № | Дүүрэг | Гэрээ байгуулсан эмийн сангийн тоо | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|
| | | | сая төг | хувь |
| 1 | Баянгол | 166 | 5.723.5 | 19.2% |
| 2 | Баянзүрх | 215 | 6.779.8 | 22.8% |
| 3 | Сонгинохайрхан | 121 | 4.526.9 | 15.3% |
| 4 | Сүхбаатар | 105 | 4.022.0 | 13.5% |
| 5 | Хан-Уул | 137 | 4.006.4 | 14.5% |
| 6 | Чингэлтэй | 71 | 3.122.6 | 10.5% |
| 7 | Багануур | 10 | 696.8 | 2.4% |
| 8 | Налайх | 13 | 539.6 | 1.8% |
| **Нийт** | | **838** | **29.817.6** | **100.0%** |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Нийслэлийн хэмжээнд нийт 838 эмийн сан хөнгөлөлттэй эмийн жороор даатгуулагчдад үйлчилж, 29.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас авсан байна. Байршлаар нь харахад Баянзүрх дүүрэгт байрлалтай эмийн сангууд хамгийн өндөр буюу санхүүжилтийн 22.8 хувийг, харин Налайх дүүрэгт байрлалтай эмийн сангууд хамгийн бага буюу 1.8 хувийн санхүүжилтийг тус тус авсан байна.

*График 16. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймгаар*




Аймаг, орон нутгаар нь харахад Баян-Өлгий, Орхон, Дархан-Уул аймгийн эмийн сангууд бусад аймгуудтай харьцуулахад өндөр санхүүжилт авсан байна.

*Хүснэгт 6. Өндөр дүнтэй санхүүжилт авсан аймгууд*

| № | Аймаг | Суурин хүн амын тоо | Гэрээ байгуулсан эмийн сангийн тоо | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | | | сая төг | хувь |
| 1 | Баян-Өлгий | 108.376 | 53 | 3.793.2 | 6.3% |
| 2 | Орхон | 104.737 | 67 | 2.713.2 | 4.5% |
| 3 | Дархан-Уул | 106.145 | 53 | 1.875.0 | 3.1% |

*График 17. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, сараар*




Нийт санхүүжилтийн хамгийн их буюу 8.0 тэрбум төгрөгийг 07 дугаар сард, хамгийн бага буюу 2.5 тэрбум төгрөгийг 02 дугаар сард гэрээ бүхий эмийн сангуудад тус тус олгосон байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 7. ЭМДС-аас хөнгөлөлттэй олгосон эмийг өвчний бүлгээр*

| № | Эмийн бүлэг | Санхүүжилт | |
|---|---|---|---|
| | | сая төг | хувь |
| 1 | Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм | 332.3 | 0.6% |
| 2 | Арьсны өвчнийг эмчлэх бэлдмэл | 7.5 | 0.01% |
| 3 | Бөөр, шээсний замд нөлөөлөх эм | 933.6 | 1.5% |
| 4 | Вирусийн эсрэг бэлдмэл | 95.1 | 0.2% |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Даавар, даавраын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл | 4047.9 | 6.7% |
| 6 | Дархлаа дарангуйлах эм | 155.4 | 0.3% |
| 7 | Зүрх судасны эм | 30374.6 | 50.3% |
| 8 | Нүдний өвчинд хэрэглэх бэлдмэл | 282.1 | 0.5% |
| 9 | Окситоцин ба түүний эсрэг бэлдмэлүүд | 89.9 | 0.1% |
| 10 | Опиодын буюу наркотик өвдөлт намдаах эм | 0.7 | 0.001% |
| 11 | Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм | 1306.1 | 2.2% |
| 12 | Салга өвчнийг эмчлэх эм /паркинсоны өвчин/ | 39.1 | 0.1% |
| 13 | Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм | 3560.4 | 5.8% |
| 14 | Түрүү булчирхайн эмгэгт хэрэглэх эм | 7.2 | 0.01% |
| 15 | Уналт, таталтын эсрэг эм | 1757.9 | 2.9% |
| 16 | Халдварын эсрэг бэлдмэл | 2965.4 | 4.9% |
| 17 | Харшлын ба анафилаксийн эсрэг эм | 72.6 | 0.1% |
| 18 | Ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм | 9439.3 | 15.6% |
| 19 | Цусанд нөлөөлөх эм | 4813.7 | 8.0% |
| 20 | Чихрийн шижин эмчлэх | 119.0 | 0.2% |
| **Нийт** | | **60,400.0** | **100.0%** |

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгосон нийт эмийн 50.3 хувь нь зүрх судасны үйл ажиллагааны алдагдал, 15.6 хувь нь хоол боловсруулах замын үйл ажиллагааны алдагдлын үед хэрэглэх бэлдмэл, 6.7 хувь нь даавраын гаралтай бэлдмэл, 4.9 хувь нь халдварын эсрэг бэлдмэл, 2.9 хувь нь уналт таталтын эсрэг бэлдмэл, 5.8 хувь нь сэтгэцэд нөлөөт эмийн бэлдмэл байгаа бол 8.0 хувийг цусанд нөлөөлөх эмийн бэлдмэл, 2.2 хувийг өвдөлт намдаах эмийн бэлдмэл, 1.5 хувийг бөөр шээсний замын эмгэгийн үед хэрэглэх эмийн бэлдмэлүүд тус тус эзэлж байна.

*График 18. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт даатгуулагчийн төрлөөр*




Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 72.9 хувийг эзэлж байгаа бол хугацаат цэргийн албан хаагч, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, ял эдэлж байгаа ялтан санхүүжилтийн хамгийн бага хувийг эзэлж байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*График 19. Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчид, насны бүлгээр*




Хөнгөлөлттэй эмийн хэрэглээг насны бүлгээр нь харахад 65-аас дээш насны хүн амын хөнгөлөлттэй эмийн хэрэглээ өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь тэтгэврийн насны хүн амын дунд зонхилон тохиолдох зүрх, судасны өвчлөл, мэдрэлийн гаралтай өвчлөл, бөөр шээсний замын өвчлөл, хоол боловсруулах замын өвчлөл зэрэг архаг өвчин өндөр байдагтай холбоотой юм.

*График 20.0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ, эмийн өвчний бүлгээр*




0-19 насны даатгуулагчдын хувьд халдварын эсрэг бэлдмэл хамгийн өндөр буюу 44.5 хувь, уналт, таталтын эсрэг эм 21.6 хувь, вирусийн эсрэг эм 9.6 хувийг эзэлж байна. Халдварын эсрэг бэлдмэлийн хэрэглээ өндөр байгаа нь бага насны хүүхдүүдийн дунд амьсгалын замын өвчлөл буюу томуу, томуу төст өвчин, арьсны идээт ба мөөгөнцөрт өвчнүүд их байдагтай холбоотой.

0-19 насны даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалаас хамгийн өндөр санхүүжилт авсан дараах 5 бүлгийн эм, бэлдмэлүүд дотроос хамгийн их хэрэглээнд гарсан эмийг худалдааны нэршлээр нь харууллаа.

UIH.MN ЦАХИМ НОМЫН САН

*Хүснэгт 8. 0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан халдварын эсрэг эмийн тоо болон олгосон санхүүжилт*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Амоксиклав 250мг | 56,972 | 14.7% | 66.6 | 26.2% |
| 2 | Клавомид 375 250мг | 62,871 | 16.2% | 52.6 | 20.7% |
| 3 | Флемоксин солутаб 250мг | 163,886 | 42.3% | 48.5 | 19.1% |
| 4 | Лево-денк 250 250мг | 10,822 | 2.8% | 17.9 | 7.1% |
| 5 | Моксиклав 250мг | 10,727 | 2.8% | 11.6 | 4.6% |
| 6 | Кмоксилин 250мг | 12,015 | 3.1% | 7.0 | 2.7% |
| 7 | Теоклав-375 250мг | 9,048 | 2.3% | 6.3 | 2.5% |
| 8 | Фромилид 500мг | 1,976 | 0.5% | 4.5 | 1.8% |
| 9 | Амоксициллин 250мг | 15,282 | 3.9% | 4.3 | 1.7% |
| 10 | Леваксела 250мг | 2,563 | 0.7% | 3.4 | 1.3% |

*Хүснэгт 9. 0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан уналт, таталтын эмийн тоо болон олгосон санхүүжилт*

| | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Депакин хроно | 64,774 | 27.2% | 59.4 | 48.2% |
| 2 | Эпилиптор ср 200мг | 69,458 | 29.1% | 24.3 | 19.7% |
| 3 | Матевер | 14,394 | 6.0% | 21.0 | 17.0% |
| 4 | Карбамазепин | 78,825 | 33.1% | 12.5 | 10.1% |
| 5 | Тебантин 300мг | 2,730 | 1.1% | 1.8 | 1.5% |
| 6 | Валептик 250мг/5мл - 120 мл | 101 | 0.0% | 1.6 | 1.3% |
| 7 | Кепрептол ср 500мг | 1,280 | 0.5% | 0.8 | 0.6% |
| 8 | Барбитал 5мг | 3,262 | 1.4% | 0.8 | 0.6% |
| 9 | Трилептал | 545 | 0.2% | 0.2 | 0.2% |
| 10 | Опипентин 300мг | 200 | 0.1% | 0.2 | 0.1% |

*Хүснэгт 10. 0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан вирусийн эсрэг эмийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Юухан н флу 75мг | 17,220 | 100% | 54,6 | 100% |

*Хүснэгт 11. 0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан окстоцин ба түүний эсрэг эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Нобивент 2.5мг / 2.5мл | 236 | 5.2% | 4.1 | 9.7% |
| 2 | Окскорил 100мл | 401 | 8.9% | 9.9 | 23.5% |
| 3 | Салброн 4мг | 2,936 | 65.2% | 7.1 | 16.9% |
| 4 | Салбутино 100мкг/доз - 200доз | 467 | 10.4% | 11.3 | 27.0% |
| 5 | Сальбутамол ав 100мкг/200доз | 462 | 10.3% | 9.6 | 22.8% |

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 12. 0-19 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Нольпаза | 8,971 | 19.4% | 9.3 | 28.4% |
| 2 | Урсофальк | 5,320 | 11.5% | 6.0 | 18.4% |
| 3 | Промез 20мг | 16,151 | 35.0% | 5.9 | 18.0% |
| 4 | Гасек 20 гастрокапс | 4,687 | 10.1% | 4.4 | 13.4% |
| 5 | Омепразол 20мг | 6,282 | 13.6% | 3.5 | 10.6% |
| 6 | Панто-денк | 818 | 1.8% | 0.8 | 2.5% |
| 7 | Озид 20мг | 1,396 | 3.0% | 0.8 | 2.3% |
| 8 | Эманера | 854 | 1.8% | 0.7 | 2.2% |
| 9 | Контролок | 314 | 0.7% | 0.5 | 1.6% |
| 10 | Ультоп 20мг | 260 | 0.6% | 0.2 | 0.8% |

*График 21.20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ*




UIH.MN СУДАЛГААНЫ САН

20-39 насны даатгуулагчдын хувьд зүрх судасны эм, ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эмүүд хамгийн өндөр хувийг эзэлж байна. Энэ нь идэр насны хүн амын дунд зүрх судасны болон хоол боловсруулах замын өвчлөл байгааг харуулж байна. 20-39 насны даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалын сангаас хамгийн өндөр санхүүжилт авсан дараах 5 бүлгийн эм, бэлдмэлүүд дотроос хамгийн их хэрэглээнд гарсан эмийг худалдааны нэршлээр нь харууллаа.

*Хүснэгт 13. 20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан зүрх судасны өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Аторис 40мг | 167,296 | 11.1% | 317.2 | 18.5% |
| 2 | Диротон 10мг | 149,946 | 9.9% | 151.6 | 8.8% |
| 4 | Экватор | 104,871 | 6.9% | 129.4 | 7.5% |
| 6 | Лориста | 144,581 | 9.6% | 118.9 | 6.9% |
| 3 | Предизин 35мг | 158,676 | 10.5% | 102.4 | 6.0% |
| 5 | Амло-денк 10 10мг | 83,521 | 5.5% | 76.9 | 4.5% |
| 7 | Карведи - денк 6.25мг | 46,204 | 3.1% | 58.9 | 3.4% |
| 8 | Эксфорж 10мг + 160мг | 35,776 | 2.4% | 47.7 | 2.8% |
| 9 | Ксарелто 20мг | 7,058 | 0.5% | 41.8 | 2.4% |
| 10 | Аторис 10мг | 22,660 | 1.5% | 36.1 | 2.1% |

*Хүснэгт 14. 20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Нольпаза | 490,260 | 35.5% | 595.3 | 35.5% |
| 2 | Урсофальк | 672,637 | 32.7% | 868.9 | 51.7% |
| 6 | Панто-денк 20 | 28,340 | 2.1% | 30.8 | 1.8% |
| 7 | Ноцид | 35,210 | 2.5% | 26.8 | 1.6% |
| 8 | Эманера | 20,284 | 1.5% | 20.8 | 1.2% |
| 9 | Урсобил | 13,451 | 1.0% | 18.9 | 1.1% |
| 10 | Промез | 28,630 | 2.1% | 18.7 | 1.1% |
| 11 | Панто-денк 40 | 12,676 | 0.9% | 15.9 | 1.0% |

*Хүснэгт 15. 20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан халдварын эсрэг эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Фромилид | 62,179 | 10.0% | 152.1 | 16.4% |
| 2 | Флемоксин солутаб | 108,201 | 17.5% | 106.8 | 11.5% |
| 3 | Амоксиклав | 62,941 | 10.2% | 92.7 | 10.0% |
| 4 | Кларитромицин | 31,599 | 5.1% | 59.9 | 6.5% |
| 5 | Амоксиклав 2х | 27,085 | 4.4% | 53.5 | 5.8% |
| 6 | Кларитромицин протех-500 | 23,399 | 3.8% | 51.2 | 5.5% |
| 7 | Клавомид 625 | 35,068 | 5.7% | 49.9 | 5.4% |
| 8 | Кларитрон | 20,803 | 3.4% | 47.3 | 5.1% |
| 9 | Флемоклав солутаб | 28,073 | 4.5% | 43.9 | 4.7% |
| 10 | Амоксициллин | 32,481 | 5.2% | 28.8 | 3.1% |

УИХМН СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 16. 20-39 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Брайнакт | 252,861 | 85.2% | 355.5 | 82.1% |
| 2 | Цераксон | 7,767 | 2.6% | 38.8 | 9.0% |
| 3 | Зирепин | 19,707 | 6.6% | 27.4 | 6.3% |
| 4 | Этекс цитиколин | 5,367 | 1.8% | 6.0 | 1.4% |
| 5 | Торендо ку-таб | 5,969 | 2.0% | 2.7 | 0.6% |
| 6 | Озапекс | 1,000 | 0.3% | 1.1 | 0.2% |
| 7 | Фоксетин | 1,752 | 0.6% | 0.7 | 0.2% |
| 8 | Мирзентак | 1,237 | 0.4% | 0.6 | 0.1% |
| 9 | Асентра | 318 | 0.1% | 0.1 | 0.0% |
| 10 | Перидол | 680 | 0.2% | 0.1 | 0.0% |

*График 22.40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ*




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Дээрх графикаас харахад 40-59 насны хүн амын хөнгөлөлттэй эмийн хэрэглээний дийлэнх буюу нийт эмийн 50.9 хувийг зүрх, судасны эмийн хэрэглээ эзэлж байна. Мөн хоол боловсруулах замын эм, бэлдмэл болон ходоод гэдэсний замын өвчнийг эмчлэх эмүүд өндөр хувийг эзэлж байна. 40-59 насны даатгуулагчдын эрүүл мэндийн даатгалын сангаас хамгийн өндөр санхүүжилт авсан дараах 5 бүлгийн эм, бэлдмэлүүд дотроос хамгийн их хэрэглэсэн эмийг худалдааны нэршлээр нь харууллаа.

*Хүснэгт 17. 40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан зүрх судасны өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Аторис | 911,367 | 8.3% | 1499.6 | 13.2% |
| 2 | Диротон | 1,300,937 | 11.9% | 1244.0 | 10.9% |
| 3 | Экватор | 974,329 | 8.9% | 1136.1 | 10.0% |
| 4 | Лориста | 1,381,556 | 12.7% | 1135.7 | 10.0% |
| 5 | Предизин | 1,054,219 | 9.7% | 686.4 | 6.0% |
| 6 | Амло-денк 10 | 709,571 | 6.5% | 629.5 | 5.5% |
| 7 | Амлесса | 513,247 | 4.7% | 503.1 | 4.4% |
| 8 | Эксфорж | 378,193 | 3.5% | 475.9 | 4.2% |
| 9 | Конкор | 321,856 | 2.9% | 399.7 | 3.5% |
| 10 | Вальсакор | 416,905 | 3.8% | 380.9 | 3.3% |

*Хүснэгт 18. 40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Урсофальк | 1,674,031 | 50.5% | 2094.4 | 58.0% |
| 2 | Нольпаза | 1,121,754 | 33.8% | 1109.9 | 30.8% |
| 3 | Ноцид | 146,270 | 4.4% | 113.1 | 3.1% |
| 4 | Панто-денк | 85,534 | 2.6% | 81.5 | 2.3% |
| 5 | Промез | 132,937 | 4.0% | 77.0 | 2.1% |
| 6 | Эманера | 54,493 | 1.6% | 49.6 | 1.4% |
| 7 | Уколик | 33,052 | 1.0% | 29.7 | 0.8% |
| 8 | Омепразол | 30,414 | 0.9% | 19.4 | 0.5% |
| 9 | Мотилиум | 9,497 | 0.3% | 11.1 | 0.3% |
| 10 | Гасек 20 гастрокапс | 8,219 | 0.2% | 9.0 | 0.2% |

*Хүснэгт 19. 40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан цусанд нөлөөлөх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Клопи-денк | 568,876 | 47.2% | 968.8 | 48.2% |
| 2 | Зиллт | 367,570 | 30.5% | 559.2 | 27.8% |
| 3 | Тессирон | 146,169 | 12.1% | 270.1 | 13.4% |
| 4 | Копидрел | 68,141 | 5.7% | 113.0 | 5.6% |
| 5 | Плавикс | 9,080 | 0.8% | 55.6 | 2.8% |
| 6 | Клопида | 21,900 | 1.8% | 23.6 | 1.2% |
| 7 | Плогрель | 14,069 | 1.2% | 15.7 | 0.8% |
| 8 | Варфарин никомед | 9,346 | 0.8% | 3.9 | 0.2% |

*Хүснэгт 20. 40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Гальвус мет | 486,936 | 36.6% | 593.2 | 43.8% |
| 2 | Тамсол | 103,158 | 7.8% | 142.4 | 10.5% |
| 3 | Омник | 69,666 | 5.2% | 119.1 | 8.8% |
| 4 | Омник окас | 32,799 | 2.5% | 101.9 | 7.5% |
| 5 | Гальвус | 66,040 | 5.0% | 90.0 | 6.6% |
| 6 | Метформин денк | 125,588 | 9.5% | 78.2 | 5.8% |
| 7 | Глимепирид денк | 56,892 | 4.3% | 58.0 | 4.3% |
| 8 | Метформин денк | 134,339 | 10.1% | 53.7 | 4.0% |
| 9 | Л-тироксин | 180,302 | 13.6% | 72.2 | 5.3% |
| 10 | Одестон | 35,018 | 2.6% | 22.5 | 1.7% |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 21. 40-59 насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Брайнакт | 850,455 | 92.2% | 1,111.4 | 89.2% |
| 2 | Зирепин | 20,454 | 2.2% | 29.0 | 2.3% |
| 3 | Фоксетин | 3,617 | 0.4% | 1.6 | 0.1% |
| 4 | Торендо ку-таб | 3,135 | 0.3% | 1.4 | 0.1% |
| 5 | Озапекс | 1,139 | 0.1% | 1.2 | 0.1% |
| 6 | Асентра | 811 | 0.1% | 0.4 | 0.0% |
| 7 | Мирзентак | 970 | 0.1% | 0.4 | 0.0% |
| 8 | Перидол | 1,130 | 0.1% | 0.1 | 0.0% |
| 9 | Галоперидол-рихтер | 90 | 0.0% | 0.1 | 0.0% |
| 10 | Ван ин литийн карбонат | 126 | 0.0% | 0.1 | 0.0% |

*График 23. 60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан эмийн хэрэглээ*




Дээрх графикаас харахад 60-аас дээш насны хүн амын хөнгөлөлттэй эмийн хэрэглээний дийлэнх буюу нийт эмийн 54.9 хувийг зүрх, судасны эм, 12.8 хувийг ходоод гэдэсний замын өвчний эм, 8 хувийг даавар, даавРын үйлдэлт бусад бэлдмэл эзэлж байна. 60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй эмийн хэрэглээнээс харахад эрүүл мэндийн даатгалын сангаас хамгийн өндөр санхүүжилт авсан дараах 5 бүлгийн эм, бэлдмэлүүд дотроос хамгийн их хэрэглээнд гарсан эмийг худалдааны нэршлээр нь харууллаа.

*Хүснэгт 22. 60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан зүрх судасны өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Экватор | 1,734,558 | 10.5% | 1,951.6 | 11.9% |
| 2 | Лориста | 2,078,386 | 12.5% | 1,743.8 | 10.6% |
| 3 | Аторис | 946,876 | 5.7% | 1,561.2 | 9.5% |
| 4 | Диротон | 1,425,597 | 8.6% | 1,362.6 | 8.3% |
| 5 | Амло-денк 10 | 1,429,619 | 8.6% | 1,238.7 | 7.5% |
| 6 | Предизин | 1,857,345 | 11.2% | 1,198.8 | 7.3% |
| 7 | Амлесса | 978,552 | 5.9% | 921.6 | 5.6% |
| 8 | Эксфорж | 627,112 | 3.8% | 766.2 | 4.7% |
| 9 | Нормодипин | 663,479 | 4.0% | 635.5 | 3.9% |
| 10 | Конкор | 486,006 | 2.9% | 578.4 | 3.5% |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 23. 60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Нольпаза | 1,627,254 | 42.3% | 1,461.8 | 38.2% |
| 2 | Урсофальк | 1,393,824 | 36.3% | 1,792.4 | 46.9% |
| 3 | Ноцид | 236,776 | 6.2% | 166.8 | 4.4% |
| 4 | Промез | 258,320 | 6.7% | 145.7 | 3.8% |
| 5 | Панто-денк 20 | 73,750 | 1.9% | 56.2 | 1.5% |
| 6 | Эманера | 55,003 | 1.4% | 43.7 | 1.1% |
| 7 | Панто-денк 40 | 35,827 | 0.9% | 35.3 | 0.9% |
| 8 | Омепразол | 58,631 | 1.5% | 33.9 | 0.9% |
| 9 | Уколик | 17,826 | 0.5% | 17.1 | 0.4% |
| 10 | Оларокс 20 | 17,314 | 0.5% | 10.0 | 0.3% |

*Хүснэгт 24. 60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Гальвус | 493,670 | 25.2% | 628.8 | 26.5% |
| 2 | Метформин денк | 285,671 | 14.6% | 153.4 | 6.5% |
| 3 | Л-тироксин | 215,428 | 11.0% | 93.1 | 3.9% |
| 4 | Глимепирид денк 2 | 71,396 | 3.6% | 66.4 | 2.8% |
| 5 | Глидабет | 14,974 | 0.8% | 7.3 | 0.3% |
| 6 | Глизид мр30 | 6,960 | 0.4% | 3.8 | 0.2% |
| 7 | Невокс икср | 4,415 | 0.2% | 2.0 | 0.1% |
| 8 | Метлонг | 3,235 | 0.2% | 1.2 | 0.1% |
| 9 | Глюкофаж хр | 2,010 | 0.1% | 1.0 | 0.0% |
| 10 | Мф 500 | 400 | 0.0% | 0.1 | 0.0% |

*Хүснэгт 25. 60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан цусанд нөлөөлөх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Клопи-денк | 663,683 | 47.7% | 1,118.0 | 48.7% |
| 2 | Зиллт | 416,446 | 29.9% | 628.7 | 27.4% |
| 3 | Тессирон | 175,940 | 12.7% | 318.5 | 13.9% |
| 4 | Копидрел | 73,833 | 5.3% | 121.3 | 5.3% |
| 5 | Плавикс | 9,874 | 0.7% | 59.8 | 2.6% |
| 6 | Клопида | 24,198 | 1.7% | 25.9 | 1.1% |
| 7 | Плогрель | 18,391 | 1.3% | 21.9 | 1.0% |
| 8 | Варфарин никомед | 8,188 | 0.6% | 4.0 | 0.2% |

*Хүснэгт 26. 60-аас дээш насны даатгуулагчдын хөнгөлөлттэй авсан сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм, бэлдмэлүүдийн хэрэглээ*

| № | Эмийн худалдааны нэр | Олгосон эмийн тоо | | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|---|
| | | ширхэг | хувь | сая төг | хувь |
| 1 | Брайнакт | 1,258,708 | 93.8% | 1,621.3 | 91.2% |
| 2 | Цераксон | 21,018 | 1.6% | 79.4 | 4.5% |
| 3 | Этекс цитиколин | 39,466 | 2.9% | 47.4 | 2.7% |
| 4 | Зирепин | 17,469 | 1.3% | 25.3 | 1.4% |
| 5 | Торендо ку-таб | 2,161 | 0.2% | 1.3 | 0.1% |
| 6 | Озапекс | 1,216 | 0.1% | 1.3 | 0.1% |
| 7 | Фоксетин | 985 | 0.1% | 0.4 | 0.0% |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

### 3.4.Эмийн үнийн хөнгөлөлт 2022 оны эхний 8 сар

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх зайлшгүй шаардлагатай эмийн нэр төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөх хэмжээ”-ний жагсаалтад багтсан 141 ерөнхий нэршлийн 410 худалдааны нэрийн эмэнд эрүүл мэндийн даатгалын сангаас 30-70 хувийн үнийн хөнгөлөлт олгож, гэрээ бүхий эмийн сангуудад эмийн үнийн хөнгөлөлтийн санхүүжилт олгож байна.

Энэ оны эхний 8 сарын байдлаар эрүүл мэндийн даатгалын сангаас 1520 эмийн санд 96.055.083 ширхэг эмийн үнэд 64.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.

*Хүснэгт 27. Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймаг, нийслэлээр*

| № | Аймаг | Эмийн тоо | | Санхүүжилт /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| | | Хайрцгаар | Ширхэгээр | |
| 1 | Архангай | 73,277 | 2,181,339 | 1,331,611,967 |
| 2 | Баян-Өлгий | 119,881 | 3,669,241 | 2,465,291,587 |
| 3 | Баянхонгор | 71,772 | 2,214,614 | 1,397,281,685 |
| 4 | Булган | 63,331 | 2,019,775 | 1,359,641,539 |
| 5 | Говь-Алтай | 40,525 | 1,257,951 | 777,619,396 |
| 6 | Говьсүмбэр | 14,933 | 475,644 | 295,717,251 |
| 7 | Дархан-Уул | 81,724 | 2,697,185 | 1,780,161,445 |
| 8 | Дорноговь | 45,781 | 1,564,470 | 964,974,337 |
| 9 | Дорнод | 58,593 | 1,808,367 | 1,089,707,080 |
| 10 | Дундговь | 25,187 | 768,209 | 448,330,804 |
| 11 | Завхан | 56,626 | 1,716,619 | 1,078,247,437 |
| 12 | Орхон | 115,432 | 3,738,360 | 2,763,688,312 |
| 13 | Өвөрхангай | 97,643 | 2,980,179 | 1,720,915,783 |
| 14 | Өмнөговь | 42,713 | 1,308,370 | 866,939,297 |
| 15 | Сүхбаатар | 48,240 | 1,568,408 | 891,605,586 |
| 16 | Сэлэнгэ | 82,475 | 2,725,471 | 1,702,979,392 |
| 17 | Төв | 67,244 | 2,065,618 | 1,231,243,881 |
| 18 | Увс | 80,637 | 2,567,153 | 1,565,037,857 |
| 19 | Ховд | 72,229 | 2,237,193 | 1,397,747,892 |
| 20 | Хөвсгөл | 71,700 | 2,236,037 | 1,343,426,794 |
| 21 | Хэнтий | 49,207 | 1,548,739 | 998,380,109 |
| 22 | Улаанбаатар | 1,566,712 | 52,706,141 | 37,183,621,438 |
| | Нийт дүн | 2,945,862 | 96,055,083 | 64,654,170,869 |

Нийт олгосон санхүүжилтийн 57.5 хувийг Улаанбаатар хотод, 42.5 хувийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа эмийн сангуудад олгосон байна.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 28.Нийслэлийн дүүргүүдийн эмийн сангуудад олгосон санхүүжилт*

| № | Дүүрэг | Гэрээ байгуулсан эмийн сангийн тоо | Санхүүжилт | |
|---|---|---|---|---|
| | | | Төгрөгөөр | Хувиар |
| 1 | Баянзүрх | 182 | 8,354,282,827 | 22.5% |
| 2 | Баянгол | 140 | 7,578,500,136 | 20.4% |
| 3 | Сонгинохайрхан | 113 | 5,591,529,789 | 15.0% |
| 4 | Хан-Уул | 112 | 5,542,643,552 | 14.9% |
| 5 | Сүхбаатар | 88 | 5,093,283,753 | 13.7% |
| 6 | Чингэлтэй | 57 | 3,658,112,328 | 9.8% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Багануур | 9 | 699,184,987 | 1.9% |
| 8 | Налайх | 12 | 666,084,066 | 1.8% |
| **Нийт** | | **713** | **37,183,621,438** | **100.0%** |

Нийслэлийн хэмжээнд нийт 713 эмийн сан хөнгөлөлттэй эмийн жороор даатгуулагчдад үйлчилж, 37.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг эрүүл мэндийн даатгалын сангаас авсан байна.

*График 24.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, аймгаар*




Аймаг, орон нутгаар нь харахад Орхон аймаг 10.1 хувь, Баян-Өлгий 9.0 хувь, Дархан-Уул 6.5 хувь буюу хамгийн их харин Говьсүмбэр аймаг хамгийн бага буюу 1.1 хувийн санхүүжилт авсан байна.

*График 25.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт, дүүргээр*




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Байршлаар нь харахад Баянзүрх дүүрэгт байрлалтай эмийн сангууд хамгийн өндөр буюу санхүүжилтийн 22.5 хувийг, харин Налайх дүүрэгт байрлалтай эмийн сангууд хамгийн бага буюу 1.8 хувийн санхүүжилтийг тус тус авсан байна.

*График 26.Хөнгөлөлттэй эмийн санхүүжилт даатгуулагчийн төрлөөр*




Даатгуулагчийн төрлөөр нь авч үзэхэд тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэд хөнгөлөлттэй эмийн нийт санхүүжилтийн 78.1 хувийг эзэлж байгаа бол хугацаат цэргийн алба хаагч, хүүхдээ асарч буй эх/эцэг, гадаадын иргэн, харьяалалгүй иргэн, ял эдэлж байгаа ялтан санхүүжилтийн хамгийн бага хувийг эзэлж байна.

*График 27.Хөнгөлөлттэй эм авсан даатгуулагчид, насны бүлгээр*




Хөнгөлөлттэй эмийн хэрэглээг насны бүлгээр нь харахад 65-аас дээш насны хүн амын хөнгөлөлттэй эмийн хэрэглээ өндөр байгаа нь харагдаж байна. Энэ нь тэтгэврийн насны хүн амын дунд зонхилон тохиолдох зүрх, судасны өвчлөл, хоол боловсруулах замын өвчлөл зэрэг архаг өвчин өндөр байдагтай холбоотой юм.

UIH.MN СУДАЛГААНЫ САН

*Хүснэгт 29. ЭМДС-аас хөнгөлөлттэй олгосон эмийн бүлгээр*

| № | Эмийн бүлгийн нэр | Эмийн тоо | | Санхүүжилт /төг-өөр/ |
|---|---|---|---|---|
| | | Хайрцгаар | Ширхэгээр | |
| 1 | Амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх эм | 23,310 | 356,856 | 462,943,011 |
| 2 | Арьсны өвчнийг эмчлэх бэлдмэл | 739 | 743 | 4,337,700 |
| 3 | Бөөр, шээсний замд нөлөөлөх эм | 41,641 | 1,563,638 | 641,000,443 |
| 4 | Вирусийн эсрэг бэлдмэл | 3,817 | 41,668 | 74,933,123 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Даавар, дааврын үйлдэлт бусад бэлдмэл ба жирэмслэлтээс сэргийлэх бэлдмэл | 171,291 | 6,094,279 | 4,338,774,803 |
| 6 | Дархлаа дарангуйлах эм | 2,275 | 211,681 | 238,073,418 |
| 7 | Зүрх судасны эм | 1,467,515 | 47,643,209 | 28,641,725,928 |
| 8 | Нүдний өвчинд хэрэглэх бэлдмэл | 27,661 | 306,979 | 117,072,312 |
| 9 | Окситоцин ба түүний эсрэг бэлдмэлүүд | 6,349 | 14,571 | 34,786,884 |
| 10 | Опиодын буюу наркотик өвдөлт намдаах эм | 43 | 1,514 | 419,250 |
| 11 | Өвдөлт намдаах, халуун бууруулах, үрэвслийн эсрэг эм | 122,383 | 2,182,410 | 545,668,422 |
| 12 | Салга өвчнийг эмчлэх эм /паркинсоны өвчин/ | 1,104 | 67,025 | 54,012,210 |
| 13 | Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийг эмчлэх эм | 92,363 | 4,279,803 | 4,259,656,716 |
| 14 | Түрүү булчирхайн эмгэгт хэрэглэх эм | 861 | 25,628 | 19,594,057 |
| 15 | Уналт, таталтын эсрэг эм | 99,804 | 5,062,304 | 2,090,498,266 |
| 16 | Хавдрын эсрэг, дархлал дарангуйлах, хөнгөвчлөх эмчилгээний эм | 2,245 | 82,789 | 138,714,489 |
| 17 | Халдварын эсрэг бэлдмэл | 253,139 | 5,141,280 | 4,623,288,742 |
| 18 | Харшлын ба анафилаксийн эсрэг эм | 6,917 | 159,615 | 38,736,695 |
| 19 | Ходоод, гэдэсний замын өвчнийг эмчлэх эм | 364,310 | 15,134,419 | 9,876,562,627 |
| 20 | Цусанд нөлөөлөх эм | 250,747 | 7,468,277 | 7,727,306,742 |
| 21 | Чихрийн шижин эмчлэх | 7,348 | 216,395 | 726,065,031 |
| | Нийт | 2,945,862 | 96,055,083 | 64,654,170,869 |

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгосон нийт эмийн 44.3 хувь нь зүрх судасны үйл ажиллагааны алдагдал, 15.3 хувь нь хоол боловсруулах замын үйл ажиллагааны алдагдлын үед хэрэглэх эм бэлдмэл, 12.0 хувь нь цусанд нөлөөлөх эм, 7.2 хувь нь халдварын эсрэг бэлдмэл, 6.7 хувь нь дааврын гаралтай бэлдмэл, 6.6 хувь нь сэтгэцэд нөлөөт эмийн бэлдмэл, 1.1 хувийг чихрийн шижин эмчлэх эмийн бэлдмэлүүд тус тус эзэлж байна.

*Хүснэгт 30.* Хамгийн их санхүүжилт авсан эм /худалдааны нэрээр/

| № | Эмийн худалдааны нэр | Эмийн тоо | Санхүүжилт төгрөгөөр | Нийт санхүүжилтэд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Урсофальк | 3,942,705 | 4,586,494,519 | 7.1% |
| 2 | Клопи-денк | 3,906,413 | 3,813,191,679 | 5.9% |
| 3 | Брайнакт | 3,850,600 | 3,721,860,325 | 5.8% |
| 4 | Экватор | 4,788,832 | 3,386,762,877 | 5.2% |
| 5 | Диротон | 4,450,534 | 2,652,420,553 | 4.1% |
| 6 | Лориста | 5,457,790 | 2,629,860,656 | 4.1% |
| 7 | Аторис | 3,514,189 | 2,496,535,180 | 3.9% |
| 8 | Нольпаза | 5,549,390 | 2,152,270,913 | 3.3% |
| 9 | Амло-денк 10 | 3,280,212 | 1,829,681,816 | 2.8% |
| 10 | Зиллт | 2,157,814 | 1,775,613,361 | 2.7% |
| 11 | Амлесса | 2,939,080 | 1,718,992,741 | 2.7% |
| 12 | Юперио | 543,733 | 1,697,754,831 | 2.6% |
| 13 | Гальвус мет | 1,856,980 | 1,654,636,437 | 2.6% |
| 14 | Предизин | 5,195,707 | 1,592,721,669 | 2.5% |
| 15 | Вемлид | 767,765 | 1,556,072,050 | 2.4% |
| 16 | Эксфорж | 1,932,003 | 1,538,745,537 | 2.4% |
| 17 | Тамсол | 1,470,747 | 1,423,038,426 | 2.2% |
| 18 | Ксарелто | 229,122 | 1,225,862,672 | 1.9% |
| 19 | Тебантин | 2,274,327 | 1,189,201,144 | 1.8% |
| 20 | Плавикс | 209,629 | 1,098,202,060 | 1.7% |
| | Дүн | 58,317,572 | 43,739,919,446 | 67.7% |

UIH.MN СУДАЛГААНЫ САН

Энэ оны эхний 8 сарын байдлаар нийт зарагдсан 410 нэрийн эмийн дотор хамгийн их дүнгээр зарагдсан эмүүд нь урсофальк 7.1 хувь, клопи-денк 5.9 хувь, брайнакт 5.8 хувь, экватор 5.2 хувь, диротон 4.1 хувийг тус тус эзэлж байна.

*Хүснэгт 31. Хамгийн их санхүүжилт авсан эмийн сан*

| № | Эмийн сан | Эмийн тоо | | Санхүүжилт /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|
| | | Хайрцагаар | Ширхэгээр | |
| 1 | Маго Парадокс | 18,770 | 656,446 | 519,613,839 |
| 2 | Энхийн тун дархан | 19,957 | 666,572 | 465,462,975 |
| 3 | Маго | 16,909 | 596,213 | 466,787,718 |
| 4 | Ухаа булаг | 23,942 | 738,748 | 439,942,010 |
| 5 | Маго "Маго коёото" | 10,167 | 413,230 | 415,404,631 |
| 6 | Нони | 8,849 | 326,713 | 376,910,190 |
| 7 | Жинст эрд | 13,061 | 426,479 | 347,590,365 |
| 8 | Монос УБ - Мойл | 10,355 | 334,416 | 339,228,905 |
| 9 | Их халзан бүргэдэй | 12,811 | 440,834 | 332,227,733 |
| 10 | МЭИК - Төв | 17,709 | 546,578 | 319,250,946 |

Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй эмийн хамгийн их санхүүжилт авсан эмийн сангууд нь Маго Парадокс, Энхийн тун дархан, Маго эмийн сан байна.

*График 28. Хөнгөлөлттэй эм олгосон эмийн сангийн салбар, санхүүжилт*




*График 29. Хөнгөлөлттэй эм олгосон эмийн сангийн салбар, эмийн тоо*




UIH.MN СУДАЛГААНЫ САН

Эмийн сангийн салбараар нь авч үзэхэд Монос эмийн сангийн салбар хамгийн их, ЭНТО эмийн сангийн салбар хамгийн бага санхүүжилт авсан байна.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ


Олон улсын туршлага

- https://www.who.int/medicines/publications/druginformation/WHO-DI_30-4_RegCollaboration.pdf
- https://au.int/en/pressreleases/20200205/african-medicine-agency-ama-treaty
- https://www.bnt.eu/en/news/legal-news/2602-launch-of-eurasian-economic-union-eaeu-medicines-registration-procedure
- Dumitriu, H. I. (1997). Good drug regulatory practices: a regulatory affairs quality manual. CRC Press.
- https://www.who.int/medicines/areas/quality_safety/safety_efficacy/pharmvigi/en/
- https://www.who.int/medicines/areas/quality_safety/safety_efficacy/National_PV_Centres_Map/en/
- https://www.who.int/medicines/areas/quality_safety/safety_efficacy/Joining_the_WHO_Programme.pdf?ua=1
- http://digicollection.org/whoqapharm/documents/s23432en/s23432en.pdf

БНСУ

- NHI https://www.nhis.or.kr/nhis/index.do
- Act on the Promotion of Korea medicine and pharmaceuticals https://law.go.kr/LSW/eng/engLsSc.do?menuId=2&section=lawNm&query=PHARMACEUTICAL&x=0&y=0#liBgcolor0
- National Health Insurance Act https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=59574&type=sogan&key=10
- NHIS https://www.nhis.or.kr/english/wbheaa02200m01.do
- Kela https://www.kela.fi/yhteistyokumppanit-laakeyritykset-laake-sai-korvattavuuden

БНФУ

- Medicines Act https://www.fimea.fi/documents/160140/765540/18580_Laakelaki_englanniksi_paivitetty_5_2011.pdf
- Health Insurance Act https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/2004/en20041224_20110911.pdf
- Pharmaceuticals Pricing board https://www.hila.fi/en/operations-and-organisation/#PharmaceuticalsPricingBoard
- Анхан шатны эмийн нөхөн олговор https://www.kela.fi/laakkeet#alkuomavastuu
- 10 Тусгай эмийн нөхөн олговор https://finlex.fi/fi/laki/ajantasa/2013/20130025

БНХАУ

- https://globalpricing.com/articles/china-issues-2021-national-reimbursement-drugs-list/
- https://www.pharmaceutical-technology.com/pricing-and-market-access/china-nrdl-foreign-pd1-inhibitors/
- https://remapconsulting.com/emerging-developing-markets/nrdl-inclusion-in-china/#:~:text=Historically%20access%20to%20the%20market,NRDL)%20has%20become%20more%20established.
- https://www.researchgate.net/publication/315846396_Pharmaceutical_Policy_in_China


UIH.MN СУДАЛГААНЫ САН

- https://www.healthaffairs.org/doi/pdf/10.1377/hlthaff.27.4.1042
- https://www.euro.who.int/__data/assets/pdf_file/0020/320465/Pharmaceutical-policy-China-challenges-opportunities-reform.pdf
- http://www.pharmadj.com/en/cms/detail.htm?item.id=1abe2390597111ecbee6fa163e42049a
- https://remapconsulting.com/emerging-developing-markets/nrdl-inclusion-in-china/

АНУ

- Medicare Prescription Drug, Improvement, and Modernization Act https://en.wikipedia.org/wiki/Medicare_Prescription_Drug,_Improvement,_and_Modernization_Act
- Medicare Part D https://en.wikipedia.org/wiki/Medicare_Part_D
- Medicare https://en.wikipedia.org/wiki/Medicare_(United_States)
- https://en.wikipedia.org/wiki/340B_Drug_Pricing_Program
- Medicaid https://en.wikipedia.org/wiki/Medicaid
- Affordable Care Act https://en.wikipedia.org/wiki/Affordable_Care_Act
- Health Care and Education Reconciliation Act of 2010 https://en.wikipedia.org/wiki/Affordable_Care_Act
- United States Department of Health and Human Services https://en.wikipedia.org/wiki/United_States_Department_of_Health_and_Human_Services
- FDA https://en.wikipedia.org/wiki/Food_and_Drug_Administration

ХБНГУ

- ХБНГУ-ын эрүүл мэндийн даатгалын тогтолцоо https://www.germany-visa.org/insurances-germany/health-insurance/#:~:text=Yes%2C%20your%20health%20insurance%20plan,are%20covered%20for%20the%20rest.
- Allgemeine Ortskrankenkassen https://www.aok.de/pk/
- GKVSpitzenverband https://www.bundesgesundheitsministerium.de/themen/gesundheitswesen/selbstverwaltung/spitzenverband-bund-der-krankenkassen-gkv-spitzenverband.html
- Arzneimittelgesetz (AMG) https://www.gesetze-im-internet.de/englisch_amg/
- Bundesinstitut für Arzneimittel und Medizinprodukte (BfArM)) https://reimbursement.institute/glossar/bfarm/


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН